



Уул уурхайн салбарын бодлогын зарим асуудлууд

Оюу толгойн жишээн дээр гаргасан
санал, зөвлөмж

Улаанбаатар
2009 он

DDC
354.39
У-591

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН
БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДЛУУД

© НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр хувилахыг хүсвэл
Нээлттэй Нийгэм Форумын хаягаар хандан зохих зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян Гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 48
Монгол Улс
Утас: 976 - 11 - 313207
Факс: 976 - 11 - 324857
Веб: <http://www.forum.mn/>

ISBN 978-99929-56-72-0

ГАРЧИГ

Өмнөх үг	5
Оршил:	Оюу толгойн гэрээг хийхээс өмнө хариулт авах ёстой долоон асуулт	7
Хэсэг I.	Уул уурхайн орлогын бодлогын асуудлууд	11
	Бүлэг 1. Уул уурхайн гэрээнд орох татвар, төлбөр	11
	Бүлэг 2. Монгол Улсын зарим хуулийн төсөлд уул уурхайн татвар, төлбөрийн талаар өгсөн санал зөвлөмж	16
	Бүлэг 3. Нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг өөрчлөх санал	23
	Бүлэг 4. Оюу Толгойн ашиглалтын цогцолбор төлөвлөгөө	27
Хэсэг II.	Уул уурхайн үйлдвэрлэл дэх гэрээний дүн шинжилгээ	30
	Бүлэг 5. Уул уурхайн гэрээний хэлбэр	30
	Бүлэг 6. Гэрээ, хэлэлцээр хийх үйл ажиллагаа	32
	Бүлэг 7. Уул уурхайн гэрээнд үнэлгээ өгөхөд ашиглах эдийн засгийн тооцооны талаархи зөвлөмж	34
	Бүлэг 8. Гэрээн дэх төрийн оролцооны зарим асуудал	42
	Бүлэг 9. Гэрээ хэлцлийн ил тод байдал	46
	Бүлэг 10. Монгол Улсын Засгийн газар ба Айвенхоу майнз монгол инк ХХК-ийн хооронд хийх Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд хийсэн дүн шинжилгээ (хураангуй)	48
	Бүлэг 11. Оюу толгойн ордыг ашиглах гэрээний төсөлд хийсэн эдийн засгийн жишиг дүн шинжилгээ	53
Хэсэг III.	Уул уурхай дахь хөрөнгө оруулалтын гэрээг боловсронгуй болгох зөвлөмж	60
	Бүлэг 12. Уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээг санхүүжүүлэх	60
	Бүлэг 13. Уул уурхай дахь төрийн оролцоог санхүүжүүлэх асуудлыг дахин авч үзэх нь	61
	Бүлэг 14. Санал болгож буй уул уурхайн санхүүгийн дэглэм	65
	Бүлэг 15. Бүтээгдэхүүн хуваах гэрээ	71
Хэсэг IV.	Уул уурхайн орлогын зарцуулалтын асуудал	76
	Бүлэг 16. Эрдэс баялгийн сан байгуулах нь	76
Дүгнэлт:	Иргэддээ ээлтэй уул уурхай ба ил тод байдал	80

Хавсралт болон зураг	81
Хавсралт 1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, тооцох арга зарим улс оронд	81
Хавсралт 2. Уул уурхайн төсөв, санхүүгийн дэглэмийн харьцуулсан судалгаа	83
Хавсралт 3. Төсвийн дэглэмийн хувилбаруудыг тоогоор үзүүлэх тооцооны загвар	90
Хавсралт 4. Өнөөгийн үйлчилж буй хууль, гэрээний төслийн заалтуудын харьцуулалт ..	96
Хавсралт 5. Гэрээнд үнэлгээ өгөх ажлыг эхлэхэд шаардлагатай мэдээллийн загвар тайлан	98
Хавсралт 6. Монгол Улсын Засгийн газар, Айвенхоу майнз монгол инк ХХК-ийн хооронд байгуулагдах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл ба Оюу толгой төслийн хувь нийлүүлэгчдийн гэрээний төсөлд өгөх тайлбар, санал	99
Хавсралт 7. Боловсруулах шатны ашгийг хүртэхийг эрмэлзэхээс үүсэх эрсдлийн жишээ	108
Хавсралт 8. Жишиг дүн шинжилгээг хийхэд ашигласан урьтал нөхцөл	112
Хавсралт 9. Суурь кейсийн үр дүн	114
Хавсралт 10. Үнэ өөрчлөгдөх үеийн Монгол Улсад ногдох өнөөгийн үнэ цэнийн хувь	114
Хавсралт 11. Зээлийн бүтэц өөрчлөгдөх үеийн Монгол Улсад ногдох өнөөгийн үнэ цэнийн хувь	115
Хавсралт 12. Хорогдуулах хувь өөрчлөгдөх үеийн Монгол Улсад ногдох өнөөгийн үнэ цэнийн хувь	115
Хавсралт 13. Санал болгосон санхүүгийн дэглэм	116
Хавсралт 14. Бүтээгдэхүүн хуваах гэрээ, олон улсын харьцуулалт	119
Хавсралт 15. Бүтээгдэхүүн хуваах энгийн жишээ	124
Зураг 1. Зэсийн үнийн өөрчлөлт Монгол улсын авах өнөөгийн үнэ цэнийн хувь хэмжээнд нөлөөлөх нь	126
Зураг 2. Зээлийн бүтэц Монгол улсын авах өнөөгийн үнэ цэнийн хувь хэмжээнд нөлөөлөх нь	126
Зураг 3. Хорогдуулах хувь Монгол улсын авах өнөөгийн үнэ цэнийн хувь хэмжээнд нөлөөлөх нь	126
Зураг 4. Бүтээгдэхүүн хуваах гэрээ	127
Зураг 5. Төрийн хувь эзэмших оролцоотой бүтээгдэхүүн хуваах гэрээ	128
Зураг 6. Түлшнээс бусад ашигт малтмалд өргөн хэрэглэгддэг төсөв санхүүгийн хэрэгслүүд	129

ӨМНӨХ ҮГ

Байгалийн нөөц баялаг ихтэй улс орны ард иргэд баян чинээлэг амьдрах бүрэн боломжтойг зарим орны туршлага, эдийн засгийн энгийн ухаан өгүүлдэг. Гэвч баялагтай улс орон хоосрол ядуурал, авилга хээл хахууль, тэмцэл зөрчилдөөний талбар болсон түүх даанч олон. Энэ үзэгдлийг «нөөц баялгийн хяслан» гэх бөгөөд байгалийн баялгийг төрийн ухаалаг бодлогоор ашиглах тохиолдолд тойрон гарах бүрэн боломжтой. Гагцхүү төрийн бодлого олон ашиг сонирхолыг дэнсэлж, ил тод, иргэдийн оролцоотойгоор боловсрогдож, олон нийтийн хяналтан дор хэрэгжих аваас байгалийн баялаг хүний хөгжлийн түлхүүр болох учиртай.

Монгол Улсад сүүлийн 10 гаруй жил ашигт малтмалын эрэл, хайгуул идэвхтэй өрнөж, олон төрлийн ашигт малтмалын олборлолт хийгдэж ирлээ. Харин үр дүнд нь байгаль эвдэрч сүйдэж, ашгаас нь ард иргэд тэр бүр тэгш хүртээгүй байдал ажиглагдаж байгаа нь ашигт малтмалыг ашиглах бодлого, түүний хэрэгжилтэд олон нийтийн анхаарлаа хандуулахад хүргэсэн билээ. Нөгөө талаас эрдэс баялгаа ашиглан түргэн хөгжих асар их нөөц боломж байгаа учир олон нийт санаа бодлоо уралдуулахад хүрсэн билээ. Энэ зүй ёсны үйл явцад хувь нэмрээ оруулахыг Нээлттэй Нийгэм Форум өөрийн нэгэн үүрэг, улс орны хөгжилд оруулах чухал хувь нэмэр хэмээн үзэж хөндлөнгийн шинжээч хэд хэдэн удаа урьж зөвлөлгөө авч санал зөвлөмж гаргуулсан бөгөөд эдгээр санал, зөвлөмжийг тухай бүрд нь асуудал бүрээр Улсын Их Хурал, Засгийн газар, олон нийтэд хүргүүлж байсан болно. Нээлттэй Нийгэм Форум болон олон улсад нөөц баялгийн хясланг тойрон гарах чиглэлээр ажилладаг Орлогын ажиглагч хүрээлэнгийн зөвлөх зөвлөлийн дарга, хуульч Жозеф Бэлл, Дюкийн их сургуулийн профессор, эдийн засагч Роберт

Конрад, Орлогын ажиглагч хүрээлэнгийн захирал Карин Лиссакерс нарын 2005-2008 оны хооронд гаргасан санал зөвлөмжийн баримт бичгийг нэгтгэн «Уул уурхайн салбарын бодлогын зарим асуудлууд, Оюу толгойн жишээн дээр гаргасан санал зөвлөмж» хэмээх энэхүү гарын авлагыг гаргаж байгаа болно. Цаг хугацааны болон зорилтот бүлгүүдийн хувьд харилцан адилгүй нөхцөлд эдгээр санал, зөвлөмж, тооцоо судалгааг бэлтгэгдсэн ч үндсэн асуудлууд нь цаашид уул уурхайн бодлогыг томъёолох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахад чухал ач холбогдолтой олон асуултад хариу өгнө гэдэгт итгэлтэй байна.

Уул уурхайн салбарын бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, сонирхогч нарт энэ салбарын бодлогын зарим асуудлаар арга зүйн болон практик туслалцаа үзүүлэх зорилготой эл гарын авлага нь дараахи 5 хэсгээс бүрдэнэ:

I Хэсэг - Уул уурхайн татвар, орлогын бодлогын асуудлыг авч үзэж албан татвар, төлбөр, бусад орлогын төрлийн талаар Нээлттэй Нийгэм Форум, хөндлөнгийн шинжээчдийн 2005 оны сүүлчээс 2006 оны дунд үе хүртэлх хугацаанд гаргасан санал зөвлөмж, мөн Ашигт малтмалын тухай болон татварын багц хуулиудын төслийг судалж гаргасан санал зөвлөмж зэргийг авч үзнэ. Энэ хэсэгт Айвенхоу майнз-ийн Монголын олон нийтэд танилцуулсан «Орд ашиглалтын цогцолбор төлөвлөгөө» болон хавсралт «Стоксын тайланд хийсэн шинжилгээ, түүний дагуу нийтэд гаргасан үзэл бодлыг оруулна. Дээрх асуудлыг 3 бүлэгт багтаан танилцууллаа.

II Хэсэг - Уул уурхайн үйлдвэрлэл дэх хөрөнгө оруулалтын гэрээний асуудлууд, тухайлбал, гэрээний хэлбэр, гэрээ хэлцэл хийх үйл ажиллагаа, гэрээн дэх төрийн

оролцооны зарим асуудал, гэрээ хэлцлийн ил тод байдал зэргийг авч үзнэ. Энэ хэсэгт Монгол Улсын Засгийн газар ба Айвенхоу майнз монголиа инк ХХК-ийн хооронд хийх Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд хийсэн дүн шинжилгээ, Оюу толгойн ордыг ашиглах гэрээний төсөлд хийсэн жишиг дүн шинжилгээг оруулна. Дээрх асуудлыг 6 бүлэг болгон авч үзнэ.

III Хэсэг – Уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээг боловсронгуй болгох зөвлөмж, тухайлбал уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээг санхүүжүүлэх, уул уурхай дахь төрийн оролцоог санхүүжүүлэх асуудал, энэ талаархи санал зөвлөмжийг нэгтгэн авч үзнэ. Мөн энэ хэсэгт шинжээчдээс санал болгосон уул уурхайн татварын дэглэм, бүтээгдэхүүн хуваах гэрээний тухай асуудлыг оруулна. Энэ хэсгийг 4 бүлэг болгон авч үзнэ.

IV Хэсэг – Уул уурхайн орлогын зарцуулалтын асуудлыг товч авч үзнэ. Энэ хэсэг 1 бүлэг байна.

ҮХэсэг–Дүгнэлт-Уул уурхайн салбарын бодлогын асуудлуудын талаарх **нэгтгэсэн дүгнэлт, цаашид авах арга хэмжээний** талаар өгүүлнэ.

VI Хэсэг – Хавсралт болон зураг. Энэ хэсэгт уул уурхайн хөрөнгө оруулалт, Оюу толгойн гэрээтэй холбоотой хөндлөнгийн шинжээчдийнхийсэншинжилгээ,харьцуулсан судалгаа, хүснэгт, зураг зэргийг хавсралт болгон орууллаа.

Энэхүү бодлогын асуудлаарх гарын авлага нь та бүхний хэрэгцээ шаардлагад нийцэж, нөөц баялаг нь хяслан бус хөгжлийн түлхүүр байх нөхцлийг бүрдүүлэхүйц бодлогыг боловсруулан, хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулна гэж найдаж байна.

Нээлттэй Нийгэм Форумын
Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

Оршил: Оюу толгойн гэрээг хийхээс өмнө хариулт авах ёстой долоон асуулт

Засгийн газар Оюу толгойн орд газрыг ашиглах талаар Айвенхоу майнз монгол инк ХХК-тай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслөө боловсруулж хэлэлцэн Улсын Их Хуралд танилцуулсан нь нийтэд ил тод болсон билээ. Энэхүү гэрээ нь Монголын ирээдүйд нэн чухал ач холбогдолтой загвар болох юм. Зарим тооцоогоор Оюу толгойн орд нь манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүнийг ирэх жилүүдэд 35 хүртэл хувиар нэмэгдүүлж болзошгүй байна. Улсын Их Хурал энэхүү гэрээг хэлэлцэх явцдаа зайлшгүй анхаарлаа хандуулбал зохих ёстой гэж Нээлттэй Нийгэм Форумын зүгээс авч үзэж буй зарим асуултыг дор авч үзвэл:

Нэгдэх асуулт: Гэрээний төсөл хэр зэрэг шударга болсон бэ? Гэрээний дагуу монголчууд бид энэ их баялгийнхаа үр шимийг нь хүртэж чадахаар байна уу?

Уул уурхайгаас монголчуудын хүртэх үр шим нь бодит байдал дээр улсын төсөвт оруулж байгаа хувь нэмрээр тодорхойлогдох юм. Энэ бол амаргүй асуулт. Үүнд Улсын Их Хурал, Засгийн газраас өгөх хариулт нь тухайн гэрээ болон түүнд шийдвэрлэх нөлөөтэй чухал таамаглалуудыг сайтар ойлгохоос хамаарна. Гэрээний өгөгдсөн нөхцлүүдэд, ялангуяа ашигт малтмалын ирээдүйн үнэтэй холбоотой тодорхойгүй зүйлс байгаа ч, орлогын тооцоо нь ашгийг хэрхэн хуваахыг үнийн янз бүрийн «хувилбарууд»-аар харуулах ёстой. Эдгээр бүх хувилбарт уг гэрээний төсөл нь гэрээ байгуулсан аль аль талд нь адил тэгш үйлчилж чадаж байна уу? Засгийн газар хэр их хувь хүртэхийг хэлэх төдий өнгөрөх нь хангалтгүй. Тэр ч байтугай, Засгийн газар Айвенхоутой

орлогоо 50, 50 хувиар хуваалцана гэж хэлэх ч хангалтгүй. Зарим улс төрчид болон зарим хүмүүсийн дэвшүүлээд байгаа 50:50 хувийг хэзээ хүртэх вэ, яг юуны 50:50 хувийг хүртэх вэ гэдгээс хамаарч энэ хувь Засгийн газрын хувьд хэтэрхий их, эсхүл хэтэрхий бага байж ч болно. Саяхан Ливи Улсад дуудлагаар худалдсан газрын тосны орд газрын нийт ашгийн төрд ногдох хувь нь 80 хувиас илүү гарч байв. Иймд Засгийн газар тооцоолж гаргасан нийт ашигт ажиллагааны хэмжээ, «Засгийн газрын хүртэх хувь», уг тооцоог хийхэд тулгуурласан санхүүгийн загварын талаарх мэдээллийг Улсын Их Хуралд өгөх ёстой юм. Дүн шинжилгээ ч бэлхнээ байгаа. Айвенхоу майнз компани үүнийг өөрөө дотооддоо хийж гүйцэтгэдэг. Айвенхоу майнз ийм шинжилгээг Ашиглалтын цогцолбор төлөвлөгөөндөө бие даан гүйцэтгэж, нийтийн хүртээл болгосон бөгөөд уг төлөвлөгөөгөө шинэчилж байна. Оюу толгойн орд газар онцгой ач холбогдолтой тул Улсын Их Хурал уг гэрээний талаар санал хураахаасаа өмнө Засгийн газраас болон хөндлөнгийн шинжээчийн боловсруулсан шинжилгээний дүнг мэдэж байх ёстой. Ийм шинжилгээний дүн иргэний нийгэм, иргэдэд ч хэрэгтэй.

Хоёр дахь асуулт: Амьдралд биелэх, хэрэгжүүлж болохуйц гэрээ мөн үү?

Цаасан дээр бичигдсэн тоонууд шударга мэт харагдаж байвч тэр нь амьдрал дээр бодитойгоор хэрэгжих эсэхийг Улсын Их Хурал өөрөө шалгаж магадлах ёстой. Засгийн газарт орох орлогын хэмжээнд олон тооны техникийн шинж чанартай асуудлууд нөлөөлдөг ба үүнд нөөц ашигласны төлбөрийг тооцоолоход

ашигласан үнэ, зэс, алтны экспортын борлуулалтын үнэ, тэдгээрийн ил тод байдал, харъяа буюу холбоотой компаниудад төлөх үйлчилгээний хөлс, Засгийн газрын орлогыг бууруулахад хүргэдэг өрийн санхүүжилтийг ашигласан, хязгаарласан байдал, гэрээнд хяналт шинжилгээ хийсэн болон гэрээг хэрэгжүүлэхэд хялбар дөхөм байдал зэргийг дурьдаж болно. Гэрээнд аудитын ямар хамгаалалт хийгдсэн байна вэ? Юун түрүүнд Айвенхоугийн аль хэдийнэ хөрөнгө оруулсан гээд байгаа 600 сая ам.долларын хөрөнгө оруулалтад аудит хийсэн эсэхийг тодорхойлох шаардлагатай.

Гурав дахь асуулт: Хайлуулах үйлдвэр барьж ажиллуулах Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараас Засгийн газар татгалзах хэмжээний үнэ цэнэтэй юу?

Айвенхоу майнз монгол инк компани олборлосон алтаа Төв банкаар дамжуулан борлуулах болон таван жилийн дотор зэс хайлуулах үйлдвэр байгуулах үүрэг хүлээсэн тохиолдолд Засгийн газрын хөрөнгө оруулалтын гэрээгээр Айвенхоу майнз монгол инк компанийг алт, зэсний үнийн өсөлтийн албан татвараас бүрэн чөлөөлөх тухай гэрээний төсөлд заасан байна. Энэхүү зэс хайлуулах үйлдвэр Монголын хувьд тааруухан наймаа болж болзошгүй. Хэдийгээр хайлуулах үйлдвэр өндөр үнэтэй, түүнчлэн зэсийн үнэ өнөөгийн төвшнөөсөө буурсан ч гэсэн ийм үйлдвэр байгуулах хүртэлх таван жилийн хугацаанд (одоогийн хуулиар бол Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар энэ хугацаанд үйлчлэх ёстой) зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараас авч болох орлого хэдэн тэрбум доллараар хэмжигдэж, магадгүй хайлуулах үйлдвэр байгуулах хөрөнгийн нийт зардлаас хоёр дахин давах боломжтой байж мэднэ. Иймд Засгийн газар зэс хайлуулах үйлдвэрийг өөрөө байгуулж, өөрөө эзэмшээд дээр нь илүү орлоготой үлдэх бүрэн

бололцоотой юм. Анхаарал татсан, эгзэгтэй өөр бас нэг учир шалтгаан байна. Хайлуулах үйлдвэр нь шинээр ажлын байр төдийлөн нэмэгдүүлэхгүйн зэрэгцээ хүнцэл, хүхрийн давхар исэл, тоос болон нүүрс төрөгчийн дан исэл ялгаруулан байгаль орчны хувьд ноцтой асуудлууд үүсгэх талтай. Уг гэрээгээр эрх олгосон аливаа хайлуулах үйлдвэр нь олон улсын хамгийн өндөр стандартад нийцсэн, нэн сүүлийн үеийн байгаль орчны хяналттай байна гэдэг итгэл, хүлээлт л байна. Тэгвэл учирч болзошгүй хор хохирлыг тооцоолвол Монгол Улс Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараа авахаар байлгаж, гол зах зээл болох гадаад улсад хайлуулах үйлдвэртэй холбоотой байгаль орчны өртөг зардлыг үүрүүлсэн нь дээр ч байж мэдэх юм.

Дөрөв дэх асуулт: Засгийн газар хувь эзэмшихийн тулд юу төлөх вэ, хувьцаанаасаа ямар үр өгөөж хүртэх вэ?

Уг гэрээгээр Засгийн газар нийт хөрөнгийн 34 ба түүнээс дээш хувийг эзэмших төлөвтэй байна. Энэхүү хувь эзэмших сонголтод хайлуулах үйлдвэрийн нэг адил тусад нь санхүүгийн шинжилгээ хийх ёстой. Ямар өртөг зардал гарах вэ? Засгийн газар ямар бодит үр өгөөж хүртэх вэ? Хувь эзэмших нь хэдийгээр түгээмэл байдаг ч сайн наймаа биш ч байж болно. Зүгээр л үнэ төлбөргүй хувь эзэмшинэ гэж хэзээ ч байхгүй. Хувь эзэмших нь эдийн засгийг олон тулгууртай болгохоосоо илүү уул уурхайгаас улам бүр хамааралтай болгоно. Засгийн газар өөрийн эзэмших хувийг худалдаж авах (буюу тэр мөнгийг Айвенхоу майнз монгол инк компаниас зээлж авах) учраас ямар нэг эдийн засгийн үр шим хүртэх асуудал ихээхэн хол сонстож байна. Засгийн газар ямар нэг үр шим хүртэх болтол хэдэн жил шаардагдах бол? Ямар ч үр өгөөж хүртэх байсан, түүний оронд Айвенхоу майнз монгол инк компанийн төлөх байсан татвар болон хувь эзэмшсэний төлөө Айвенхоу майнз монгол инк компанид

үзүүлж байгаа бусад хөнгөлөлт, урамшууллыг харьцуулж үзэх хэрэгтэй. Олон тохиолдолд, зүгээр л ногдол ашиг, хүү, үйлчилгээний төлбөрүүд зэрэг эхний өдрөөсөө эхлээд орлого оруулах төлбөрүүдийг хуульд заасан хувь хэмжээгээр аваад явж байхад бидэнд илүү ашигтай байж болох юм. Түүнчлэн Засгийн газар ямар эрх эдлэх вэ гэдэг бас нэг асуулт чухал билээ. Монгол Улсын хуулинд заасан жижиг буюу цөөнх хөрөнгө оруулагчдыг хамгаалах хамгаалалтууд үйлчлэх үү? Аливаа шийдвэр гаргахад Засгийн газар цөөнх хувьцаа эзэмшдэг хөрөнгө оруулагчийн хувьд зөвшөөрөл олгох боломжтой байна уу? Засгийн газар эзэмшлээ худалдан борлуулж болох уу? Хятад, Оросын хувь эзэмшилд, эсхүл үл мэдэгдэх Монгол этгээдийн эзэмшил бүхий уурхайд Засгийн газар хувь эзэмших нөхцөл үүсэх боломжтой юу? Эцэст нь, Засгийн газрын бусад бодлоготой зөрчилдөж байгаа асуудлыг хэрхэн зохицуулах вэ? Засгийн газар өөрийн хувь эзэмшлээ хамгаалахын тулд байгаль орчны, эсхүл аюулгүй байдлын арга хэмжээгээ сулруулахаас сэргийлсэн хамгаалалт байна уу?

Тав дахь асуулт: Гэрээгээр нутгийн иргэд, газар нутаг хамгаалагдсан уу?

Уул уурхай нь байгаль орчны болон нийгмийн ноцтой үр дагавар дагуулдаг. Аз болоход, Айвенхоу майнз монгол инк компанийн шинэ хувьцаа эзэмшигч Рио Тинто компани энэ талаар нэр хүнд сайтай. Тус компани НҮБ-ын Глобал компакт, бизнесийн хээл хахуулийг таслан зогсоход чиглэсэн Транспаренси Интернэйшнлийн хүчин чармайлт болон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын анхны дэмжигчдийн нэг юм. Тэгвэл уг гэрээнд Айвенхоу майнз монгол инк компани дээрх хувьцаа эзэмшигчийнхээ мөрддөг эдгээр практикийг даган баримтлах эсэх, Рио Тинто хөрөнгө оруулагч байхаа больсон ч эдгээр практик үргэлжлэх нөхцлийг

хангах уу? Уурхайг ашиглах явцад Монгол Улс байгаль орчны болон хөдөлмөрийн хуулиудаа өөрчлөн сахиулах эрхээ хадгалж үлдэх үү? Эдгээр нь бас хариулт хүлээсэн асуудлууд юм.

Зургаа дахь асуулт: Гэрээ нь хууль тогтоомжийг тодорхойлох уу, эсхүл гэрээ нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд хийгдэх үү?

Дөнгөж нэг жил гаруйхны өмнө Улсын Их Хурал Ашигт малтмалын тухай болон Татварын багц хууль тогтоомжид өргөн хүрээтэй шинэчлэл хийж батлан мөрдөж байна. Энэхүү хууль тогтоомжууд хөрөнгө оруулалтын гэрээнд чухал боловч, цөөн тооны хувьсагч тусгахыг зөвшөөрсөн байдаг. Гэвч Айвенхоу майнз монгол инк компанитай Засгийн газраас байгуулах хөрөнгө оруулалтын гэрээ олон талаар эдгээр хууль тогтоомжийг зөрчиж, эсхүл өөрчлөх нөхцлийг бүрдүүлж байна. Үүний нэг жишээ бол Засгийн газар Айвенхоу майнз монгол инк компанитай байгуулах гэрээний төсөлд Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварыг авахгүй байхаар заасан юм. Өөр нэг тохиолдол нь аливаа стратегийн хөрөнгө оруулалтын эзэмшлийн 10 хувь нь дотоодын хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг байх хуулийн шинэлэг шаардлагыг энэхүү гэрээнд хэрэгсэхгүй байхаар тохиролцож байгаа явдал гэж ойлгож байна. Хуулийн энэ заалт нь зөвхөн монголчууд үндэсний баялагтаа хөрөнгө оруулж (хууль ёсны дагуу, шударга үнээр, нийтэд ил тод байдлаар) эзэмшихийг зөвшөөрөөд зогсохгүй хөрөнгийн биржийн дүрмийн дагуу тухайн биржид бүртгэлтэй компани өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлангаа нийтэд ил тод мэдээлэх нөхцлийг бүрдүүлж байгаа заалт юм. Хэрэв Улсын Их Хурал гэрээнд заасан хууль тогтоомж зөрчсөн заалтын дагуу хуулийг засч өөрчлөх шаардлагатай гэж үзэж байгаа бол өөрчлөх нь зүйн хэрэг, гэхдээ тодорхой хөрөнгө

оруулалтын гэрээтэй уялдуулан хуульд өөрчлөлт хийх нь зохисгүй юм.

Долоо дахь асуулт: Урт хугацаагаар байгуулах гэрээний хэрэгжих хугацаанд нөхцөл байдал өөрчлөгдөх нь гарцаагүй, тэгвэл юу болох вэ?

Оюу толгой бол томоохон хөрөнгө оруулалт бөгөөд уг гэрээ хэдэн арван жил ч үргэлжилж болно. Тэгвэл Монгол Улс өөрийн хууль тогтоомжийг нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх боломжийг энэ гэрээ

олгож байна уу? Хэрвээ эдийн засгийн байдал муугаар эргэвэл Айвенхоу майнз монгол инк компани Засгийн газрын үүдийг сахиж татварын хөнгөлөлт үзүүлэхийг хүсэх нь мэдээж юм. Харин зэсийн үнэ 2, эсхүл 3 ам доллар хэвээр байх нөхцөл үргэлжлэх юм бол юу болох вэ? Энэ нь Айвенхоу майнз монгол инк компанийн хувьд гэнэтийн их олз ашиг болно. Үүнээс нь Монгол Улс хуваалцах уу? Хөрөнгө оруулагчдад баталгаа хэрэгтэй, тэглээ гээд хөрөнгө оруулалтын гэрээ нь тухайн улс орны хувьд хүлээс болох ёсгүй.

Хэсэг I. Уул уурхайн орлогын бодлогын асуудлууд

Бүлэг 1. Уул уурхайн гэрээнд орох татвар, төлбөр

Ашигт малтмалын гэрээ, хэлэлцээрийн санхүүгийн бүтцийг авч үзвэл гурван нийтлэг элемент агуулдаг байна: а) нөөц ашигласны төлбөр; б) аж ахуйн нэгжийн орлого буюу ашгийн татвар; в) хэт өндөр ашгийн татвар / нөөц ашигласны «супер» төлбөр (манай улсын зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар) зэрэг болно. Санхүүгийн бусад элементэд үл хөдлөх хөрөнгийн болон нэмэгдсэн өртгийн татварууд буюу тэдгээрийн чөлөөлөлтүүд, ажилтнууд ба бусад холбогдох асуудлаарх татварын онцгой хандлагууд орно. Гэрээний санхүүгийн үндсэн бүтэц болсон эдгээр асуудлын заримыг дор тусгайлан авч үзэж байна.

Нөөц ашигласны төлбөр

Нөөц ашигласны төлбөрийн зорилго бол нөөц баялгийг олборлох эрхийн төлөө авч байгаа төлбөр буюу нөөц баялгийг олборлосны нөхөн төлбөр байдаг. Жишээлбэл, эрдэс баялгийг өмчлөх эрх нь хувийн салбарт байдаг АНУ шиг орнуудад ашигт малтмал олборлогч нь тухайн нөөц баялгийн эзэнтэй харилцан тохиролцож нөөц ашигласны төлбөр төлөх юм. Мөн энэ нөхөн төлбөр нь ихэвчлэн эцсийн бүтээгдэхүүний үнийн дүнгийн тодорхой хэсэгтэй уялдсан бүтээгдэхүүний төлбөр байдаг. Монгол Улсад бусад дийлэнх орнуудын адил эрдэс баялгийг төр өмчлөх эрхтэй, гэлээ ч нөөц ашигласны төлбөрийн эдийн засгийн чиг үүрэг энд мөн адил байна. Нөөц ашигласны төлбөр бол ямар нэг татвар биш, харин ажил хөдөлмөрийн төлөө цалин хөлс авдаг шиг үйлдвэрлэлийн үнэт зүйл болох байгалийн нөөц баялгаар хангасныхаа хариуд авч буй төлбөр юм.

Түүхээс үзэхэд, нөөц ашигласны төлбөр нь нэг бол бүтээгдэхүүний нэг нэгжид инфляцийг тооцон ногдуулсан тогтмол төлбөр, эсхүл уурхайгаас гарах үеийн

үнийн тогтмол хувь байдаг. Уурхай дээрх үнийг /mine-mouth/ ерөнхийдөө цэвэр ашиг тооцох журмаар тооцоолдог бөгөөд богино хугацааны ашгийг тооцоолон гаргахын тулд үйл ажиллагааны тодорхой зардлуудыг хасч тохируулах замаар тооцдог. Геологийн болон зардлын хүчин зүйлсийг харгалзан үзвэл нөөц ашигласны төлбөр нь уурхай бүрд харилцан адилгүй байна. Сүүлийн жилүүдэд нийт олборлолт, чанар болон бусад хүчин зүйлсийг харгалзсан томъёогоор нөөц ашигласны төлбөрийг тохируулан тооцдог болоод байна.

Ашигт малтмалын нөөц ашигласний төлбөрийн хувь хэмжээ бусад улс оронд ямар байгаа болон түүнийг тооцох аргыг судалж хавсаргав (Хавсралт 1-г үзнэ үү). Нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээний хувьд нөөц баялгийн нэр төрлийн сууриас хамаарч 1-12 хувийн хооронд хэлбэлзэж байна. Олон оронд энэхүү хувь хэмжээ нь хувьсах хэлбэртэй байна. Энэ хувьсах хувь хэмжээ нь тодорхой орд газруудын чанар, өртгийн давуу талуудыг тусгасан явдал юм. Өөрөөр хэлбэл, өндөр чанартай нөөцтэй томоохон орд газарт харьцангуй өндөр түвшний нөөц

ашигласны төлбөр тогтоож, харин хүдрийн чанар доогуур, жижиг уурхайд бага түвшний нөөц ашигласны төлбөр ногдуулж байна. Ийнхүү уян хатан хандах нь улс өндөр үнэ цэнэтэй орд газраас ашиг шим хүртэхийн хажуугаар жижиг хэдий ч эдийн засгийн хувьд үр ашигтай орд газруудыг ч ашиглах боломжийг олгож байна.

Орлогын буюу ашгийн татвар

Нийтээр мөрдөгддөг аж ахуйн нэгжийн орлого буюу ашгийн татварт уул уурхайн компаниуд хамрагдах ёстой байдаг. Энэ хүрээнд хийх төлбөрийг хөрөнгө оруулалтын өгөөжид ногдуулж байгаа татвар гэж ойлгодог. Онолын хувьд уул уурхайн үйл ажиллагаанд бусад аль ч төрлийн капиталын хөрөнгө оруулалттай адилхан хандах ёстой. Өөрөөр хэлбэл, ашгийн татварт уул уурхайн үйл ажиллагааг илүүд үзэх, эсхүл ялгаварлан гадуурхах асуудал байх ёсгүй. Энэ зорилтыг хангахын тулд салбарын чанартай зарим заалтууд зайлшгүй шаардлагатай байж болох юм. Жишээлбэл, хайгуул, хөгжлийн гэх мэт үйлдвэрлэлийн өмнөх шатны зардлуудад зориулсан тодорхой дүрмүүдтэй байх зайлшгүй шаардлагатай. Мөн уул уурхайн зориулалттай тоног төхөөрөмжүүдийн хөрөнгө оруулалтад зориулсан салбарын онцлогтой элэгдэл хорогдол тооцох дүрэм шаардлагатай байж болох юм.

Шилжүүлгийн үнийг тооцох дүрэм гэх мэт ашгийн татварын хуулийн зарим ерөнхий заалт, зохицуулалтууд ч уул уурхайн салбарт онцгой ач холбогдолтой байж болно. Жишээлбэл, ашигт малтмалын олборлолтын үнийн дүнг тодорхойлоход цэвэр ашгийн үнийн /боловсруулсан бүтээгдэхүүний зарагдах үнээс бүх боловсруулах, тээвэрлэх зардлыг хасан тооцсон үнэ цэнэ/ арга шаардлагатай байж болно. Ер нь улс орнууд олон улсын тогтсон үнийг суурь үнэлгээ болгон ашиглаад (тухайлбал, Лондонгийн

Металлын биржийн дундаж үнийг жишиг үнэ болгон ашиглаж болох юм), дараа нь олон улсын хилээр гаргах бүтээгдэхүүний цэвэр ашгийн үнийг тооцоолон гаргахдаа тээвэрлэлт, боловсруулалт, цэвэршүүлэлтийн зардлуудыг хасдаг. Эдгээр тооцоог тодорхой болгох шаардлагатайн зэрэгцээ хараат бус аудит хийгдсэн байх ёстой. Орцод зориулсан шилжүүлгийн үнийн дүрмүүд, түүний дотор технологи ашигласны төлөөх нөөцийн төлбөрийг бүх салбаруудад зориулан тодорхойлж, боловсруулсан байх ёстой. Ашигт малтмалын хөрөнгө оруулалтыг үндэстэн дамнасан томоохон нэгдмэл компаниуд хамтарч хийх хандлагатай байдаг учраас уул уурхайн салбарт ийм зохицуулалтууд чухал байдаг. Түүнчлэн, орлогыг татварын хууль тогтоомжоос гадуур ашиг орлогоо харилцан хамаарал бүхий этгээдэд шилжүүлэх, өр зээлийн сүлжээ үүсгэн ашиглах боломжтой учраас капиталжуулалтын түвшин тодорхой хязгаартай буюу бага байх дүрэм зайлшгүй шаардлагатай болно.

Монголд хэрэглэж буй хэмжээний татварын суутгалыг ашгийн татварын тогтолцооны нэг хэсэг болгон авч үзэх шаардлагатай. Ийм суутгал татварыг аж ахуйн нэгжүүдээс хуваарилж байгаа орлогууд, түүний дотор нөөц ашигласны төлбөр, ногдол ашиг, салбарын ашиг, үйлчилгээний хураамж, хүү болон бусад төлбөрт ногдуулан хэрэглэж болох бөгөөд ингэх ч ёстой гэж үзэж байна.¹ Татварын суутгал бол татварын тогтолцооны салшгүй чухал хэсэг байх ёстой бөгөөд ашигт малтмалын гэрээнд үүнээс чөлөөлөх ёсгүй.

Эцэст нь, тусгаарлалтын /ring-fencing/ дүрэм шаардлагатай байж болно. Тусгаарлалтын дүрэм нь ашгийн татварын хуулийн нэг хэсэг байж ч болно, үгүй ч байж болно. Гэхдээ хуулийн нэг хэсэг биш тохиолдолд ч тусгаарлалтыг хэрхэн тодорхойлж, хэрэгжүүлэхэд зориулсан ашгийн татварын (болон нэмэгдэл ашгийн

¹ Татварын суутгалыг бүх хуваарилсан ашиг орлогоод ногдуулах, эсхүл зөвхөн гадаадын иргэдэд хуваарилсан ашиг орлогоод ногдуулан хийх эсэх нь татварын бодлогын ерөнхий асуудал.

татварын) дүрэм журам байдаг. Ийм дүрэм нь уул уурхайн орлогыг бусад орлогоос, тухайлбал үйлдвэрлэлийн өмнөх үйл ажиллагаа, уул уурхайтай холбогдолгүй үйл ажиллагааны (санхүүгийн, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн, эсхүл ерөнхий үйлдвэрлэл, түгээлтийн гэх мэт) орлогоос ялган тусгаарлахад хэрэглэдэг. Ашигт малтмалын гэрээ хэлэлцээр (буюу энэ удаад тогтвортой байдлын гэрээ)-т орсон аж ахуйн нэгжүүд татварын ерөнхий хуулинд хамаарах бусад үйл ажиллагаа явуулж болох учраас ийм тусгаарлалт хийх зайлшгүй шаардлагатай. Тусгаарлалтын хоёр дахь онцлог бол бизнесийн төрөл бүрийн ашиг сонирхолоо татварын зорилгоор нэгтгэх явдлыг хязгаарлах боломжийг Засгийн газарт олгож болох юм. Жишээлбэл, хоёр буюу түүнээс дээш уурхай ажиллуулж байгаа хөрөнгө оруулагчид нэг уурхайнхаа алдагдлыг (тухайлбал, хайгуулын зардлыг) нөгөө олборлох ажиллагааныхаа ашгаар нөхөх боломжийг хязгаарлаж өгөх юм. Мөн ашигт малтмалын гэрээ бүрт зориулсан тусгай хуулийн этгээд байгуулахыг шаардах (улмаар гэрээ бүрээр тусгаарлах), эсхүл гэрээний тодорхой нэг үйл ажиллагаанд зориулсан санхүүгийн хязгаарлалт тогтоох байдлаар тусгаарлалт хийж болно.

Хэт өндөр ашгийн татвар буюу Нөөц ашигласны «супер» төлбөр

Уул уурхайн үйл ажиллагаанаас нөөцийн төлбөр ба ашгийн татвар хоёрын дараахь нилээд их хэмжээний орлого олж болно. Нэн ялангуяа газрын тос, шатахуунтай холбоотой² байдаг хэт өндөр ашгийн татвар ч бас уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой. Эдгээр татварууд нь нөөцийн түрээсийн татвар, олз ашгийн татвар, илүүдэл ашгийн татвар, эрсдэл хуваалтын төлбөр гэх мэт янз бүрийн нэртэй байдаг. Харин ийм татварын хувьд нийтлэг олон шинж байдгийн дотор:

- Суурь үнэлгээг бэлэн мөнгөний урсгалтай харьцуулж хэмждэг (ашгийн татварын хуульд шаарддаг шиг аккруэл бүртгэлд тулгуурлахгүйгээр);
- Хөрөнгө оруулалтын өгөөжийн тогтоосон хувь (тэг ч байж болно) гэж байдаг. Энэ хувь нь ашигт ажиллагаа буюу үнээс хамаарч янз бүр байж болно;
- Хөрөнгө оруулагчид татвар ногдуулахын өмнө бүх холбогдох зардлаа нөхөж авахыг зөвшөөрдөг;
- Тусгаарлалт хэрэглэдэг (татварыг тодорхой ашигт малтмалын ордод ногдуулдаг).

Эдгээрдөрвөн элемент нь бэлэн мөнгөний урсгалд тулгуурласан татвар (буюу өнөөгийн цэвэр үнэ цэнийн ямар нэгэн хэмжүүр)-ын нэг хэсэг юм. Гэхдээ ашгийн татварын бусад боломжит хувилбарууд ч байдаг. Жишээлбэл, зарим орнууд (тухайлбал, Доминикан, Орос зэрэг улсууд) үнэ ба зардлын итгэлцүүрийн хослолд тулгуурласан янз бүрийн хувьтай нэгжийн үнүүдийг ашиглаж байна. Үнэ өсөх тусам татварын хувь шатлан өсдөг, улмаар тухайн улс ашигт малтмалын үнийн эрсдлийг хуваалцах хувиа өөрчилдөг байж болох юм. Гэхдээ нийт үйлдвэрлэлийн зардал буюу бусад ил харагдах зардлын өсөлтийн итгэлцүүр ашиглан дээрх хувиудыг багасгаж болно. Энэхүү бүтэц нь хэт өндөр ашгийн татварыг аль болох бүрэн авахын зэрэгцээ захиргааны зардлуудыг бууруулах зорилгоор хийгдсэн байдаг. Ийм учраас авилгал, захиргааны чадавхийн тухай асуудал ихэд санаа зовоож байгаа Орос гэх мэт улсуудад эдгээр бүтцийг хэрэглэж байна.

Хэт өндөр ашгийн татвар тогтвортой байдлын гэрээний нэг хэсэг байх ёстой, түүнийг бусад татвар, хураамж (ялангуяа нөөц ашигласны төлбөр)-ийн хэмжээтэй зөв харьцаатай тогтоох ёстой. Түүнчлэн захиргааны буюу зохион байгуулалтын асуудлуудыг харгалзан үзэх шаардлагатай.

² Үнэн хэрэгтээ нөөцийн түрээсийн татвар нэртэй анхны илүүдэл ашгийн татварыг Папау Шинэ Гвиней дэх зэсийн орд газарт хэрэглэжээ.

Бусад татвар

Аливаа хөрөнгө оруулагч дараахь хоёр онцгой тохиолдлоос бусад бүх нийтээр мөрдөгдөж буй татварт хамрагдах ёстой.

Нэгдүгээрт, нэмэгдсэн өртгийн албан татвар (цаашид НӨАТ гэх)-аас чөлөөлөх асуудлыг авч үзэж болох юм. Бүгд биш юмаа гэхэд нилээд бүтээгдэхүүн экспортлогдох болно. Иймээс ихэнх тохиолдолд НӨАТ нөхөн төлөгдөх шаардлагатай болно. Экспортын нөхөн төлбөрийн систем нь аливаа НӨАТ-ын тогтолцооны нэг хэсэг байх ёстой, гэхдээ нөхөн төлбөрийн хэмжээ, ялангуяа хөрөнгө оруулалтын эхний шатны нөхөн төлбөр, уг систем нарийн түвэгтэй бөгөөд өртөг зардал ихтэй болохыг харуулж байж болно. Энэ тохиолдолд хэрвээ дотоодын үйлдвэрлэлийн хамгаалалт байхгүйгээс дотоодын үйлдвэрлэлээс нийлүүлсэн бүтээгдэхүүнүүд импортын бүтээгдэхүүнээс илүү өрсөлдөх чадвартай гэж үзэх боломжтой, мөн болзошгүй, магадгүй санамсаргүй гаргасан зөрчлүүдийг хянах аргатай бол татвараас чөлөөлөх арга хэрэглэх нь зүйтэй байж болох юм. Болзошгүй зөрчлүүдийн тоонд аж ахуйн нэгжүүд эцсийн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн (жишээлбэл, автомашин), эсхүл уул уурхайн бус үйл ажиллагаанд ашиглах бараа, бүтээгдэхүүнийг татвараас чөлөөлсөн байдлаар худалдан авах, эсхүл бүтээгдэхүүнээ дотоодын зах зээлд татвараас чөлөөлсөн байдлаар борлуулах явдал орно.

Хоёрдугаарт, ашигт малтмалын бусад гэрээнд өрсөлдөөний шалтгаанаар импортын татвараас чөлөөлөх явдал байдаг. Дээр дурдсанчлан, уул уурхайн ихэнх бүтээгдэхүүн экспортлогддог учраас импортлосон бараа, түүхий эдэд татвар ногдуулах нь экспортын өрсөлдөх чадварыг бууруулдаг. Өртөг зардлын энэхүү сул талыг багасгах буюу арилгахын тулд татварын хойшлуулах систем болон бусад чөлөөлөлтүүдийг ашиглаж байна. Уул уурхайн үйл ажиллагааны хэмжээ,

цар хүрээ талаасаа ч авч үзсэн энэ асуудлыг шийдэхэд чөлөөлөлтийн арга нь бусдаасаа дээр байж болох юм. Мөн л Монголд хамгийн сайн тохирох аргыг олж тогтоохын тулд захиргааны шинжтэй үндэслэл болон дагаж мөрдөх сонирхол хоёрын зохистой харьцааг сайтар барих зайлшгүй шаардлагатай.³

Уул уурхайн санхүүгийн дэглэмийн харьцуулалт

Уул уурхайн салбарын санхүүгийн дэглэмийн талаархи зарим харьцуулсан судалгааг Хавсралт 2-т танилцуулж байна. Энд танилцуулсан татвар, төлбөрийн тогтолцоог төрийн хувь эзэмшин оролцох оролцооны талаархи мэдээлэлтэй нэгтгэн үзвэл зохино. Уг хавсралтад ийнхүү олон хэрэгслийг оруулж өгсөнөөр төрийн хувь нийлүүлэх оролцоог тухайн улсын төсвийн ерөнхий дэглэмийн хүрээнд авч үзэх боломж олгох ач холбогдолтой юм. Тухайлбал, Мексик, Австрали зэрэг улсад хэт өндөр ашгийн өндөр татвартай ч төр хувь нийлүүлэх хэлбэрээр оролцдоггүй байна. Гана Улсад төр 10 хувийг үнэгүй эзэмшдэг ч гэнэтийн ашгийн татвар үгүй. Папуа Шинэ Гвиней-д гэнэтийн ашгийн татвар (нөөцийн рентийн татвар) ч, хувь эзэмших оролцоо ч байдаг байна.

Төсвийн бусад нөхцөл өөрчлөгдөхөд нөөц ашигласны төлбөр хэрхэн өөрчлөгдөж байгааг анзаарах хэрэгтэй. Тухайлбал, Папуа Шинэ Гвиней-д нөөц ашигласны төлбөр нь хувь эзэмших оролцоо, гэнэтийн ашгийн татвар аль аль нь байхгүй, тухайлбал Чили зэрэг бусад улс орныхтой харьцуулахад бага хувь хэмжээтэй байна. АНУ-ын Холбооны Засгийн газар далай тэнгист олборлох газрын тосны 16 2/3 хувийг нөөц ашигласны төлбөрт авдаг ч хувь эзэмших, эсхүл гэнэтийн өндөр ашгийн татвар авах хэлбэрээр оролцдоггүй байна.

Хавсралтад байгаа мэдээллийг зөвхөн хоёрдагч эх үүсвэрүүдээс түүн цуглуулсан

³ Сүүлийн үеийн зарим гэрээнд импортын татварыг хэвээр үлдээсэн байна. Жишээлбэл, Афганистанд санал болгосон гэрээнд импортын татвараас чөлөөлөх заалт байхгүй. Эдгээр татварыг захиргааны болон орлогын шалтгаанаар хэвээр үлдээжээ.

билээ. Тиймээс зарим зүйлийг орхигдуулсан, эсхүл илүү дэлгэрэнгүй танилцуулаагүй байгаа (тухайлбал, нөөц ашигласны төлбөрийг тооцох суурь, ашгийн татварыг хэрхэн тооцдог г.м.). Гэхдээ улс орнуудад төсөв санхүүгийн нөхцөл янз бүр байдаг ба

төрийн хувь эзэмших оролцоог (мөн төсвийн бусад хэрэгслүүдийг) төсвийн ерөнхий дэглэмийн хүрээнд авч үзэх шаардлагатайг уг хүснэгт хангалттай хэмжээнд харуулж өгч байна.

Бүлэг 2. Монгол Улсын зарим хуулийн төсөлд уул уурхайн татвар, төлбөрийн талаар өгсөн санал зөвлөмж

Монгол Улсын татварын багц хуулийг 2006 онд шинэчлэн найруулсан ба эдгээр хуулийн төслүүдэд тусгагдсан уул уурхайн татвар, орлогын чиглэлээр хийсэн шинжилгээг дор танилцуулж байна. Энэхүү дүн шинжилгээг Нээлттэй Нийгэм Форумас Улсын Их Хурлын ажлын хэсэгт 2005 оны 9 дүгээр сард уламжилсан санал, зөвлөмжид үндэслэсэн болно.

Хуулийн төслүүдийн тухай санал шүүмжлэл⁴. Хүн амын орлогын албан татварын, Нэмэгдсэн өртгийн албан татварын, Ажахуйн нэгжийн орлогын албан татварын, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын, Онцгой албан татварын таван багц хуулийн төслийг хэлэлцэж байна. Эдгээр татварын хуулийн төслүүд богинохон товч боловч татвар бүрийн онцлог чанарыг (хувь хэмжээ, тооцох суурийн ерөнхий тодорхойлолт, чөлөөлөлт, татвар төлөгчдийн ерөнхий тодорхойлолт) харуулсан байна. Уг хуулийн төслүүд товч байгаа нь нөгөө талаас олон зүйлийг санамсаргүйгээр, эсхүл зориуд орхигдуулсан гэсэн утга агуулж байна. Түүнчлэн, маш цөөн тооны захиргааны зохицуулалтын байр суурийг (тухайлбал, татвар төлөгчөөр бүртгүүлээгүй тохиолдолд оногдуулах шийтгэлийн талаар) оруулсан байна. Иймээс, зохицуулах, тайлбарлах, шүүхийн шийдвэр гаргах их зүйл үлдээд байна. Тухайн бодлогуудын онцлог элементүүдийг агуулсан багц хууль гаргаж, ил тод зохицуулалтын үйл явцыг бүрдүүлж, уг үйл явцаар тодорхой бодит баримт, нөхцөл байдлуудыг авч үзмээр

байна. Хуулийн төслүүд аль ч стандартаар бодсон хэт ерөнхий байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын татварын хуулийн төсөл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн төсөлд уул уурхайд тухайлан хамааруулсан хэд хэдэн заалтууд байна: Дээрх заалтуудын талаархи санал шүүмжлэл гэвэл:

- Хуулийн төслийн 2.2-т дотоодын аж ахуйн нэгжийн татварыг ашигт малтмалын гэрээгээр зохицуулна гэжээ. Хуулийн төслийн энэ хэсгийг хасах хэрэгтэй. Дотоодын татварын хуулийн дээр зөвхөн олон улсын хууль л үйлчлэх ёстой. Хэрвээ уул уурхайн үйлдвэрлэлийн татвар аливаа гэрээний нэг хэсэг болон орох юм бол ил тод байдал алдагдах бөгөөд татварын хуулиуд дотоодын өөр бусад хуулиудад захирагдахад хүрэх аюултай.
- Хязгаарлагдмал тооны биет бус хөрөнгийн элэгдэл хорогдлыг тооцох журмыг хуулийн 13 дугаар зүйлд заажээ; 13 дугаар зүйлд өөрчлөлт оруулах шаардлагатай.⁵ Уул уурхайн тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдлыг зөвшөөрсөн боловч биет бус

⁴ Тухайн үед үйлчилж буй хуулиудтай эдгээр хуулийн төслүүд илүү сайжирсан эсэх талаар харьцуулсан санал шүүмжлэл гаргаагүй болно. Харин бусад орны туршлагатай харьцуулан санал шүүмжлэл гаргалаа.

⁵ Эдгээр санал болгосон өөрчлөлтийг батлагдсан хуулийн 13.1, 13.5, 13.6-р заалтуудад тодорхой хэмжээгээр оруулсан байгаа. Мөн Улсын Их Хурлаар 2006 онд баталсан Ашигт малтмалын тухай хуулийн 61 дүгээр зүйлд уул уурхайн үйлдвэрлэлийн санхүү, бүртгэлийн онцлог гэсэн зүйл нэмж, биет болон биет бус зардлыг бүртгэх, тооцох, элэгдэл хорогдлын шимтгэлийн сан байгуулах зэрэг 7 хэсэг орсон.

хөрөнгийн элэгдлийг түрээслэгчид болон тогтоосон гүйлгээнүүдээр хязгаарласан байна. Хайгуул, үйлдвэр барих шатанд гардаг үйлдвэрлэлийн өмнөх томоохон биет бус зардлын тухай огт дурдаагүй байна. Заримдаа ийм зардал нийт хөрөнгө оруулалтын зардлын 75 хувиас хэтрэх явдал байдаг. Энэ байдлаас дүгнэхэд одоогийн хуулийн төслөөр эдгээр биет бус хөрөнгийг зарлагадах юм байна. Хууль тогтоогчид ийм санаа агуулсан эсэх нь тодорхойгүй байна. (Энэ талын бодлого муу байна гэж үзэхээр байна. Гэхдээ үйлдвэрлэлийн өмнөх зардалд яаж хандахаа тодорхой болгох явдал нь биет бус хөрөнгийг ашгийн татварын зорилгоор зарлагадах, эсхүл капиталжуулах эсэхээс үл хамааран зайлшгүй хийгдэх ёстой.)

- Хуулийн төслийн 12.1.34-т нөхөн сэргээлтийн зардалтай холбогдох тайлбарыг Ашигт малтмалын тухай хуультай холбосон байна.⁶ Нөхөн сэргээлтийн зардлын талаар Ашигт малтмалын тухай хуульд хандах үндэслэлтэй ч орлогын татварын хуульд өөрт нь тодорхой үг хэллэг оруулах шаардлагатай. Ингэж татварын хуулийг өөрийн гэсэн агуулгатай болгож, татварын бодлогоор бусад агентлаг, сонирхогч талуудыг барих боломжтой болгохгүй бол Ашигт малтмалын хууль өөрчлөгдөх болгонд орлогын татварын хууль өөрчлөгдөхөд хүрнэ. Тухайн хуулиас дээгүүр зохицуулалт байхгүйн хэрээр аж ахуйн нэгжийн орлогын татварын бараг бүхий л талууд уул уурхайн компаниудад үйлчилж байдаг.

Хуулийн төслийн зарим нэг онцгой заалтуудыг тодруулан авч үзэх нь зүйтэй байна. Тухайлбал:

- Хуулийн төслийн 3.2 дугаар хэсэгт заасан аж ахуй эрхлэх хэлбэрээсээ хамаарч хамтарсан үйлдвэр, эсхүл нөхөрлөлүүд аж ахуйн нэгжийн орлогын албан татварт хамрагдах эсэх нь тодорхойгүй байна;
- Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд зөвхөн шууд өмчлөлийн шалгуураар холбогдох талуудыг тодорхойлж байна (Ийм учраас уул уурхайн компаниуд бусад төслүүдэд шууд бус сонирхолтой байж, төсөлд заасан холбогдох талын тухайн журамд захирагдахгүй байж болохоор байна.);⁷
- Хуулийн төслийн 10 дугаар зүйлд шилжүүлгийн үнийн дүрмүүд, түүний дотор хэзээ, хэрхэн шилжүүлгийн үнийн дүрэм хэрэглэх тухай асуудал бүрхэг, дур зоргоор хэрэглэх юм шиг харагдаж байна;
- Хуулийн төслийн 17 дугаар зүйлд уул уурхайн салбар бол 5 хувийн хөрөнгө оруулалтын хөнгөлөлт эдлэх эрхтэй онцгой салбар мөн эсэх нь тодорхойгүй байна;⁸
- Хуулийн төсөлд аж ахуйн нэгжийг шинэчлэн зохион байгуулах, эсхүл татан буулгах журам байхгүй байна. Иймээс ямар нэг уул уурхайн компани дахин зохион байгуулагдах буюу бусадтай нэгдэх тохиолдолд татварыг хэрхэн зохицуулах нь тодорхойгүй байна;
- «Хүү», «ногдол ашиг», «тохируулсан суурь» зэрэг чухал нэр томъёо болон бусад нэр томъёонуудад тодорхой тайлбар байхгүй байна;

⁶ Энэ зөвлөмжийг хууль батлахад анхаарч найруулга хийсэн ч Ашигт малтмалын тухай хуулийн заалтыг ишэлсэн хэвээр байгаа.

⁷ Батлагдсан хуульд хуулийн үйлчлэх хүрээ гэсэн хэсгийг гурав болгон дэлгэрүүлж оруулсан байна. Хуулийн хамрах хүрээний тухай энэ ойлголтыг хуулийн 5 дугаар бүлэгт албан татвар төлөгч гэдгээр 5 хэсэг, 8 заалт болгож, 6 дугаар бүлэгт харилцан хамаарал бүхий эдгээд гэж 1 хэсэг, 3 заалт болгон дэлгэрүүлж оруулсан нь ойлгомжтой болсон байна.

⁸ Батлагдсан хуулинд татварын 10 хувийн хөнгөлөлтөд хамрагдах тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар гаргахаар заасан ба одоогоор уул уурхайн салбар энэ жагсаалтад хамрагдаагүй байгаа.

- Элэгдэл хорогдолыг тооцоход ашиглалтад орсон гэсэн дүрэм ашиглаж байгаа боловч ашиглалтад орсон гэдгийг тайлбарласан тодорхойлолт байхгүй байна;
- Хөрөнгийн үнийн дүнгийн 30 хувиас хэтэрсэн зээлийн хүүгийн төлбөртэй (өр төлбөр ба хөрөнгийн харьцаа 3/10) байхыг зөвшөөрөхгүй гэсэн капиталжуулалтын явцуу дүрэм үйлчилж байна. Хөрөнгийн тооцох суурь ба хэмжээг тодорхойлоогүй байна (Суурь нь нэг бол журналын дэвтрийн бүртгэлийн, эсхүл татварын хэмжээ байж болох юм);
- Нягтлан бодох бүртгэлийн акруэл зарчимд тулгуурласан мэт боловч тодорхой заагаагүй;
- Татан буугдах, дахин байгуулах, эсхүл нэгдэх тухай дүрэм байхгүй;
- Аж ахуйн нэгж, байгууллагын тухай тодорхойлолт нилээд бүрхэг, улмаар жирийн нөхөрлөл, хамтарсан үйлдвэрүүд гэх мэт зохион байгуулалтын хэлбэрүүд татвар төлөгч мөн эсэх нь тодорхойгүй;
- Олон улсын татварын үзэл баримтлалуудад хандсан тайлбар бага байна (байнгын байгууллага гэх мэт);
- Найдваргүй өр төлбөрийн нөөц, хасалт гэх мэт нягтлан бодох бүртгэлийн ойлголтуудыг дурдсан боловч нөөц гэж юу болохыг огт тодорхойлоогүй;
- Уул уурхайд зориулсан ганц хоёр заалтаас өөр салбарын онцлогтой заалтууд байхгүй байна. Банк, санхүүгийн байгууллагууд, харилцаа холбоо, тээвэр, арилжааны хөдөө аж ахуй, бусад салбаруудад зориулсан дүрмүүд байх шаардлагатай;
- Хоршоодод ногдуулах татварын тухай огт дурдсангүй;
- Ашгийн төлөө бус байгууллагыг татвараас чөлөөлсөн боловч хоорондоо холбогдолгүй аж ахуйн орлогын тухай тодорхой дүрэм байхгүй, ашгийн төлөө бус ба ашгийн төлөө байгууллагуудын харилцаа холбооны тухай дүрэм байхгүй байна;
- Шилжүүлгийн үнийн тухай ерөнхий дүрэм байхгүй;
- Хоорондоо холбоотой талуудын тухай дүрмийг хялбархан буруугаар ашиглаж болохоор байна;⁹
- Нягтлан бодох бүртгэлийн заалтууд нь оруулах ба хасах зүйлсийн жагсаалт болох хандлагатай байна. Татвар ногдох орлого гэдэг бол бүх эх үүсвэрээс олж байгаа болон бүх үндэслэл бүхий хасалтуудыг хийж болох, татвараас чөлөөлөхөөр зааснаас бусад бүх төрлийн орлогыг хэлнэ гэсэн ерөнхий нэг тодорхойлолт байх шаардлагатай;
- Эхэнд гарсан алдагдлыг дараа орлогоос нөхөх талаар ямар нэг заалт олж харсангүй.
Эдгээр санал шүүмжлэл нь илүү тодорхойлж өгөх шаардлагатай заалтуудын дөнгөж нэгээхэн хэсгийг харуулж байна. Гадаад валютын гүйлгээ, дэвтрүүдийн байрлал, нягтлан бодох бүртгэлд хэрэглэх валют, татан буулгалтын зардлууд зэрэг бусад асуудлыг мөн энд авч үзэх шаардлагатай.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн төсөл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн төсөлд уул уурхайн үйлдвэрлэлийг онцлон заасан хоёр заалт байна. 9.2.9 дүгээр заалтад газрын тос олборлох тоног төхөөрөмж импортлоход (буюу худалдан авахад) нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө гэжээ. 9.2.15 дугаар заалтад алтны борлуулалтыг (борлуулагч, худалдан авагч, санаа зорилгоос

⁹ Батлагдсан хуулийн Харилцан хамаарал бүхий этгээдийн хооронд хийгдсэн бараа борлуулалт, ажил, үйлчилгээний албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох 11 дүгээр зүйлд орлого тодорхойлохдоо ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын зах зээлийн үнийг жишиг болгон хэрэглэхээр зааж, жишиг үнэ хэрэглэх аргачлалыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан байна.

үл хамааран) уг татвараас чөлөөлж байна.¹⁰

Уул уурхайн ажиллагаанд шууд нөлөө үзүүлж болох бусад заалтуудад:

- Нэгтгэсэн тайлагналыг зөвшөөрөх (Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн дагуу татвар төлөгч, түүнтэй холбоотой талууд нэмэгдсэн өртгийн албан татварын бүхий л үйл ажиллагаандаа нэгдсэн нэг тайлан гаргах боломжтой байж болзошгүй байна);
- Импортлосон үйлчилгээнд хариу татвар ногдуулах (5.3.9-р заалтыг үзнэ үү);
- Татварыг тэглэсэн импортууд;
- Хийн түлш (жижиглэн худалдааны гэж ойлгож байна) болон хийн түлшээр ажилладаг тодорхой тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх (9.2.13-р заалтыг үзнэ үү).

Дээрх заалтын талаархи санал шүүмжлэл: Уул уурхайг (зөвхөн анхан шатны боловсруулалт) хоёр шалтгаанаар нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх явдал нийтлэг байдаг. Нэгдүгээрт, ихэнх бүтээгдэхүүнийг голдуу экспортолж, ихэнх капиталын барааг (болон олон тооны үйлчилгээг) импортлодог. Иймээс тухайн Засгийн газар төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг 100 хувь буцааж төлөх шаардлагатай болно. Хоёрдугаарт, нэмэгдсэн өртгийн албан татвар нь дараагийн шатны боловсруулалт, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, дотоодод хийгдэж байгаа борлуулалтын хэмжээг нэгтгэн тооцоход хүргэх ба ингэж ч тооцох ёстой. Дараагийн шатны боловсруулагчид нэмэгдсэн өртгийн

албан татвар цуглуулж авах боловч энэхүү татварын буцаан олголтыг авахгүй учраас анхан шатны уул уурхайн үйлдвэрлэлийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх нь онолын хувьд үр дүнгүй юм. Иймээс нэмэгдсэн өртгийн албан татварыг дотоодын хэрэглээнээс бүрэн төлөх ёстой.

Тухайн нэг улсад татвараас чөлөөлөх, эсхүл буцаан олгох явдал илүү үр нөлөөтэй байх эсэх нь захиргааны зохицуулалтын асуудлуудаас хамаардаг. Түүнчлэн, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд (эсхүл гэрээгээр дамжуулан) уул уурхайд зориулсан чөлөөлөлт оруулах эсэх нь ил тод байдлын асуудал байдаг. Зөвхөн анхан шатны олборлох үйл ажиллагаа болон түүнтэй шууд холбоотой татвар ногдох бараа, түүхий эдээр чөлөөлөлтийг хязгаарлах байдлаар төсөл боловсруулахад анхаарах шаардлагатай.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн төсөлд *Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төсөлтэй* төстэй асуудлууд гарч байна. Хуулийн төсөлд олон улсын стандарт нийлүүлэлтийн үед тооцох дүрмийг оруулсан боловч бусад чухал зүйлсийг нэг бол орхигдуулсан, эсхүл тодорхой заагаагүй байна.

- Эх үүсвэрийн дүрмийн утга тодорхойгүй;
- Байнгын тогтолцоонууд нь татвар төлөгчид мөн эсэх нь тодорхойгүй;
- Нэгтгэсэн тайланг ашиглаж байгаа нь Монголоос бусад улсад ховор байдаг. Нэгтгэсэн тайлан ашиглах үндэслэл байж болох авч энэ аргыг практик дээр хэрхэн ашиглах тухай зарим талаар бодож үзэх хэрэгтэй;

¹⁰ Улсын Их хурал 2006 оны 6 дугаар сарын 29-ны өдөр баталсан *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд төсөлд байгаагүй Хуулийн үйлчлэх хүрээ гэсэн 3 дугаар зүйл нэмж оруулсан байна. Мөн хуулийн 6.5-д «Энэ хуулийн 6.4-т заасан орлого болон хөрөнгө оруулалт нь сүүлийн нэг жилд тухайн иргэн, хуулийн этгээдийн орлого, татвар тодорхойлох хуудас болон орлогын албан татварын тайлангаар нотлогдсон байхаас гадна уг этгээд нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын стандартын дагуу хөтөлж хэвшсэн байвал зохино.» гэж, 6.6-д «Сайн дураараа нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэх тухай өргөдөл гаргах болон гэрчилгээ олгоход энэ хуулийн 6.1 (борлуулалтын орлогын хэмжээ нь 10 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн) болон 6.2 (нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэж, тухайн этгээдэд татварын алба гэрчилгээ олгосон)-т заасан хугацаа нэгэн адил хамаарна.» гэж заасан нь мөн хуулийн Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа, ажил үйлчилгээ гэсэн 7 дугаар зүйл, энэхүү хуулийн бусад зүйл, хэсэг, заалттай нөхцөлдөн дотоодын хэрэглээнээс нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх нөхцлийг бүрдүүлж байна.*

- Холимог борлуулалтын тухай ямар нэг дүрэм байсныг санахгүй байна;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын нэхэмжлэхийн загварыг дурдсан боловч тодорхой сайн зааж өгөөгүй байна;
- Нэр томъёонуудыг сайн тодорхойлж тайлбарлаагүй байна (тухайлбал үнийн дүн гэдгийг).

Эдгээр нь мөн тодруулан авч үзэх ёстой зүйлсийн нэг л жишээ юм.

Хүн амын орлогын албан татварын хуулийн төслийн тухайд хэд хэдэн асуудал гарч байна:

- Татвар төлөгч гэдэг бол нэг биет хүн (хамтарч тайлагнахыг зөвшөөрөхгүй) мэт харагдаж байгаа боловч тодорхой бус байна. Хэрвээ татвар төлөгч нэг биет хүн юм бол орлогыг хувааж зарцуулах асуудлыг хөндөж авч үзэх шаардлагатай;
- Мэргэжлийн орлого, аж ахуйн бус байгууллагаас олсон орлого, үүний адил бусад орлогод хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу татвар ногдуулж байна. Орлогыг тооцох дүрэм нь тодорхой бус байна. Дэлхийн хэмжээгээр олсон цэвэр ашгийн татварын санаа гарсан боловч тодорхой заасангүй. Түүнчлэн, хуримтлагдсан цэвэр орлогын ойлголтыг ашиглах нь бага (буюу дунд) хэмжээний аж ахуйн бус орлогод татвар ногдуулах шилдэг арга мөн эсэх нь тодорхойгүй. Гэвч, жижиг бизнесийн татвар гэж байхгүй, мөн жижиг бизнест зориулсан нягтлан бодох бүртгэлийн тодорхой дүрэм журам алга байна;
- Өөр өөр төрлийн орлогод өөр өөр хувийн татвар ногдуулахаар байна (ногдол ашиг ба цалингийн орлогод өөр өөр хувийн татвар ногдуулж байна);
- Суутгал хийх нь дотоодын иргэдийн хувьд эцсийн татвар эсэх, эсхүл эцсийн нэгдсэн тохируулга хийхэд зориулсан урьдчилсан төлбөр эсэх нь тодорхойгүй байна.

Онцгой албан татварын хуулийн

төслийн тухайд харьцангуй үндэслэлтэй хэлбэрээр хийгджээ. Гэвч зарим нэг дутагдалтай, тодорхойгүй зүйлс байна:

- Согтууруулах ундаа үйлдвэрлэгчид онцгой албан татвар төлөх нь тодорхой байна. Гэвч бензин, шатахууны болон бусад онцгой албан татварыг хаана (бөөний худалдаа, борлуулагч, эсхүл жижиглэн худалдааны түвшинд) төлөх нь тодорхойгүй байна.
- Бага хүрээнд ашиглах явдлыг бууруулах заалт байхгүй байна (тухайлбал, бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглаж байгаа согтууруулах бодис).
- Инфляцийн түвшинд автоматаар тохируулдаг тохируулга алга байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хуулийн төслийн тухайд өнөөгийн нөхцөл байдалтай холбоотой хоёр санал шүүмжлэл байна.

- Энэ татварыг татвар төлөгчид биш, эд хөрөнгөд ногдуулах ёстой. Иймээс татвар ногдуулахын тулд тухайн өмч хөрөнгийг хэн эзэмшиж байгааг мэдэх (тэр хүнийг бүртгэж авах) шаардлагагүй;
- Ямар нэг үнэлгээний арга заагаагүй, газрын үнэ цэнийг түүн дээр байгаа байгууламжийн үнээс салгаж тооцох боломжтой эсэх нь тодорхойгүй байна.

Захиргааны тухайд эдгээр хуулийн алинд ч оногдуулах шийтгэл, хүү, эсхүл дагаж мөрдөх үйл ажиллагааны талаар цөөхөн заалт орсон байна. Татвар хураах, маргааныг шийдвэрлэх аргууд байхгүй байна. Магадгүй эдгээр нь татварын ерөнхий хуулинд тусгалаа олсон байх.

Нөөц ашигласны төлбөр. Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд нөөц ашигласны төлбөр алтнаас бусад бүх ашигт малтмалын хувьд 5 хувь, алтны хувьд 7.5 хувь байхаар заасан байна. 5 хувийн нөөц ашигласны төлбөр нь боломжийн, гэхдээ суурийг хэрхэн тооцохоос хамааран зөвшөөрөгдөх хэмжээний дээд хэсэгт байна гэж бид үзэж байгаа. Нөөц ашигласны төлбөрийг

тооцох зохицуулалтыг нийтлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн заалт хуулийн төсөлд орсон байна. Нөөц ашигласны төлбөрийн суурийн талаар парламентын түвшинд хэлэлцэж, ил тод аргачлалыг боловсруулан гаргах шаардлагатай юм. Нээлттэй Нийгэм Форумын зүгээс нөөц ашигласны төлбөр олон улсын түвшинд нийтлэгддэг үнийн (Лондоны металлын бирж, эсхүл өөр нийтээр мэддэг үнэ) тодорхой хувь хэмжээн дээр суурилсан аргачлалыг авч үзэхийг зөвлөмж болгосон байгаа. Ингэвэл нөөц ашигласны төлбөрийг олборлолтын (эсхүл боловсруулсан бүтээгдэхүүний) нэгжид ногдох тогтмол төлбөр хэлбэрээр ногдуулах боломжтой.¹¹ Мөн захиргааны зардал буурахаас гадна ил тод байдал нэмэгдэх болно. Хуулийн төсөлд орлогыг хуваарилах талаар, тухайлбал нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг холбогдох орон нутагт хуримтлуулах талаар дурьдсан байгаа нь ажиглагдаж байна. Ийнхүү хуваарилах нь оновчтой эсэх талаар дүгнэлт хийх үндэс бидэнд байхгүй ч эрдэс баялгийг ашигласнаас орон нутгийн иргэд үр шимийг хүртэх (мөн магадгүй хөрөнгийн захиран зарцуулалтыг шийдвэрлэхэд оролцох) орлогын ямар нэгэн төрлийн хуваарилалтыг дэмжиж байна.¹²

Дүгнэлт. Бидний дүгнэлтээр эдгээр хуулийн төсөлд өргөн хүрээтэй татварын багц хууль боловсруулахад чиглэсэн хүрээ орсон боловч доторх агуулгыг нь илүү их тодорхой болгох шаардлагатай байна гэж үзэж байна. Эдгээр агуулгыг ил тод зохицуулалтын үйл явцаар оруулж болох боловч зарим нарийвчилсан зүйлсийг хуулинд зааж өгөх шаардлагатай (тухайлбал, шинэчлэн

байгуулагдагсдад татвар ногдуулах, найдваргүй өрийн нөөц, нэмэгдсэн өртгийн албан татварын дагуух холимог борлуулалт болон бусад олон зүйлс). Түүнчлэн бодлогын олон асуудлуудыг авч хэлэлцэх шаардлагатай (бөгөөд тодорхой бодлогуудыг хөндөж гаргаж тавьсангүй), түүний дотор нэмэгдсэн өртгийн албан татварын олон шатлалт хувь, чөлөөлөлтүүд, өөр төрлийн орлогод өөр суутгалын хувь тооцох, гадаадын эд зүйлсэд хандах хандлага, хилийн гүйлгээ, холбогдох талын дүрмүүд, жижиг бизнесийн татвар, компанийн нэгдэл болон бусад бодлогууд орно. Иймээс, Засгийн газрын зүгээс уг хуулийн төслүүдэд засвар өөрчлөлт хийхийн өмнө тодорхой бодлогын хүрээ бий болгох асуудлыг авч үзэх шаардлагатай. Яваандаа бодлогын хүрээнд үл хамааран тодорхой техникийн шинжтэй, нарийн ширийн зүйлүүд дээр ажиллах явдлыг хууль боловсруулагчид авч үзэх биз (тухайлбал, эх үүсвэрийн дүрэм, холбогдох талуудын дүрэм, хүлээн зөвшөөрөгдөх шилжүүлгийн үнийн дүрэм, мөн хүү, ашгийн төлөө бус, ногдол ашиг, тохируулсан суурь зэрэг бусад нэр томъёоны тодорхойлолтууд). Захиргааны өөрчлөлтийг дагаж хувьсан хөгжиж болох ерөнхий хууль боловсруулахдаа захиргааны заалтууд ба захиргааны чадавхид анхаарлаа хандуулах шаардлагатай.

Одоогийн энэ ашгийн татварын хуулийн төслийнашигт малтмалын хөрөнгө оруулалтын гэрээнд үзүүлэх нөлөө тодорхойгүй байна. Хэрвээ тухайн гэрээний тухай заалт уг хэрэгжүүлж буй хуулиасаа дээгүүр үйлчилж байвал энэ төсөл ямар нэг нөлөө үзүүлэхгүй. Засгийн газар дор хаяж л нягтлан бодох

¹¹ Ашигт малтмалын тухай батлагдсан хуулийн 47.3-т, мөн хуулийн 47.7-д нөөц ашигласны төлбөрийг тооцох суурь үнийн талаар зөвлөмжтэй нийцэхүйц заалтуудыг оруулжээ. Мөн биржийн нэр зарлах тухай Засгийн газрын 2007 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 88 дугаар тогтоолоор экспортын 4 бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог Лондонгийн металлын бирж, зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох Монгол банкны болон зах зээлийн эх сурвалжийн нэрийг тогтоож, нийтэд зарласан байна.

¹² Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хуваарилах (хуулийн 58.2), хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хуваарилах (хуулийн 59.2)-аар оруулж хуульд заасны дагуу дээрх 2 төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журмыг Засгийн газрын 2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 272 дугаар тогтоолоор батлан мөрдөж байна.

бүртгэлийн болон уул уурхайн салбарт хяналт шинжилгээ хийх багц асуудлуудыг боловсруулах шаардлагатай гэж үзэж байна. Шинжилгээ хийгдэх явцад гэрээний болон татварын бодлогын асуудлууд тодорхой болж ирнэ. Тухайлбал, биет бус хөрөнгөд хандах хандлага, хамтарсан үйлдвэрүүдэд хандах хандлага зэрэг асуудлууд, мөн хүү, холбогдох талуудын хоорондын наймааны үнийн дүн зэрэг нэр томъёоны тодорхойлолтыг авч үзэх ёстой. Ингэх нь хоёр талын ашиг тустай. Нэгдүгээрт, гэрээний болон уул уурхайн татварын илүү сайн шинжилгээ хийх боломжийг олгох хүрээг тодорхойлно. Энэхүү хүрээг гэрээний нөхцөлд заалт оруулахын эсрэгээр татварын ерөнхий хуулиудад ямар заалтууд орох шаардлагатайг тогтооход ашиглаж болно. Хоёрдугаарт, уг хүрээ нь татварын хуулиудын ерөнхий хүрээг болон бүх салбаруудад нийтлэг байдаг асуудлуудыг шалгаж тогтоох нэг үндэслэл болно.

Эцэст нь, стратегийн хувьд тогтвортой байдлын гэрээний загварыг боловсруулж, гэрээнд аж ахуйн нэгжийн татварын заалтуудыг тусгаж өгөх нь зохистой байж болзошгүй. Татварын шинэтгэлийг тогтвортой байдлын гэрээг эцэслэн шийдвэрлэтэл хойшлуулж болох юм. Ингэх нь хоёр давуу

талтай байж болзошгүй. Нэгт, тогтвортой байдлын гэрээний үр ашигтай байдлыг хангахын тулд аж ахуйн нэгжийн татварын бараг бүх асуудлыг боловсруулсан байх шаардлагатай. Үүнд аж ахуйн нэгжийн мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дүрэм, заалтууд тогтвортой байдлын гэрээнд тусгаснаар орлогын татварын оновчтой хуулийг боловсруулах суурь болж өгнө. Хоёрт, өнөөгийн орлогын татварын заалтууд болон татварын шинэчлэлийг хэзээ хийхээс үл хамааран тогтвортой байдлын гэрээ хэлэлцээрийг хийх боломжтой. Уул уурхайн салбар Монгол Улсад ихээхэн ач холбогдолтой байж болзошгүйг харгалзан үзвэл энэ салбарын хувьд зохистой татварын дүрэм, журмыг боловсруулах нь зайлшгүй чухал. Эдгээр дүрэм, журам нь татварын шинэчлэлийн ерөнхий оролдлогод эргээд тустай байх боломжтой. Энэхүү хандлагын эрсдэл нь гэрээн дэх татварын дүрмүүдийг тааруухан боловсруулж, хуулин дахь дүрэм, журамтай харьцуулахад хэлэлцэж тохирсон татварын дүрмүүд илүү ил тод бус байх боломжтой. Энэхүү эрсдэлийг багасгахын тулд татварын дүрэм, журмыг олон нийтийн хараа хяналтад байлгаж¹³, Засгийн газар гэрээ хэлэлцээрт сайтар бэлтгэх явдал юм.

¹³ Татварын заалтуудыг нийтэд ил байлгасан ч гэрээний тодорхой асуудлуудыг нууц байлгах боломжтой.

Бүлэг 3. Нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг өөрчлөх санал

Ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэхэд олон нийтийн үзэл бодлыг сонсох зорилгоор 2006 оны 2-р сарын 6-ны өдөр УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос нээлттэй сонсгол зохион байгуулсан ба үүнд Нээлттэй Нийгэм Форумгаас танилцуулсан саналыг энэ бүлэгт толилуулж байна.

Байнгын хорооны дарга, гишүүдээ,

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан өөрсдийн саналыг танилцуулах боломж олгож байгаад Нээлттэй Нийгэм Форум талархаж байна. Ашигт малтмалын баялаг нөөцөө ашиглах нь манай улсын эдийн засгийн хөгжлийн тулгуур үндэс болох боломжтой. Алт, зэс, нүүрс, бусад ашигт малтмалаас олох орлогыг боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц дэх тулгамдсан хэрэгцээг хангах, ядуурлыг бууруулах зэрэгт зарцуулах бололцоотой. Гэхдээ ингэхийн тулд Монгол улс нөөц баялгаа хамгийн боломжийн үнэд хүргэн зах зээлд гаргах нь юу юунаас чухал гэдэгтэй та бүхэн санал нийлнэ биз. Газар доорх эрдэс баялгийг сан хөмрөг дэх мөнгө болгон хувиргаж, ингэснээр уг сан хөмрөгөө нийт хүн ардынхаа тусын тулд ухаалаг зарцуулах шаардлагатай билээ.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад анхаарах ёстой чухал асуудал бол ашигт малтмалаас авах нөөц ашигласны төлбөр (буюу роялти, цаашид роялти гэж хэрэглэх болно) ба лицензийн төлбөрийг оновчтой хэмжээ, хэлбэрээр тогтоох явдал юм. Бид роялтигийн талаар олон улсад ямар туршлага байдаг талаар зарим судалгаа хийсэн ба үүнтэй холбоотой хэд хэдэн үндсэн зарчмуудыг байнгын хороо анхааралдаа авахыг хүсэж байна.

Нөөц ашигласны төлбөр (роялти) ба төсвийн харилцаа

Роялти бол татвар биш гэдгийг ойлгох нь чухал. Энэ нь харин эзэнтэй нөөц баялгийг олборлон, ашиглах эрхийн төлөө төлж буй төлбөр юм. Эзэн нь мэдээж хувь хүн, эсвэл Монгол Улсын Засгийн газар ч байж болно. Роялти нь засгийн газрын хувьд хамгийн тодорхой, найдвартай орлогын эх үүсвэр ба үнэндээ уурхай ашиглалтын эхний жилүүдэд харьцангуй бага хэмжээтэй лицензийн төлбөрийг эс тооцвол засгийн газрын хувьд орлогын цорын ганц эх үүсвэр болж болзошгүй. Түүнчлэн засгийн газар илүү өндөр үнэ цэнэтэй ашигт малтмал, баялгаасаа шударга хувь хэмжээг хүртэх үүднээс роялтигийн хэмжээг зохицуулан өөрчлөх бололцоо илүү байдаг.

Роялтийг орлогын татвартай зэрэгцүүлэн ялгаатай талаас нь харьцуулж үзэж болох юм. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, эсвэл бэлтгэл ажил болон бусад зардал гарснаар эхэн үед «алдагдал» хүлээх тул уг алдагдлыг дараа үед олох орлогогоос хасах хэлбэрээр шилжүүлэн тооцдог (loss carry forward) зэргээс шалтгаалан уурхай ашиглалтын эхний жилүүдэд орлогын татвар хураах боломжгүй байна. Түүнчлэн татвар хураалтын тогтолцоо сул, дүрэм журам бүрэн төгс боловсруулагдаагүй, гадаадын аж ахуйн нэгжүүдээс татвар авах болдог зэргээс шалтгаалан уул уурхайн компаниудаас

орлогын татварыг үр дүнтэй хураахад хүндрэлтэй байж болно. Энд хэд хэдэн техникийн асуудлыг авч үзэж, шийдвэрлэж, хянах шаардлагатай. Үүнд орц, гарцыг үнэлэх, хоорондоо холбоотой нэгжүүдийн хоорондын шилжүүлгийг үнэлэх, өр зээлийн бүтцийн үр нөлөөг тооцох, мөн төрөл бүрийн гадаад валютыг тооцох ханш зэрэг асуудлууд орно. Эцсийн дүнд эдгээр нь орлогын татварын хэлбэрээр орж ирэх бодит орлогыг ихээхэн хэмжээгээр бууруулж болзошгүй. Ямар ч тохиолдолд орлоготой холбоотойгоор төлбөр авах нь төвөгтэй болж ирдэг ба ашиглалтын үед ил тод байдлыг хангах боломж байхгүй тохиолдолд авилгал үүсэх аюултай. Бид бүгдийн мэдэх Бороо Голдын жишээ ийнхүү орлогын татвар авах боломжгүй болох нэгэн жишээ билээ.

Роялти нь уурхайн ашиглалтын эхний жилүүдэд Монгол улсад орж ирэх цорын ганц мэдэгдэхүйц хэмжээний орлого тул түүнийг зөв хэмжээ, хэлбэрээр тогтоох нь нэн чухал. Хувь хэмжээг нь хэт доогуур тогтоовол засгийн газар болон ард иргэд өмчилж буй баялгаа алдахад хүрэх бол хэт өндөр тогтоовол нөөц баялгийг огт ашиглахгүйд ч хүргэх боломжтой.

Өрсөлдөх чадвартай байх талаарх ташаарал

Олон тооны уул уурхайн экспертүүд уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хайж байгаа бусад улс оронтой өрсөлдөхүйц хэмжээнд Монгол улс роялтийгээ бүрдүүлэх ёстой ба роялтигийн хувь хэмжээ хэт өндөр бол хөрөнгө оруулалт бусад улс руу чиглэх болно гэж зөвлөж ирсэн. Мэдээж, роялтигийн түвшин хэт өндөр бол хөрөнгө оруулалт өөр тийш чиглэх болно. Гэхдээ хэт өндөр гэж чухам ямар түвшинг хэлэх вэ? Газарт байгаа алт, зэс нь газартай төстэй. Үр шимтэй, өндөр үнэ цэнэтэй газар эзэмшиж байгаа бол энгийн нэгэн газартай харьцуулахад хэд дахин өндөр үнээр зарна гэж болно. Үүний адилаар өндөр түвшний роялтийг тогтоосон хэрнээ хөрөнгө оруулалтыг татаж чадах эсэх нь Монгол

Улсад байгаа нөөц баялгийн чанартай шууд холбоотой. Бидэнд дэлхийн түвшний зэс, алт, бусад нөөц баялаг байгаа ба бид асар том зах зээлийн хажууд байрлаж байна. Тиймээс бид нөөц баялгаа хэт хямд зарах учиргүй ба баялгаа бусад газрын «дундаж» үнээр үнэлэх ёсгүй.

Роялти нь нөөц баялгийн үнэ цэнийг тусгах ёстой гэсэн энэхүү зарчмыг бусад орны туршлагаас харж болно. Бид төрөл бүрийн улс орон дахь роялтигийн хувь хэмжээг цуглуулан энэхүү илтгэлийн хавсралтад (Хавсралт 1) үзүүлэв. Хүснэгтээс харахад хувь хэмжээ, уг хувь хэмжээг бодох суурь үнэлгээ нь улс орон бүрт харилцан адилгүй байна. Хувь хэмжээний хувьд төрөл бүрийн сууриас бодоход 12%-иас 1%-н хооронд хэлбэлзэж байна. Гэхдээ 2.5% нь медиан дунджаас доогуур байгаа нь тодорхой. Олон улс оронд (тухайлбал Австрали, Зимбабве зэрэг улс) хувь хэмжээ нь хувьсах хэлбэртэй байгааг анхаарах хэрэгтэй. Энэ хувьсах хувь хэмжээ нь тодорхой орд газруудын чанар, өртгийн давуу талуудыг тусгасан явдал юм. Өөрөөр хэлбэл, өндөр чанартай нөөцтэй томоохон орд газарт харьцангуй өндөр түвшний роялти тогтоож, харин хүдрийн чанар доогуур, жижиг уурхайд бага түвшний роялти ногдуулж болох юм. Ийнхүү уян хатан хандах нь улс орон өндөр үнэ цэнэтэй орд газраас ашиг шим хүртэхийн хажуугаар жижиг хэдий ч эдийн засгийн хувьд үр ашигтай орд газруудыг ч ашиглах боломжийг олгож байдаг. Эцэст нь роялтийг тооцох суурь үнэлгээ янз бүр байгааг тэмдэглэх хэрэгтэй. Зарим улсад, тухайлбал ОХУ-д олон улсын үнийг суурь болгон авч байхад бусад улс оронд зардлыг хассан ашгийг тусгасан үнэ, эсвэл цэвэршүүлэх шатны ашгийн үнийг (тухайлбал Аргентин улс) тооцож ашиглахыг оролддог. Бусад улс орны туршлагын «дундаж» туршлагыг авч ашиглах нь цаана нь иймэрхүү ялгаатай зүйлс байгааг далдлахаас гадна манай улсын нөөц баялгийн чанарыг тооцож үзэхгүй байгаа явдал юм.

Роялтигийн бүтэц

Монголд өнөөдөр хэрэглэж байгаа роялти нь үнээс хувь тооцох хэлбэртэй байгаа. Энэ нь нэг шатлалтай буюу 2.5% ба энэ хувь хэмжээг ашигт малтмалын борлуулалтын тооцсон үнээр үржүүлж төлөх ёстой роялтигийн хэмжээг тодорхойлдог. Роялтигийн хураалтыг илүү тодорхой болгох, мөн төрөл бүрийн орд газруудын үнэ цэнэ ялгавартай байдгийг тооцох үүднээс УИХ роялтигийн бүтцийг өөрчлөх талаар хэд хэдэн боломжийг авч үзэх ёстой болов уу. Юуны өмнө тодорхой нэг түвшний роялтийг тогтоохын оронд ашиглаж буй тодорхой орд газрын чанар, байдлыг харгалзан үзэж хувь хэмжээг тодорхой заагтай тогтоох боломжтой. Өндөр чанартай хүдэр бүхий томоохон ордуудад өндөр түвшинд, доогуур чанартай, эсвэл ашиглалтын өртөг өндөр ордод доогуур түвшинд тогтоож болох юм. Орон нутгийн уул уурхайн болон татварын албан тушаалтнуудад хэт их эрх мэдэл олгохгүйн үүднээс ямар хэмжээтэй роялти тухайн орд газар хамааралтай байх журмыг нэг бол хуульд оруулж өгөх, эсвэл объектив дүрэм журам боловсруулах эрхийг холбогдох яаманд олгох хэрэгтэй.

Хоёрдугаарт, УИХ роялтийг үнэлгээний хувиар бус нэгж бүтээгдэхүүнд үндэслэн тооцох боломжийг авч үзэх хэрэгтэй. Өнөөгийн хууль тогтоомжоор ашигт малтмалын «борлуулалтын үнэ»-ийг холбогдох албад тодорхойлох ба энэ нь лиценз эзэмшигч, үнэ тогтоогч хоёрын хооронд ноцтой зөрчилд хүргэх боломжтой. Борлуулалтыг бие биентэйгээ холбоотой аж ахуйн нэгжүүд хоорондоо хийх боломжтой ба энэ тохиолдолд үнийг доогуур тогтоох сонирхол үүснэ. Хоорондоо хамааралгүй аж ахуйн нэгжүүдийн хувьд ч авилгал, гар цайлгах, бусад хэлбэрээр далд урамшуулал олгох зэрэг явдал гарах боломжтой. Түүнчлэн лиценз эзэмшигч олж буй орлогоо тодорхойлохдоо нягтлан бодох бүртгэлийн аргуудыг ашиглан дотоод зардлаа хасч тооцох боломж байдаг. Шударгаар орлогоо

тодорхойлох тохиолдолд ч лиценз эзэмшигч, татварын албадын хооронд санал үл нийлэх байдал үүсэх боломжтой учир татварын албадад ихээхэн эрх мэдэл олгож байгаа явдал юм. Ийм тохиолдолд авилгалд өртөх боломж, сонирхол байгаа нь ойлгомжтой.

Ийм байдлаас сэргийлэх нэгэн боломж бол ОХУ-д газрын тосонд тогтоосон шиг бүтээгдэхүүний нэгжид ногдуулдаг роялтийг ашиглах явдал юм. Энд тооцох шаардлагатай ганц зүйл бол металын агууламжаар үнэлэх бүтээгдэхүүний хэмжээ юм. Энэ үед зарим нэгэн бэрхшээл гарч болох ч тооцоход илүү хялбар ба бодитой үнэлэх боломж илүү байх юм. Бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийг тооцохын тулд ихээхэн ил тод, бодитой үнийг үзүүлдэг Лондонгийн металлын бирж зэрэг олон улсын зах зээлийн үнийн өөрчлөлтийг харгалзан үзэж суурь нэгжид ногдох хувь хэмжээг өөрчлөн тогтоох боломжтой. Нэгжид ногдох роялтийг татвар тооцох үеийн үнийг суурь үнэлгээний үнэд харьцуулсан хувиар үржүүлж тооцох боломжтой. Жишээлбэл, зэсийн Лондонгийн металлын бирж дээрх үнэ нэг фунт нь 1 доллар байхад суурь хувь хэмжээг фунт нь 5.00 доллар байхаар тогтоож болох юм. Татвар тооцох үед Лондонгийн металлын биржийн үнэ 2.0 доллар болвол фунтэд ногдох нөөцийн төлбөрийг 10.00 доллар гэж тооцох боломжтой ($5.00 \times (2.00/1.00)$). Индекс суурилсан үнийг зах зээл тогтоодог ба бүгдэд ил тод тул борлуулалтын үнийг тооцох захиргааны хүндрэлүүдийг арилгахын сацуу бүтээгдэхүүний үнэ өсөх, буурахад роялтигийн хэмжээ ч даган өсч буурах болно. ОХУ ийм индекс суурилсан нэгжид ногдуулах роялтийг газрын тосны хувьд ашиглаж байна. ОХУ-д роялтийг тооцдог томъёог хавсралтаар үзүүлэв.

Дүгнэлт

УИХ-аас роялтийн хэмжээг оновчтой өөрчлөн тогтоох нь манай улсын ирээдүйн хөгжлийг хангах эдийн засгийн хамгийн чухал асуудлын нэг мөн. Монгол хүнээс гадна бидний хамгийн том хөрөнгө бол баягалийн

баялаг ба роялтигийн хэмжээ, бүтэц нь уг баялгийн үнэ цэнэтэй дүйцсэн байх нь чухал. Өнөөгийн роялтигийн хэмжээ хэт доогуур түвшинд байгаа гэж үзэж байгаа тул уг хэмжээг өөрчилж, ингэхдээ бусад улс орны роялтигийн хэмжээний талаарх мэдээлэл,

мөн баялгийн үнэ цэнийг тооцох аргуудын талаар анхааран үзэхийг хүсч байна.

Энэхүү нээлттэй сонголыг зохион байгуулж байгаад байнгын хороонд талархал илэрхийлэхийн ялдамд оролцох боломж олдсонд баяртай байгаагаа илэрхийлье.

Бүлэг 4. Оюу Толгойн ашиглалтын цогцолбор төлөвлөгөө

Айвенхоу майнз компанийн гаргасан «Орд ашиглалтын цогцолбор төлөвлөгөө» болон хавсралт «Стоксын тайлан»-д Нээлттэй Нийгэм Форумын хийсэн шинжилгээ

Айвенхоу майнз компанийн гаргасан «Орд ашиглалтын цогцолбор төлөвлөгөө» болон хавсралт «Стоксын тайлан»-д Нээлттэй Нийгэм Форум 2006 оны 1 дүгээр сард хийсэн шинжилгээг үндэслэн гаргасан үзэл бодлыг энэ бүлэгт авч үзэв. Эцэст нь ашигт малтмалын гэрээний заалтуудыг хэрхэн өөрчилснөөс гарах боломжит үр нөлөөг үзүүлэх тооцооны загварыг 2005 оны 12 дугаар сард боловсруулсныг оруулав.

Айвенхоу майнз компанийн гаргасан «Орд ашиглалтын цогцолбор төлөвлөгөө» болон хавсралт «Стоксын тайлан»-д Монгол Улс болон Монголын ард түмэнд асар их үр өгөөж амлажээ. Гэвч энэ төлөвлөгөө, тайлан нь хамгийн чухал асуудлуудад хариу өгөхгүй байгаагаас гадна олон тохиолдолд ташаа сэтгэгдэл төрүүлж болзошгүй байна. Айвенхоу майнзын Оюу толгойн ашиглалтын цогцолбор төлөвлөгөөг өнгөцхөн харахад ч татварын болон уул уурхайн хуучин мөрдөж байсан хууль тогтоомжийн хүрээнд уг төсөл улс оронд орлогын шударга хувь хэмжээг өгч чадахгүй, харин Айвенхоу майнз, түүний хөрөнгө оруулагчдад үлэмж их ашиг олох боломж олгож байгаа нь харагдаж байна. Оюу толгойн орд газрын нөөц нь Монгол Улсын хамгийн чухал хөрөнгийн нэг яалтгүй мөн. Айвенхоу майнзийн төлөвлөгөөнд дурдснаар энэхүү байгалийн нөөц баялагийн өнөөдрийн үнэ цэнэ янз бүрийн нөхцөл байдалд 4 тэрбум ам доллартай тэнцэж болзошгүй байна. Энэ нь Монгол Улсын 2004 оны дотоодын нийт бүтээгдэхүүнээс даруй хоёр дахин илүү дүн юм. Цаашилбал алт, зэс, бусад түүхий эдийн үнэ өнөөгийн өндөр түвшинд ойр байхад л дээрх үнэ цэнэ ихээхэн хэмжээгээр нэмэгдэх боломжтой.

Хэдий олон хуудастай ч дээр дурдсан төлөвлөгөө Стоксын тайланд тусгасан Монгол Улсын хөгжлийн болон олох орлогын талаархи амлалтууд нь тухайн уурхайн санхүүгийн гүйцэтгэл хийгээд түүний улс оронд үзүүлэх нөлөөллийн байж болох бодит хэмжээтэй тун тааруу уялджээ. Дэлхийн банкны судалснаар үүнтэй адил төстэй хэмжээ бүхий ийм төрлийн уул уурхайн бизнесээс гадаадын хөрөнгө оруулагчид гол төлөв 15-20 орчим хувийн ашиг хүртэх хүлээлттэй (IRR буюу төслийн дотоод өгөөжийн төвшин) байдаг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулсан доллар тутамд Айвенхоу майнз жилд 15-20 хувийн ашиг олно гэсэн үг. Дээрх төлөвлөгөөнөөс харахад Айвенхоу майнз нь дээд буюу 20 хувиас арай доогуур төвшний төслийн дотоод өгөөжтэй байх хүлээлттэй байгаа ажээ. Гэвч уг төлөвлөгөөний үндэс болсон эдийн засгийн загварын нөхцлүүдийг авч үзвэл уг 20 хувь нь Айвенхоу майнз-ийн хүлээгдэж буй бодит өгөөжөөс ихээхэн доогуур түвшинд байна.

Юуны өмнө, уг судалгаанд төслийг 100 хувь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх нөхцөлтэй байхаар авч үзжээ. Үнэндээ бол бодит амьдралд Оюу толгой шиг хэмжээний аливаа төслийг өөрийн болон өр зээлийн хөрөнгөөр хэсэгчлэн санхүүжүүлдэг.

Судалгаанд илтгэсэн мэдээллийн үндсэн дээр яг тодорхой тооцоо хийх боломжгүй ч уг уурхайг бодитой нөхцөл гэж үзэж болох 50 хувийн өр зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд Айвенхоу майнз-ийн хүлээгдэж буй өгөөж 30 хувь орчим буюу хэвийн түвшнээс хамаагүй илүү буюу судалгааны суурь хувилбарынхаас 50 хувиар өндөр байхаар байна.

Хоёрт, судалгааны суурь хувилбарт тооцоолсноор бол зэсийн үнэ нэг фунт нь 1 ам доллар ба алтны үнэ нэг унц нь 400 доллар байх нөхцөлтэй байна. Энэхүү загварын хувьд хүлээгдэж буй өгөөжийг тооцоход эдгээр үнийн нөхцлүүд нэн чухал үүрэгтэй. Жишээлбэл, Айвенхоу майнз-ийн загвар дахь үнийг 1990-ээд оны (өнөөдрийн өндөр төвшинд хүрэхээс өмнөх үе) дундаж үнээр буюу 1.24 ам доллараар өөрчлөн тооцвол Оюу толгойн өгөөжийн тооцоо ихээхэн нэмэгдэх болно. Айвенхоу майнз-ийн өөрийн тооцоогоор зэсийн үнэ 1.20 ам доллар болж өөрчлөгдвөл уурхайн үнэ цэнэ даруй 50 хувиар өсөхөөр байна. Цаашилбал алт, зэс өнөөгийн үнэтэйгээ буюу зэсийн фунт бүр 2.00 ам доллар ба алтны унц бүр 500 ам доллараас дээш байвал төслийн хугацаан дахь Айвенхоу майнз-ийн жил бүр хүртэх өгөөж гайхамшигтай өндөр байх болно.

Төслийн хэмжээнээс хамааран Засгийн газрын орлогын аливаа тооцоо ялангуяа өнөөдрийн орлоготой харьцуулахад харьцангуй өндөр мэт санагдаж болно. Гэхдээ шударга тэнцвэртэй байдал байгаа эсэхийг тодорхойлоход төлбөрийг хэдийд хийх, мөн Айвенхоу майнз-ийн олж байгаа ашгийн хэмжээг харгалзан үзэх ёстой. Гэтэл одоогийн байгаа хувилбараар бол Монголын Засгийн газар нөөц ашигласны төлбөр болон хөрөнгийн маш бага хэмжээтэй төлбөрийг эс тооцвол уг төслөөс арван жилийн хугацаанд ямар нэгэн орлого авахааргүй байна. Татвараас чөлөөлөх, хөнгөлөх, хөрөнгө оруулалтыг хасч тооцох зэргийн нийлбэр нь татварын орлогыг бараг арван жилийн хугацаанд хойшлуулах болно. Түүгээр үл

барам татвар ногдуулах орлоготой байлаа ч Айвенхоу майнз уг орлогыг нэмэлт хөрөнгө оруулалтын хэмжээгээр багасгаж, дараа нь элэгдэл хорогдлыг тооцох замаар уг хөрөнгө оруулалтаасаа хоёр дахь удаагаа хасалт хийх боломжийг Монголын өнөөгийн хууль тогтоомж олгож байна. Ийм л горим нөхцлийг Айвенхоу майнз компани Монголын Засгийн газартай байгуулах тогтвортой байдлын гэрээнд тусгахыг оролдож байгаа юм.

Монгол Улсад ногдох ашиг өгөөжийг мөн өөр арга хэлбэрээр ч ташаа мэдэгджээ. Засгийн газрын авах орлогын ихэнх хэсэг төслийн сүүлийн жилүүдэд хийгдэхээр заасан мөртлөө дээрх төлөвлөгөө болон Стоксын тайлангийн ихэнх харьцуулалтуудыг бууруулан тооцох үндсэн дээр хийгээгүй байгаа нь өнөөдөр Айвенхоу майнз өөртөө авч үлдэж байгаа нэг долларыг Монголын Засгийн газарт арван жилийн дараа төлөх нэг доллартай тэнцүүлж байгаа хэрэг билээ. Мөн Айвенхоу майнз-ийн хураангуй танилцуулгад ажиллагсдын төлөх татвар болон нийгмийн даатгалын төлбөрийг төслөөс гарч байгаа мэтээр үзүүлснээр Засгийн газар хүртэх ашиг өгөөжийг давхардуулан тооцжээ.

Стоксын тайланд тооцсоноор, Оюу толгойн Монголын нийт эдийн засагт үзүүлэх таамаглаж буй нөлөө нь мөн ташаа ойлголт төрүүлэхээр байна. Стоксын тайланд уг төслийн Монголд үзүүлэх үнэ цэнийг хэмжихэд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийг ашиглажээ. ДНБ нь Стоксын өөрийнх нь хүлээн зөвшөөрч байгаагаар Монгол дахь эдийн засгийн үйл ажиллагаанаас бий болгож буй орлогын хэмжүүр юм. Тэгвэл энэ нь Монголчуудад үлдэж буй зүйлийн хэмжүүр огт биш. Монголчууд бидний хүртэх үнэ цэнэ нь экспортлож буй зэс, алтны ашгийн манай Засгийн газарт татвар хэлбэрээр төлж буй хэсэг, эсхүл Монголын нийлүүлэгч болон ажиллах хүчинд төлж байгаа хэсэг л байх учиртай. Энэ нь нийт борлуулалтын үнийн багахан хэсэг л болж байгаа юм. Үлдсэн хэсэг нь хэдий ДНБ-д тооцогддог ч гадаад хүмүүст төлөгдөнө.

Айвенхоу майнз-ийн судалгаа болон сурталчилгаа нь санхүүгийн ашиг өгөөжийг ташаа үзүүлж байгаагаар үл барам Оюу толгойн ордын Монголын хөгжилд үзүүлэх үр ашгийг хэт дөвийлгөн харуулж байна. Жишээлбэл, өнөөгийн байдлаар байнгын дэд бүтцийн томоохон хэсэг нь Хятадад хамаагүй илүү ашигтай байхаар байна. Гол зам, төмөр зам, цахилгааны борлуулалт (Монголд үйлдвэрлэсэн байлаа ч) бүгд Хятад улсыг чиглэж байна. Харин нөгөө талд Монгол Улс нөөц, ус зэргийг хангах ба хог хаягдал, байгаль орчны доройтлын үр дагаврыг өөрөө үүрэхээр байгаа юм.

Хөдөлмөр эрхлэлтийн үр нөлөөг мөн хэтрүүлэн мэдэгджээ. Тайланд Оюу толгойн хөрөнгө оруулалтын ашиг өгөөжид уурхай дээрх бүх ажлын байр болон төслийн нийлүүлэгчдэд үүсэх нэмэлт ажлын байрыг жагсаан дурьджээ. Гэвч ингэж үзэх нь эдгээр уурхай дээрх ажлын байр болон нийлүүлэгч дээрнэмэлтээр үүсэх ажлын байранд ажиллах бүх хүмүүс уг уурхайг ажиллах хугацаанд ажилгүй, эсхүл ямар нэгэн бүтээмжгүй байна гэсэн төсөөлөл бөгөөд энэ нь зүгээр л үнэнд нийцэхгүй. Түүнчлэн Монголын эдийн засагт үзүүлэх давхар нөлөөг тооцоход ашигласан үржүүлэгчид нь дээрхийн адил ташаа төсөөллүүд дээр үндэслэсэн байна. Үүнд өмч хөрөнгийг дотоод болон гадаад өмчлөгчтэй байх, уурхай байгаагүй тохиолдолд экспортлогдох болон импортлогдох зүйлсийн талаар тооцоонд оруулаагүй байна.

Монгол Улс, түүний иргэдийн дээд ашиг сонирхлыг хамгаалахын тулд манай Засгийн газар байгалийн нөөц баялгийн хувьд хамгийн ашигтай байх гэрээ хийж чадаж байгаа эсэхээ хөндлөнгийн этгээдээр баталгаажуулах

шаардлагатай юм. Энэ чиглэлд Айвенхоу майнз нь Монголын Засгийн газар болон олон нийтэд ашиглалтын төлөвлөгөөний загвар болон өөрсдийн дотоод санхүүжилтийн загварын нарийн мэдээллийг ил болговол олон нийтэд тустай. Эдгээр загвар ил байх аваас Засгийн газар өөрийн экспертүүдийг ашиглан Оюу толгойн хувьд ашиглалтын шударга төлөвлөгөө болон татварын дэглэмийг боловсруулах бололцоотой болох юм. Улс орны ашигт малтмалын баялгийг ашиглах ийм төлөвлөгөө нь байгаль орчны доройтлоос ангид, Монгол Улсын хүний хөгжлийг дэмжсэн, Монгол орны байгалийн баялгийн үнэ цэнийг төр засаг, иргэд шударга хүртэх явдлыг хангасан байх ёстой.

Ирэх саруудад хийгдэх гэрээ хэлэлцээр нь Монгол Улсын 40 гаруй жил үргэлжилж болох дэглэмд халдаж болзошгүй тул улс орон хоёр үе дамжин хүлээн зөвшөөрөх шийдвэрийг Монголын Засгийн газар эдүүгээ гаргаж байгаа гэж хэлэхэд хэтрүүлэг болохгүй. Тиймээс энэ шийдвэр нь оновчтой мэргэн байх нь юу юунаас чухал билээ.

Энэ бүлгийг Нээлтэй Нийгэм Форум 2006 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр үзэл бодлоо олон нийтэд илэрхийлсэн билээ. Хөндлөнгийн шинжээч нар тогтвортой байдлын гэрээний заалтуудыг хэрхэн өөрчилснөөс гарах боломжит үр нөлөөг үзүүлэх тооцооны загварыг 2005 оны 12 дугаар сард боловсруулсан байна. Хавсралт 3-ыг үзнэ үү. Энэхүү загварыг ашиглан боловсруулсан гэрээний хувилбаруудыг үнэлэх боломжийг ашиглана уу. Энэхүү загвар нь Засгийн газар төдийгүй сонирхогч судлаач, иргэний нийгмийн байгууллага гээд хэн ч ашиглаж болох загвар болно.

Хэсэг II. Уул уурхайн үйлдвэрлэл дэх гэрээний дүн шинжилгээ

Бүлэг 5. Уул уурхайн гэрээний хэлбэр

Олборлох үйлдвэрлэлд хэрэглэгддэг янз бүрийн төрлийн гэрээнүүд тухай улсын Засгийн газар ба арилжааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн эрх, үүргүүдийг тодорхойлдог. Аливаа санхүүгийн гэрээ, түүний дотор ашигт малтмалтай холбоотой гэрээ нь тухайн хөрөнгө оруулалтын ашиг, эрсдлийг хэрхэн хуваалцах талаар хоёр буюу түүнээс олон талуудын хоорондын харилцан тохиролцох үйл явцын үр дүн байдаг.

Хөрөнгө оруулалтыг хүлээн авагч улсын Засгийн газар ба гэрээлэгч хоорондын ашигт малтмалын гэрээ хэлэлцээрүүд хэд хэдэн хэлбэртэй байж болохын дотор хөнгөлөлтийн (консессион) гэрээ буюу тогтвортой байдлын гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ (газрын тос, байгалийн хийн салбарт нийтлэг), ажлын гэрээ буюу техникийн үйлчилгээний гэрээ болон бусад хэлбэрүүд ордог. Тухайн гэрээ ямар нэртэй байхаас үл хамааран хэд хэдэн нийтлэг элементүүдтэй байдаг.

Хөнгөлөлтийн гэрээ

Хөнгөлөлтийн гэрээ нь ямар нэг компани (ихэвчлэн тэргүүлэх компани ба түүний хамтарсан үйлдвэрийн түншлэгч нарт)-д тодорхой газар нутгийг ашиглах тусгай зөвшөөрөл олгодог. Нөөц баялгийг (газрын тос, эсхүл зэс гэх мэт) ашиглах эрхийг тухайн арилжааны үйл ажиллагаа явуулагч хууль ёсоор эзэмшдэг. Хөнгөлөлт эдлэгч нь хайгуул, ашиглалт, үйлдвэрлэлийн бүх зардлаа өөрөө санхүүжүүлдэг. Засгийн газар голдуу нөөц ашигласны төлбөр, талбайн хэмжээний хураамж, хамтарсан үйлдвэрийн хувьд төлөх татвар, бонус болон нийгмийн татварууд авдаг. Уул уурхайн салбарт бол нөхөн төлбөрийн нөхцлүүд ба хэрэгжүүлэлтийн зохицуулалтуудыг уул

уурхайн хууль, журмуудад зааж өгсөн байж болно. Хэрэв Засгийн газар хамтарсан үйлдвэрийн түншлэгчээр оролцож байгаа бол өөрийн эзэмшиж буй хувьтай тэнцэх хувь хэмжээний бүтээгдэхүүн авдаг. Хөнгөлөлтийн гэрээг зарим тохиолдолд татвар/нөөц ашигласны төлбөрийг хослуулсан тогтолцоо ч гэж нэрлэдэг.

Бүтээгдэхүүн хуваах гэрээ

Бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьд засгийн газарт, эсхүл үндэсний газрын тосны компанид ногдох ашгийн тос шилжин очих мөч хүртэл газрын баялгийг эзэмших эрх хөрөнгө оруулагч компанид шилждэггүй. Хэдийгээр гол төлөв газрын тос, байгалийн хий ашиглахтай холбоотой байгуулагддаг ч зарчмын хувьд уул уурхайн салбарт ч хэрэглэх боломжтой юм. Бүтээгдэхүүн хуваах гэрээний тухай энэхүү гарын авлагын Бүлэг 15-д тодорхой авч үзэх болно.

Техникийн үйлчилгээний гэрээнүүд

Техникийн үйлчилгээний гэрээний дагуу бол тухайн нөөц баялаг Засгийн газрын хяналтанд байх бөгөөд хайгуулын ажил, барилгын ажил, ашиглалтын удирдлагын хэлбэрээр техникийн үйлчилгээ үзүүлэх

компанитай ийм гэрээ байгуулдаг. Үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүнийг Засгийн газар эзэмших бөгөөд тухайн компанид мөнгөн, эсхүл бараа, түүхий эд (газрын тос гэх мэт)-ийн хэлбэрээр төлбөр төлдөг.

Энэ төрлийн гэрээгээр олгох ажлын хөлсийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд бус, хийж гүйцэтгэсэн ажил (жишээ нь, гэрээлэгчийн ажилласан хүн цаг)-д тулгуурлан тооцдог байна. Эдгээр нь ерөнхийдөө газрын тосны компаниудын сонирхлыг татдаггүй боловч ирээдүйтэй талбай олж авах, эсхүл дараа нь тодорхой хэмжээний эрсдэлтэй талбай ашиглах үйл ажиллагаа болгох нэг арга зам гэж үзэж болно. Ийм төрлийн гэрээнүүдийг Ойрхи Дорнод дахь Газрын тос экспортлогч орнуудын байгууллага (ОПЕК)-ын зарим орнууд, түүний дотор Иран, Кувейт, Саудын Араб зэрэг улсад тодорхой судалгаа хийлгэх юмуу барилгын төсөл хэрэгжүүлэх зорилгоор богино хугацаагаар байгуулж ирсэн байна.

Дээрх гурван үндсэн төрлийн гэрээг хэд хэдэн үзүүлэлтээр харьцуулах боломжтой.

Үүнд:

- Баялгийн өмчлөлийн эрх хэзээ, хаана, ямар хэлбэрээр хөрөнгө оруулагчид шилжих буюу эс шилжих
- Тухайн олборлолтыг хийхээр барьсан уурхай буюу үйлдвэр хөрөнгө оруулагчийн эсхүл засгийн газрын мэдэлд байх
- Өртөг зардлаа нөхөх боломж, түүний хязгаарыг тогтоосон эсэх зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг авч үзэж болно.

Газрын тос олборлодог улс орныг харьцуулсан 2001 оны Д.Жонстоны судалгаанд уг салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээг 72 оронд, харин консессийн гэрээг 64 оронд хэрэглэдэг байна. Харин хамгийн их хэмжээний газрын тос олборлодог буюу олборлох төлөвтэй 25 улс орны дотроос 19 нь бүтээгдэхүүн хуваах гэрээг ашиглаж байв. Бүтээгдэхүүн хуваах гэрээг уул уурхайн салбарт хэрэглэсэн түүх ховор ч зарчмын хувьд боломжгүй зүйл биш юм.

Бүлэг 6. Гэрээ, хэлэлцээр хийх үйл ажиллагаа

Энэхүү бүлэгт хөндлөнгийн шинжээч нараас хэлэлцээр хийх баг байгуулах, хэлэлцээрийн бэлтгэл хангах, уулзалт, гэрээний явцад анхаарах асуудал, уул уурхайн гэрээнд үнэлгээ өгөхөд ашиглах эдийн засгийн тооцооны талаархи зөвлөмж зэрэг Засгийн газар, Улсын Их Хурлын түвшинд асуудлыг хэлэлцэхэд анхаарах зарим асуудлыг орууллаа.

Хэлэлцээр хийх баг байгуулах. Аливаа ашигт малтмалын гэрээ тун нарийн түвэгтэй баримт бичиг байдаг бөгөөд гэрээний эцсийн баримт бичигт Монгол Улсын эрх ашиг туссан байх нөхцлийг хангах шаардлагатай. Олон тохиолдолд гэрээ хэлэлцээр хийх зорилгоор ашигт малтмалын хэлэлцээрийн багууд байгуулагдаж байдаг. Ерөнхийдөө дотоодын иргэд болон гадаадын иргэдийн аль аль нь Засгийн газрын багт орсон байж болно. Гаднаас авах мэргэжилтнүүдэд дараахи хүмүүс орно:

- Ашигт малтмалын гэрээний эрх зүй, олон улсын гэрээ, олон улсын маргаан шийдвэрлэлтээр мэргэжсэн, тухайн гэрээг хэлэлцэн тохирох үүрэгтэй хуульч (эсхүл хуульчид) (ерөнхийдөө хуулийн компани);
- Ашигт малтмалын гэрээ, олон улсын татварын асуудлууд болон дотоодын татварын хуулийн талаар сайн мэдэх татварын хуульч (буюу хуульчид);
- Гэрээний заалт бүрээр эдийн засгийн шинжилгээ хийх, мөн гэрээний ерөнхий бүтцийн талаар шинжилгээ хийх үүрэгтэй төсөв санхүүгийн эдийн засагч (буюу эдийн засагч нар);
- Гэрээний баримт бичгийг хянаж, санал болгосон үйл ажиллагааны хэрэгжих үндэслэлийн талаар дүгнэлт гаргах уул уурхайн инженер (буюу инженерүүд ба геологич);
- Олон улсын орчин дахь ашигт малтмалын

нягтлан бодох бүртгэлийн захиргааны талын асуудлуудыг сайн мэдэх нягтлан бодогч (буюу нягтлан бодох бүртгэлийн компани);

- Байгаль орчны эрсдлүүд, холбогдох байгаль орчны асуудлуудыг сайн мэдэх байгаль орчны мэргэжилтэн (буюу байгаль орчны компани). Байгаль орчинд учрах аюулын эрсдлийг хуваалцах асуудал маш чухал учраас аливаа гэрээний байгаль орчны хэсэг хамгийн өргөн хүрээтэй (бөгөөд хамгийн урт) хэсэг байж болно. Иймээс, дээрх багийн нэг чухал хэсэг нь байгаль орчны мэргэжилтнүүд байдаг.

Дотоодын мэргэжилтнүүдийн дотор янз бүрийн яамд (ялангуяа байгаль орчин, сангийн яамд)-ын болон төв банк, ерөнхийлөгчийн засаглалын төлөөлөгчид ордог.

Монгол Улсад уул уурхайн салбар ирээдүйд чухал ач холбогдолтой учраас тус улс иймэрхүү багтай байх шаардлагатай гэж үзэхийн зэрэгцээ энэ ажилд зохих ёсны гадны мэргэжилтнүүдийн туслалцааг шаардлагатай түвшинд авч ашиглахыг зөвлөмж болгож байна.

Хэлэлцээрийн бэлтгэл хангах. Уг баг хэлэлцээрийн бэлтгэлийг хангасан байх нь чухал. Бэлтгэл ажилд дараахи зүйлс орно:

- Хэлэлцээрийн тухай сургалт (Үүнд ерөнхийдөө хэлэлцээр хийх арга барил, стратегийн талаархи 2-3 семинар байна);
- Хэлэлцээрт оролцогч эсрэг талынхаа

- тухай ойлголтыг хөгжүүлэх (тухайн компанийн тухай зах зээлийн судалгаа, түүний стратегийн зорилгууд, санал болгож буй уурхай тухайн компанийн бизнесийн стратегид хэр нийцэж байгаа эсэх, мөн тухайн компанийн санхүүгийн байдлын тухай судалгаа);
- Ашигт малтмалын гэрээнүүдэд гарч буй сүүлийн үеийн чиг хандлагуудын тухай зарим ойлголтыг хөгжүүлэх;
 - Санал болгосон үйл ажиллагааны эдийн засгийн загварыг боловсруулах (Энэ загварыг эсрэг талтай тохирсон үзүүлэлтүүдэд тулгуурлан гаргаж болно, гэхдээ Засгийн газрын хувьд гэрээний нөхцлийн боломжит хувилбаруудын үр ашиг болон хуваалцах эрсдлийг тооцох өөрийн гэсэн арга зүйтэй байх нь чухал).

Хэлэлцээр хийх уулзалтууд. Нэгэнт бэлтгэл хангагдсан тохиолдолд албан ёсны уулзалтуудын давтамж, гэрээний техник асуудлуудаас хамаарч хэлэлцээрийг 3 сараас жилийн хугацаанд хаа нэгтээ хийж болно.

Гэрээний үйл явц. Газрын тос, байгалийн хий, уул уурхайн гэрээний төсөл боловсруулагчид гэрээний хугацаанд тохиолдож болох бүхий л боломжийг тооцохыг оролдож, улмаар урьдаас тооцоологдоогүй гэнэтийн үйл явдал тохиолдоход талууд юу хийх ёстойг урьдчилан тодорхойлохыг хичээдэг учраас энэ төрлийн гэрээнүүд маш урт, нарийн төвөгтэй үйл явцаар дамжиж болно.

Гэхдээ аливаа гэрээнд ордог гол нөхцлүүд ба үндсэн асуудлын тоо харьцангуй цөөн байдаг. Гол ач холбогдолтой нөхцлүүдийн дотор дараахи асуудал ордог:

- Хайгуул, боловсруулалтын зардлыг хэн төлөх вэ?
- Үйлдвэрлэлийн зардлыг хэрхэн санхүүжүүлэх вэ?
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэн удирдах вэ?
- Үйлдвэрлэсэн баялгийг хэрхэн хуваах буюу борлуулах вэ?
- Талуудын төлбөрийг ямар дарааллаар төлөх вэ?

Гэрээний төрөл бүр эдгээр хүчин зүйлсэд өөр өөрөөр ханддаг.

Олборлох үйлдвэрлэлийн компаниуд эрсдэлтэй бизнес эрхэлдэг гэдгийг ойлгох нь чухал. Компаниуд хайгуул болон бараа, түүхий эдийн үнийн хэлбэлзэлтэй холбоотой эрсдлүүд хүлээдэг бөгөөд хайгуул, ашиглалт төдийгүй техникийн мэдлэг туршлага, үйл ажиллагааны удирдлагыг санхүүжүүлэлтээр хангах ёстой. Үүнийхээ хариуд компаниуд тэгш шударгаар шагнал хүртэх, хөрөнгийнхөө өгөөжийн хувийг шударгаар тогтоолгох, тухайн хөтөлбөрийн удирдлагыг гартаа авахыг хичээдэг. Бараа, түүхий эдийн бүхий л олборлолт эрсдэлтэй байдаг боловч энэ нь тооцоологдсон эрсдэл байдаг. Эрсдэлийн тооцоог олон янзын хүчин зүйлсийн нөлөөлөх магадлалд тулгуурлаж гаргадаг. Үр дүнд нь, компаниуд бүтэлгүйтсэн хайгуулын ажиллагаанд алдсан мөнгөө (өөрөөр хэлбэл, эрсдэл үүрэх) нөхөж чадах хэмжээний хангалттай амжилттай үйл ажиллагаа явуулах (өөрөөр хэлбэл, шагнал хүртэх) нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байдаг.

Бүлэг 7. Уул уурхайн гэрээнд үнэлгээ өгөхөд ашиглах эдийн засгийн тооцооны талаархи зөвлөмж

Засгийн газар ба гадаадын хөрөнгө оруулагч хоёрын хооронд Оюу Толгой ордыг ашиглах талаар хийхээр тохиролцоод буй гэрээний төсөл нь санхүүгийн томоохон хэмжээний гүйлгээ юм. Монгол Улсын хувьд газар дор байгаа нөөц нь ихээхэн хэмжээний санхүүгийн хөрөнгө буюу актив. Гадаадын хөрөнгө оруулагчийн хувьд менежментийн ур чадвар, биет хөрөнгө, мөн өөрийн хөрөнгө болон зээлийн хөрөнгө босгох үүднээс олон улсын хөрөнгийн зах зээлд гарах шууд гарцтай зэрэг нь мөн чухал актив болно. Тиймээс санхүүгийн гүйлгээний хувьд гэрээ хэлцэл хийх зорилго нь хоёр тал өөрсдийн тус тусын активыг нийлүүлж нэг үйл ажиллагаа болгож, ашиг, алдагдал, эрсдлийг хуваалцах нөхцлүүдийг тодорхойлох явдал юм.

Монгол Улсын хувьд санал болгоод буй Оюу Толгойн гэрээнд үнэлгээ хийх нэг арга замыг энэ хэсэгт тайлбарлана. Техникийн бус хэлбэрээр, энгийн жишээ ашиглах замаар чухал асуулт, ухагдахууны талаар ойлголт өгнө. Үүний зорилго нь аливаа гэрээний санхүүгийн ашиг, алдагдлын талаар Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газар, хэвлэл мэдээллийнхэн, иргэний нийгэм ба олон нийт мэдээлэлд тулгуурласан үнэлэлт дүгнэлт хийх суурийг бүрдүүлэх явдал юм. Энэ хэсэгт зөвхөн эдийн засгийн асуудлын талаар өгүүлнэ. Эрх зүйтэй холбоотой асуудлуудыг тусгайлан авч үзэх шаардлагатай.

Өнөөдрийн байдлаар Оюу Толгойн гэрээний төсөл нь Монгол Улсад санхүүгийн хувьд хэр ашигтай болох талаар шууд дүгнэлт хийх боломжгүй байна гэж бид үзэж байна. Учир нь хэд хэдэн тодорхой асуултад эхлээд хариулт авах шаардлагатай ба эдгээр асуултад хариулт өгөх мэдээлэл одоогоор алга байна. Энэ байдал нь эсхүл дүн

шинжилгээг хийгээгүй, нэг бол олон нийтэд ил мэдээлээгүй байгаатай холбоотой. Эдгээр үндсэн асуултыг дор сийрүүлэв.

Үндсэн асуултууд. Гэрээний хэлэлцээг хийсэн баг чин сэтгэлээр ажилласан, мөн байж болох хамгийн сайн хувилбарыг хийсэн гэдэгт итгэлтэй байсан ч энэ нь уг гэрээнд гарын үсэг зурж, төслийг хэрэгжүүлэх ёстой гэсэн үг биш билээ. Хэлэлцээ хийсэн талууд өөрсдийн удирдлагадаа гэрээг танилцуулж, эцсийн шийдвэрийг удирдлага буюу менежмент нь гаргадаг. Одоогийн нөхцөлд холбогдох уул уурхайн компаниудын төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл удирдлагын баг буюу зөвлөл тухайн компанийн ерөнхий байр сууринаас авч үзэхэд тухайн гэрээ нь хэлэлцсэн байдлаар ашигтай бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцнэ гэдэгт итгэх ёстой. Монголчууд ч үүнээс дутахааргүй хэмжээнд тодорхой асуултууд тавих ёстой ба Засгийн газар энэ тохиолдолд удирдлагын зөвлөлийн үүргийг гүйцэтгэх Улсын Их Хуралд гэрээг танилцуулахдаа шаардлагатай баримт материалыг хангалттай хэмжээнд гаргаж өгөх ёстой. Ингэснээр гэрээ нь нийгмийн ерөнхий байр суурьнаас ашигтай эсэх, хувьцаа эзэмшигчид буюу Монгол Улсын нийт иргэдийн ашиг сонирхолд нийцэж байгаа эсэхэд хариулт өгч, шийдвэр гаргах боломжтой болох юм.

Удирдах баг болох Улсын Их Хурлын гишүүд нь тухайн гэрээ ашигтай байх боломжтой эсэхийг тодорхойлохын тулд дараахи дөрвөн асуултыг асуух учиртай. Бусдыг буюу ард түмнийг төлөөлж байгаагийн хувьд наад захын хариуцлага хүлээх явдлыг хангах үүднээс эдгээр асуултад хариулт өгсөн байх ёстой юм:

- Бидний хувьд өөрсдийн активаа ашиглахад ямар сонголт, хувилбарууд байна?
- Бид хэзээ мөнгө олж авах буюу зарцуулах, цаг хугацааны хувьд ямар мөчлөгт хичнээн төгрөг олж авах, энэ мөнгөний өнөөгийн үнэ цэнэ ямар байх вэ?
- Тухайн цаг хугацааны мөчлөг тус бүрт бид мөнгийг хэрхэн олж авах, хэрхэн зарцуулах вэ?
- Тухайн цаг хугацааны мөчлөгт бид тодорхой хэмжээний мөнгийг олж авах магадлал ямар вэ?

Чухал үзүүлэлтүүд (нөөцийн хэмжээ, үнэ, зардал, байгаль орчны хүчин зүйлс, нийгмийн хүчин зүйлс) бүгд нилээд тодорхой бус учир ихээхэн нарийвчлалтайгаар эдгээр асуултад хариулт авах боломжгүй нь ойлгомжтой. Ийм ч учраас хэлэлцээ хийж буй баг нь тухайн хариултыг сонгож авахад хүргэсэн тодорхой нөхцөл байдалд бодитой үнэлэлт өгөх, ашигласан аргачлал, төсөөлөл, нөхцлүүд, мөн эдгээр төсөөлөл, нөхцөл нь хариултуудад хэрхэн нөлөөлөх талаар үнэлгээ гаргаж өгөх хариуцлагыг хүлээнэ. Ингэснээр менежментийн баг, Улсын Их Хурал, олон нийт аль аль нь тодорхой эдийн засгийн болон технологийн орчинд өөрчлөлт ороход өөрт нь ногдох ашиг, хүлээх алдагдал яаж өөрчлөгдөх талаар тодорхой ойлголттой болох юм. Тухайлбал, Оюу Толгойн гэрээний хэрэгжих хугацаанд Монгол Улсад 15 тэрбум ам доллар, хөрөнгө оруулагчид 12 тэрбум доллар орно гэж мэдээлж байсан. Яг ийм мэдэгдэл бол энэ хэлбэрээрээ ямар нэгэн утга агуулж чадахгүй юм. Хоёр талын хөрөнгө оруулагчийн удирдлага ийм мэдэгдлийг шууд хүлээж авахгүй бөгөөд аливаа шийдвэр гаргахад түүнийг ашиглах боломжгүй. Харин дараахи асуултыг нэмж асууснаар уг мэдэгдэл нь утга учиртай болно

а. Өөрсдийн активаа ашиглах ямар сонголт, хувилбар бидэнд байна вэ? Дээрх мэдэгдлийн хувьд удирдлагын зөвлөл дараахи хариултыг өгөх боломжтой: «Энэ тохиолдолд бид 15 тэрбум доллар авах юм

байна. Харин өөрсдийн активыг бид өөр хэлбэрээр ашиглавал 20 тэрбум доллар авч болно. Тийм тохиолдолд 15 тэрбум нь муу наймаа байх болно.» Өөрөөр хэлбэл, өөрсдийн активыг өөр хувилбараар ашиглах сонголтууд юу вэ? Гадаадын хөрөнгө оруулагчид өөрсдийн нөөц хөрөнгийг ашиглах талаар ийм асуултыг тавина, харин монголчууд Оюу Толгойн ордыг ашиглах талаар мөн ижил асуултыг тавих ёстой. Тухайн санал болгож буй гэрээнээс гадна наад зах нь дөрвөн сонголт монголчуудын хувьд байгаа. Үүнд:

1. *Өнөөгийн үйлчилж буй хууль тогтоомжийг татвар, санхүүгийн хүрээ болгон ашиглах.* Өнөөдөр үйлчилж буй хуулиуд нь хууль ёсны дагуу бүрдүүлсэн эрх зүйн хүрээ буюу орчин болох учир гэрээнд ард түмний зүгээс тавих нөхцлүүдийг илэрхийлж болох юм. Энэхүү хүрээ нь аливаа буюу бүх хөрөнгө оруулагч ашиглаж болох татварын болон бусад зохицуулалтын хүрээ юм. Тиймээс олон нийтээр хэлэлцэж баталсан хуулийг дагах хөрөнгө оруулагчийг төсөлд татан оролцуулах нь Засгийн газрын бодлого байж болох юм. Харин үүнийг хүлээн зөвшөөрч, дагах этгээд байхгүй байж болно. Ийм тохиолдолд ард түмэн нэг бол хуулиа өөрчлөх, эсхүл тухайн эрх зүйн хүрээ буюу орчин нь Монгол Улсын хувьд хүлээн зөвшөөрөх наад захын бүтэц гэж үзвэл нөөц баялгаа газарт нь хадгалах боломжтой.

Хавсралт 4-д тухайн гэрээний төслийг өнөөгийн үйлчилж буй хуулийн заалтуудтай зэрэгцүүлсэн харьцуулалтыг үзүүлэв. Ялгаа их байгаа тул өнөөгийн хүчинтэй хуулиудыг гэрээгээр сольсоноор санхүүгийн ашиг, алдагдал, мөн эрсдэл ямар байх, мөн хэлэлцээ хийх үед ямар буулт хийж, ямар нөхцөл хүлээлгэж чадсаныг Монголчууд асуух шаардлагатай.

2. *Санал болгож буй гэрээний төслийг өөрчлөх.* Чин сэтгэлээсээ ажилласан ч гэрээний хэлэлцээ хийсэн багийнхан ашигтай байж болох сонголтуудыг бүрэн авч үзээгүй байж болно. Тиймээс хөрөнгө

оруулагчийн хувьд компанийн удирдлага, Монгол Улсын хувьд Улсын Их Хурал тус тусын, бүр цаашилбал хамтын байр сууринаас хандахад гэрээг сайжруулах боломжтой гэж үзсэн сонголтуудыг санал болгох үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурал болон компанийн удирдлага үнэлгээ өгөх үйл явцад идэвхгүй оролцох ёсгүй, харин ч үр бүтээлтэй хувилбаруудыг хамгийн идэвхтэйгээр санал болгох ёстой. Тухайлбал, гэнэтийн ашгийн татварыг өөрчилж болох юм. Зарим улс оронд хуримтлагдсан ашигт ногдуулдаг «нөөцийн рентийн татвар»-ыг ашигладаг байхад заримд нь нэмэлт ашгаас тодорхой хувийг татаж авах өөр хэлбэрийн татварууд ч байдаг. Өөр нэг сонголт бол өнөөгийн үйлчилж буй татварын орчныг хэвээр нь үлдээж, харин хайлуулах үйлдвэрт Монгол Улс шууд санхүүжилт хийж болох юм. Хайлуулах үйлдвэр барих нэг үндэслэл бол Оюу Толгойгоос бусад газраас олборлох хүдрийг боловсруулахтай холбоотой үр өгөөж юм. Энэ үр өгөөжийн зарим хэсгийг хөрөнгө оруулагч хүртэхгүй тул хайлуулах үйлдвэр барих сонирхолгүй байх ч төлөх татвараа бууруулах хэрэгсэл, эсхүл зүгээр хэлэлцээ хийх стратеги болгон ашиглаж байж болох талтай. Тиймээс өнөөгийн үйлчилж буй хуулийн дагуух татварын дэглэмийг өөрчлөх шахалтад авталгүйгээр Засгийн газар хайлуулах үйлдвэрийг өөрөө санхүүжүүлэх шийдвэр гаргаж болох юм.

3. *Юу ч хийхгүй байх (одоохондоо нөөцийг газарт нь хадгалах).* Газар дахь нөөц нь үндсэн хөрөнгө буюу актив юм. Банкин дахь хадгаламжийн нэгэн адил энэ нөөц нь Монгол Улсын баялгийн нэгэн хэсэг билээ. Тиймээс наад зах нь активаа өнөөдөртөө газарт нь үлдээж (үндсэндээ мөнгөө банкинд хадгалах), ирээдүйд олборлож (тухайн үед банкнаас хадгаламжаа авч, өөр активт хөрөнгө оруулалт хийх) ашиг олох хувилбараас илүүтэйгээр Монгол Улсыг баян болгох нөхцлөөр гэрээ хийгдэх учиртай.

4. *Өөрсдөө хийх.* Монгол Улсын ард түмэн өөрсдөө хуулийн этгээд байгуулж,

бүх актив, нөөц баялаг, мөн ердийн үндсэн хөрөнгийг өмчлөх боломжтой. Монголчууд тухайн бизнесийг авч явах туршлага, мэдлэггүй байж болох ч тодорхой шийдлүүд үүнд байна. Тухайлбал, Засгийн газар тодорхой (Айвенхоу, эсхүл Рио Тинтотой адилхан) компанийг гэрээлж, Монгол Улсын нэрийн өмнөөс уурхайг төлөвлөж загварчлах, барьж байгуулах, үйл ажиллагааг нь явуулах ажлыг гүйцэтгүүлж болно. Гэрээлсэн компанид гарах бүх зардал, мөн үйлчилгээ үзүүлсний төлбөр, эсхүл Монголын тал хүссэн ба компани эрсдлийг хуваалцахыг зөвшөөрсөн тохиолдолд ашгийн тодорхой хувийг төлөх боломжтой. Энэ тохиолдолд бүх зүйл ил тод хийгдвэл ард түмэн газар дахь нөөцийн өмчлөгч хэвээр байж, мөн уурхайг барьж байгуулах бүх нэмэлт хөрөнгө оруулалтыг ч өмчилж, харин уурхайг үр ашигтай ажиллуулах туршлага, мэдлэгийг худалдаж авах боломжоор хангагдана.

Дүгнэхэд, Засгийн газарт 15 тэрбум доллар орно гэдэг мэдэгдэл нь цэвэр үнэ цэнэ бус нийт үнэ цэнийн талаар ярьж байгаа тул ямар нэгэн утга учиртай зүйл биш юм. Харин «Засгийн газар уг гэрээний дагуу 15 тэрбум төгрөг авах ба харин өнөөгийн хуулийн заалтуудыг л ашиглан төслийг хэрэгжүүлбэл 14 тэрбум доллар авна. Тиймээс уг гэрээг хүлээн авбал Монгол Улс 1 тэрбум долларыг нэмж олох боломжтой» гэсэн утгатай мэдэгдэл нь тухайн гэрээний үнэ цэнийг тодорхойлоход шаардлагатай харьцуулалт хийх хүрээг тодорхой хэмжээнд томъёолж байгаа юм.

б. Бид хэзээ мөнгө олж авах буюу зарцуулах, цаг хугацааны хувьд хэзээ, ямар мөчлөгт хичнээн төгрөг олж авах, энэ мөнгөний өнөөгийн үнэ цэнэ ямар байх вэ? «Монгол Улс уг гэрээний дагуу 15 тэрбум төгрөг авах ба харин өнөөгийн хуулийн заалтуудыг ашиглавал 14 тэрбум доллар авна» гэсэн мэдэгдэл ч цааш нь дэлгэрүүлэн тодорхойлохгүй бол мөн л ямар нэгэн утгагүй билээ. Аливаа компанийн удирдлага дараахи асуултыг асуух болно. Үүнд:

- Бид хэзээ мөнгөө авах вэ? Хэзээ мөнгөө зарах вэ?
- Цаг хугацааны мөчлөг бүрт бид хэр хэмжээний мөнгө авах вэ?
- Тухайн бэлэн мөнгөний урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцоход ямар хүү (буюу хорогдуулах хүү)-гийн түвшинг ашигласан бэ?

Гэрээний төслийн нэгэн заалтад (3.3.1) өгөгдсөн олборлолтын хэмжээний талаархи хүснэгт («Олборлох хүдэр, зэс, алт, мөнгөний урьдчилсан тооцоо»)-тэй нэгэн адил хүснэгт хэрэгтэй ба гагцхүү энэ хүснэгтэд тухайн төслийн орлого, түүнээс бүх зардлыг хассан тооцоог жил тус бүрээр, хөрөнгө оруулагч болон Засгийн газрын хувьд тодорхой харуулсан байх шаардлагатай. Ийм хүснэгт байх, мөн аливаа үзүүлэлтийн дүнг тооцоход ашигласан нөхцлүүдийг мэдэж байх нь талуудад очих бэлэн мөнгөний урсгалын цаг хугацааны онцлогийн талаар наад захын ойлголт авах боломжийг бүрдүүлнэ.

Тухайн үзүүлэлтийн дүн цаг хугацааны хувьд ямар хуваарьтай байхыг мэдэх тохиолдолд дараагийн асуулт бол нийт дүнг буюу үнэ цэнийг тооцохын тулд тэдгээрийг хэрхэн нэгтгэх явдал юм. Заримдаа нийт дүнг тооцоход жил тус бүрийн дүнг хооронд нь ямар нэгэн тодотгол буюу засвар хийлгүйгээр нэмж гаргадаг. Тухайлбал, 2007 ба 2008 оны бэлэн мөнгөний урсгал тус бүр -1000 ба +1015 байсан гэж үзье. Энэ хоёр дүнг хооронд нь нэмбэл +15 гарна. Ийнхүү хоорондын нийлбэрийг олох нь хамгийн оновчгүй зүйл ба аливаа шийдвэр ийм тооцоонд үндэслэх ёсгүй. Цаг хугацааны хувьд өөр үед орж ирж буй долларыг хооронд нь нэмэх нь оновчгүй гэж байгаа шалтгаан нь 2007 оны үеийн нэг доллар нь 2008 он, эсхүл 2037 оны доллараас огт ондоо зүйл юм. 2007 оны доллар дээр 2007 оны төгрөгийг нэмэх нь аль нэг валютыг нөгөө валют руу тодорхой ханшаар хөрвүүлэхгүйгээр ямар ч утгагүй гэдгийг хүн бүр мэднэ. Цаг хугацааны өөр үе мөчлөг дэх долларыг нэг тооцооны нэгжид хөрвүүлэх ямар нэгэн засваргүйгээр

(валютын ханшийн засвартай нэгэн адил) 2007 оны доллар дээр 2037 оны долларыг нэмэх нь үүний нэгэн адил утгагүй зүйл юм. Ийм хөрвүүлэлтийг хийх шалтгаан нь цаг хугацаа өөрөө үнэ цэнэтэй ба энэ үнэ цэнэ нь цаг хугацааны мөчлөг хоорондын мөнгөний харьцангуй үнэ цэнэд тусгалаа олсон байна. Үүнийг жишээгээр тайлбарлая. 2 куб метр эзлэхүүнтэй модыг 2007 онд тарьсан ба нэг жил ургуулсан гэж үзье. 2008 онд модны эзлэхүүн 3 куб метр болж болно. Тиймээс 2007 оны хоёр куб метр модыг нэг жилийн хугацаатай нийлүүлбэл дараа жил нь гурван метр куб модыг бий болгоно. Ирэх жилийн гурван куб метр нь өнөөдрийн гурван куб метртэй тэнцүү гэж хэн ч хэлэхгүй байх. Харин өнөөдрийн хоёр куб метр нь ирээдүйн гурван куб метртэй адил, учир нь хоёр куб метрийг цаг хугацаатай нийлүүлэн тооцвол ирээдүйд ийм эзлэхүүнийг бий болгоно. Үүний нэгэн адилаар цаг хугацааны үнэ цэнэ мөнгөний хувьд ч хамаатай. 2007 онд банкинд 100 төгрөг хадгалсан гэж үзье. Энэ дүнг нэг жилийн хугацаатай нийлүүлбэл ирэх жилд 110 төгрөг болно. Өнөөдрийн 100 төгрөг дээр нэг жилийг нэмбэл ирэх жил 110 нэгж мөнгийг бий болгоно. Цаг хугацааны үнийг санхүүгийн зах зээлд хүүгийн түвшинг ашиглах замаар илэрхийлдэг. Төгрөгийн хувьд цаг хугацааны үнэ жил болгон 0.10 төгрөг буюу хувиар илэрхийлбэл 10% байна. Төгрөгөөр тооцвол 2007 оны 1 төгрөг 2008 оны 1.10 төгрөгтэй тэнцүү гэсэн үг. 2008 оны 1.10 төгрөг 2007 оны 1 төгрөгтэй тэнцүү ч гэж хэлж болох юм. Тиймээс «хорогдуулах» (discounting) хэмээх нэр томъёог цаг хугацааны мөчлөг хоорондын мөнгөний үнэ цэнийг тодорхойлоход ашигладаг болно.

Гадаадын хөрөнгө оруулагч, мөн түүний менежментийн баг Оюу Толгойд хөрөнгө оруулах шийдвэрээ цаг хугацааны туршид хүү (буюу цаг хугацааны үнэ цэнэ)-ийг тооцохгүйгээр долларыг хооронд нь нэмсэн дүнд үндэслэн гаргахгүй. Тухайлбал, Морнинг Стар-ын мэдээлж байгаагаар Рио Тинто болон Айвенхоу-ийн 10 жилийн турш дахь

ашгийн түвшин ойролцоогоор 21 хувь байна.¹⁴ Тухайн компанийн хувьцааг худалдан авахад ийм хэмжээний ашгийн түвшинг (татвар, инфляцийг оролцуулан тооцоод) шаардах болно гэсэн үг юм. Тиймээс Рио Тинто, Айвенхоу нь энэхүү хүүгийн түвшинг ашиглаж өөрсдийн мөнгөний урсгалыг хорогдуулах болно. Учир нь 21 хувиас доогуур ашиг нь тэдний хувьцааны үнэ цэнийг урт хугацаанд бууруулах болно. Үүнийг дээрх жишээ буюу 2007 ба 2008 оны бэлэн мөнгөний урсгал тус бүр -1000 ба +1015 байх тохиолдол дээр тооцож үзье. Энэ хоёр тоог нэг нэгдсэн нэгж болох өнөөдрийн долларт хувиргавал, нийлбэрийн дүнд гарах бэлэн мөнгөний урсгал -132 (буюу -1000 + 1015/1.21) байна. Энэ тохиолдолд удирдлагын баг төслөөс татгалзах шийдвэр гаргана.

Монгол Улсын хувьд хүлээн зөвшөөрөх хорогдуулах хувиар засварласан үнэ цэнийн нэгтгэсэн (доллараар хэмжсэн) дүнг мэдээлэхийг олон нийт шаардах ёстой. Хорогдуулан тооцох хүүгийн яг ямар түвшинг ашиглах нь олон хүчин зүйлээс хамаарна. Гэхдээ хамгийн доод нэрлэсэн хүү нь наад зах нь Засгийн газрын олон улсын хөрөнгийн зах зээлд аюулгүй активт оруулах боломжтой хөрөнгийн, инфляци болон Монголын хүлээх эрсдлийг тусгасан хүү байх ёстой. (ЛИБОР буюу Лондонгийн банк хоорондын санал болгож буй хүү нь инфляцийг оруулаад өнөөдөр 5.4% орчим байгаа бол АНУ-ын Сангийн үнэт цаас (Treasury Bill)-н хүү 4.6 % байгаа).

Дүгнэвэл, цаг хугацааны үнэ цэнийг тооцоогүй ямар нэгэн дүнг ашиглах нь гэрээний үнэ цэнийг тодорхойлох хангалттай үндэс болж чадахгүй. Үйл ажиллагаа явагдах жил бүрийн хувьд Засгийн газарт орох бэлэн мөнгөний урсгалын дүнг, эдгээр бэлэн мөнгөний урсгалыг тооцоход ашигласан төсөөлөл, нөхцлийг, мөн Засгийн газарт орох нийт мөнгөний өнөөдрийн үнэ цэнийг

тооцоход ашигласан цаг хугацааны үнэ цэнийг монголчууд мэдэх, асуух ёстой.

в. Тухайн цаг хугацааны мөчлөг тус бүрт бид мөнгийг хэрхэн олж авах, хэрхэн зарцуулах вэ? Гэрээг хүлээн зөвшөөрвөл Монгол Улс наад зах нь гурван үндсэн эх үүсвэрээс бэлэн мөнгөний урсгал хүлээн авах болно. Эдгээр нь: нөөц ашигласны төлбөр, ашгийн татвар ба суутгал татварууд, мөн хувь эзэмшигчийн хувьд авах ногдол ашиг юм. Мөн одоогийн хувилбараар гэрээг хүлээн зөвшөөрвөл гэнэтийн ашгийн татварыг Засгийн газар авахгүй. Наад зах нь гурван шалтгаанаар авах болон авахгүй татвар, төлбөрүүд цаг хугацааны хувьд хэзээ орж ирэх, ямар бүтэцтэй байгааг ойлгох нь чухал.

Нэгд, төлбөр тус бүр эдийн засгийн хувьд өөр өөр чиг үүрэгтэй. Нөөц ашигласны төлбөрийг татвар гэж ойлгохоос илүү Оюу Толгой орд гэх үнэ цэнэ бүхий үйлдвэрлэлийн хүчин зүйлийн төлөө төлж байгаа төлбөр гэж ойлгож болно. Нөөц ашигласны төлбөрийг ямар хэмжээгээр, хэдийд төлөхийг мэдэх нь тухайн активын эдийн засагт хэр хэмжээний үнэ цэнэтэйг харуулах үзүүлэлт болно. Бусад бизнес машин, эсхүл бусад үндсэн хөрөнгийг үнэлдэгтэй нэгэн адил энэ төлбөрийн үнэ цэнийг тухайн нөөцийн үнэ цэнийг тооцоход ашиглах боломжтой. Ашгийн татвар бол оруулсан хөрөнгийн ашигт ногдуулдаг татвар. Энэ нь тодорхой уурхайгаас хамаарах татвар биш, мөн ашигт малтмалын олборлолтод ногдуулах татвар биш. Харин хөрөнгө оруулагчийн тухайн компанид оруулсан хөрөнгөд ногдуулах татвар ба үүнд тухайн нөөцийн үнэ цэнийг оруулахгүй. Татварын сайн бодлогын нэг шинж нь ашгийн татвар аль нэг салбарын төлөө, эсхүл эсрэг ялгаварлахгүй байх явдал байдаг. Тиймээс бусад хөрөнгө оруулалттай харьцуулахад уул уурхайн үйл ажиллагаанд ногдох татварын бодит түвшин илүү өндөр байна уу, бага

¹⁴ Эдгээр дүнг КАПМ (Capital Asset Pricing Model) гэх аргыг ашиглан гаргаж авсан. Тухайн компанийн хувьцааг авахаас өмнө хөрөнгө оруулагч авахыг хүсч буй, эрсдлийг тусгасан ашгийн түвшинг тооцоход энэ аргыг ашигладаг. Уг дүн нь инфляцийг тооцоогүй болно.

байна уу гэдгийг тодорхойлоход ашгийн татварын урсгалын тооцоог мэдэх нь чухал юм. Ногдол ашиг нь оруулсан хөрөнгийн ашиг, эсхүл ашигт малтмалын нөөцийн ашиг биш. Хэлэлцээ хийх явцад хийсэн байж болох аливаа санхүүгийн буулт буюу хөнгөлөлтүүд дээр нэмээд гэрээ байгуулсны дараа хийгдэх үндсэн хөрөнгийн зардлын 34 хувийг Монгол Улс санхүүжүүлэх шаардлагатай учир үнэндээ бусад хийж болохуйц хөрөнгө оруулалт, зарцуулалтыг хийхгүйд хүрэх юм. Тиймээс ногдол ашгийн орж ирэх урсгалыг мэдсэнээр ашигт малтмалыг өмчлөхөөс гадна үйлдвэр, тоног төхөөрөмжид оруулсан хөрөнгийн өгөөж буюу өгч буй ашиг нь Засгийн газрын мөнгөн хөрөнгийг бусад зориулалтаар ашиглах хувилбаруудтай харьцуулахад өрсөлдөхүйц хэмжээнд байгаа эсэхийг мэдэх боломжтой болно.

Хоёрт, Монгол Улсад орох төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг бүр өөр өөр эрсдэл дагуулна. Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа тохиолдолд цалин хөлс төлөгдөхийн нэгэн адилаар нөөц ашигласны төлбөр хийгдэж байх учир уг төлбөр нь ерөнхийдөө хамгийн бага эрсдэлтэй юм. Ашгийн татварын хувьд зардлыг хасч тооцдог тул нөөц ашигласны төлбөрөөс илүү эрсдэлтэй. Хөрөнгө оруулалтын зардал өндөр байх ба алдагдлыг ирээдүйд шилжүүлэх боломжтой тул үйлдвэрлэл эхлээд эхний үед ашгийн татварыг авахгүй. Харин ногдол ашиг бол бүх татвар, өр зээл болон бусад зардлыг нөхөн төлсний дараа олгогддог тул хамгийн их эрсдэлтэй юм. Өөрөөр хэлбэл, ямар нэгэн зүйл үлдсэн тохиолдолд л ногдол ашгийг төлнө. Тиймээс ногдол ашиг олон жилийн турш, заримдаа бүр хэзээ ч төлөгдөхгүй байж болдог ба өмнөх хоёр төлбөртэй харьцуулахад хэмжээний хувьд илүү хэлбэлздэг.

Гуравт, дээрх гурван төлбөрийн хувьд төлбөрийн урсгалыг хянах, уг тогтолцоог хэрэгжүүлэх боломж өөр өөр байдаг. Нөөц ашигласны төлбөр нь тооцох суурийг нь тодорхой зааж өгсөн тохиолдолд хураахад хамгийн хялбар байдаг. Учир нь энд хоёр

зүйлийг л буюу бүтээгдэхүүний хэмжээ (яаж ч тодорхойлсон байж болно) ба түүний үнэ цэнэ (мөн л яаж ч тодорхойлсон байж болно) хоёрыг л мэдэж байх шаардлагатай. Ашгийн татварыг хураах чадвар нь татварын албаны чадавхи, мөн татварын тогтолцооны хялбар, эсхүл нүсэр байдлаас хамаарна. Ногдол ашиг, компанийн ашгийг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах боломжтой ч аудит гадаадын компаниудад бус зөвхөн дотоодод бүртгэлтэй компанид хийгдэх учир нягтлан бодох бүртгэлийн олон тооны зохицуулалтыг хийх шаардлагатай болно. GAAP буюу бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн стандартуудын дагуу ч ийм зохицуулалтыг хийх олон сонголт хувилбарууд байдаг ба эдгээр сонголтоос ногдол ашгийн төлбөр шууд хамаардаг. Тиймээс эдгээр сонголт ямар байхыг ойлгох нь ногдол ашигт ямар нөлөө үзүүлэхийг ойлгох боломж олгох юм. Эцэст нь Монгол Улс цөөнх хувьцааг эзэмшигчийн хувьд ногдол ашиг, үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын бодлого зэрэгт нөлөөлөх боломжгүй юм.

Гэрээнд үнэлгээ өгөх ажлыг эхлэхэд шаардлагатай мэдээллийн хүснэгтийг Хавсралт 5-д үзүүлэв. Хүснэгтэд дээрх хэсэгт болон хорогдуулах хувийн тухай хэсэгт тайлбарласан асуудлуудыг тусгасан болно. Тухайн гэрээний төслийн санхүүгийн үр дагаварыг тооцон үзэхэд наад зах нь энэ хүснэгт дэх мэдээлэл, мөн тодорхой үзүүлэлтүүдийг тооцох дүрэм, нөхцлийн талаархи мэдээллийг зайлшгүй авсан байх шаардлагатай.

г. Тухайн цаг хугацааны мөчлөгт бид тодорхой хэмжээний мөнгийг олж авах магадлал ямар вэ? Уул уурхайн үйл ажиллагаанд 6 төрлийн тодорхой бус байдал үүснэ. Бүтээгдэхүүний үнэ, хүүгийн түвшин, инфляци, харьцангуй цалин хөлс, валютын ханш, бусад үнэ хэлбэлзэх учир эдийн засгийн тодорхой бус байдал үүснэ. Ашиглахаас нааш ордын мөн чанарыг бүрэн мэдэх боломжгүй тул геологийн тодорхой бус байдал байна. Үйлдвэрлэлийн осол, гэмтэл

гардаг ба шинэ технологи, шинэ мэдээллээс хамаарч заримдаа өртөг өндөр өөрчлөлт шинэчлэлийг хийх шаардлагатай болдог тул технологийн тодорхой бус байдал үүсдэг. Ус ашиглах, хортой байж болох хаягдлыг шийдвэрлэх, газрын унаган төрхийг өөрчлөх, зам барих зэрэгтэй холбоотойгоор, мөн хайлуулах үйлдвэр агаарыг бохирдуулах бололцоотой тул байгаль орчны тодорхой бус байдал үүснэ. Хөрөнгө оруулагч дампуурах, Оюу Толгойтой холбогдолгүй шалтгаанаар санхүүгийн хүндрэлд орох, удирдлага солигдох, компанийн бодлого өөрчлөгдөх, хөрөнгө оруулагч солигдох буюу хөрөнгөө бусдад зарах зэрэг нөхцөл байдал үүсэх боломжтой учир үйл ажиллагааны тодорхой бус байдал үүснэ. Эцэст нь Засгийн газар, төрийн бодлого өөрчлөгдөх боломжтой ба Монгол Улсын бүрэлдэн тогтож буй эдийн засгийн болон улс төрийн тогтолцоо, түүний институциональ бүтэц уурхайг ашиглах явцад өөрчлөгдөж болох тул *улс төрийн эрсдэл* үүснэ.

Хөрөнгө оруулагчид өөрсдийн үүрэх эрсдлээ зохих хэмжээнд удирдан зохицуулах болно гэдэгт итгэлтэй байж болно. Геологийн эрсдлийг зардлын хэмнэлттэйгээр шийдвэрлэнэ, техникийн эрсдлийг бизнес төлөвлөгөө боловсруулахдаа тусгана, эдийн засгийн эрсдлийг ямар нэгэн хамгаалалт (hedging) хийх замаар, зээл авах болон бусад стратегиар шийдвэрлэнэ. Байгаль орчны эрсдлийг ч зардлын хувьд хамгийн ашигтай хувилбараар бууруулна. Мөн улс төрийн эрсдлийг татвар, санхүүгийн орчныг тогтвортой болгох замаар бууруулахыг хөрөнгө оруулагч оролдож байгаа билээ.

Монгол Улсын иргэд ч Засгийн газраасаа үүнээс багагүй зүйлийг шаардах ёстой. Ялангуяа дэлхийн зах зээл дээрх зэсийн үнээс Монгол Улс хамаарах байдлыг ямар аргаар бууруулах талаар асуух нь чухал. Уг гэрээг байгуулснаар дараахи хоёр шалтгаанаар эдийн засаг зэсээс улам илүү хамааралтай болох тул энэ асуултыг асуух нь онцгой чухал юм. Нэгд, Засгийн газар шинээр хийх

хөрөнгө оруулалтын 34 хувийг төлөх ёстой. Хоёрт, хайлуулах үйлдвэр байгуулахаар тохиролцож байна. Энэ хоёр шийдвэр нь нөөц баялгийг зөвхөн өмчлөх хувилбартай харьцуулахад Монгол Улсын зэсийн үнийн өөрчлөлтөөс хамааран үүрэх эрсдлийг нэмэгдүүлж байгаа юм. Учир нь эдийн засгийг олон тулгуурт болгож төрөлжүүлэх зорилгоор хийгдэх ажилд хийж болох байсан хэмжээнд хөрөнгө оруулахгүйд хүрэх юм. Тиймээс ч хүлээгдэж буй ашигтай харьцангуйгаар эрсдэл ийнхүү нэмэгдсэний үнэ өртөг ямар байх, энэ эрсдлийг бууруулахын тулд ямар арга хэмжээ авахыг Засгийн газраасаа асуух нь зүй ёсны хэрэг билээ.

Байгаль орчны эрсдэл ч ихээхэн чухал асуудал ба үүнд хоёр шалтгаан байна. Нэгд, байгаль орчны аливаа нөхөн төлөгдөөгүй хохирлыг эцсийн дүндээ Монгол Улс үүрэх учир үйл ажиллагаа явагдах үед, мөн зогссоны дараа байгаль орчны тогтолцоог хянах буюу мониторинг хийх ямар арга хэмжээ авагдахыг мэдэх нь чухал. Түүнчлэн ийм хяналтыг хийх институциональ тогтолцоо байгаа эсэхийг ч үнэлэх нь чухал. Хоёрт, хувь нийлүүлэгч хөрөнгө оруулагчийн хувьд Монгол Улсын Засгийн газар өөрөө бохирдуулагч, нөгөө талаас өөрөө байгаль орчны хохирлыг хянагч байх нь. Энэхүү болзошгүй зөрчлийг шийдвэрлэх ямар нэгэн арга байгаа эсэх талаар Улсын Их Хурал, олон нийт мэдэж байх нь чухал.

Дүгнэлт. Олон нийт тухайн гэрээний төслийн ашиг, хохирлыг үнэлэхэд шаардлагатай зарим зүйлсийн талаар ойлголт өгөхийг энэ хэсэгт зорьсон билээ. Үр дүн нь ирээдүйд гарах санхүүгийн шийдвэрийн хувьд нарийн төвөгтэй асуудал, тодорхой бус байдал заавал байдаг тул бүх зүйлийг төгс, өндөр нарийвчлалтайгаар мэдэх ёстой гэж хэлэхгүй. Гэхдээ компанийн удирдлага ч, Улсын Их Хурал ч бусад хувилбаруудтай харьцуулахад цэвэр ашиг, алдагдал ямар байхыг хэмжих боломжоор, мөн тухайн гэрээг түүнээс давсан өргөн хүрээнд үнэлсэн нэмэлт дүн шинжилгээгээр хангагдсан байх

ёстой. Аливаа шийдвэр гаргагч, тухайлбал компанийн удирдлага, эсхүл Улсын Их Хурал гэрээг илүү өргөн хүрээнд авч үзэж, тухайн санхүүгийн тохиролцоо нь компанийн нийт бүтцэд хэрхэн нөлөөлөх талаар асуух ёстой. Тухайлбал компанийн менежмент дараахи асуултыг асуух хэрэгтэй:

- Энэхүү активыг ашиглах нь бидний бизнесийн хөгжлийн ерөнхий стратегид ямар нөлөөтэй вэ?
- Энэхүү гэрээтэй холбогдон гарах эрсдлүүдийг зөөлрүүлэн тархаахын тулд бид ямар арга хэмжээ авах ёстой вэ?
- Орж ирэх мөнгөн хөрөнгийг хэрхэн зарцуулах (эсхүл хөрөнгө оруулах) вэ?
- Гэрээг хянах, хэрэгжилтийг хангах ямар арга байгаа вэ? Ийм хяналтыг хэр бодитойгоор хэрэгжүүлж болох вэ?
- Байдал таагүйгээр эргэвэл юу болох вэ? зэрэг асуулт хамарна.

Бүлэг 8. Гэрээн дэх төрийн оролцооны зарим асуудал

Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд төрийн оролцооны талаар өгсөн санал зөвлөмж

Улсын Их Хурлын хэсэг гишүүдээс өргөн барьсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 2006 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр дараахи хэсэгт танилцуулсан санал зөвлөмжийг гаргаж өгсөн билээ.

Хуулийн төслийн 5.3 дахь хэсэгт «Төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил нь хийгдсэн стратегийн ач холбогдолтой орд газрын 50-иас дээш хувийг төр өмчилнө» гэж заажээ. Энд «Стратегийн ач холбогдол бүхий орд газар» гэсэн нэр томъёог тодорхойлоогүй байна. Зарим эх сурвалжаас авч байгаа мэдээллээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалд томоохон ордууд болон алт, цацраг идэвхт эрдэс зэрэг ашигт малтмал хамарна гэж ойлгосон. Хуулийн төслийн 4.20-д «төсвийн хөрөнгөөр хайгуул хийх» гэдгийг тодорхойлсон байна. Хайгуулийн ажлыг хийхээр төсвийн санхүүжилтийг хэн авч болох, мөн өмнө нь төсвийн хөрөнгөөр хайгуулийг хийсэн өмчийн лицензийг хэн авч болох талаар хязгаарлалт байхгүй мэт ойлгогдож байна. Эцэст нь, хайгуулийн ажлыг төрөөс санхүүжүүлээгүй тохиолдолд төрийн оролцоо шаардлагагүй ба Айвенхоу Майнзын санал болгож буй хөрөнгө оруулалт тухайн эрдэс баялаг стратегийн ач холбогдолтой гэж үзсэн ч энэ заалтад хамрахгүй гэж бид ойлгож байна.

Төрөөс ямар нэгэн хэлбэрээр хувь эзэмшигчээр оролцох нь олонтаа дурьдагддаг шалтгаануудын улмаас татгалзах хэрэгтэй

зүйл гэдэгт бид итгэж байна. Гэхдээ өнөөгийн энэ саналын нэг зөвтгөх шалтгаан нь төсвийн хөрөнгөөр хайгуулийн ажлыг санхүүжүүлэх нь үнэндээ Засгийн газрын хөрөнгө оруулалт тул ийнхүү хөрөнгө оруулсны төлөө зохих хэмжээний ашиг хүртэх учиртай. Энэ байр суурь үндэслэлгүй биш юм. Гэхдээ төрийн хөрөнгө оруулсан хувь хэмжээг хайгуулийн зардлыг оруулж тооцсон нийт хөрөнгө оруулалтын хэмжээнээс тооцох ёстой. Тухайлбал, Засгийн газар хайгуулийн зардалд 10-ыг (хуримтлагдсан авч болох байсан буюу алдагдсан хүү, инфляцийн тохируулга, төрийн ордын хувьд эзэмших эрхийг хадгалах өртөг зэрэг бүх холбогдох зардлыг оруулаад) ба капитал хөрөнгө оруулалтад 90-ийг зарцуулан байжуурхайг ашиглаж, ажиллуулах шаардлагатай гэж үзье.¹⁵ Энэ тохиолдолд нийт хөрөнгө оруулалтаас төрд ногдох хувь нь нийт хөрөнгийн өртгийн 10 хувь байх ёстой. Энэ жишээнээс харахад компанийн хөрөнгө оруулсан капиталаас ямар нэгэн ашиг төр авна гэж хүлээхээргүй байгаа нь тодорхой. Харин төр эрэл хайгуулийн зардалын хэлбэрээр хөрөнгө нэмэрлэж байгаа тул түүндээ ногдох өгөөж хүртэх ёстой. Тиймээс нийт хөрөнгийн 10 хувиас илүү хувь хэмжээ

¹⁵ Энэ бол хялбаршуулсан жишээ ба өмчийн хөрөнгө оруулалтыг хорогдуулан (өсгөн) тооцох зэрэг чухал техникийн асуудлуудыг орхигдуулсан болно. Өр зээлийн бүтцийн асуудлыг ч эс тооцсон болно. Гэхдээ төр засгийн ашгийн хэмжээ нь өр төлбөрийн бүтцээс үл хамаарах ба нийт хөрөнгийн үнэ цэнээс тооцогдох ёстой.

нь үндсэндээ хөрөнгө оруулагчдад ногдуулж буй татвар ба 10 хувиас доогуур хувь эзэмших бол уг төсөлд зохих хэмжээнд эрх мэдэлтэйгээр оролцох үндэс суурь байхгүй байна. Хэдийгээр энэ нь жишээ ч ерөнхийдөө хайгуулийн зардал нийт капитал хөрөнгө оруулалтын 50 хувиас доогуур хэмжээтэй байдаг.¹⁶ Тиймээс эрсдэлийг хамгийн багаар тооцсон ч оролцоог хэрхэн тодорхойлохоос үл хамааран доод тал нь 50 хувийг эзэмших нь хөрөнгө оруулалтыг зайлуульж болзошгүй.¹⁷

Энэ жишээнд үзүүлсэн тооцоог бодит байдалд хийхэд хүндрэлтэй байж болзошгүй ба төрийн оролцооны хувь хэмжээг хэрхэн тооцох талаар хуульд тусгаагүй байна. Энэхүү тооцоог хэрхэн хийхийг бүх тал ойлгож байх нь чухал ба үүнийг хуульд, эсхүл дүрэм журамд зааж өгөх хэрэгтэй.

Хувь эзэмшин оролцох нь төсвийн санхүүжилттэй хайгуулийн үр шимийг хүртэх явдлыг хангах нэг л арга юм.¹⁸ Өөр сонгож болох аргуудад нөөцийн төлбөрийг нэмэгдүүлэх, хэт өндөр ашгийн татварын ямар нэгэн хэлбэрийг хэрэглэх өгөөжийн суурь түвшнийг доогуур тогтоох, эсхүл супер нөөцийн төлбөр (эсхүл экспортын татварын)-ийн хувьд үйлчилж эхлэх үнийн түвшинг доогуур тогтоох зэрэг орно. Томоохон орд газруудын хувьд дуудлага худалдааг ашиглаж болох юм. Эрхийг олгох дуудлага худалдаа нь газрын тосны орд газрын хувьд нийтлэг зүйл бөгөөд орд газар томоохон хэмжээтэй бөгөөд хайгуулийн эрсдэл нэг их чухал хүчин зүйл биш тохиолдолд бусад эрдэс

баялгийн хувьд хэрэглэх боломжтой байж болох талтай. Түүнчлэн, хайгуулийн зардлыг хөрөнгө оруулагч хасаж тооцох боломжгүй тул Засгийн газар ашгийн татвараар дамжуулан илүү өндөр хэмжээний орлого олох боломжтой.¹⁹ Хувь эзэмших хэлбэрээр оролцохтой харьцуулахад эдгээр сонголтууд нь илүү оновчтой ба хууль шинэчлэх явцдаа шинжлэн үзэх хэрэгтэй гэдэгт бид итгэж байна.

Хоёр асуудлыг нэмж хөндөхийг хүсч байна. Нэгт, төсвийн хөрөнгөөр хайгуулийг санхүүжүүлсэн болон санхүүжүүлэх газрууд тодорхой бөгөөд олон нийтэд ил тод байх нь чухал. Уул уурхайн кадастрт ийм газруудыг хэвлэн нийтлэх нь эхний алхам байх болно. Хоёрт, стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялгийг хуульд сайтар тодорхойлж өгөх хэрэгтэй ба тухайн тохиолдлоос хамааран янз бүрээр тайлбарлах боломжгүй байх ёстой.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд тогтвортой байдлын гэрээний тухай заасан байна. 20-50 сая ам долларын хөрөнгө оруулалтад Засгийн газарт, 50 сая ам доллараас дээш хөрөнгө оруулалтад Улсын Их Хуралд бүрэн эрх олгожээ. Тогтвортой байдлыг хангах хугацаа байх шаардлагатай гэж үзвэл бүх хөрөнгө оруулалт (хэмжээнээс үл хамааран)-ын хувьд нэгдсэн нэг л хугацаа байх ёстой ба хууль тогтоомжид тогтвортой байдлын үргэлжлэх нэг л хугацааг тусгах хэрэгтэй. Засгийн газарт энэ хугацааг тогтоох эрх олгосон тохиолдолд ил тод байдал алдагдах ба томоохон хөрөнгө оруулалт

¹⁶ Тухайлбал, 4 сарын 22-нд Монголын уул уурхайн ассоциациас зохион байгуулсан нийтийн форум. Айвенхоу Майнз компанийн төлөөлөгч одоогоор 300 сая ам долларыг Монголд зарцуулаад байгаагаа мэдэгдсэн. Харин нийт хөрөнгө оруулалт 1.5 тэрбум доллар байх тул нийт хөрөнгө оруулалтын 17 хувь буюу 300 сая ам доллартай тэнцүү гэж төсөөлөхөөр байна.

¹⁷ Төрийн өмчийн оролцоог өөр талаас нь ойлговол Засгийн газар ашигт малтмалд хөрөнгө оруулж байгаа бол компани нөхөн сэргээгдэх капиталд хөрөнгө оруулж байгаа явдал юм. Эзэмших хувь нь ашигт малтмалын үнэ цэнэ (нөөц ашигласны төлбөр болон бусад төлбөрүүдийг суутгасан)-с хамааран янз бүр байх болно.

¹⁸ Засгийн газар ирээдүйд хайгуулийн зардлыг санхүүжүүлэхийг хүсэх шалтгаан тодорхойгүй байна. Төр засгийн дэмжлэггүйгээр ч Монголын уул уурхайн салбар ихээхэн сонирхол татаж байгаа. Түүнчлэн, хайгуулийг санхүүжүүлснээр төр засаг ихээхэн эрсдэл хүлээж байгаа ба энэ эрсдлийг Засгийн газрын нийт багц үйл ажиллагааны хүрээнд, ийм үйл ажиллагаанд мөнгө зарцуулсанаас үүсэх алдагдсан боломжийн (тухайлбал, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал зэрэгт) өртгийг тооцож үнэлэх хэрэгтэй.

¹⁹ Ашгийн татварыг тооцоход хайгуулийн зардлыг зарлагаддаг. Тиймээс хөрөнгө оруулагч хайгуулд зардал гаргаагүй бол ашгийн татвар нэрлэсэн үнэ, өнөөгийн үнэ цэнээрээ харьцангуй дээгүүр дүнтэй гарна.

бүрийн хувьд Улсын Их Хурал шийдвэр гаргах тохиолдолд тогтвортой байдлыг хангах хугацаа нь уул уурхайн шинэ төсөл тус бүрийн хувьд улс төрийн асуудал болж хувирна.

Хөрөнгийг нөхөх хугацаа нь жижиг хөрөнгө оруулалттай харьцуулахад том хөрөнгө оруулалтын хувьд илүү урт тул илүү урт тогтвортой байдлын хугацаа шаардлагатай гэж төсөөлж болох юм. Гэвч ийм төсөөлөл нь үндэслэлгүй байж болно. Жижиг хөрөнгө оруулалттай харьцуулахад том хөрөнгө оруулалтын хувьд үйлдвэрлэлийн хэмжээ илүү өндөр, бэлэн мөнгөний урсгал илүү их хэмжээтэй байдаг. Мөн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх хэрээр ашиглалтын болон боловсруулалтын дундаж өртөг буурах боломжтой. Тиймээс хөрөнгө оруулалтын хэмжээ ихсэхэд нөхөн төлөгдөх хугацаа хэд хэдэн хүчин зүйлээс хамааран уртсах буюу богиносх боломжтой. Ийм төвөгтэй харьцаа байдаг тул хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааран тогтвортой байдлын хугацааг ялгаварлах нь субъектив чанартайг анхаарч, хялбар, ил тод байх үндэслэлээр нэгэн жигд хэлбэрээр асуудалд хандах нь илүү оновчтой.

Хавсралт 2-т уул уурхайд зарим улсын төрийн оролцоог татвар, төлбөртэй нь харьцуулсан судалгааг үзүүлсэн болно.

Уул уурхай дахь төрийн оролцооны эрсдэл. Уул уурхайн бизнест төрийн өмчийн оролцоог хангах сонирхол ихээхэн байгаа нь ажиглагддаг. Төрийн өмчийг ашиглах талаар зарим нэгэн сэрэмжлэх асуудал байгааг дор тэмдэглэв.

Төрөлжилт ба эрсдэл. Монгол Улс нөөц баялаг ихтэй орон. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн бусад салбарын хувьд Монгол Улс ядуувтар, мөн хөрөнгийн сайтар төрөлжсөн, олон тулгуурт суурь байхгүй гэсэн үг. Төрөлжилт ийнхүү хангалтгүй байхын үр дагаварт орлого, гадаад валютын эх үүсвэрийн ихэнх хэсэг нь цөөн тооны олон улсын зах зээлээс ихээхэн хамаардаг явдал ордог. Ихээхэн хэлбэлзэлтэй байж болох

ашигт малтмалын үнэ өөрчлөгдөхөөс үүсэх үр дагавараас эдийн засгийг хамгаалах боломж бага байна. Мөн нөөц баялгийг олборлож, байгалийн баялгийн орлогыг бусад салбарт (гадаад валютаар олон улсад хөрөнгө оруулах нь нэг хэлбэр байж болно) хөрөнгө оруулахад ашиглах нь дотоодын эдийн засгийн төрөлжилтийг сайжруулах хамгийн үр дүнтэй арга байж болох юм. Уул уурхайн үйл ажиллагаанд шууд төлбөр хийх болон компаниар «даалгах» замаар хувь буюу өмч эзэмшин оролцох нь бусад хүчин зүйл тэнцүү тохиолдолд дээрх эрсдлийг нэмэгдүүлж, төрөлжилтийг хязгаарлах болно.

Эрсдэл хүлээсний өртөг. Монгол Улсын хувьд эрсдэл хүлээсний өртгийг олон улсын хөрөнгө оруулагчидтай харьцуулан авч үзэх хэрэгтэй. Олон улсын компаниуд тухайн салбарын онцлог бүхий эрсдлийг багасгах үүднээс наад зах нь хэд хэдэн улс оронд хөрөнгө оруулдаг. Мөн гадаадын хөрөнгө оруулагчид олон улсын хөрөнгийн зах зээлд шууд гарцтай байхаас гадна гадаадын хөрөнгө оруулагчдын хувьцааг эзэмшигчид нь эрдэс баялгийн үнийн өөрчлөлтөөс үүсэх эрсдлийг саармагжуулахын тулд хөрөнгө оруулалтаа төрөлжүүлэх олон төрлийн аргыг хэрэглэх боломжтой байдаг. Монголтой харьцуулахад олон улсын хөрөнгө оруулагчдын хувьд зээлийн өртөг харьцангуй доогуур байх боломжтой ба тэд ийм бага өртөгтэй зээлийг ашиглан үр дүнтэй хэлбэрээр эрсдлийн зарим хэсгийг банк болон бусад зээлдүүлэгчдэд шилжүүлэх боломжтой. Эцэст нь, олон улсын хөрөнгө оруулагчид өөрсдийн эрсдлийг бууруулах үүднээс хамгаалалт баталгаа, гэрээний нийлүүлэлтийн нөхцлүүдийг ашигладаг. Хөрөнгө оруулагчийн эрсдэл үүрэх өртөг Монгол Улсынхаас бага бол Монгол Улс өмчлөгч хэлбэрээр оролцоогүй тохиолдолд уул уурхайн үйл ажиллагааны эрсдлийг тооцсон нийт үнэ цэнэ илүү өндөр байх болно. Үүний дүнд Монгол Улсад орох орлогын үнэ цэнэ илүү өндөр байх боломжтой.

Төслийг хамтарсан аж ахуй, эсхүл

хаалттай компани хэлбэрээр хэрэгжүүлэхэд үүсэх асуудлууд. Төрийн өмчийн оролцоог нийтэд нээлттэй арилжигддаг компанийн хувьцаа хэлбэрээр хангаж болох юм. Эзэмших хувьцаа нь цөөн, нийтийн өмнө хариуцлага тооцолт сайтай тохиолдолд ийнхүү өмчлөгч байхаас шууд утгаараа нэг их хүндрэл учрахгүй.²⁰ Засгийн газар өмчийн хөрөнгөд хувь эзэмшигч ба ногдол ашиг, хөрөнгийн үнийн өсөлтөөс ашиг хүртэх болно.²¹

Хөрөнгө оруулагчид манипуляци хийх. Ялангуяа эрдэс баялгийн гэрээнд үнэгүйгээр хувь эзэмших заалт орсон тохиолдолд хөрөнгө оруулагчид өмчийн оролцоог татвар гэж хүлээж авч болзошгүй. Үүний дүнд хөрөнгө оруулагчид төр засагт төлөх төлбөрөө олон тооны аргыг ашиглан бууруулахыг оролдож болзошгүй. Ийм аргуудад албан ёсоор тайлагнах ашгийг бууруулах салбар хоорондын өр зээлийг илүүтэй ашиглах болон шилжүүлгийн үнийн аргууд орж болно. Ингэснээр Засгийн газарт өгөх ногдол ашиг, Засгийн газрын нийт ашгийн хэмжээ буурч, гадаадын хөрөнгө оруулагчийн хувьд ашигтай байх болно.

Ил тод бус байдал. Ашигт малтмалаас төлбөр авах бусад аргуудтай харьцуулахад Засгийн газрын өмчийн оролцоо нь

харьцангуй ил тод бус байж болох юм. Хаалттай дотоодын аж ахуйн нэгжээс ногдол ашиг, бусад төлбөрийг нийтийн хяналтаас гадуур олгох боломжтой ба авилгал үүсэх боломж нэмэгддэг.

Нэгтгэн дүгнэхэд, төр засаг газарт байгаа ашигт малтмалыг 100 хувь өмчилдөг ба энэхүү хөрөнгийг өмчлөгчийн хувьд эрсдлийг тооцсон байдлаар өрсөлдөхүйц хэмжээний ашиг хүртэх ёстой болохыг онцлож байна. Энэ зорилгод хүрэхэд уул уурхайн компанийн бусад капитал хөрөнгөд эдийн засгийн хувь эзэмшихгүйгээр татвар, санхүүгийн сайтар боловсруулсан тохирох тогтолцоог (үүнд нөөцийн төлбөр, ашгийн татвар ба хэт өндөр ашгийн татвар орно) бүрдүүлж болох юм. Төлбөр авлага, тооцоог хянах боломжийг олгох нийтээр мэддэг арга хэрэгслийг ашиглан Засгийн газар, компанийг хариуцлагатай байх нөхцлийг бүрдүүлбэл иргэдийн сэтгэл зовж буй асуудлуудыг хөнгөлөх боломжтой. Эцэст нь, ихэнх гадаадын хөрөнгө оруулагчид өөрсдийн улс орондоо үйл ажилагаагаа олон нийтэд ил тайлагнах үүрэг хүлээдэг тул Монголчууд тухайн компанийг ийм тайлангаар нь хянах боломжтой ба энэ нь ил тод байдлыг нэмэгдүүлэхэд тустай.

²⁰ Олон нийтийн өмнө хариуцлага хүлээх үүднээс эзэмших өмчийн хувь, хувьцааны үнэ цэнэ, олох шаардагатай орлогын хэмжээ зэргийг тайлагнана. Төр засаг ямар хэлбэрээр өмчийн хувь эзэмших болсоноос үл хамааран шууд болон шууд бус бүх өмчлөх эрхийн талаар нийтэд мэдээлэх нь нэн чухал.

²¹ Төр засгийн оролцоо нь компаниар «даалгах» хэлбэртэй бол ийнхүү үнэгүйгээр төр хувь эзэмших болсонтой холбоотойгоор ашгийг бууруулан тооцохтой холбоотой асуудал үүсэх боломжтой. Ийнхүү бууруулан тооцох явдал гарах эсэх нь ашигт малтмалын ордын үнэ цэнэ өмчийн хөрөнгийн үнэд хэрхэн тусгалаа олж байгаагаас (төр засгийн өмчийн хувь байсан ч, байгаагүй ч) хамаарна.

Бүлэг 9. Гэрээ хэлцлийн ил тод байдал

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах нь Засгийн газрын түвшинд ч, аж ахуйн нэгжийн хувьд иргэдийн өмнө хүлээсэн хариуцлагатай үүрэг амлалт мөн.

Аливаа гэрээ хэлэлцээр, тэр дундаа монголын нийт иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлж байгаа, тэдний хүсэн хүлээж байгаа гэрээний зарчим, түүний хэлэлцээрийн явцын тухай мэдээлэл, гэрээний үндсэн агуулга, тоо баримт нийтэд ил тод байх учиртай. Хэлэлцээрийн явцад хэлэлцэгдэж байгаа санал бүр ил тод биш байж болох ч хэлэлцээрийн явц, үндсэн агуулгыг тухай бүр нийтэд заавал мэдээлж байх нь зүйтэй. Энэ нь уг гэрээ, түүний хэлэлцээрийн явцад аливаа хардлага үүсэхээс сэргийлэхийн хамт, эрдэмтэн судлаач, төрийн бусад байгууллага, иргэний нийгмийн байгууллага, иргэд тухайн гэрээний талаар санал бодлоо илэрхийлэх, өөр хувилбар боловсруулах үндэслэл болно.

Засгийн газар Айвенхоу майнз монголиа инк ХХК хоёрын хооронд байгуулах гэрээ, түүний хэлэлцээрийн явц төдийлөн ил тод бус байсан нь иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн дунд элдэв хардлага төрүүлж байлаа. Үүний зэрэгцээ гэрээнд тусгагдсан зарим тоо баримт болон тооцоо судалгааны тайлбар байхгүй, Засгийн газраас хийсэн шинжилгээ нийтэд төдийлөн нээлттэй биш байсан нь бидний шинжилгээний дүнд нөлөөлж байсныг холбогдох бүлэгт бичсэн болно.

АММИ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг хянах тул Рио Тинто ба Айвенхоу нь компанитай холбоотой аливаа мэдээллийг ил тод тайлагнах асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй байна. Хувь нийлүүлэгчдийн гэрээнд Монгол Улсын хуулийн дагуу ил тайлагнах шаардлагатай зүйлсийн талаар

ч тусгайлан оруулж өгөөгүй байна. Засгийн газрыг төлөөлөх төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд тодорхой хэмжээний мэдээлэл авах эрхтэй ч түүнийгээ хөрөнгө оруулагчдын зөвшөөрөлгүйгээр Улсын Их Хурал, эсхүл олон нийттэй хуваалцах эрхгүй байна. Оюу толгойн ач холбогдлыг бодолцвол АММИ нь хаалттай бус нээлттэй хувьцаат компанийн нэгэн адилаар санхүүгийн болон бусад материаллаг мэдээллийг ил тайлагнах шаардлагыг тавих нь зохистой ба уг гэрээ нь Монголын хуулиас дээгүүр эрхтэй байх ёсгүй.

Уул уурхайн үйлдвэрлэл нь асар их мөнгө эргэлддэг учир хээл хахуульд өртөмтгий салбар гэж үздэг. Иймд уул уурхайн үйлдвэрлэл тэр дундаа Засгийн газартай гэрээ байгуулж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нийтэд ил тод байх нь чухал. Ингэх нь аливаа хардлага сэрдлэгээс хамгаалах төдийгүй, компанийн нэр хүндэд сайнаар нөлөөлнө.

Уул уурхайн үйлдвэрлэлд ил тод байдлыг нэмэгдүүлэх үндэс нь нэг талаас аж ахуйн нэгж, нөгөө талаас Засгийн газрын байгууллагуудын түвшинд мөрдөх хууль тогтоомж, зохицуулалтын дүрэм, журмууд нь парламентын түвшинд тал бүрээс нь хэлэлцэгдсэн нийтэд тов тодорхой байхаас эхэлнэ. Ялангуяа аливаа татвар, төлбөрийг тооцох аргачлал, татвар, төлбөрийн төлөлт, чөлөөлөлт, хойшлуулалт, орлого бүрдүүлэх, түүнийг хуваарилах, зарцуулах, суутгал хийх, тайланг гаргах, хэрэглэх валют, валютын гүйлгээ, шилжих үнэ, санхүүгийн тусгаарлалт,

нягтлан бодох бүртгэл, хилийн гүйлгээ, мөнгө гадаадад гаргах, мэргэжилтэн, зөвлөх үйлчилгээнд зарцуулах хувь хэмжээ зэрэг зохицуулалтууд хэнд ч ойлгогдохоор хууль тогтоомж, дүрмээр зохицуулагдсан байх ёстой. Мөн хайгуул, хөгжлийн гэх мэт үйлдвэрлэлийн өмнөх шатны зардлыг тооцох, түүнд хийх аудит, үйлдвэрлэлийн, боловсруулалтын, борлуулалт, холимог борлуулалт, тээврийн, захиргааны зардлуудыг тооцох, зохицуулах дүрэм, элэгдэл хорогдол тооцох аргачлал, аж ахуйн нэгжийг байгуулах, татан буулгах, эрх шилжүүлэх, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, үйлдвэрлэлийн технологи, бүтээгдэхүүний хэмжээ, үнэ тооцох, байгаль орчны нөхөн сэргээлтийн хууль тогтоомж, зохицуулалтын дүрмүүд ч тодорхой байх шаардлага бий. Мөн аливаа хууль тогтоомж, зохицуулалтын дүрмүүдийг дагаж мөрдөх, тэдгээрийг зөрчигчдөд ногдуулах хариуцлага, түүнийг хэрэгжүүлэх эзэн зэрэг захиргааны зохицуулалтууд тодорхой, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа ч ил тод байх нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай. Энэ бүгд нь гэрээний хэрэгжилтийн ил тод байдлыг хангах гол хэрэгсэл болно. Энэ зорилгоор татварын багц хуулинд өгсөн зөвлөмжийг өмнө авч үзсэн билээ.

Гэрээт компанийн хувьд Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжаалах нь нээлттэй компанийн нийтээр хүлээн зөвшөөрдөг, компанийн хувьд өөрсдийн үйл ажиллагааны санхүүгийн болон бусад чухал мэдээллийг хөрөнгө оруулагч (олон улсын хөрөнгө оруулагч, дотоодын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж, хувь хүмүүс) болон нийтэд ил тод тайлагнах үүргийг хуулиар хүлээдэг,

ингэж ажиллаж байж эдийн засгийн хувьд биеэ даан оршин тогтнож, хөгжиж байдаг.

Уул уурхайн үйлдвэрлэл эрхэлсэн аж ахуйн нэгж, түүнтэй гэрээ байгуулсан, гэрээ байгуулаагүй ч Засгийн газар олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах санаачлагыг хэрэгжүүлэх ёстой. Энэ асуудал зөвхөн Монголын хувьд төдийгүй олон улсын түвшинд хэрэгжүүлж байгаа санаачлага болно.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хүрээнд уул уурхайн компаниуд улс, орон нутагт төлсөн материаллаг төлбөрөө ил тод тайлагнах, Засгийн газар уул уурхайн компаниудаас хүлээн авсан материалаг орлогоо нийтэд ил тод тайлагнах үүрэгтэй.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын өнөөгийн явуулж байгаа хүрээг хэрэгжүүлж хэвшүүлэхийг зэрэгцээ

- санхүүгийн нэгтгэн тулгалтаас илүү өргөн хүрээтэй аудитад шилжих;
- биет аудит хийх;
- олборлох үйлдвэрлэлийн голлох үйл явцуудыг шалгах;
- тусгай зөвшөөрлийн олголт;
- сайдын удирдлага;
- орон нутгийн хуваарилалт ба зарцуулалт;
- салбарын зардлуудыг харьцуулан жиших, орлогын хүрээнээс хальж түүний хуваарилалтыг шалгах зэрэг илүү өргөн хүрээг хамрах болж байна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх нь аливаа гэрээний чухал хэсэг байх хэрэгтэй байна.

Бүлэг 10. Монгол Улсын Засгийн газар ба Айвенхоу майнз монгол инк ХХК-ний хооронд хийх Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд хийсэн дүн шинжилгээ (хураангуй)

Засгийн газар Оюу толгойн ордыг ашиглах талаар Монгол Улсад бүртгэлтэй Айвенхоу Майнз Монгол Инк ХХК-тай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Улсын Их Хуралд танилцуулсан билээ. Энэхүү гэрээний төсөлд Нээлттэй Нийгэм Форум, Орлогын ажиглагч хүрээлэн хамтран 2007 оны 7 дугаар сард хийж, Улсын Их Хурлын ажлын хэсэгт өгсөн дүн шинжилгээг энэхүү бүлэгт авч үзэж байна.

Энд хоёр гэрээний тухай асуудал яригдаж байгаа. Эхний гэрээ нь Айвенхоу майнз монгол инк ХХК (цаашид «АММИ» гэх) Оюу Толгойн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанитай Засгийн газрын хийх Хөрөнгө оруулалтын гэрээ, харин хоёрдахь нь Виржиний Аралд үүсгэн байгуулагдсан, АММИ-ийн хувьцааны 66 хувийг эзэмших гадаадын компанитай Засгийн газрын хийх «хувь нийлүүлэгчдийн» гэрээ юм. Виржиний Арлын компанийг Айвенхоу Майнз Лимитед ба Рио Тинто групп эзэмшдэг. Хувь нийлүүлэгчийн гэрээнд АММИ-ийн 34 хувийг Засгийн газарт зарахаар заасан ба энэ өмчлөлтэй холбоотой Засгийн газарт үүсэх эрхийг зохицуулж өгсөн байна. Энэ хоёрдахь гэрээ нь Хөрөнгө оруулалтын гэрээг баталсан тохиолдолд л хүчин төгөлдөр болно.

Уг гэрээний төсөлд хамгийн их анхаарал татаж байгаа хоёр зүйл бол стратегийн орд газарт оруулах хөрөнгийн хэмжээгээр төр 34 хүртэл хувийг эзэмшиж болох Ашигт малтмалын тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх, мөн алт, зэсийн хувьд Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар буюу гэнэтийн ашгийн татвараас чөлөөлөхөөр байгаа явдал юм. Хуулийн холбогдох заалтын дагуу уг гэрээгээр тодорхой татварын түвшнийг тогтворжуулах ёстой хэдий ч үнэн

хэрэгтээ уг гэрээ нь өнөөгийн үйлчилж буй хуулийг хэд хэдэн чухал асуудлын хувьд өөрчилж байгаа гэж үзэхээр байна. Мөн Оюу Толгой ордын хувьд Засгийн газрын эдлэх эрхийг ихээхэн хязгаарласан байна.

Аливаа хөрөнгө оруулалтын гэрээнд үнэлгээ өгөх нь амаргүй ажил бөгөөд заримдаа зөрчилтэй сонирхлуудыг харьцуулан үнэлэх шаардлагатай болдог. Энэхүү гэрээ, мөн холбогдох хувь нийлүүлэгчийн гэрээний талаар дүгнэлт хийхэд нэн хүндрэлтэй байгааг дурдах нь зүйтэй болов уу. Гэрээний төслийн олон заалт нь нээлттэй орхигдсон, агуулга нь тэр бүр тодорхой бус, зарим заалт нь ямар зорилгоор хэрэглэх нь ойлгомжгүй байна. Гэрээ нь 30 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх тул энэ үед алт, зэсийн үнэ гэх мэт эдийн засгийн нөхцлүүд ихээхэн өөрчлөгдөх боломжтой юм. Цаашилбал, Засгийн газар тухайн гэрээ Монгол Улсын хувьд ямар ашиг өгөх талаар зарим тойм тоог зарласан ч үүнийг тооцсон өөрсдийн дүн шинжилгээг нийтэд ил болгоогүй учир зарласан тоог нягтлах, мөн эдгээр үр дүн нь ирээдүйг төсөөлсөн тодорхой эдийн засгийн нөхцлүүдээс хамааран хэрхэн өөрчлөгдөх талаар тодорхойлох боломж хязгаарлагдмал байна.

Энэхүү хураангуй дүн шинжилгээ болон түүний хавсралтуудыг Улсын Их Хурал тухайн гэрээг батлах эсэх талаар шийдвэр гаргахад туслах зорилгоор бэлтгэсэн болно. Дараахи материалыг хавсралтаар танилцууллаа.

Хөрөнгө оруулалтын гэрээ болон хувь нийлүүлэгчдийн гэрээний тодорхой зүйл, заалтуудтай холбоотойгоор хийсэн нарийвчилсан тайлбар, тавьсан асуулт, гаргасан санал. Үүнийг Хавсралт 6-аас үзнэ үү.

Засгийн газар өөрийн хөрөнгийг бусад салбарт бус уул уурхайд хувь нийлүүлэгчийн хэлбэрээр оруулахтай холбоотойгоор Монгол Улс илүү эрсдэл хүлээх талаарх хэлэлцүүлэгт зориулсан санал. Үүнийг Хавсралт 7-оос үзнэ үү.

Гэрээнүүдийн дүн шинжилгээ. Уг гэрээнүүдийн төслийн талаар өөрсдийн үнэлэлт дүгнэлтийг хийхийн өмнө Улсын Их Хурал хэд хэдэн хүчин зүйлсийг авч үзэх хэрэгтэй. Юуны өмнө Оюу Толгойг ашиглах шаардлагатай ба уг орд нь Засгийн газрын хувьд орлогын чухал эх үүсвэр, ялангуяа барилга байгууламж барих үе шатандаа томоохон ажил олгогч болох бөгөөд шаардлагатай хангамж нийлүүлэлтийг хийх салбаруудад хөрөнгө оруулалтыг татах, бусад төлөвлөгөөтэй уялдуулж чадсан тохиолдолд тээвэр, эрчим хүчний дэд бүтцийг хөгжүүлэхэд чухал түлхэц болох зэрэг чухал ач холбогдолтойг онцолж байна. Цаашилбал, нээлттэй хувьцаат компаниуд хөрөнгө оруулагчаар оролцох нь давуу тал гэж үзэж байна.²² «Нээлттэй» компаниуд өөрсдийн үйл ажиллагааны санхүүгийн болон бусад чухал мэдээллийг хөрөнгө оруулсан хувь хүмүүс болон олон нийтэд ил тайлагнах үүрэг хүлээдэг. Түүнчлэн Рио Тинто зэрэг уул

уурхайн томоохон компаниуд байгаль орчны болон бусад төрлийн олон тооны стандарт, хэм хэмжээг хүлээн зөвшөөрч ирсэн. Эдгээр нь уул уурхайн илүү зохистой туршлагыг, мөн тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд чиглэгдсэн байдаг.²³ Ийнхүү ач холбогдолтой, өгөөжтэй олон тал байгаа ч үүнийг өртөг зардалтай нь дэнслэн тооцох шаардлагатай.

Энэхүү хураангуйд Улсын Их Хурал авч үзэх шаардлагатай гэж үзсэн эдийн засаг, техник, институцийн талаархи тодорхой асуудлуудыг онцлон тэмдэглэж байна.

Гэрээ нь шударга болж чадсан уу? Хамгийн гол, үндсэн асуудал бол «Гэрээ нь шударга болж чадсан уу?» хэмээх асуулт юм. Монгол Улс өөрийн нөөц баялаг болох зэс, алтнаас хүртэх ашиг орлого, нөгөө талаас хөрөнгө оруулагчийн төлөх хөрөнгө, хийх менежмент, ашиглах технологи болон үүрэх эрсдлийнхээ төлөө хүртэж байгаа ашиг, орлого хоёр хэр зохистой харьцаанд байна вэ?

Зөвхөн өнөөгийн үйлчилж буй хууль тогтоомжийн заалтуудын дагуу хөрөнгө оруулалтын гэрээг Засгийн газар хийж болох юм. Ингэхдээ Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу татварын тогтвортой байдал болон бусад цөөн тооны баталгааг хангаж болно. Харин дээрх гэрээний төслүүд үүнээс хавьгүй давсан, илүү өргөн хүрээний «тогтвортой байдал»-ыг хангасан төдийгүй нийт үйлдвэрлэх зэсийн 40-өөд хувийг л боловсруулах хүчин чадалтай хайлуулах үйлдвэрийг таван жилийн дотор АММИ барих нөхцөлтэйгээр түүнийг алт болон зэсэд ногдох Гэнэтийн ашгийн татвараас бүрэн чөлөөлж байна. Энэ болон бусад хөнгөлөлттэй нөхцлийн хариуд хөрөнгө оруулагчид өөрсдийн хувь эзэмшлийн төлөө

²² «Нээлттэй» компани нь зохион байгуулалттай хөрөнгийн бирж дээр хувьцаа нь арилжигддаг, ийм хөрөнгийн биржийн хувьцаа арилжигдах болон мэдээллээр хангах шаардлагыг биелүүлэх ёстой компани юм. Ялангуяа том хөрөнгийн биржийн хувьд, тухайлбал Нью Йоркийн хөрөнгийн бирж, Лондонгийн хөрөнгийн биржийн хувьд мэдээллийг нийтэд ил тайлагнах шаардлага өндөр байдаг. Айвенхоу Майнз, Рио Тинто нь хэд хэдэн хөрөнгийн биржид бүртгэлтэй ч гэрээнүүдийн дагуу Монголд бүртгэлтэй компани нь аль нэг бирж дээр арилжигдах нөхцөл тавигдаагүй учир Монголд бүртгэлтэй компанийн хувьд мэдээллээ олон нийтэд ил тайлагнахгүй нь.

²³ АММИ-д хөрөнгө оруулсан компаниудын хувьд хяналтыг шилжүүлэх талаар гэрээнд хязгаарласан ямар нэг заалт ороогүй тул Рио Тинто, эсхүл Айвенхоу майнз Оюу Толгойн эзэд хэвээр үлдэнэ гэсэн баталгаа байхгүй байна.

төлж байгаа зардалтай адил үнээр Засгийн газрыг тодорхой хувь эзэмших боломжоор хангаж байна.²⁴ Гэрээ шударга болсон уу? гэдэг асуултад өгөх хялбар хариу байхгүй. Дараагийн бүлэгт эдийн засгийн хувьд хийж болох шинжилгээний нэг жишээг танилцууллаа. Зураг 1-д гурван тохиолдлын хувьд тухайн уурхайгаас Монгол Улсын хүртэх ашгийн хувь хэмжээг үзүүлсэн байгаа. Үүнд: 1) Өнөөгийн хуулийн дагуу ордыг ашиглах, гэхдээ төр ямар нэгэн хувь эзэмшихгүй, 2) Улсын Их Хуралд өргөн барьсан гэрээний төслийн дагуу, 3) Улсын Их Хуралд өргөн барьсан гэрээний төслийн дагуу, гэхдээ гэнэтийн ашгийн татварыг авах гэсэн гурван хувилбарыг ашигласан. Зэсийн үнэ фунт нь 2.00 доллар (тонн нь 4400 доллар) байхад хувь эзэмшихгүйгээр өнөөгийн хуулийг дагаж мөрдөх болон өргөн бариад буй гэрээний төслийн дагуу үйл ажиллагааг явуулах хоёр хувилбар Засгийн газарт өгөх орлогын хувьд ойролцоо дүнтэй байна. Үнэ уг түвшингээс доош байвал гэрээ нь ашигтай ба харин дээш байвал хувь нийлүүлэгчээр оролцохгүй байсан тохиолдолд ч өнөөгийн хууль тогтоомж илүү ашигтай байхаар байна. Гэхдээ энэ хоёр хувилбараас гуравдахь буюу уг гэрээний төслийг гэнэтийн ашгийн татвар ногдуулан ашиглах хувилбар илүү ашигтай байгаа нь ойлгомжтой.

Харин гэрээ нь сайн уу, муу юу гэдгийг зөвхөн өнөөгийн үйлчилж буй хуультай харьцуулан шийдвэрлэх боломжгүй юм. Өнөөгийн хуулийн дагуу гэнэтийн ашгийн татвар ба 34 хувийг төр эзэмших гэж байгаа нь хөрөнгө оруулагчийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй нөхцөл байж болох юм. Гэхдээ бас л өнөөгийн хуулийн дагуу хөрөнгө оруулагч хөрөнгө оруулахад шаардлагатай хэмжээнээс хавьгүй илүү ашиг олох боломжтой ч байж болох юм. Тухайлбал, зарим тохиолдолд

ашигт ажиллагааг үнэлэхэд ашигладаг Хөрөнгө оруулалтын дотоод өгөөжийн түвшинг бид дээрх хувилбаруудын хувьд тооцож үзэхэд Дэлхийн банкны судалсан уул уурхайд хөрөнгө оруулалт хийхэд шаардагдах өгөөжийн түвшнээс наад зах нь хоёр дахин их буюу 40 хувиас дээш хэмжээний өгөөжтэй байна.

Гэнэтийн ашгийн татвараас чөлөөлөхөөр байгааг тусгай асуудал болгон авч үзэх шаардлагатай. Өнөөгийн үйлчилж буй хуулийн дагуу Монголд цэвэршүүлэх зэсийн баяжмалын хувьд энэ татвараас чөлөөлөхөөр байгаа ч хайлуулах үйлдвэр барихаас өмнө экспортлох, эсхүл хайлуулах үйлдвэр байгуулсны дараа ч цэвэршүүлэхгүйгээр шууд экспортолж болох зэсийн баяжмалд уг чөлөөлөлт хамаарахгүй юм. Харин тус гэрээний төсөлд зэсийн тодорхой хэсгийг л хайлуулж, цэвэршүүлэх хайлуулах үйлдвэрийн төлөө Засгийн газар алт болон зэсээс авах ёстой гэнэтийн ашгийн бүх татвараас татгалзаж байна.

Бусад асуудлууд. Ерөнхий эдийн засгийн тооцооноос гадна Улсын Их Хурал хэд хэдэн асуудлыг авч үзэх ёстой гэж үзэж байна.

Хэт өргөн хүрээтэй тогтворжилт. Өнөөгийн хуулийн дагуу зөвхөн татваруудыг л тогтворжуулахыг зөвшөөрсөн байтал дээрх гэрээний төслийн дагуу бүх хууль тогтоомжийг, түүний дотор Оюу толгойтой холбоотой ус, нохойн татварын хувь хэмжээг хүртэл тогтворжуулж буюу «царцааж» байна. Энэ гэрээ нь 30 жилийн хугацаатай байна. Ийм хугацаанд гэрээнд заасан хэмжээнд тогтворжилтыг хангах нь зохистой юу? Шаардлагатай юу? Ийм хэт өргөн хүрээтэй тогтворжилт нь өнөөгийн хуультай зөрчилдөхөөс гадна бусад улс оронд ч хэрэглэгддэггүй туршлага юм.

Өмчлөгчид өөрчлөгдөх явдал. Рио

²⁴ Зарим хүмүүсийн хэлж байгаагчлан төрийн эзэмших хувь нь «үнгэгүй» биш юм. Засгийн газар ирээдүйд хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх хүсэлтийн дагуу өөрт ногдох хувийг төлөх шаардлагатай ба энэ хөрөнгийн зарим хэсгийг өнөөг хүртэл авсан зээл зэргийг ч нөхөн төлөхөд зарцуулж болох юм. Тиймээс хөрөнгө оруулагчийн нэгэн адил өөрийн эзэмших хувийн төлөө төлбөр төлөх нь. Цаашилбал гэнэтийн ашгийн татвараас чөлөөлөх зэрэг бусад хөнгөлөлтийг ч дээр нь нэмж өгч байж хувь эзэмших эрхийг авч байгааг анхаарах хэрэгтэй.

Тинто-ийн хувьд дэвшилттэй, нэр хүндтэй олон улсын компани. Гэхдээ гэрээнд Айвенхоу майнз, эсхүл Рио Тинто өөрсдийн хувийг өөр хөрөнгө оруулагчдад (бусад орны иргэдэд, хувийн хөрөнгө оруулалтын сангуудад г.м.) шууд бус замаар борлуулах явдлыг хязгаарласан заалт огт байхгүй байна. АММИ-ийн хувьцааг зарах эрх хязгаарлагдмал байгаа ч Виржиний Аралд бүртгэлтэй толгой компанийн хувьцааг борлуулах замаар өөрсдийн хувийг бусдад шилжүүлэх бүрэн боломжтой. Монгол Улсын зөвшөөрөлгүйгээр ийнхүү өмчлөгч солигдох нь Монгол Улсын үндэсний эрх ашигт нийцэх үү?

Тодорхой бус асуудлууд. Дэд бүтэц, байгаль орчин болон бусад хөгжлийн зорилгод хамаарах чухал асуудлыг ирээдүйд тохиролцохоор нээлттэй үлдээсэн байна. Хөрөнгө оруулалтын гэрээг нэгэнт байгуулсан тохиолдолд улс орны хөгжилд чухал ч Айвенхоу-ийн хувьд өртөг зардалтай асуудлаар өөрийн байр суурийг хүлээн зөвшөөрүүлэх Засгийн газрын боломж багасна. Ийм асуудлуудыг нээлттэй орхих нь зөв үү? Ер нь Монгол Улс үнэхээр хэдий хэмжээний ашиг хүртэх явдалд тодорхойлох нөлөөтэй олон нарийн асуудал байна. Ийм асуудлуудыг Хавсралт 6-д танилцууллаа.

Ил тод байдал. АММИ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг хянах тул Рио Тинто ба Айвенхоу майнз нь компанитай холбоотой аливаа мэдээллийг ил тод тайлагнах асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй. Хувь нийлүүлэгчдийн гэрээнд Монгол Улсын хуулийн дагуу ил тайлагнах шаардлагатай зүйлсийн талаар ч тусгайлан оруулж өгөөгүй байна. Засгийн газрыг төлөөлөх төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд тодорхой хэмжээний мэдээлэл авах эрхтэй ч түүнийгээ хөрөнгө оруулагчдын зөвшөөрөлгүйгээр Улсын Их Хурал, эсхүл олон нийттэй хуваалцах эрхгүй байна. Оюу толгойн ач холбогдлыг бодолцвол АММИ нь хаалттай бус нээлттэй хувьцаат компанийн нэгэн адилаар санхүүгийн болон бусад материаллаг мэдээллийг ил тайлагнах шаардлагыг тавих

нь зохистой ба уг гэрээ нь Монголын хуулиас дээгүүр эрхтэй байх ёсгүй.

Илүү их эрсдэл хүлээх явдал. Ихээхэн яригдаж, дэмжигдэж байгаа ч Монгол Улс хувь эзэмших нь ирээдүйд Засгийн газрын үүрэх эрсдлийг нэмэгдүүлж байгаа юм. Ногдол ашгаар эргэн төлж байгаа тул хувь эзэмших нь үнэ өртөггүй зүйл биш. Ирээдүйд үндсэн хөрөнгөд хийх хөрөнгө оруулалтын өөрт ногдох хувийг Монгол Улс төлөх учиртай. Ингэх нь хөгжлийн бусад зорилгоор зарцуулах байсан нөөц хөрөнгийг хувь эзэмшихэд зориулахад хүргэнэ гэсэн үг ба Монгол Улсын үүрэх эрсдлийг нэмэгдүүлэх болно. Монгол Улс өнөөдөр ч уул уурхайгаас ихээхэн хамааралтай байгаа бөгөөд өөрийн уул уурхайгаас олох орлогоос уул уурхайд хөрөнгө оруулахаар байгаа нь уг салбар, уул уурхайн бүтээгдэхүүний үнээс бүр ихээр хамааралтай болоод зогсохгүй эдийн засаг болон нөөц хөрөнгөө олон салбарт тархааж, эдийн засгаа төрөлжүүлэх бодлогыг хэрэгжүүлж чадахгүйд хүргэнэ. Энэ асуудлыг Хавсралт 7-д авч үзлээ.

Энд дурдсан болон бусад бүх асуудлыг Хавсралт 6-д дэлгэрэнгүй хөндсөн байгаа болно.

Бусад хувилбар, сонголтууд. Хэрэв уг гэрээний төслийг Улсын Их Хурал батлахгүй гэж шийдвэл Засгийн газар болон хөрөнгө оруулагчийн эрх ашгийн илүү тэнцвэрт харьцааг олоход чиглэсэн хувилбарыг, ялангуяа уул уурхайн татварын дэглэмийн өөр боломжит хувилбаруудыг авч үзэж болох юм. Энд ашиглаж болох боломжит хувилбаруудын багцыг Бүлэг 14-т бичив. Уг бүлэгт нөөц ашигласны болон орлогын татварын суурийг тогтооход шийдвэрлэх үүрэгтэй элементүүдийг илүү сайн тодорхойлж өгсөн болно. Мөн үнэ өндөр буюу ашиг ихтэй үед хэрэглэж болох нэмэлт татваруудын хоёр боломжит хувилбарыг танилцуулсан болно. Аль ч хувилбар нь нэмэлт татвар хэрэглэхээс өмнө хөрөнгө оруулалтаа нөхөж авах боломжийг хөрөнгө оруулагчид олгох зорилготой. Үүний эхнийх

нь гэнэтийн ашгийн шинэчилсэн татвар байж болно. Одоогийн гэнэтийн ашгийн татвараас ялгаатай нь, хөрөнгө оруулалтын эхний үе шатанд үйлчлэхгүй бөгөөд ашиглалт явагдаж эхэлснээс тодорхой хугацааны дараа, эсхүл хөрөнгө оруулалтаа тодорхой хэмжээнд нөхсөний дараа үйлчлэх татвар байж болох юм. Хоёрдахь хувилбар нь нөөцийн рентын татвар байх ба энэ тохиолдолд бэлэн мөнгөний урсгал дээр суурилан тооцоход хөрөнгө оруулалтдаа багагүй хэмжээний ашиг олсон тохиолдолд л татвар үйлчилж эхэлнэ.

Ийм татварыг зөвхөн хөрөнгө оруулагч тодорхой хувь хэмжээний ашиг хүртсэний дараа ногдуулах юм. Яг хэзээ татвар үйлчилж эхлэхийг нэг бүрчлэн тохиролцох, эсхүл тогтмол хэмжээнд тогтоох, мөн томъёогоор тооцох, үүнийгээ хуульчлах боломжтой. Мөн тодорхой өрсөлдөөнт нөхцөл байдалд хамгийн бага өгөөж буюу ашгийн түвшинг шаардсан хөрөнгө оруулагчдад тодорхой төслийг хэрэгжүүлэхээр өгөх зарчмыг баримталж болох юм.

Бүлэг 11. Оюу толгойн ордыг ашиглах гэрээний төсөлд хийсэн эдийн засгийн жишиг дүн шинжилгээ

Оюу толгойн орд газрыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл нь бусад сонголттой харьцуулахад ямар давуу болон сул талтай болох, Монгол Улс болон хөрөнгө оруулагчийн олох ашгийн хэмжээнд эдийн засгийн холбогдох үзүүлэлтүүд ямар нөлөөтэй байх, мөн ашиг орлогод эрсдэл хэрхэн нөлөөлөх зэргийг ойлгоход уг гэрээний төслийн санхүүтэй холбоотой асуудалд зарим дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай. Мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргахад ямар бэлтгэл ажил хийсэн байж болох талаар зарим дүн шинжилгээ хийснийг үүгээр танилцуулж байна.

Энэхүү дүн шинжилгээг жишиг гэж нэрлэж байгаа учир нь хэд хэдэн нөхцлийг төсөөллийн хэмжээнд, мөн зөвхөн олон нийтэд ил байгаа мэдээллийг ашигласантай холбоотой. Урьтал нөхцөл, өгөгдлийн хязгаарлалтад анхаарал хандуулж байгаагийн учир нь аливаа асуудлаар нэгдмэл ойлголттой байх үүднээс Улсын Их Хурал болон иргэд Засгийн газраас ийм төрлийн мэдээллийг гаргуулан авах шаардлагатай байгаа явдал юм. Хэдийгээр энэ дүн шинжилгээ нь жишиг хэлбэртэй ч хэд хэдэн чухал асуудлыг хөндөн тавьж байгаа ба гэрээ байгуулах оновчтой шийдвэрийг гаргах байтугай мэдээлэлд тулгуурласан аливаа хэлэлцүүлгийг өрнүүлэхийн өмнө эдгээр асуудлын хариуг авсан байх ёстой гэж үзэж байна. Ийм асуудалд:

- Тодорхой тооцоонуудыг хэрхэн гүйцэтгэх талаар тайлбар авах (жишээлбэл, нөөц ашигласны төлбөрийг тооцоход);
- Монгол Улс болон хөрөнгө оруулагчийн байр сууринаас хандахад хайлуулах үйлдвэр ба цахилгаанаар хангах хувилбарууд төслийн санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлөхийг тодруулах;
- Монгол Улс хувь нийлүүлэгчээр оролцох оролцоогоо санхүүжүүлэх болон дотооддоо хайлуулах үйлдвэр барих

болсноос ашигт малтмалын үнийн хэлбэлзлийн эрсдлийг илүү их хэмжээгээр үүрэх ба үүнийгээ хэрхэн зохицуулах;

- Төслийн үйл явцад мониторинг хийх Монгол Улсын чадавхи ямар хэмжээнд байгаа ба хэрэгжүүлэх чадавхитай холбоотой аливаа хязгаарлалтуудыг хэрхэн шийдвэрлэх;
- Хувь нийлүүлэгчээр оролцоход шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг өөрөөр зарцуулах ямар сонголт Монгол Улсын хувьд байгаа зэрэг орно.

Дүн шинжилгээний агуулга. Таван гектар газар өмчилж байгаа хүнд дараахи саналыг тавьсан гэж үзье. Энэ санал нь «Та газраа надад зарвал би 100,000 төгрөг өгье. Дээр нь ирэх 10 жилийн турш үйлдвэрлэх тарианы үнийн 10 хувийг өгье» гэсэн утгатай. Мэдээж энэ санал нь дангаараа ямар нэгэн утга агуулга үгүй бөгөөд уг саналыг сайн наймаа гэж шийдэхэд тодорхой нөхцөл байдлын хүрээнд авч үзэх шаардлагатай. Ийм нөхцөл байдлыг дараахи байдлаар тодорхойлно:

- Сонголт хувилбаруудыг жагсаах (тухайлбал, газрыг өөрөө боловсруулж ашиглах, газрыг байшин барихад зориулж зарах, эсхүл газрын үнэ ирээдүйд

нэмэгдэнэ гэж найдан газрыг ямар нэгэн байдлаар ашиглахгүй орхих г.м.);

- Тухай санал болон хувилбаруудын мөнгөн үнэ цэнийг тооцож үзэх;
- Тухайн санал болон хувилбаруудын өнөөгийн үнэ цэнийг тооцож үзэх;
- Зарим нэгэн мэдрэмжийн (эсхүл эрсдлийн) дүн шинжилгээ хийж, эдийн засгийн төрөл бүрийн хүчин зүйлс эцсийн үр дүнд хэрхэн нөлөөлөх талаар ойлголттой болох.

Тиймээс ийм дүн шинжилгээг Оюу Толгой ордын хувьд жишээ болгон танилцуулж байна. Тухайлбал:

- Санал болгоод байгаа гэрээний төслийг өөр нэг хувилбар буюу өнөөгийн үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд явагдаж болох төсөлтэй хийсэн харьцуулалт;
- Хөрөнгө оруулагч болон Монгол Улсын хувьд уурхай нь ямар мөнгөн үнэ цэнэтэй болохыг гэрээний хугацааны хувьд харуулсан тооцоо;
- Сонголт тус бүрийн өнөөгийн үнэ цэнийн тооцоо;
- Хувилбаруудын мөнгөн дүн, эрэмбэ дэс дараад үнэ, зээлийн хэмжээ, хүүгийн түвшин зэрэг хүчин зүйлс хэрхэн нөлөөлөхийг харуулсан тооцоо зэргийг танилцуулж байна.

Урьтал нөхцөл. Хавсралт 4-д энэхүү дүн шинжилгээнд ашигласан төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийг танилцуулав. Өнөөгийн үйлчилж буй хууль, санал болгож буй гэрээ хоёрын бүтцийг харьцуулсан байдлаар харуулав. Монгол Улс ирээдүйд хийгдэх хөрөнгийн зарцуулалтад эзэмших хувь хэмжээгээрээ хөрөнгө оруулах шаардлагатай, гэнэтийн ашгийн татвараас чөлөөлж байгаа, хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт үзүүлж байгаа, алдагдлыг ирэх 5 жилд шилжүүлж байгаа зэрэг талаараа хууль, гэрээ хоёр зөрүүтэй байгааг онцлон тэмдэглэж байна.

Хавсралт 8-д жишиг үр дүнг тооцон

гаргахад ашигласан урьтал нөхцлүүдийг танилцуулсан. Дараахи хүчин зүйлсийг онцолж байна:

- Олборлолт болон хөрөнгө оруулалтын хэмжээг гэрээний төслийн холбогдох заалтаас авсан;
- Дүн шинжилгээний хамрах хугацаа нь гэрээний хүчинтэй үйлчлэх хугацаа байна;
- Өртөг, орлогын бүтцийн хувьд Айвенхоу-ийн 2005 онд нийтэлсэн Орд ашиглалтын цогцолбор төлөвлөгөөний Гүйцэтгэлийн хураангуй-д үндэслэсэн;
- Уурхайн ашиглалтын өнөөгийн үнэ цэнэ нь цахилгаан эрчим хүчийг хэрхэн хангах, хайлуулах үйлдвэр байгуулагдах эсэхээс хамаарахгүй байхаар төсөөлсөн. Өөрөөр хэлбэл, уурхайн үнэлгээ нь цахилгааны эх үүсвэр, хайлуулах үйлчилгээний нийлүүлэлтээс хамаарахгүй;
- Дотоодын хайлуулах үйлдвэрийн болон эрчим хүчний үйлдвэрлэлийн өргөтгөлийн өнөөгийн үнэ цэнэ тэгтэй тэнцүү байна. Өөрөөр хэлбэл, энд зөвхөн уурхайн ашиглалтыг л авч үзэж байгаа. Хайлуулах үйлдвэр болон эрчим хүчний нийлүүлэлтийн аливаа сонголтуудыг үнэлэхэд тусдаа дүн шинжилгээ хийх шаардлагатай.

Гурван сонголт, хувилбарыг энд авч үзэж байгаа болно:

- Өнөөгийн хууль тогтоомж;
- Санал болгож буй гэрээ;
- Санал болгож буй гэрээ, гэхдээ гэнэтийн ашгийн татварыг ногдуулах хувилбараар (дотоодын хайлуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн, борлуулалтад ногдуулахгүй ч шууд экспортлож байгаа баяжмалд ногдуулах хувилбар).

Суурь кейс

а. Энэхүү дүн шинжилгээг хийхэд нэгэн кейс буюу тохиолдлыг суурь кейсийг төлөөлүүлэхээр сонгон авав. Суурь кейсийн

үр дүнг тооцохын тулд дараахи нэмэлт нөхцлүүдийг тавьсан:

- Зэсийн үнэ = нэг фунт нь 2.00 ам доллар
- Алтны үнэ = унц нь 500 ам доллар
- Хүүгийн түвшин = 10 хувь
- Инфляцийн түвшин = 0 хувь
- Зээлийн хэмжээ = 10 хувийн хүүтэйгээр хөрөнгийн 50 хувийг зээлээр санхүүжүүлсэн

б. Энэхүү суурь кейсийн хувьд тооцсон үр дүнг Хавсралт 9-т үзүүлсэн болно.

- Хавсралтад харуулснаар гэрээ байгуулах нь өнөөгийн мөрдөгдөж байгаа хуулийн дагуу төслийг хэрэгжүүлэх хувилбартай харьцуулахад Монгол Улсад ногдох өнөөгийн цэвэр үнэ цэнийн хувьд бараг нөлөө үзүүлэхгүй байна. Харин санал болгож буй гэрээг Гэнэтийн ашгийн татварыг авахаар гүйцэтгэсэн тохиолдолд 6 хувийг Монголын талд шилжүүлж байна.
- Дунджаар тооцвол, хөрөнгө оруулагчийн ашгийн түвшин (төслийн дотоод өгөөжийн түвшинээр тооцвол) гэрээ байгуулах хувилбарын хувьд нэмэгдэж байна (40 орчим хувиас бараг 54 хувь хүртэл).²⁵ Харин гэрээг гэнэтийн ашгийн татварыг авахаар байгуулбал хөрөнгө оруулагчийн ашгийн түвшин 42 хувь хүртэл буурч байна. Хэдийгээр Монгол Улсын авах

бэлэн мөнгөний урсгал илүү их байгаа ч цаг хугацааны хувьд энэ урсгал нь төслийн сүүлийн жилүүдэд орж ирэхээр байгааг энэ нь илтгэнэ. Үүний шалтгаан нь олон байж болох ч гэнэтийн ашгийн татварыг эхний жилүүдэд авахгүй байгаа, мөн төр хөрөнгө оруулалтын өөрт ногдох хувь хэмжээг санхүүжүүлэх шаардлагатай учир сөрөг утгатай бэлэн мөнгөний урсгалтай тулгарах явдал юм. Сүүлд орж ирэх бэлэн мөнгө нь илүү эрсдэлтэй. Тиймээс бусад зүйл өөрчлөгдөөгүй байгаа тохиолдолд Монгол Улс үүрэх нэмэлт эрсдлийн хэмжээний талаар сонголт хийх шаардлагатай байж болох юм.²⁶

в. Нэгтгэн дүгнэхэд, дээрх нөхцлүүд хангагдах үед гэрээ байгуулах нь Монгол Улсын хувьд ашигтай байна. Гэхдээ эдгээр нөхцөл үүсч, ашиг уг хэмжээнд байх магадлал тэгтэй тэнцүү гэж хэлж болно. Тиймээс нөхцөл байдлыг улам тодорхой тусгах үүднээс мэдрэмжийн зарим нэгэн дүн шинжилгээ хийх шаардлагатай.

Зарим дүн шинжилгээ

Нийт төсөл. Ашиг, алдагдал нь хоёр талд хэрхэн хуваарилагдан очихыг тооцохгүйгээр нийт төслийн хувьд зарим үзүүлэлтийн доод хязгаарыг тодорхойлох зорилгоор хоёр туршилтыг хийлээ. Эдгээр доод хязгаарын

²⁵ Төслийн дотоод өгөөжийн түвшинг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах хэрэгсэл болгон ашиглахад хэд хэдэн хязгаарлагч нөхцлүүдийг тавих шаардлагатай. Мөн бэлэн мөнгөний урсгалын бүтцээс хамааран тухайн ордын хувьд дотоод өгөөжийн түвшин цорын ганц утгатай байхгүй. Энд тооцсон үр дүнг бусад утгыг хайхгүйгээр компьютерийн програмаар гаргасан. Төслийн дотоод өгөөжийн түвшин нь дээр дурьдсан чухал хязгаарлалтуудтай ч Монгол Улсын хувьд мөнгө хэзээ орж ирэх талаархи дүгнэлтүүд бол эргэлзэх зүйлгүй юм. Хайлуулах үйлдвэр баривал гэнэтийн ашгийн татвараас чөлөөлөх тул татварын орлого цаг хугацааны хувьд хойшилж байгаа юм. Харин хайлуулах үйлдвэрийг цаг хугацаанд нь барьж чадахгүй бол хөрөнгө оруулагчид сөрөг нөлөөтэй дүн гарна.

²⁶ Хөрөнгө оруулалтын 34 хувийг санхүүжүүлэх тул төслийн эхний жилүүдэд сөрөг бэлэн мөнгөний урсгал гарах учраас Монгол Улсын хувьд дотоод өгөөжийн түвшинг гэрээний төслийн хувилбарын хувьд тооцох боломжтой юм. Уг хувь нь 76 хувиас илүү байгаа ч үүнд ач холбогдол өгч болохгүй. Учир нь өнөөгийн хуулийн хувилбарын хувьд Засгийн газар (санхүүгийн утгаар) ямар нэгэн бэлэн мөнгө гаргахгүй тул дотоод өгөөжийн түвшин хязгааргүй их байна. Тиймээс гэрээ байгуулснаар Монгол Улсын хувьд дотоод өгөөжийн түвшин харин ч буурч байгаа юм. Энэ нь дотоод өгөөжийн түвшин ашигт ажиллагааны хэмжүүр болдоггүй бас нэг шалтгаан юм. (Эдгээр абсолют утгатай тооцоог хийхдээ газар доорх нөөц баялгийн алдагдсан боломжийн өртөг тэгтэй тэнцүү гэж үзэж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Хөрөнгийг энэ зорилгоор ашигласнаар Монгол Улс үнэн хэрэгтээ ихээхэн боломжийг алдаж байгаа.) Бүрэн дүн шинжилгээ хийхийн тулд энэхүү алдагдсан боломжийн өртгийг ямар нэгэн байдлаар тусгах шаардлагатай болно.

үзүүлэлтүүд биелээгүй тохиолдолд аль нэг тал уг төсөлд хөрөнгө оруулахгүй тул уг мэдээлэл ихээхэн тустай юм.

Доод үнэ. Эрсдлийн нэг үзүүлэлт бол төслийн өнөөгийн үнэ цэнэ тэгээс доош байх үнийг тооцох явдал юм. Дээрх нөхцлүүд биелсэн тохиолдолд энэ үнийг 0.42 доллар байх тооцоог хийлээ. Энэ үнэ нь боловсруулсан зэсийн өнөөдрийн (spot) үнээс хамаагүй доогуур байгаа ч уг төсөл урт хугацаанд хэрэгжих ба дэлхийн зэсийн зах зээлийн үнийн хэлбэлзлийн түүхийг бодолцвол огт байж болохгүй үнэ биш юм.

Үнэ өсөх хэрээр зардал өснө. Үнийн ерөнхий инфляци нь төслийн өнөөгийн нийт үнэ цэнэд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй. Харин өнөөгийн үнэ цэнэд харьцангуй үнийн өөрчлөлт нөлөө үзүүлэх юм. Тухайлбал, цалин хөлс, бусад орцын өртөг ерөнхий инфляциас илүү хэмжээгээр өсөх боломжтой. Тиймээс өртөг зардлын харьцангуй өсөлтийн ямар түвшинд өнөөгийн үнэ цэнэ сөрөг дүнтэй болох вэ гэдэг асуулт сонирхол татаж байгаа юм. Энэ хэмжээ дээрх нөхцлүүдийн хувьд 10.5 хувь байхаар тооцлоо. Татвар, санхүүгийн нөхцөл, эсхүл ашиглах технологи өөрчлөгдөхгүй тохиолдолд өртөг зардлын инфляци өндөр байх тохиолдолд ойролцоогоор 15 жилийн дараа өртөг зардал борлуулалтын орлогоос давах тул уурхайг хаах шаардлагатай болох юм.

Харьцуулсан дүн шинжилгээ. Үнэ, санхүүжилтийн бүтэц, хүү гэх гурван хүчин зүйлсийн мэдрэмжийн шинжилгээг бидний авч үзэж буй гурван хувилбарын хувьд харьцуулсан эрэмбэ чансаад нь хэрхэн нөлөөлөхийг судлах үүднээс гүйцэтгэлээ. Тухайн хүчин зүйл тус бүр өөрчлөгдөхөд Монгол Улсад ногдох өнөөгийн үнэ цэнийн хувь хэмжээ хэрхэн өөрчлөгдөж байгааг энд харуулсан болно. Эдгээр хүчин зүйл өөрчлөгдсөнөөр талуудад хуваарилагдаж байгаа өнөөгийн үнэ цэнийн хувь хэмжээ шилжин өөрчлөгдөж байгаа юм. Нийт үнэ цэнийг тооцсон тохиолдолд Монгол Улсад

чухам ямар хувь нь ногдох нь тухайн татвар, санхүүгийн орчноос хамааралтай. Тиймээс ч Монгол Улсад ногдох өнөөгийн үнэ цэнийн хувь хэмжээг ашиглах нь бидний тавьсан асуултын хувьд бодитой үзүүлэлт болох юм.

Үнийн өөрчлөлт. Дээрх нөхцлүүдийн хувьд зэсийн үнэ 0.42 ам доллараас доош түвшинд очвол аль ч тал Оюу Толгойд хөрөнгө оруулахгүй гэж дээр тооцсон. Энэ үнээс дээш үнэ тогтсон тохиолдолд үнэ нэмэгдэх тусам Монгол Улсад ногдох өнөөгийн үнэ цэнийн хувь хэмжээ нэмэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл, үнэ өсөх тохиолдолд татвар, санхүүгийн тогтолцооноос үл хамааран хөрөнгө оруулагчтай харьцуулахад Монгол Улсын хувьд илүү ашигтай байх болно. Өнөөгийн хууль тогтоомж үйлчлэх хувилбарын хувьд үнэ өсөхөд Засгийн газар ашгийн илүү их хувь хэмжээг гэнэтийн ашгийн татвараас авах болно. Учир нь уг татварын хувьд зардал хувьсахгүй байгаа. Санал болгоод буй гэрээний хувьд, мөн өнөөдрийн хууль үйлчлэх хувилбарын хувьд нөөц ашигласны төлбөр болон ашгийн татвар Монгол Улсад ногдох хувь хэмжээг нэмэгдүүлж байна. Бүтээгдэхүүний үнэ 10 хувиар нэмэгдэхэд зардал тогтмол байна гэвэл татвар ногдох ашгийг 10-аас илүү хувиар нэмэгдүүлэх тул үнэ өсөхөд хөрөнгө оруулагчтай харьцуулахад Засгийн газарт илүү ашигтай байх болно.

Үнэ өөрчлөгдөхөд гурван хувилбарт ямар өөрчлөлтүүд гарахыг Зураг 1 болон Хавсралт 10-т үзүүлсэн болно. Үнэ харьцангуй доогуур түвшинд байхад гэрээ хийх хоёр хувилбар нь өнөөгийн хууль үйлчлэх хувилбараас илүү байхаар байгаа ч үнэ өндөр болоход үр дүн нь эсрэг буюу өнөөгийн хуулийн дагуух хувилбар илүү болж байна. Үүний учир нь үнэ өндөр түвшинд байхад өнөөгийн хуулийн дагуу хувь нийлүүлэгчээр төсөлд оролцох явдалтай харьцуулахад гэнэтийн ашгийн татвар пропорциональ бус түүнээс илүү хувь хэмжээгээр Монгол Улсад ашиг өгөх болно. Харин гэнэтийн ашгийн татвар авах гэрээний

²⁷ Эдийн засгийн эерэг өсөлтийн нэг үзүүлэлт бол бодит цалин хөлсний нэмэгдэл юм.

хувилбарын хувьд уг ашиг багасч, цаашилбал гэнэтийн ашгийн татвараас чөлөөлөх тохиолдолд уг ашиг үндсэндээ байхгүй болж байна.

Санхүүжилтийн бүтцийн өөрчлөлт. Зээлийн хэмжээ нь Монгол Улсад ногдох ашгийн хэмжээнд хоёр замаар нөлөөлнө. Нэгд, ашгийн татвараас хүүгийн төлбөрийг хасч тооцдог. Хоёрт, гэрээг батлах юм бол Монгол Улс хөрөнгө оруулалтын харьцангуй бага хувийг санхүүжүүлэх шаардлагатай болох ба учир нь уурхайг ашиглах дотоодын компанид зээл олгогдох юм. Гэхдээ ирээдүйд зээлийн хүү болон үндсэн төлбөрийг хийх шаардлагатай болно. Ерөнхийдөө бол зээлийн өртөг нь хувь нийлүүлэх (өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх) өртгөөс бага байгаа тохиолдолд зээл авахыг зорих болно.

Санхүүжилтийн бүтэц дэх өөрчлөлтийн үр нөлөөг Зураг 2 болон Хавсралт 11-т үзүүлээ. Ашгийн татвар буурах тул аль хувилбар байгаагаас үл хамааран Монгол Улсад ногдох хувь хэмжээ буурч байна.

Хорогдуулах хувь хэмжээний (Discount Rate) өөрчлөлт. Тухайн хөрөнгө оруулагчийн эрсдэл хүлээх сонирхол, өмч хөрөнгийн хэмжээ, бусад хүчин зүйлээс хамааран хүлээн зөвшөөрөх хорогдуулах хувь хэмжээ янз бүрийн түвшинд байна. Монгол Улсын хувьд санхүүгийн урсгалыг хорогдуулан тооцох ямар хувь хэмжээг ашиглаж байгааг бид мэдэхгүй байна. Тиймээс суурь кейсийн бусад нөхцлийг өөрчлөхгүйгээр хорогдуулах хувь хэмжээг өөрчлөн зарим нэгэн тооцоог хийлээ. Эдгээрийн үр дүнг Зураг 3 болон Хавсралт 12-д үзүүлээ. Хорогдуулах хүүгийн түвшин нэмэгдэхэд өнөөгийн хууль үйлчлэх хувилбартай харьцуулахад гэрээний аль аль хувилбарын харьцангуй давуу талууд байхгүй болж байна.²⁸ Тиймээс хүүгийн түвшин доогуур байхад санал болгож буй гэрээ илүү

ашигтай ч хүүгийн түвшин нэмэгдэх хэрээр, гэхдээ 12 хувиас доогуур байхад өнөөгийн хууль үйлчлэх хувилбар нь илүү ашигтай, харин түүнээс хүүгийн түвшин цааш өсвөл, гэхдээ 20 хувь хүртэл хэмжээнд байвал, гэнэтийн ашгийн татварыг авах гэрээний хувилбар илүү ашигтай болж байна.

Гэрээний хувилбарыг өнөөгийн хуулийн хувилбартай харьцуулахад ирэх орлого хугацааны хувьд цаашилж байгааг энэ үр дүн илтгэж байгаа. Гэрээ байгуулснаар эхний жилүүдэд Монгол Улсад орох орлогын хэмжээ буурч байгаа ба энэ нь хэд хэдэн шалтгаантайн дотор гэнэтийн ашгийн татвараас чөлөөлөх, илүү урт хугацаагаар алдагдлыг дараагийн жилүүдэд шилжүүлэх, хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт олгох, мөн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх шаардлага зэрэг бусад нөхцөл үүсч байгаатай холбоотой. Хувь нийлүүлэгчээр төсөлд оролцож байгаа тул төслийн сүүлийн жилүүдэд орох орлогын хэмжээ нэмэгдэж байгаа. Тиймээс тодорхой сонголт хийхэд хорогдуулах ямар хувь хэмжээг ашиглаж байгаагаас үр дүн хамаарах болно. Хорогдуулах хувь нь 12-оос дээш болбол Монгол Улсын хувьд өнөөгийн хууль үйлчлэх хувилбартай харьцуулахад гэрээ сонирхол татахуйц байхаа болих болно (харин гэнэтийн ашгийн татварыг авах гэрээний хувилбарын хувьд 20 хувь орчим). Тиймээс эрсдлийг тооцсон эдгээр хүүгийн түвшин хэт өндөр үү, эсхүл хэт доогуур уу гэдэгт хариу авах нь чухал. Хөрөнгийн биржийн ашгийн хувь хэмжээг үндэслэн нэг хариу өгч болох юм. Рио Тинто болон Айвенхоу-ийн хүлээгдэж буй ашгийн тооцоо тус бүр 20.90 хувь ба 22.46 хувь байна.²⁹ Олон улсын зах зээлийн хувьд дундаж ашгийн түвшин 14.62 хувь байгаатай үүнийг харьцуулж болно. Харин эдгээрийн хоорондын зөрүү нь уул уурхай нь бусад эдийн засгийн хөрөнгө оруулалттай харьцуулахад

²⁸ Гэрээний хувьд үнэ цэнэ нь нэмэгдэж байгаа нь энд хамаагүй юм. Учир нь боломжит бүх хувилбарын хувьд гэрээний хувьд өөрчлөлтийн хувь өнөөгийн хуулийн хувилбарынхаас үргэлж доогуур түвшинд байна. Боломжит хувилбар гэдэгт эерэг өнөөгийн үнэ цэнэтэй тохиолдлыг хэлнэ. Хүүгийн түвшин 40 хувиас дээш болоход төслийн өнөөгийн үнэ цэнэ сөрөг дүнтэй болж байна.

илүү эрсдэлтэй болохыг илэрхийлэх ба хөрөнгө оруулагчид уг эрсдлийг үүрэхийн тулд илүү ашиг авахыг хүсдэгтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, бусад нөхцөл өөрчлөгдөхгүй тохиолдолд хорогдуулах нэрлэсэн хувь 20 хувь орчим байхад өнөөгийн үнэ цэнэ нь тэгээс бага төсөлд аль нэг компани хөрөнгө оруулбал түүний хувьцааны үнэ буурах болно.³⁰

Дээрх уул уурхайн компаниудын хувь эзэмшигчидтэй харьцуулахад Монгол Улсын эрсдэлхүлээхчадвархарьцангуйдоогуурбайх хэд хэдэн шалтгаан байж болно: 1) Монгол Улс 2.5 сая хүн амтай, 2) Монголын эдийн засаг дэлхийн хөрөнгийн зах зээл шиг олон төрөлжсөн бус, 3) Уул уурхайн компаниудын хувь эзэмшигчид өөрсдийн хүлээх эрсдлийг тархаахын тулд төрөл бүрийн санхүүгийн харьцангуй хямдхан хэрэгслүүдийг ашиглах боломжтой байдаг бол Монгол Улсын хувьд ийнхүү тархаах өртөг зардал нь илүү өндөр байх боломжтой, 4) Монгол Улс харьцангуй ядуу орон. Эдгээр болон бусад шалтгаанаас үзвэл Монгол Улсын эрсдэл үүрэх өртөг наад зах нь эдгээр компаниудынхаас доошгүй хэмжээнд байна. Тиймээс тухайн гэрээний холбогдох асуудлуудын талаар шийдвэр гаргахаас өмнө ямар учир шалтгаанаар илүү эрсдэл үүрэхийг (хувь нийлүүлэгчээр төсөлд оролцох болон хайлуулах үйлдвэр барих замаар) хүсэж байгаа болон ийм эрсдлийг хэрхэн зохицуулах талаар Засгийн газар тодорхой тайлбарлах нь чухал.

Дүгнэлт. Энэхүү дүн шинжилгээ нь жишиг хэлбэртэй учир цааш нь сайжруулах ёстой. Гэхдээ энэ шинжилгээний дүнгээс харахад тухайн санал болгоод байгаа гэрээний талаар

олон нийтээр хэлэлцүүлэхэд хөндөгдөх ёстой ямар асуудлууд байж болох талаар тодорхой ойлголт өгч байгаа юм. Тиймээс Улсын Их Хурал, олон нийт гэрээний төслийг хэлэлцэхээс өмнө хэд хэдэн зүйлийг шаардах ёстой:

- а. Засгийн газрын хийж гүйцэтгэсэн байж болох аливаа тоон болон санхүүгийн дүн шинжилгээ;
- б. Бэлэн мөнгөний урсгалыг бодитойгоор тооцоход шаардлагатай мэдээлэл, тухайлбал үйл ажиллагааны зардал, борлуулалтын гэрээ болон бусад мэдээлэл;
- в. Тодорхой үзүүлэлтүүдийг хэрхэн тооцох талаарх техникийн шинжтэй нарийн мэдээлэл (тухайлбал ногдол ашиг, нөөц ашигласны төлбөр, мөн Хавсралт 8-д дурьдсан бусад зүйлсийн талаарх мэдээлэл).

Эцэст нь, хүлээх эрсдэл, олох ашгийн хувьд төслийн дөрвөн тусдаа асуудлыг нягтлан шалгах хэрэгтэй:

- Монгол Улс газрын доорх хөрөнгийг өмчлөгч тул түүнийхээ төлөө өрсөлдөхүйц хэмжээний ашиг хүртэх ёстой;
- Монгол Улс нь татвар хураагч ба Засгийн газрын орлогын бааз суурийг төрөлжүүлж, олон тулгуурт болгох тодорхой алхмуудыг аваагүй тохиолдолд татвар нь уул уурхайгаас илүү хамааралтай болно;
- Монгол Улс нөөц баялгийг өмчлөөд зогсохгүй уурхай, тоног төхөөрөмжид хувь нийлүүлэгчийн хувьд хөрөнгө оруулахаар зэхэж байна;

²⁹ Эдгээрийг *Capital Asset Pricing Model (CAPM)* гэх загварыг ашиглан тооцсон. Дэлхийн ашгийн хувьд *Standard and Poor's 1200* Олон улсын Индексийг ашигласан ба сүүлийн 5 жилд 14.62 хувь байсан. Эрсдэлгүй хүүгийн түвшин нь АНУ-ын 30 өдрийн *Treasury Bill*-н хүү буюу одоогоор 4.7 хувь байхаар авсан. Хувьцааны үнийн харьцангуй хувьсамтгай байдлыг («бэга» гэж нэрлэдэг) *Рио Тинто*-ийн хувьд 1.633, *Айвенхоу*-ийн хувьд 1.79 байхаар тооцлоо. Эдгээр нь нэрлэсэн ашиг буюу хувь хүний орлогын албан татварыг тооцоогүй тул татварыг хамарсан дүн болно. Долларын инфляцийг бодолцвол тухайн үнэ цэнэ нь 19 хувь хүртэл хэмжээгээр буурна.

³⁰ Улс төрийн эрсдлээс хамааран уул уурхайн компаниудын хувьд Монгол дахь төслийн эрсдэл хүлээх өртөг Австрали, Канад дахь төслүүдтэй харьцуулахад илүү өндөр байх магадлалтай.

- Монгол Улс гэнэтийн ашгийн татвараар дамжуулж хайлуулах үйлдвэр байгуулах явдлыг урамшуулах ил бодлого явуулж ирсэн хэдий ч хайлуулах үйлдвэр нь эдийн засгийн хувьд үр ашиггүй байж болох юм.

Уурхайд хувь нийлүүлэгчээр оролцох, мөн дотооддоо хайлуулах үйлдвэр байгуулах нь Монгол Улсын хувьд дэлхийн зах зээлийн үнийн илүү их хувийг хүртэх боломжийг олгох нь үнэнд нийцнэ. Гэхдээ үнэ нэлээдгүй хэлбэлздэг учир уул уурхайн тоног төхөөрөмж, боловсруулах шатны үйл ажиллагаанд оруулах хөрөнгө нэмэгдэх тусам Монгол Улсад орох ашиг ихээхэн хэлбэлзэх болно. Түүнчлэн ийнхүү эдийн засгаа олон тулгуурт бус, төрөлжсөн бус болгох нь үнэ өртөг өндөртэй. Учир нь төр хувь нийлүүлэх хөрөнгийг өөрөө төлөх шаардлагатай. Цаашилбал хайлуулах үйлдвэрт хөрөнгө оруулаад илүү их ажлын

байр бий болгох, эдийн засгийн илүү ашиг өгөх, мөн илүү тогтвортой байдлыг бий болгох бусад зорилгоор хөрөнгийг ашиглах боломжгүй тул түүнд магадгүй татаас өгөхөд хүрч болох юм. Нэгэнт нэг салбарт дотоодын ихээхэн хэмжээний хөрөнгийг зориулах асуудал яригдаж байгаа тул дээр дурдсан дөрвөн асуудлын хувьд хамтад нь буюу тус тусад нь дүн шинжилгээ хийж, ашиг, эрсдлийг нь тооцох боломжтой. Улсын Их Хурал бүрэн мэдээлэл дээр тулгуурлан шийдвэр гаргахад ийм дүн шинжилгээг урьдчилан гүйцэтгэсэн байх шаардлагатай.

Одоогийн байдлаар бүрэн мэдээлэлд тулгуурласан харьцуулалт хийж, шийдвэр гаргахад шаардлагатай хэмжээний мэдээлэл байхгүй байна. Тиймээс ч энэхүү гэрээний төсөл нь Монгол Улсын алс хэтийн эрх ашигт нийцэх эсэхийг бүрэн тодорхойлох боломжгүй юм.

Хэсэг III. Уул уурхай дахь хөрөнгө оруулалтын гэрээг боловсронгуй болгох зөвлөмж

Бүлэг 12. Уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээг санхүүжүүлэх

Уул уурхайн хөрөнгө оруулалтын томоохон хэмжээний аливаа төслийг хувийн хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгөөр болон зээлийн хөрөнгөөр хэсэгчлэн санхүүжүүлдэг дэлхий нийтийн тогтсон жишиг бий.

Төр уул уурхайд хувь эзэмших хөрөнгийг өөрөө төлөх шаардлагатай. Зарим улс оронд төрийн оролцоо байгаа ч, хувь эзэмших хөрөнгийг санхүүжүүлэх өөр өөрийн хууль тогтоомж мөрдөж байна. Ашигт малтмалын тухай хуульд стратегийн ач холбогдол бүхий ордод төрийн оролцооны хувь хэмжээг заасан боловч, хэрхэн санхүүжүүлэх зарчим, арга хэлбэрийг зааж өгөөгүй билээ.

Хавсралт 2-т төрийн оролцооны талаар танилцуулсан билээ. Энэ харьцуулсан үзүүлэлтийг төрийн хувь эзэмшин оролцох оролцооны талаархи мэдээлэлтэй нэгтгэн үзвэл зохино. Тухайлбал, Гана Улсад төр 10 хувийг үнэгүй эзэмшдэг ч гэнэтийн ашгийн татвар үгүй. Папуа Шинэ Гвиней-д гэнэтийн ашгийн татвар (нөөцийн рентийн татвар) ч, хувь эзэмших оролцоо ч байдаг байна. Гэхдээ улс орнуудад төсөв санхүүгийн нөхцөл янз бүр байдаг ба төрийн хувь эзэмших оролцоог (мөн төсвийн бусад хэрэгслүүдийг) төсвийн ерөнхий дэглэмийн хүрээнд авч үзэх шаардлагатайг уг хавсралтад харуулсан болно.

Бүлэг 13. Уул уурхай дахь төрийн оролцоог санхүүжүүлэх асуудлыг дахин авч үзэх нь

Энэхүү гарын авлагын Б-д ашигт малтмалын гэрээн дэх төрийн оролцооны асуудлыг авч үзэхдээ Ашигт малтмалын тухай хуулийн төслийг 2006-2007 онд хэлэлцэх явцад гаргасан зөвлөмж болон уул уурхай дахь төрийн эрсдлийг авч үзсэн билээ. Энд төрийн оролцоог санхүүжүүлэх асуудал ч тусгагдсан. Ашигт малтмалын тухай хуулийг Улсын Их Хурал 2006 онд баталсны дараахнаас уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ярих болсон. Улсын Их Хурал, Засгийн газар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж стратегийн бүх орд газарт төр доод тал нь 51 хувийг эзэмшихээр яригдаж байна. Ийм шийдвэр эцэслэн гаргахын өмнө анхаарч үзэх хэд хэдэн асуудал байгаа тухай зөвлөмжийг энд авч үзлээ.

Үндсэн хуулинд зааснаар Монголын ард түмэн стратегийн орд газрын бүх баялгийг нэгэнт 100 хувь өмчилж байгаа. Энэхүү нөөц баялгийг зохистой, цаг алдалгүй ашиглахад шаардагдах хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх нь Улсын Их Хурал, Засгийн газрын үүрэг билээ. Харин энэ баялгийг ашиглахдаа ямар ч хэлбэртэй, ямар ч нэртэй байсан гагцхүү шаардагдах хөрөнгө, менежментийн ур чадвар, технологийг татахуйц хөрөнгө оруулалтын тогтолцоог бүрдүүлэх учиртай. Зарчмын хувьд төр өөрөө уул уурхайд хөрөнгө, менежментийн ур чадвар, технологи нийлүүлж болно. Эрдэнэт үйлдвэрийн жишээ ч ийм. Гэхдээ ашигт малтмалын томоохон орд газруудыг ашиглахад шаардлагатай хөрөнгийг босгох, менежментийн үйлчилгээг үзүүлэх төрийн өөрийн боломж чадавхи хязгаарлагдмал. Ийм чадавхи төрд байсан ч тухайн орд газрын шинж чанар, ашиглалтын төлөвлөгөө зэргээс хамааран технологи, уурхайн үйлчилгээ зэргийг бусдаар төлбөртэйгээр гүйцэтгүүлж байж олборлолтыг үр ашигтай явуулж чадна.

Төр нь ийм чадавхи, боломжийн хязгаартай тулгардаг тул нөөц баялгийнхаа үр шимийг бүрэн хэмжээгээр хүртэхийн

тулд хувийн хөрөнгө оруулагчдад хандах нь практик хэрэгцээ шаардлага юм. Үүнийг хийх цорын ганц зам бол тухайн хувийн хөрөнгө оруулагчийн шаардлагатай үйлчилгээ, технологи, хөрөнгөө нийлүүлэх сонирхлыг төрүүлэхүйц хэмжээний ашгийг тодорхой төслүүдээс хувийн хөрөнгө оруулагчид өгөх явдал билээ. Шаардагдах хөрөнгө оруулалтыг олон төрлийн ашигт малтмалд ямар ч цаг үед татахуйц урамшууллын багцыг оновчтой тодорхойлох нь төрийн зүгээс явуулах төсөв, санхүүгийн бодлогын үндсэн асуудал юм.

Баялгийн үнэ цэнийг төр олон арга замаар хүртэж болно. Тухайлбал, төрөл бүрийн татвар, нөөц ашигласны төлбөр, төлбөр хураамж, нийгмийн шинжтэй төлбөр, хувь эзэмшил, өмчлөл гэх мэт. Харин үлдэх ашиг нь хөрөнгө оруулагчийн хувьд төрийн хүсч буй тэр ашиглалтыг явуулахад хангалттай юу гэдэг нь асуудал юм. Энэ бол төсөл тус бүрээр тусад нь шийдвэрлэж болох практик шинжтэй асуудал ч төсөл бүрийн хувьд тусгай тохиролцоог хийх нь «арилжаа хийх» буюу транзакцийн зардал өндөртэй байхаас гадна Засгийн газрын хязгаарлагдмал нөөцийг ихээр шаардаж, мөн тал тохой татах нөхцлийг бүрдүүлнэ. Ийм нэг бүрчилсэн

хэлэлцээрийн дүнд төсөв, татварын олон янзын зохицуулалт үүсэх тул хэрэгжүүлэх, хяналт тавихад ихээхэн хүндрэл учирна. Тиймээс ч хууль тогтоомж, татварын уян хатан, гэхдээ зарчимч тогтолцоог бүрдүүлэх нь оновчтой. Төрийн хувь эзэмших оролцооны хувьд ч уул уурхайн төрөл бүрийн төсөлд нийтлэг хэрэглэж болох нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй.

Төрийн оролцооны доод хэмжээг зааж өгсөнөөр Улсын Их Хурал, Засгийн газар ямар зардлыг хариуцах үүрэг үүсэх, тэрхүү зардлыг хэрхэн санхүүжүүлэх асуудалтай тулгарна. Ийм сонголт хийх нь зардал, ашиг, хүлээх эрсдэл Засгийн газар, хөрөнгө оруулагчдын хооронд хэрхэн хуваарилагдахад ихээхэн нөлөөлнө. Нэгэнт тогтоогдсон орд газрын хувьд Засгийн газар бэлэн мөнгө төлөөд бусад хөрөнгө оруулагчийн нэгэн адилаар зах зээлийн нөхцлөөр тодорхой хувийг худалдан авч болно. Гэхдээ энэ тохиолдолд хувь эзэмшсэнээр нэг их онцын давуу тал үүсэхгүй. Тэр мөнгөөрөө гадаад, дотоодын зах зээлээс бонд, хувьцаа ч худалдаж авч болно. Харин өөр нэг хувилбар бол төр ирээдүйд гарах хөрөнгийн болон үйл ажиллагааны зардлын өөрт ногдох хувийг хариуцах явдал юм. Ингэснээр нөөц баялгийн зах зээлийн үнэ, түүнийг ашиглахад гарах зардал хоёрын хоорондын зөрүүнээс Засгийн газар ашиг хүртэх болно. Үндсэндээ ийм байдлаар Оюу толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл хийгдсэн ба гагцхүү Засгийн газрын оруулах хөрөнгийг хөрөнгө оруулагч тодорхой хугацаанд «даах» буюу зээлэхийг зөвшөөрсөн байсан. Дээрх хувилбарын аль аль нь уул уурхайн эрсдэл төрд болон эдийн засагт нөлөөлөх үүдийг нээж өгч байгаа. Уул уурхайн чиг хандлага, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс хамааран тухайн төсөл ашиггүй болвол төрийн оруулсан хувь эзэмшил алдагдах буюу үр ашиггүй болно.

Мөн татвар, нөөц ашигласны төлбөрийн орлого ч алдагдахад хүрнэ. Хэдийнээ эдийн засгийн хувьд ихээхэн хамааралтай болсон уг салбарт хөрөнгө оруулснаар Засгийн газар ирээдүйд үүсч болох эрсдлийг нь ч давхар үүрэх болж байна. Төрийн оролцоог хангахад зарцуулах хөрөнгийг эдийн засгаа олон тулгуурт болгон төрөлжүүлж, үүсэх эрсдлийг саармагжуулахад зориулж болно.

Оюу толгойн хувьд Засгийн газрын хувийг тодорхой хугацаагаар хөрөнгө оруулагч «даах» хувилбарыг хөрөнгө оруулалтын гэрээний Улсын Их Хурлаас татан авсан хувилбарт санал болгож байсан. Өөрөөр хэлбэл, өөрийн эзэмших хувийг Засгийн газар худалдаж авах ба үүнийг хөрөнгө оруулагч зээлийн хэлбэрээр санхүүжүүлж, дараа нь ирээдүйд Засгийн газарт төлөх ёстой ногдол ашгаас зээлээ нөхөн авахаар тусгасан. Ногдол ашиг зээлийг төлөхөд хүрэлцэхгүй бол үлдэгдлийг Засгийн газар хариуцахгүй байх үндсэн дээр ийм зээл хийгддэг тул ордын ашиглалт ашиггүй болвол (тийм магадлал тун бага ч гэсэн огт боломжгүй зүйл биш) Засгийн газар зээлийг эргэн төлөх шаардлагагүй. Ингэх нь төрийн нөөцийг уг хөрөнгө оруулалтад зарцуулахаас тойрч байгаа ч огт үнэ өртөггүй зүйл биш юм. Тодорхой хугацаагаар «даалгаснаар» Засгийн газар зээл, түүний хүүг төлж дуусах хүртэл ашиг хүртэхгүй тул хөрөнгө оруулалтын өгөөж хугацааны хувьд ихээхэн хойшлогддог. Үйлдвэрлэл эхлэхтэй зэрэгцэж төлөгддөг нөөц ашигласны төлбөр, ашигтай ажиллаж эхлэхэд төлөгддөг орлогын татвар, хөрөнгө оруулагчид ашгаас хуваарилж эхлэнгүүт төлөгддөг суутгалын татвар зэрэгтэй харьцуулахад энэ хувилбар нь үлэмж ялгаатай.³¹

Харин ийм «даалгасан» хувь оролцоо нь хүүгүй бол ашигт нэмэлт татвар ногдуулж байгаа хэлбэр болно. Тухайлбал, 25 хувийн ашгийн татвартай, 51 хувийн «даалгасан»

³¹ Давхар татвар ногдуулахгүй байх Засгийн газар хоорондын хэлэлцээрээс хамааран Канад зэрэг зарим улсын хувьд Засгийн газрын ногдуулж болох суутгалын татварын хэмжээ хязгаартай. «Даалгасан» хувь эзэмших нь энэ асуудлыг тойрч гарах боломж олгодог.

хувь эзэмшдэг бол ашгийн доллар тутмаас 63 центийг нь Засгийн газарт хөрөнгө оруулагч төлөх болно. Энэ нь гэнэтийн ашгийн татварыг оруулаагүй тооцоо юм.

Төрийн оролцооны нэг давуу тал бол Засгийн газар мэдээлэл авах болон хөрөнгө оруулалтын чухал шийдвэрүүдийг хянах боломжоор хангагдах явдал юм. Харин уурхайн үйл ажиллагааг өөрөө явуулахыг төр засаг зориогүй л бол менежментийн үүрэг, хариуцлагыг анхааралтай хуваарилах ёстой. Уул уурхайн олон улсын томоохон компаниудын амжилтын нэг үндэс нь тэдний менежментийн өндөр ур чадварт байдаг тул гадаадын хөрөнгө оруулалтыг оруулах нэг эерэг тал нь уг ур чадвартай холбоотой давуу талыг ашиглах боломж мөн. Ийм ур чадвар нь төслийг хэрэгжүүлэхэд ч, цаашилбал уг чухал ур чадварт монголчууд суралцахад ч нөлөөлнө. Санхүүгийн эрсдлийг үүрэхийг Засгийн газар хөрөнгө оруулагчаас хүсч байгаа бол хөрөнгө оруулагч өөрийн оруулах хөрөнгийнхөө зарцуулалтыг хянахыг хүсэх нь ойлгомжтой ба илүү үр ашигтай үйл ажиллагаа явуулах нь орлогыг нэмэгдүүлэх тул Засгийн газрын сонирхолд ч нийцнэ.

Хувьцааны олонхийг эзэмшихгүйгээр ч мэдээлэл бүрэн хэмжээгээр авах, хяналтаа тогтоох боломж Засгийн газарт байна. Хувь нийлүүлэгчийн гэрээ, ашиглалтын үйл ажиллагаа явуулах гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ, эсхүл хууль тогтоомжоор дамжуулан ийм нөхцлийг хангах боломжтой. Хэт их буулт хийсэн хөрөнгө оруулалтын тогтвортой байдлын гэрээнд нэгэнт гарын үсэг зураагүй бол хөдөлмөрийн болон нийгмийн харилцааны асуудал, байгаль орчин, ус, газар ашиглалтын эрхтэй холбоотой ашиг сонирхолоо төр засаг хууль тогтоомжоор дамжуулан хамгаалж болно. Хамгийн гол нь хууль тогтоомж, хөрөнгө оруулалтын гэрээг зохистой хэлбэрээр гаргаж, байгуулж чадвал тусгай зөвшөөрөл, үйл ажиллагааны удирдлагын туршлагагүй, санхүүгийн чадавхи сул, нэр хүнд муутай, эсхүл үндэсний аюулгүй байдалд эрсдэл

учруулах зэрэг талтай этгээдүүдэд шууд болон шууд бусаар шилжүүлэх явдлаас сэргийлэх боломжтой. Хувь эзэмшсэнээр эдгээр асуудалтай холбоотой Засгийн газрын эрх заавал хамгаалагдах баталгаа бий болохгүй, учир нь зөвхөн дан ганц хувь эзэмших хэлбэрээр бүрэн хэмжээгээр өөрийгөө хамгаалах боломжгүй. Тухайлбал, хувь эзэмшсэн ч гэсэн тухайн хөрөнгө оруулагчийн толгой компаниудын өмчлөгчид өөрчлөгдвөл Засгийн газар өөрийн сонгоогүй шинэ түншлэгчтэй хамтран ажиллахад хүрнэ. Санахад илүүдэхгүй бас нэг зүйл бол төр хувь эзэмшсэнээр байгаль орчны болон нийгмийн зарим сөрөг үр дагавар гарч болох явдал юм. Тухайлбал, Хятад улсад тухайн салбарт оролцоо, ашиг сонирхолтой орон нутгийн засаг захиргаа байгаль орчны хуулийн хэрэгжилтэд саад учруулах нь бий. Ялангуяа бодитой эрх мэдлийг хэрэгжүүлэх хэлбэрээр хувь эзэмших нь тухайн төрийн өмчлөгчийн ашиг сонирхол, мөн түүний хяналт, зохицуулалт хийх сонирхол хоёрын хооронд зөрчил үүсгэдэг. Энэ зөрчлийг зохицуулж болно, гэхдээ төр их хэмжээний хувь эзэмших тохиолдолд асуудал томорч, зохицуулахад хүндэрдэг.

Хөрөнгө оруулагч компанийн хувийг эзэмших хэлбэрээс бусад нөөц баялгийнхаа хяналтыг хэрэгжүүлэх арга замууд бий. Тухайлбал, бүтээгдэхүүн хуваах гэрээ (энэ асуудлыг Бүлэг 15-т танилцуулсан байгаа)-ээр гуравдагч этгээдэд борлуулах үе хүртэл тухайн нөөцийг төр 100 хувь өмчлөх эрхээ хадгалах боломжтой. Нөөцийн өмчлөлийн эрхийг Засгийн газар хадгалж байгаа ч санхүүжилт, менежмент нь хөрөнгө оруулагчийн үүрэг болдог. Ийм гэрээний хувьд зарагдах бүтээгдэхүүний хэдэн хувийг хөрөнгө оруулагч авах, зардлаа нөхөх ямар дүрэм үйлчлэхийг тодорхой журам, эсхүл үнэ хаялцуулах хэлбэрээр тодорхойлдог. Орлогын татварын дүрэм журмын хамтаар эдгээр нь Засгийн газар болон хөрөнгө оруулагчид ногдох ашгийг тодорхойлдог ба хоёр талд ногдох хувийг татварын багц хууль,

холбогдох журмаар тодорхойлдогтой нэгэн адил. Гагцхүү нөөцийн өмчлөлийн эрхийн хувьд л нөөцийг олборлосон үед уг эрх шилжих үү, эсхүл борлуулсан үед үү гэдгээрээ ялгаатай. Харин менежмент, өртөг зардлыг хөрөнгө оруулагч бүрэн хариуцах ба ашгийн ногдох хувьтай дүйцэх хэмжээнд төслийн эрсдлийг үүрдэг. Энэ утгаараа ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, төслийг дангаараа хэрэгжүүлэх, гэхдээ тухайн нөөцийг аль нэг шатанд «өмчлөхгүй» хөрөнгө оруулагчаас ялгаагүй.

Төр хувь эзэмших нь төсөв санхүү, гэрээний ерөнхий нөхцлийн нэг хэсэг байж болох ч зөвхөн нэг л хэсэг нь юм. Монголчууд өөрсдийн байгалийн баялгийн үнэ цэнийг бүрэн хэмжээгээр хүртэх нөхцлийг хангах

хөрөнгө оруулалтыг татах үүднээс эрсдэл, ашгийн зохистой тэнцвэрийг олохын тулд бусад бүрэлдэхүүн хэсэгтэй нь хамтад нь үнэлэх ёстой. Цэвэр ашгийн татвар, нөөц ашигласны төлбөр, тодорхой төлбөр хураамж, гэнэтийн ашгийн татвар, өмчлөгчийн хувь оролцоо зэрэг хэрэгслүүд байгаа ч энэ бүх ачаалал тодорхой цэгээс давбал хөрөнгө оруулалт орохгүй. Төр 51 хувийг «өмчлөх» нь сонирхолтой ч төсөв, санхүүгийн бусад нөхцөл бүхий хувилбаруудын сайн, муу талыг харгалзан үзэж байж Монгол Улс байгалийн баялгийнхаа үнэ цэнийг бүрэн хэмжээгээр хүртэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг татахуйц дүрэм журам, татвар, өмчлөлийн цогцыг тодорхойлох ёстой. Тэг ашгийн зуун хувь ч тэгтэй л тэнцэнэ.

БҮЛЭГ 14. Санал болгож буй уул уурхайн санхүүгийн дэглэм

Гэрээ сайн байх угтвар нөхцөл нь татварын хууль тогтоомж боловсронгуй байх явдал юм. Иймд Улсын Их Хурлаар хэлэлцэж байсан татварын багц хуулийн төсөлд өгсөн санал зөвлөмжийг Бүлэг 2-т бид үзсэн билээ. Засгийн газраас уул уурхайн татвар, орлогын асуудлыг АММИ-тай байгуулах Оюу толгойн ордыг ашиглах гэрээний төсөлд тусгасан байдалд шинжилгээ хийж дараахи санхүүгийн дэглэмийг хөндлөнгийн шинжээчид санал болгосон байна.

Нөөц ашигласны төлбөр. Уул уурхайн олон экспертүүд уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хайж байгаа бусад улстай өрсөлдөхүйц хэмжээнд Монгол Улс нөөц ашигласны төлбөрөө тогтоож бүрдүүлэхийг зөвлөж, энэ төлбөр хэт өндөр бол хөрөнгө оруулалт бусад орон руу чиглэх болно гэж зөвлөж ирсэн. Энэ хэт өндөр гэж чухам ямар хэмжээг хэлэх вэ? Газарт байгаа алт, зэс нь газартай төстэй. Үржил шимтэй, үнэ цэнэ өндөртэй газар эзэмшиж байгаа бол энгийн нэгэн газартай харьцуулахад хэд дахин их үнээр зарах болно. Үүний нэгэн адилаар алт, зэстэй газраа, нөөц баялгаа хэт хямд зарах ёсгүй. Нөөц ашигласны төлбөрийг тогтоохдоо нөөц баялгийн үнэ цэнийг тусгах ёстой гэсэн зарчмыг бусад орны туршлагаас харж болно. Нөөц ашигласны төлбөрийг 2005 оны байдлаар Монгол Улс 2.5 гэсэн хувь хэмжээгээр тогтоож байгааг өөрчилж өндөр чанартай хүдэр бүхий томоохон ордод өндөр түвшинд, ашиглалтын өртөг өндөр ордод доогуур түвшинд тогтоох, нөөц ашигласны төлбөрийг үнэлгээний хувиар бус нэгж

бүтээгдэхүүнд үндэслэн тооцох боломжийг авч үзэх хэрэгтэй.

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар. Татварын хувь 25 байх, хоорондоо холбоотой талууд хийх гүйлгээнд урьдчилсан үнэ тогтоох гэрээ, капиталжуулалтын (зээл, өөрийн өмчийн харьцааны) хязгаарлалт, алдагдлыг дараагийн жилүүдэд шилжүүлэх, үйлдвэрлэлийн өмнөх зардлуудын элэгдэл хорогдол, үйлдвэрлэлийн дараахи зардлуудын элэгдэл хорогдол, гадаад валютын олз ба алдагдал, хамгаалалтын сангийн зардлууд, засвар үйлчилгээ, ногдол ашгийн данс, хилийн чанад руу хийх төлбөрүүд зэргийн талаар гэрээнд тусгах шаардлагатай.

Мөн хэт өндөр ашгийн татвар, нэмэгдсэн өртгийн болон гаалийн татвар, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө, бусад заалтууд зэргийг энэхүү санал болгож буй санхүүгийн дэглэмд тусгасан. (Хавсралт 12-оос дэлгэрэнгүй үзнэ үү)

Татварын хөнгөлөлт. Засгийн газрууд заримдаа хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд «татварын хөнгөлөлт» эдлүүлэхийг зөвшөөрдөг. Энэ нь хэдэн жилийн хугацаанд татвар огт ногдуулдаггүй, элэгдэл хорогдлыг чөлөөтэй тооцохыг зөвшөөрдөг, эхний хөрөнгө оруулалтыг төлөх татвараасаа бүхэлд нь суутган тооцож болдог хугацааны үе байдаг. Татварын хөнгөлөлтийг улс төрийн хувьд сөргөөр хандах болсон учраас дэмжих нь багасч байна. Шинээр үйл ажиллагаа явуулж буй уурхайн бэлэн мөнгөний урсгалд татварын хөнгөлөлтийн нөлөө тийм ч их биш байдаг нь тухайн уурхайн тэртээ тэргүй эхний жилүүдэд алдагдалтай ажиллаж, ашгийн татвар төлж чаддаггүйтэй холбоотой.

Дэвид Л.Голдвин «Гүн өрөмдөж үзэхүй» номоос

Экспортын татвар. Гэнэтийн ашгийн татвар тогтоох хэлэлцүүлэгт зориулж татварын нэг төрөл болох экспортын татварын саналын талаар 2005 оны 4 дүгээр сард зарим зөвлөмж бэлтгэснийг энд тоймлож байна. Экспортын татварыг хэрэглэхийг эсэргүүцэж байгаа ч бүтээгдэхүүнд (экспортын болон дотоодын) ногдуулсан тохиолдолд оновчтой хэмжээний супер роялти тогтоох аргачлал нь Монголд тохиромжтой байх болно гэж үзэж байна.

Гэнэтийн ашгийн татвар тогтоох тухай санаа нь ОХУ-ын газрын тосны экспортын татвар дээр үндэслэсэн гэж ойлгогдож байна. Үүнд дараахи асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагатай:

а. Үнийн индексийг тодорхойлох. Бүх сонирхогч тал ажиглах боломжтой олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн ямар нэгэн үнэ байж болох юм.

б. Суурь тэнцвэрийн (зардлаа нөхөх үеийн) үнийг тодорхойлох. Энэ үнэ нь уул уурхайн үйл ажиллагааны хугарлын цэгийн талаарх тооцоо, төсөөлөл дээр үндэслэдэг. Энэ үнийг уурхай тус бүрээр тооцох, эсхүл салбарын хувьд ерөнхийд нь нэг үнэ тодорхойлох аль нь болох нь тодорхой бус байна. Тухайлбал, тэнцвэрийн үнээр боловсруулсан зэсийн хувьд 3500 долларыг ашиглах хувилбар байж болно. Энэ үнийг тодорхойлохдоо боловсруулсан зэсийн үнийн тал хувь нь зэсийн баяжмалын фоб (fob) үнэ ба хөрөнгө оруулагчдад 40 хувийн өгөөж (нэгж бүтээгдэхүүнд) шаардагдана гэж төсөөлсөн үед ийм үнэ байна. Энэхүү харьцааг дараахи томъёогоор илэрхийлж болно³²:

$$P_B = A_C * F * (1+k)$$

Үүнд: P_B = Тэнцвэрийн үнэ

A_C = Монгол дахь баяжмалын дундаж өртөг (хил хүртэлх тээврийн үнийг оролцуулсан)

F = Боловсруулсан зэсийн боловсруулах үйлдвэрийн үүдэн дэх өртгийг тооцох фактор

k = Хөрөнгө оруулагчийн өгөөж

Үнийг 3500 доллар байна гэсэн төсөөллийг үүнд орлуулбал дараахи тооцоо гарна:

$$3,500 = 1250 * 2 * 1.4$$

в. Хэрэв ажигласан үнэ тэнцвэрийн үнээс доогуур бол экспортын татварыг ногдуулахгүй.

г. Үнэ тэнцвэрийн үнээс дээгүүр бол ажигласан үнэ, тэнцвэрийн үнэ хоёрын зөрүүний тодорхой хувийг (хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 80% гэж мэдээлж байгаа) татвараар хураах болно. в. ба г. заалтуудыг дараахи байдлаар илэрхийлж болно:

$P_W > P_B$ бол $T = t * (P_W - P_B)$ ба бусад тохиолдолд $T = 0$

Үүнд: P_W = ДЭЛХИЙН (эсхүл харьцуулалтын) үнэ

T = нэгжид ногдох хэмжээ

t = татварын хувь

Татварыг баяжмалын экспортоос тооцно. Баяжмалыг дотоод үйлдвэрлэлд (эсхүл дотоод хэрэглээнд) ашиглавал ямар нэгэн татвар ногдуулахгүй.

Эцэст нь, татварын хувь хэмжээ, суурь үнийг хөрөнгө оруулагчтай (өнөөгийн буюу боломжит хөрөнгө оруулагч) тохиролцох боломжтой гэж ойлгож байгаа. 80 хувийн татвар тогтоох талаар мөн л хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлсэн байгаа.

Энэ татварыг дэмжих дараахи хүчин зүйлс байна:

а. Эрдэс баялгийн өндөр үнээс үүсэлтэй илүүдлийг татан авах хэрэгсэл,

³² Энэхүү тэнцвэр нь net back-ийн урвуу хэлбэр. Уурхайн хувьд зардлаа нөхөхөд шаардлагатай олон улсын үнийн доод түвшнийг тодорхойлоход өртөг, ашгийн тооцоог ашигласан.

б. Хөрөнгө оруулагч боловсруулах үйл ажиллагаа явуулах хэлбэрээр хөрөнгийг тухайн улс оронд үлдээх урамшуулал. Эдгээрийг дор авч үзвэл:

а. Оросын туршлага. Оросын экспортын татварыг оросын зах зээлийн хоёр шинж тэмдгийн учир боловсруулсан гэж бид үздэг:

- 1) Ханш уналтаас үүсэх ашгийг татан авах зорилгоор нэвтрүүлсэн. 1998 оны санхүүгийн хямрал, рублийн ханшийн 30 орчим хувийн уналтаас үүдэлтэй үүссэн гэж үзэх өндөр ашгийг татан авах зорилгоор Оросын экспортын татварыг ногдуулсан. Энэ нь түр хугацааны татвар байх ёстой байсан.
- 2) Газрын тос зөөвөрлөх хоолойны рентийг татан авах зорилгоор ногдуулсан. Татварыг экспортод ногдуулсан нэг шалтгаан нь хоолойн хүртээмж хязгаарлагдмал байдлаас үүдэлтэй дотоодын болон олон улсын үнийн зөрүү юм.³³ Олон улсын үнээс хоолойн зардлыг хассан дүнгээс дотоодын үнэ доогуур түвшинд байсан (ба байгаа) ба үүний улмаас газрын тосны үйлдвэрлэгчид хоолойд гарцтай болохын тулд нэмэлт үнэ төлөхөд бэлэн байна. Эдгээр нь ОХУ-ын хувьд онцлог нөхцөл байдал ба Монголын хувьд экспортын татвар ижил зорилгыг гүйцэтгэх болно гэж итгэх шалтгаан байхгүй.

б. Дотоодын боловсруулах үйлдвэрлэлд хөрөнгө оруулах урамшуулал. Экспортын татвар эрдэс баялгийг боловсруулах дотоодын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих болно гэж зарим улс төрчид үзэж байгаа нь зөв билээ. Энд гол асуудал бол ийнхүү хийсвэрээр хөрөнгө оруулалтыг дэмжих нь Монголд эдийн засгийн хувьд оновчтой эсэх явдал юм. Ийм бодлого үр ашигтай байхгүй гэж итгэх хоёр шалтгаан байна:

- 1) Үр ашиггүй дотоодын үйлдвэрлэл. Экспортын татварын үр дүнд бий болсон дотоодын хөрөнгө оруулалт нь олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай байхгүй. Өөрөөр хэлбэл, олон улсын хэм хэмжээнээс дээгүүр боловсруулах өртөгтэй байна гэсэн үг. Тиймээс эдийн засгийн өртөг нь дотоодын боловсруулалтаас үүсч буй аливаа нэмүү өртгөөс илүү хэмжээтэй байх болно. Түүнчлэн хуваарилалтын сөрөг үр дагавар үүсэх боломжтой. Учир нь дээрх үр ашиггүй байдлаас хожих гол тал нь гадаадын хөрөнгө оруулагчид байж болзошгүй. Эрдэс баялгийн боловсруулалт нь капитал их хэмжээгээр шаарддаг ба бусад салбартай (тухайлбал оёмол сүлжмэл, бусад үйлдвэрлэлийн салбар) харьцуулахад үүсгэж буй нэг ажлын байранд ногдох капиталын зардал нь хамаагүй өндөр байдаг. Хүлээгдэж буй гадаадын хөрөнгө оруулалтын түвшинг бодвол боловсруулах үйлдвэрлэлийн ашиг шимийн ихээхэн хэсэг нь экспортод гарах болно.
- 2) Эрсдэл нэмэгдэх ба төрөлжилт буурна. Монгол Улс хэдийнээ эрдэс баялгийн орлогоос ихээхэн хамааралтай ба экспортын татвараар боловсруулах үйлдвэрлэлийг хийсвэрээр дэмжвэл эдийн засгийн төрөлжилт улам хязгаарлагдана. Учир нь боловсруулах үйлдвэрлэлд ашиглаж байгаа капиталын хөрөнгө оруулалт болон ажиллах хүчнийг бусад уул уурхайтай холбоогүй салбарт ашиглах боломжгүй. Тиймээс Монгол Улсын орлого, экспорт нь эрдэс баялгийн үнийн өөрчлөлтөөс ихээхэн хамааралтай болно. Үүний нийт эдийн засагт үзүүлэх үр нөлөө нь эдийн засгийнхаа төрөлжилтийг сайжруулах зорилгоор Засгийн газар болон хувийн хэвшил хомс нөөцийг

³³ Би (Роберт Конрад) Оросын Засгийн газартай нилээд хэдэн жил ажилласан гэж тэмдэглэсэн. Би хоолой ашиглалтын нэмэлт төлбөрийг ногдуулахыг (нэгжид суурилан) 1995 онд санал болгож байсан. Энэ саналыг Засгийн газар хоёр жилийн турш хэрэгжүүлсэн. Миний итгэж байгаагаар газрын тосны үнэ буурсан болон улс төрийн сөрөг хүчний нөлөөллөөс хамааран нэмэлт төлбөрийг мөн 1997 онд дахин хэрэгжүүлсэн.

хөрөнгө оруулах байсан бол харин ч илүү эрсдэл хүлээх нөхцөл үүснэ.

в. Уг саналыг Супер роялти буюу нөөц ашигласны төлбөр болгон ашиглах сонголт. Экспортын татвараас илүү оновчтой байж болох хоёр сонголтын талаар өмнө нь дурьдаж байсан. Нэгд, гадаадынханы ногдол ашиг болон бусад хуваарилалтад суутгах татвар ногдуулсанаар хөрөнгийг Монголд үлдээх урамшууллыг бий болгоно.³⁴ Хоёрт, хэрэв эрдэс баялгийн үнийн ихээхэн өсөлтөөс үүсэх илүүдэлд татвар ногдуулах нь бидний зорилго бол (анх зэсийн хувьд Папау Шинэ Гвиней-д хэрэглэсэн) нөөцийн рентийн татвар зэрэг хэт өндөр ашгийн татварыг ашиглах боломжтой.

Гуравдахь хувилбар бол дээр тайлбарласан аргачлалыг эрдэс баялгийн бүхий л үйлдвэрлэлд ашиглах явдал юм. Хөрөнгө оруулагчид анхны хөрөнгө оруулалтаа нөхөн, дээр нь тодорхой хэмжээний ашиг олох үүднээс уг татварыг тодорхой хугацааны хувьд ногдуулах нь тохиромжгүй гэж би итгэж байна. Хөрөнгө оруулалтаа нөхөж амжаагүй байхад татвар ногдуулах нь ашиглалт, олзворлолтод сөргөөр нөлөөлөх боломжтой. Хэт өндөр ашгийн татварыг экспортоор хязгаарлах шаардлага байхгүй ба экспортын оронд бүх үйлдвэрлэлд татварыг ногдуулах нь илүү үр ашигтай байх болно. Түүнчлэн Монгол Улс нөөцийн төлбөрийн суурь үнээр олон улсын харьцуулах үнийн тодорхой хувийг ашиглах боломжийг авч үзэхийг урьд нь бид санал болгосон байгаа. Энэ хандлагад хэд хэдэн давуу тал байна. Нэгд, зардлыг тооцсон үнийг тооцох шаардлагагүй ба ийм хүндрэлтэй тооцоог хийх захиргааны зардлыг хэмнэх болно. Хоёрт, уг тогтолцоо нь ил тод байх боломжтой ба бүх хүн (тэр дотроо иргэд) суурь нөөцийн төлбөр, супер нөөцийн төлбөрийг аль алийг нь тооцож үзэх боломжтой. Гуравт,

эрдэс баялгийн үнийн өсөлтөөс үүсэх ашгаас Засгийн газар хуваалцах болно. Эдгээр үр ашгийг үүсэх зардалтай харьцуулан үзэх хэрэгтэй. Ийм зардалд нарийвчлал алдагдах явдал ч гарна. Илүү нарийвчилсан аргатай харьцуулахад илүү, эсхүл дутуу татвар хураахад хүргэж болзошгүй. Монгол Улсын хувьд ил тод байдал, захиргааны хялбар байдал үгүйлэгдэж байгааг тооцвол энэ хандлагыг сонгон хэрэгжүүлснээс үүсэх ашиг шим нь эерэг үр дүнтэй байна гэж итгэж байна.

Гэнэтийн ашгийн татварын шинэчлэл: Альтернатив арга хэмжээнүүд. Энд 1) гэнэтийн ашгийн татварт хийж болох шинэчлэл, эсхүл 2) гэнэтийн ашгийн татварын оронд ногдуулж болох альтернатив татваруудын талаар авч үзлээ. Эдгээр нь ерөнхийд нь хууль тогтоомжоор батлан гаргаж болох, эсхүл Айвенхоу майнз монгол инк компанитай байгуулах Хөрөнгө оруулалтын хэлэлцээрт гэнэтийн ашгийн татвараас чөлөөлсөн заалтын оронд ашиглаж болох арга хэмжээнүүд юм. Гэнэтийн ашгийн татварын өнөөгийн хувь хэмжээ болох 68 хувь нь үйлдвэрлэлийн түвшин бага байхад хүчин төгөлдөр болсон болон зардлын хүчин зүйлийг хязгаарлагдмал хүрээнд авч үзсэн зэргээс болоод шаардлагатай хөрөнгө оруулалтыг цааш түлхэж болох юм. Рио Тинто өнөөгийн гэнэтийн ашгийн татвар Оюу Толгой дахь үйл ажиллагаанд үйлчилбэл тэнд хөрөнгө оруулалт хийхгүй байж болох юм.

Монголд баяжуулсан зэсийг гэнэтийн ашгийн татвараас чөлөөлөх нь тусдаа асуудал юм. Ийм урамшуулал нь Монголд хайлуулах үйлдвэр байгуулж, түүгээрээ дамжуулан Монгол дахь аж үйлдвэрийн бусад үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих гэсэн зорилготой байх. Шинэчлэлийн арга хэмжээнүүдэд татварын тогтолцоо хүчин төгөлдөр болохоос өмнө татвар үйлчилж

³⁴ Оршин суугч бус этгээдэд хийгдэж буй ихэнх төлбөрийн хувьд (хөрөнгийн нөхөн төлөлтөөс бусад) жигд суутгах татвар ногдуулах нь чухал гэж би үзэж байна. Ийм татвар нь дэлхий даяар хэрэглэгддэг ба ийм татварыг хэрэглэх бодлогын чухал учир шалтгаан ч бий.

эхлэх үнийн түвшинг дээшлүүлэх, эдгээр түвшинг инфляцитай уялдуулан аажмаар индексжүүлэх, татварын хувийг бууруулах зэрэг байж болно. Олон улсын зарим санхүүгийн байгууллагаас дараахи зөвлөмж гаргасан байна. Үүнд: Хэрэв гэнэтийн ашгийн татварыг хэвээр үлдээвэл, түүний хувийг 55 болгож бууруулах, суурь үнийн түвшинг жил бүр АНУ-ын ДНБ-ний дефлятороор шинэчилж байх, мөн ийм татварт зэсийн бүх арилжааг хамруулах зэрэг санал орсон байгаа.

Дор авч үзсэн нөөц баялгийн рентийн татварын тодорхой элементүүдээс авч хэрэглэсэн бас нэг хувилбар буюу нэмэлт арга зам нь хөрөнгө оруулагчийг анхдагч хөрөнгө оруулалтаа эргүүлэн нөхөн авах хүртэл, эсхүл тодорхой хугацаанд, тухайлбал үйлдвэрлэл эхэлснээс хойш 10 жилийн дотор татвараас чөлөөлөх асуудал байж болох юм.

Нөөц баялгийн рент / нэмэгдэл ашгийн татвар. Гэнэтийн ашгийн татварын оронд хөрөнгө оруулагч оруулсан хөрөнгөө нөхөн авч, түүний ашгийг хүртсэний дараа үйлчилж эхлэх нэмэгдэл татварын бүтэц бий болгож болох юм. Хөрөнгө оруулалтын ашгийн хувь хэмжээг хуулиар буюу хэлэлцээрээр, зарим тохиолдолд өрсөлдөөнт дуудлага худалдаагаар тогтоож болно. Хэдийгээр иймэрхүү татварын тогтолцоог мэдэхгүй тохиолдолд учир нь олдохгүй мэт санагдаж болох боловч түүнийг тогтооход татвар ногдуулах орлогыг тодорхойлох, эсхүл жил тутмын санхүүгийн тайлан баланс гаргахад шаардагддаг тийм л санхүүгийн мэдээлэл байхад хангалттай. Орлогын татварын нэмэгдэл болох нөөц баялгийн рентийн татвар нь хэрэв зөв бүтэцтэй хэрэгжүүлбэл

хөрөнгийн бүтцийг татвар бага төлөх хэлбэртэй байлгах, түүнтэй холбоотой транзакцийн замаар буруу үйл ажиллагаа явуулахаас хол байх сайн талтай.

Олон улсын валютын сангаас тийм татварын ажиллах зарчмын талаар тодорхойлсныг хялбар байх үүднээс дор сийрүүлэв. Нөөц баялгийн рентийн татвар (НБРТ) нь нийт төслийн ажиллагаанаас орсон бэлэн мөнгөний ашгийн урьдчилан тогтоосон хувь хэмжээнээс илүү гарсан хэсэгт пропорциональ татвар ногдуулахыг хэлнэ. Урьдчилан тогтоосон хувь хэмжээ гэдэг нь уул уурхайн салбарт эхэлж байгаа шинэ төслийн ашгийн шаардагдах “минимум” хувь хэмжээг тодорхойлох зорилготой. Татварыг тооцоолон гаргах зорилгоор уг хувь хэмжээг заримдаа “хуримтлалын хувь хэмжээ” гэж нэрлэх тал бий. НБРТ нь “нөөц баялгийн рент” гэх концепцээс үүдэлтэй бөгөөд энэ нь бүхий л шаардлагатай хөрөнгө, үйлдвэрлэлийн одоогийн зардал, түүний дотор төсөлд оруулсан хөрөнгийн хариуд авах зохистой ашгийн хэмжээг нийлүүлснээс илүү гарсан хөрөнгө мөнгийг хэлж байгаа юм.³⁵ НБРТ-ын гол шинж чанар нь:

1. НБРТ нь бэлэн мөнгөний урсгалд ногдуулдаг татвар бөгөөд нийт капитал, үйл ажиллагааны (гэхдээ хүү биш)-зардлыг орлогоос тэр дор нь хасаж тооцдог.³⁶
2. Хуримтлалын хувь хэмжээ (нийлмэл хүүгийн хувь буюу жилийн нийт хүүгийн ашиг)-г барилга байгууламж барьж эхэлснээс эхлэн жил бүр бэлэн мөнгөний гадагш гарах цэвэр хасах урсгалын балансад, мөн бусад татвар (гол төлөв

³⁵ *Нөөцийн рентийн татвар байхаар санал болгосон ч энэ нь үндсэндээ нөөцийн ренттэй уялдсан «хэт өндөр ашиг»-т ногдуулдаг татвар юм.*

³⁶ *Уг татварыг хэд хэдэн арга замаар хэрэгжүүлж болно. Жишээ нь, зээлийн үндсэн төлбөр, хүүг хасахыг үл зөвшөөрөхийн оронд зээлийн хөрөнгийг орж ирэх бэлэн мөнгө гэж тооцоод, дараа нь бэлэн мөнгөний урсгалаас хүү, үндсэн төлбөрийг бүрэн хэмжээгээр хасах боломж олгож болох юм. Ийм тохиолдолд санхүүжүүлэх хэлбэрээс хамааран татвар хувьсах болно.*

төслийн хайгуулын зардал зэрэг)-т ашигладаг.

3. Хуримтлагдсан бэлэн мөнгөний хасах утгатай урсгалыг орлогоор бүрэн нөхсөн үед бэлэн мөнгөний эерэг урсгалын үлдэгдэлд харилцан тохиролцсон, эсхүл хуулиар тогтоосон НБРТ-ын хувь хэмжээгээр татвар ногдуулах боломжтой болдог.
4. НБРТ-ын татварын суурийг ашгийн болоод алдагдлын данстай тооцоо нийлүүлэн, өмнөх хүүгийн ашгийг, мөн элэгдэл хорогдлын зардлыг дансны ашиг дээр нэмэн тооцдог. Хуримтлалын хувь хэмжээ нь (ашгийн нийт хувь хэмжээ) өрийн хүү болон хөрөнгийн ашгийг аль алиныг нь хамарч байгаа учир НБРТ нь санхүүжүүлэлтийн хэлбэрээс хамааран өөр үр нөлөөтэй байхгүй. Өмнө тодорхойлсон процедур нь НБРТ-ыг тооцох үед компанийн орлогын татварыг хасан тооцож байгаа юм.³⁷

R хүчин зүйл буюу буцаан төлөх харьцаа. Гуравдахь хувилбар нь хөрөнгө оруулагч оруулсан хөрөнгөө нөхөн олсон буюу хэд нугалж олсон үед нэмэгдэл ашгийн татвар авах явдал юм. Энэ арга зам нь нөөц баялгийн рентийн татвараас ялгаатай бөгөөд ашгийн тогтмол хувь хэмжээг ашигладаггүй, хорогдуулан тооцох хүчин зүйлийг авч

үздэггүй юм. Энд анхдагч хөрөнгө оруулалтын цаг хугацааны асуудлыг тооцдоггүй. Тодорхой тайлбарлах үүднээс ОУВС-гаас тийм татварын жишиг параметруудийг тодорхойлсон. Нэмэгдэл ашгийн татварын суурь нь компанийн орлогын татварын зорилгоор татварногдуулах орлогоос орлогын татварын өрийг хассан хэмжээ байх болно. Нэмэгдэл ашгийн татварын хувь хэмжээ нь *R* хүчин зүйл буюу Буцааж төлөх харьцаа; тодруулбал компанийн нийлмэл нийт орлого (CGR)-ыг компанийн нийлмэл нийт зарлага (CGO)-тай харьцуулсан харьцаа юм. Үүнд хэрэв тооцоог татварын дараахи байдлаар гаргая гэвэл компанийн орлогын татварын төлбөрүүд орно. Дээрх харьцаа нэгээс бага байвал буцааж төлөх явдал хийгдээгүй гэсэн үг. Учир нь нэмэгдэл ашгийн татварын хувь хэмжээ нэмэгдэх тусам түүнийг хэд дахин нугалсан хэмжээгээр өсгөдөг болно. *R* хүчин зүйл нь ашгийн хувь хэмжээний аргачлалаас юугаараа ялгаатай вэ гэвэл энд мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг шууд тооцдоггүйд байгаа юм. Дээрх харьцааны өсөлт хурдан байна уу, удаан байна уу гэдэг нь тооцоо хийхэд хамаагүй. Ямар ч байсан нэмэгдэл ашгийн татварын хувь хэмжээ гарах ёстой хэмжээгээрээ л гардаг. Татварын хувь хэмжээний дараагийн шатлалыг санал болгож болох юм:

<i>R</i> хүчин зүйл	Нэмэгдэл ашгийн татварын хувь (хувиар)	Нэмэгдэл ашгийн татварын хувь + Компанийн орлогын татварын түвшин (хувиар) (1)
< 2	0	25
2 < 3	20	40
3 < 4	40	55
4-өөс их >4	60	70

(1) 25%-ийн компанийн орлогын татварыг нэмэгдэл ашгийн татварын зорилгоор хасаж тооцсон гэж үзэв.

³⁷ Нөөцийн рентийн татвар нь бэлэн мөнгөнд суурилсан учир аккрузль болон бэлэн мөнгө суурьтай данснуудын, тухайлбал авлага, өглөг, бараа бүтээгдэхүүний бэлэн нөөцийн данс зэргийн хооронд хэд хэдэн тохируулга хийх шаардлагатай. Тусгай эскроу данс нээгээгүй тохиолдолд уурхайг хаах зэрэг зарим зардалтай холбоотой асуудлыг тусгайлан авч үзэж, бэлэн мөнгөөр гарах зардал болгон тусгай санд төвлөрүүлэх шаардлагатай.

Бүлэг 15. Бүтээгдэхүүн хуваах гэрээ

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Ашигт малтмалын тухай хуульд заасан, мөн Айвенхоу майнз монголиа инк ХХК, Рио Тинто компаниудтай байгуулахаар хэлэлцэж буй гэрээ хэлцэлд яригдаж ирсэн харилцааг газрын тосны салбарт өргөн хэрэглэгддэг бүтээгдэхүүн хуваах гэрээгээр орлуулах хувилбарыг авч үзэхээр Улсын Их Хурал төлөвлөж байгаа гэж бид ойлгож байна. Энэ санамжид энэ чиглэлээр олон улсын харьцуулсан мэдээлэл өгөх, бүтээгдэхүүн хуваах гэрээг хэрхэн авч хэрэглэх, мөн газрын тосны болон байгалийн хийн бус салбарт бүтээгдэхүүн хуваах тогтолцоог хэрхэн хэрэглэх талаарх анхдагч санал зөвлөмжийг өгөхийг зорив.

Бүтээгдэхүүн хуваах. Бүтээгдэхүүн хуваах нь газрын тос, байгалийн хийн нөөц баялгаа ашиглахад олон улсад хэрэглэдэг гэрээнд суурилсан тогтолцооны нэг хувилбар юм. Концессийн гэрээтэй байх, үндэсний, эсхүл дотоодын газрын тосны компанитай хамтарсан үйлдвэр байгуулахын оронд хөрөнгө оруулагч бүтээгдэхүүний тодорхой хувийг авах нөхцөлтэйгээр тухайн нөөцийг ашиглах ажлыг гүйцэтгэх гэрээг хүлээн зөвшөөрөн байгуулдаг. Иймгэрээ байгуулахад дор дурьдсан хэд хэдэн хувилбар байдаг ч ерөнхийдөө үндсэн болон урсгал зардлыг

багтаасан хөрөнгө оруулалтын зардлыг «өртөгт» тосны борлуулалтаар эхлээд нөхдөг ба үлдсэн бүтээгдэхүүн болох «ашгийн» тосыг³⁸ тухайн Засгийн газар, хөрөнгө оруулагч хоёр хувааж авдаг.

Бүтээгдэхүүн хуваах гэрээнд хамаатай эдийн засгийн ихэнх үзүүлэлтийг мөнгөний нэгж бус бүтээгдэхүүний тоо хэмжээтэй харьцуулсан байдлаар хэмждэг. Өөрөөр хэлбэл, өртөг зардал, нийт болон хуваах бүтээгдэхүүний хэмжээ зэргийг газрын тосны ямар нэгэн хэмжүүртэй харьцуулсан байдлаар хэмждэг. Энэ нь мөнгөний нэгж огт хамаагүй гэсэн үг биш бөгөөд нэгж бүтээгдэхүүний үнийг нийт хэмжээг тооцоход ашиглах шаардлагатай байдаг. Энэ хөрвүүлгийг хийсний дараахи тооцоонуудыг газрын тосны (эсхүл биет бүтээгдэхүүний) хэмжээнд үндэслэн хийдэг. Үнэндээ газрын тос өөрөө хэмжих нэгж болдог. Жишээлбэл, газрын тосны цооног дээрх үнэ баррель тутамд 50 доллар ба 100 баррелийг 1000 долларын өртөгтэйгээр үйлдвэрлэсэн гэж үзье. Мөн «ашгийн» тосны 60 хувийг төр авах ба бүтээгдэхүүн хуваахаас өмнө үйлдвэрлэгч зардлаа нөхөж авах (хэмжээг нь хязгаарлаж болдог—үүнийг дор нэмж тайлбарлав) эрхтэй. Энэ тохиолдолд бүтээгдэхүүнийг дараахи байдлаар хуваана:

	Доллар	Баррель тос
Газрын тосны олборлолт	\$5,000 = 50*100	100
Өртөг	\$1000	20 = 1000/50
Хуваах тос		80
Засгийн газарт ногдох тос		48
Хөрөнгө оруулагчид ногдох тос		32

³⁸ 1993 оны Монголын газрын тос ба Соко монгол инк компаниудын хооронд байгуулсан гэрээнд «ашгийн» газрын тосыг «хуваах тос», мөн «ашигт тос» гэж хоёр янзаар нэрлэсэн байгаа.

Мөнгөн нэгжээр Засгийн газар 2,400 доллар, компани 2,600 долларын үнэтэй (үүний 1,600 доллар нь зардлыг нөхөх тосны үнэ) газрын тосыг авна. 2600 доллар нь баррелиэр хэмжвэл 32 нэгж болно. Эдийн засгийн тооцооны хувьд бүтээгдэхүүн хуваах нь ашиг хуваах бусад тогтолцооноос ялгаагүй нь тодорхой юм. Хэмжих нэгж өөр ч баррель тосыг бэлэн мөнгөнд шилжүүлэн хэмжиж борлуулдаг. Тухайн улс бүтээгдэхүүн хуваах гэрээ, эсхүл уламжлалт татвар ба нөөц ашигласны төлбөр ногдуулах тогтолцоо (төрийн өмчийн оролцоо, гэнэтийн ашгийн татвартай ч байж болно), эсхүл хамтын үйлдвэрийн хэлбэрийг алиныг ашигласнаас үл хамааран олборлолт, өртөг зардал болон үнийн янз бүрийн хувилбарын хувьд санхүүгийн талаас яг ижил түвшний ашгийг авах бололцоо Засгийн газарт байна. Харин энэ хоёр өөр зохицуулалтын хувьд үйлдвэрлэлийн хэмжээ, өртөг зардал, үнийн өөрчлөлтөнд хувирах мэдрэмжийн түвшин өөр өөр байна. Үүнээс гадна эрх зүйн талаас дээрх тогтолцоонууд Засгийн газрын хувьд чухал ялгаа агуулж болно. Бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьд хөрөнгө оруулагч «гэрээлэгч» ба түүний өмчид очих тос бол түүний «ашгийн» тосноос хүртэх хувь, мөн гарсан зардлыг нөхөх үүднээс өөртөө үлдээх «өртөгт» тос юм.

Олон улсын туршлага. Бүтээгдэхүүн хуваах гэрээ, олон улсын харьцуулалтын жишээг Хавсралт 13-д танилцуулав. Индонези Улс дахь хоёрдахь үеийн бүтээгдэхүүн хуваах гэрээ нь дэлхий даяар ийм гэрээний жишиг болсон ба энд мөн тайлбарлав. Гэхдээ улс орон бүрт багагүй онцлог бас байдаг. Тухайлбал:

а. Өсөн нэмэгдэх хэмжээ: Хөрөнгө оруулалтын зардалд инфляци, үндсэн хөрөнгө эзэмших өртөг хоёрын хувьд тохируулга хийх боломжийг олгох үүднээс өсөн нэмэгдэх факторыг ашигладаг. Онолын хувьд үйлдвэрлэлийн өмнөх үе шатанд гарсан зардал, алдагдлыг дараадараачийн жилүүдэд шилжүүлэх ба үндсэн хөрөнгийн эрсдлийг

шингээсэн ашгийн түвшин ба инфляцийг (нөөцийн рентийн татварын үед ашигладаг хэмжээтэй төстэй байж болно) тооцон өсгөн нэмэгдүүлэх ёстой. Өсөн нэмэгдэх тогтмол хэмжээг (тухайлбал, Анголд байдаг) ашиглах нь ийм стандартад дүйж очно.

б. Өртөг зардлын хязгаарлалт: Засгийн газар өөрт ногдох хувийг эрт авах, тухайн жилд авах ашгийн хувийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн орцын хувьд шилжүүлгийн үнэ ашиглах боломжийг хязгаарлах үүднээс хөрөнгө оруулагч гаргасан зардлаа тухайн жилд нөхөх хэмжээг Засгийн газрын зүгээс хязгаарлаж өгч болдог. Тухайлбал, Хятад улсад тухайн жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 60 хувиар зардлаа нөхөх хэмжээг хязгаарладаг ба түүнээс даван гарсан хэмжээг дараа дараачийн жилд тодорхой хүүтэйгээр бүрэн хэмжээгээр шилжүүлэх боломж олгодог.

в. Бүртгэл тооцоо: Бүтээгдэхүүн хуваах гэрээг гол төлөв бэлэн мөнгө суурьтайгаар бүртгэдэг. Өөрөөр хэлбэл, Засгийн газар «ашгийн» тосноос өөрийн хувийг хүртэхээс өмнө үйлдвэрлэлийн өмнөх бүх зардлыг хасч тооцсон байх (зардлыг нөхөх хязгаартайгаас бусад тохиолдолд) үүднээс хайгуулын болон үйлдвэрлэлийн өмнөх зардлыг зардал хэлбэрээр, эсхүл элэгдэл хорогдол тооцох (тухайлбал, 5 жилд багтаан) хэлбэрээр зардал болгон бүртгэдэг.

г. Дотоодын хэрэглээ: Засгийн газар заримдаа газрын тосыг авч дотоодын хэрэгцээнд (магадгүй хямдруулсан үнээр) ашигладаг ба гэрээнд энэ талаар хүлээх үүргийг тусгадаг.

д. Ногдох хувь: Хувь хэмжээ нь газрын тос, байгалийн хийн хооронд, мөн улс орнуудын хувьд өөр өөр байдаг. Нийт бүтээгдэхүүний хэмжээ болон өртөг зардлын үзүүлэлт болсон бусад хүчин зүйлс өөрчлөгдөн нэмэгдэхэд дагаад нэмэгддэг олон шатлалтай хувийг зарим улс оронд ашиглаж эхэлсэн. Ялангуяа «R»-фактор гэгчийг ашигладаг ба өртөг зардлыг тодорхой хэмжээгээр давуулан нөхсөн тохиолдолд Засгийн газарт ногдох

«ашгийн» тосны хэмжээ нэмэгддэг байна.

е. *Ордыг тойруулан хязгаарлах*: Зөвхөн тухайн орд газар, эсхүл цооног дээр бүх тооцоо хийгдэх дүрэм (ring fencing) үйлчилдэг.

ё. *Төрийн өмчийн оролцоо*: Тодорхой нөхцөл (тухайлбал эдийн засгийн хувьд ашигтай орд) бүрдсэн тохиолдолд хувь эзэмших хэлбэрээр төр оролцох боломж (Индонези) байдаг.

ж. *Бусад татвар, нөөц ашигласны төлбөр*: Зарим улсад (Ангол) нөөц ашигласны төлбөр авдаггүй ч ихэнх улсад бүтээгдэхүүн хуваахад хасагдан тооцогддог нөөц ашигласны төлбөрийг авдаг. Мөн ихэнх улсад компанийн ашгийн татвар авдаг болсон. Аж ахуйн нэгжийн ашгийн татварын хувьд үйл ажиллагаа явуулж буй улсдаа төлсөн татварыг хөрөнгө оруулагчийн бүртгэгдсэн улсад гол төлөв татвараас хасч тооцдог. Харин бүтээгдэхүүн хуваах байдлаар хийгддэг төлбөр хоёр учир шалтгааны улмаас илүү ярвигтай. Нэгт, Засгийн газар гэрээлэгчид түүнтэй тохиролцсон хувь хэмжээгээр газрын тос өгч байгаа тул уг төлбөр нь цэвэр бус нийт орлого юм. Өөрөөр хэлбэл, Засгийн газарт ногдох хувь хэмжээ нь татвар биш юм. Хоёрт, бүтээгдэхүүнийг хуваахаас өмнө гэрээлэгч тал бүтээгдэхүүний үнэ цэнийг бүрэн хэмжээгээр хуримтлуулан авч байгаа тул гэрээний дагуух төлбөрийг татвар бус нөөцийн төлбөр гэж авч үзэх боломжтой.

Энгийнээр тайлбарлах зорилгоор бүтээгдэхүүн хуваах тогтолцоог Зураг 4-т үзүүлэв³⁹.

Зураг 5-т уул уурхайд уламжлагдан хэрэглэж ирсэн бүтээгдэхүүн хуваах нөхцөлгүй нөөц ашигласны төлбөр, татвар хосолсон тогтолцоог үзүүлэв.

Зураг 6-т нөөц ашигласны төлбөр, татвар хосолсон тогтолцоог төрийн хувь эзэмших оролцоотойгоор үзүүлэв.

Жишээ. Хавсралт 15-д бүтээгдэхүүн хуваах энгийн бүтцийн дэлгэрэнгүй жишээг үзүүлэв. Газрын тосны цооногос

борлуулалтын цэг хүргэх зардлыг хассан цэвэр үнэ баррель нь 60 доллар ба арван жилийн хугацаанд гарах зардал, олборлолтыг хүснэгтэд өгсөн. Засгийн газарт ногдох хувь 68 хувь байна. Хэд хэдэн гарах үр дүнг онцолж байна:

а. Арилжааны олборлолт эхэлснээс хэдэн жилийн дараа л Засгийн газар «ашгийн» буюу «хуваах» тосноос хүртэнэ. Засгийн газар ямар нэгэн хувь хүртэхээс өмнө хөрөнгө оруулагч олборлолтын өмнөх зардал болон бусад хөрөнгийн зардлаа голдуу нөхөж авсан байдаг. Харин зардлыг хязгаарлаж өгсөн тохиолдолд ашиг хүртэх цаг хугацаа Засгийн газрын хувьд ойртох ба харин хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтаа өсгөж нэмэгдүүлэн тооцох боломжийг олгосон тохиолдолд уг хугацаа улам холдоно.

б. Эдийн засгийн болон бизнесийн талаас авч үзвэл бүтээгдэхүүн хуваах нь ашигт ажиллагааны тодорхой нэгэн хэмжүүр дээр үндэслэсэн хэт өндөр ашгийн татварын ерөнхий хэлбэртэй ижил төстэй юм. Ашигт малтмалаас хамгийн наад захын ашиг хүртэхэд нөөц ашигласны төлбөр чухал, харин ердийн ашгаас хувь хүртэхэд ашгийн татвар оновчтой. Харин нэмэгдэл буюу хэт өндөр ашгийн татварын үүргийг бүтээгдэхүүн хуваах тогтолцоо бүрдүүлж байгаа тул авах шаардлага байхгүй.

в. Төслийн нийт үнэ цэнээс хүртэх, өнөөгийн үнэ цэнээр тооцсон Засгийн газрын хувь бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тохирсон хувиас бага хамааралтай ба бүтээгдэхүүний үнэ өсөх хэрээр буурна (бусад ашигт суурилсан тогтолцооны нэгэн адил). Энэ тохиолдолд Засгийн газрын хүртэх хувь өнөөгийн үнэ цэнийн 96 хувьтай тэнцэж байна. Харин энэ хувь нь дискаунт буюу хорогдуулах хувь хэмжээ, бэлэн мөнгө орох цаг хугацаа, бүтээгдэхүүний үнэ болон бусад хүчин зүйлсээс хамааралтай. Тухайлбал, хорогдуулах хувь нь дотоод өгөөжийн хувьтай тэнцүү байхаар авбал Засгийн газрын

³⁹ Зурагт 1 нь ОУВС-ийн Сангийн асуудал хариуцсан газрын хийсэн хүснэгтийг боловсруулсан хувилбар болно.

авах хувь 100 хувь болно. Харин цэвэр үнэ баррель нь 100 болбол Засгийн газарт ногдох хувь 69 хувь болон буурна. Тиймээс Засгийн газрын хүртэх бодит хувь 100 хувиас илүү ч байж болно (компани сөрөг тэмдэгтэй цэвэр үнэ цэнэ хүртэж, харин Засгийн газар ямар нэгэн ашиг авч байгаа бол), мөн үнэ өссөн тохиолдолд тохиролцсон хувь хэмжээгээ л авч байж болно (тохиролцсон хувь хэмжээ нь өнөөгийн үнэ цэнэ эерэг байгаа тохиолдолд Засгийн газрын хүртэх хувь хэмжээний доод хязгаар юм).

Газрын тос, байгалийн хийгээс бусад салбарт хэрэглэх нь. Эдийн засгийн ба бизнесийн асуудал. Зэс, мөн бусад ашигт малтмалын хувьд бүтээгдэхүүн хуваах тогтолцоог ашиглах нь оновчтой эсэхийг шийдэхэд эдийн засгийн гурван асуудал хамааралтай байж болох юм. Нэгт, бусад ашигт малтмалтай харьцуулахад газрын тос, байгалийн хийн хувьд хөрөнгө оруулалтын зардал нь илүү өндөр, харин үйл ажиллагааны дундаж зардал доогуур байж болзошгүй. Тиймээс газрын тос, байгалийн хийтэй харьцуулахад үйл ажиллагааны ашиг харьцангуй доогуур түвшинд байх магадлалтай. Үндсэн хөрөнгийн зардлыг нөхөх хугацаа хөрөнгө оруулалтын зардлаас хамааран илүү урт хугацаатай байж болно. Хоёрт, газрын тос, байгалийн хий нь дунджаар илүү өндөр ашигт ажиллагааны түвшинтэй байх боломжтой (дунджаар, ахиуц биш). Энэ тохиолдолд бүтээгдэхүүн хуваах тогтолцооны хэрэгжүүлэхэд гарах захиргааны зардал, хүндрэл бэрхшээлүүд ашигтай талуудаас давах боломжтой. Гуравдугаарт буюу хамгийн чухал нь бүтээгдэхүүн хуваах тогтолцоо нь хэт өндөр ашгийн татварын нэгэн хувилбар юм. Хавсралт 15-д үзүүлсэн тогтолцоо нь үнэн хэрэгтээ анх Папуа Шинэ Гвиней Улсад зэсэнд ногдуулсан нөөцийн рентийн татвартай ижилхэн юм. Бүтээгдэхүүн хуваах тогтолцоо болон бусад хэт өндөр ашгийн (ашгаас эсхүл бэлэн мөнгөний сууриас тооцдог) татварын хоорондын ялгаатай тал бол Папуа шинэ Гвиней-д эерэг утгатай хүүгийн түвшин

(эсхүл R-фактор) ашиглагддаг бол Хавсралт 15-д тэгтэй тэнцэх өсгөн нэмэгдэх фактор ашигласан явдал юм. Мөн тооцооны нэгжээр бүтээгдэхүүн хуваах гэрээнд баррель тосыг ашигладаг. Нягтлан бодох бүртгэл талаас өөр чухал ялгаа байж болох ч эдийн засгийн үндсэн бүтцээрээ бүтээгдэхүүн хуваах нь аливаа хэт өндөр ашгийн татвартай ижил төстэй юм.

Зарим нэг талаар, ялангуяа ашгийн түвшин өндөр тохиолдолд нэмэлт орлого хураах талаас бүтээгдэхүүн хуваах нь гэнэтийн ашгийн татвараас давуу байдаг. Гэнэтийн ашгийн татварын хувьд хамгийн хүндрэлтэй асуудал нь хөрөнгө оруулагч өртөг зардлаа нөхсөн эсэх, мөн хэвийн хэмжээний ашиг хүртсэн эсэхээс үл хамааран үйлчилдэгт байдаг. Бүтээгдэхүүн хуваах гэрээг оновчтой байгуулбал өртөг зардлаа нөхөх хүртэл ямар нэгэн татвар ногдуулахгүй, харин өртөгт тосны дээд хэмжээг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тодорхой хувиар хязгаарлаж өгч болдогийг дээр дурьдсан. Мөн Засгийн газарт ногдох ашгийн хувь хэмжээг нэмэгдүүлэх R-факторыг ашиглах нь төсөл тодорхой хугацаанд хэрэгжээд, хөрөнгө оруулалтын ашиг нэмэгдэх тусам Засгийн газарт ногдох хувь хэмжээ нэмэгддэг.

Бүтээгдэхүүн хуваах тогтолцооны үед ашгийн татвар, нөөц ашигласны төлбөрийг авахаар үлдээвэл нэг сууринаас хоёр ойролцоо утгатай төлбөр авах тул давхардсан зүйл болно. Тиймээс бүтээгдэхүүн хуваах гэрээг, эсхүл ашигт суурилсан гэнэтийн ашгийн татвар авах тогтолцоог хэрэглэвэл өнөөгийн үйлчилж байгаа гэнэтийн ашгийн татварыг болиулах нь зүйтэй юм.

Эцэст нь, хэт өндөр ашгийн татвар, эсхүл бүтээгдэхүүн хуваах гэрээг ашиглах үед төр хувь эзэмших хэлбэрээр төсөлд оролцохоос гарах давуу тал нь хязгаарлагдмал юм. Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр Засгийн газар бүх нөөцийг өмчилсөн хэвээр үлдэх ба хөрөнгө оруулагч бол зөвхөн гэрээлэгч, нөөцийг өмчлөхгүй. Өмчлөгчийн хувь эзэмшихээс үүсэх байсан ашиг нь хуваарилаагүй

үлдэх «хуваах» буюу «ашгийн» тосны хувь хэмжээгээр нөхөгдөн орж ирэх юм.

«Хуваах» тосны хөрөнгө оруулагчид очих хэсгийг хууль тогтоомжоор, эсхүл Засгийн газарт ногдох хувь хэмжээг хөрөнгө оруулагчид санал болгох хэлбэрээр өрсөлдөөнт шалгаруулалтаар тогтоож болно. Гэхдээ нөөц нь тодорхой бус ордуудыг

түрээслэхэд өрсөлдөөнт шалгаруулалт нэг их оновчтой биш. Хуулиар зохицуулахад хэт өндөр хувь хэмжээ заавал ашигтай байж болох олон төслүүд хэрэгжихгүй байдалд хүрэх магадлалтай. Гэхдээ энэ нь зөвхөн бүтээгдэхүүн хуваах бус, бусад тогтолцоонд ч үзүүлэлтүүдийг хэт хатуу тогтоовол нэгэн адил гарах үр дүн.

Хэсэг IV. Уул уурхайн орлогын зарцуулалтын асуудал

Бүлэг 16. Эрдэс баялгийн сан байгуулах нь

Энэ бүлэгт эрдэс баялгийн сан байгуулах үндэслэл, зорилго, анхаарах асуудал зэргийн талаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газарт 2006 оны 1 дүгээр сард зохион байгуулсан семинарын үеэр яригдсан асуудлыг сийрүүлэн танилцуулж байна.

Зорилго, үндэслэл

Уул уурхайн салбарын орлого нь ихээхэн эрсдэлтэй, дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзлээс хамааран хувьсаж байдаг. Нөгөө талаас газар доорх баялгийг өнөөдөр ашиглах, эсвэл хойч үедээ үлдээх асуудал баялагтай улс орон бүрт үүсдэг. Өнөөдөр ашигласан тохиолдолд улсынхаа төсөвт уул уурхайн орлогыг төвлөрүүлж хөрөнгө оруулалтын болон бусад хэрэгцээг санхүүжүүлэх боломжтой. Түүнчлэн иргэддээ шууд бэлэн мөнгө хэлбэрээр ч орлогыг хуваарилах хувилбар байдаг. Баялгийг өнөөдөр газар доороос гарган ирж, санхүүгийн хэрэгсэл болгон хойч үедээ үлдээх хэлбэр ч байж болох юм.

Байгалийн баялагтай улс орнууд олон төрлийн эрдэс баялгийн сан байгуулах замаар эдгээр асуудлыг шийдвэрлэхийг зорьсон. Эрдэс баялгийн төрөл бүрийн зорилготойгоор байгуулагдсан сангийн төлөөлөл болгож Аляскийн байнгын сан, Зүүн Тиморын сан, Чад-Камеруны сан, Казахстаны газрын тосны сан, Норвегийн газрын тосны сан, мөн Сао-Томе, Принципийн сан зэргийг нэрлэж болно.

Эрдэс баялгийн салбараас орж ирэх орлогыг захиран зарцуулахад чухам яагаад тусгайлсан сан байгуулдаг вэ? Энд гурван шалтгааныг дурьдаж болно. Үүнд:

1. Ил тод байдал, хяналт

Юуны өмнө тусгайлан сан байгуулах

нь хяналт тавихад хялбар, түүнчлэн ил тод байдлыг хангахад илүү дөхөм гэж үздэг. Баялгаас орох орлого чухам хэрхэн зарцуулагдаж байгаа болон өмчийн эзэн болох ард иргэдийн хүсэл сонирхолд нийцсэн хэлбэрээр, тэдэнд хүрч зарцуулагдаж байгааг хянах боломжийг төр засаг, иргэний нийгэм, компаниудад аль алинд нь олгох юм. Цаашилбал, санг зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавих, олон хөтөлбөрөөр халхавчлан зарцуулах, төсвийн гадуур хяналтгүй зарцуулах зэрэг сөрөг үзэгдлийг шийдэхэд тустай байж болно.

2. Тогтворжилт

Газрын тос, зэс, алт зэрэг байгалийн баялгийн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр ихээхэн хэлбэлзэж байдаг. Энэ хэлбэлзлээс үүдэн улсын төсөвт үүсэх эрсдлийг сөрөх зорилгоор сан байгуулах нь олон тохиолддог. Үнэ өндөр байхад санд төвлөрүүлсэн хөрөнгөд хүрэхгүй хадгалж, харин үнэ огцом буурч, төсөв даган буурах үед төсвийг нөхөх зорилгоор сангаас хөрөнгө татах хэлбэртэйгээр ийм сан үйл ажиллагаагаа явуулдаг. Ингэснээр үнэ өндөр байх үед төсвийн зарлагыг хэт нэмэгдүүлж, дараа нь үнэ буурахад зарлагаа санхүүжүүлэх боломжгүй болох урхинд орохоос сэргийлэх юм.

3. Хуримтлал, хадгаламж

Уул уурхайн баялаг нь хязгаарлагдмал бөгөөд нөхөн сэргээгдэхгүй. Хуримтлал үүсгэх зорилгоор сан байгуулснаар нөөц

баялгийг мөнгөн хэлбэрт шилжүүлж, тодорхой хэмжээгээр хадгалснаар үнэ цэнийг хойч үедээ зориулан хадгалах буюу нэмэгдүүлэх зорилготой. Харин санд хуримтлуулсан хөрөнгөөс олох ашгийг энэ үеийнхэнд зориулан зарцуулах боломжтой.

Сан байгуулсны бусад эерэг үр дагаварт дотоодын үнийн хөөрөгдлийг хязгаарлах, валютын ханшийг өсгөхгүй байх замаар Голланд өвчнийг урьдчилан сэргийлэх, төсвийн үйл явцыг илүү хариуцлагатай болгох, орлогыг илүү хариуцлагатай зарцуулах сонирхолыг бэхжүүлэх зэргийг нэрлэж болно.

Сангийн бүрдүүлэлт, зарцуулалт

Санг байгуулахад хэд хэдэн асуудлыг онцгойлон анхаарах шаардлагатай. Юуны өмнө оновчтой эрх зүйн орчныг бүрдүүлж, бодлогыг ил тод тодорхойлж, түүнийгээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байх нь онцгой чухал. Мөн санг байгуулах болон үйл ажиллагаагаа явуулах үед төсвийн цоорхойг нөхөх, зориулалтын бусаар зарцуулах улс төрийн дарамт учруулахгүй байх, түүнийг хязгаарлах улс төрийн хүсэл, соёл байх ёстой. Түүнчлэн сан байгуулах нь шинэлэг зүйл тул амжилттай байна гэсэн баталгаа байхгүйг санах хэрэгтэй. Гагцхүү хяналтын бүтцийг зөв бүрдүүлж, ажиллуулж чадах нь чухал. Түүнчлэн төр засгийн болон олон нийтийн хяналтыг бэхжүүлж, ил тод байдлыг заавал хангах нь сангийн үйл ажиллагааны амжилтын үндэс болохыг олон улсын туршлага илтгэнэ.

Сангийн үйл ажиллагааны бүтцийг дараахь хэлбэрээр зохион байгуулж болох юм.

- Гадаадад нэг дансанд хөрөнгөө байршуулна. Санг олон улсын туршлагатай байгууллага мэргэжлийн түвшинд удирдана.
- Ашигт малтмал, газрын тосноос санд орох бүх төлбөр (нөөц ашигласны төлбөр, татварууд, лицензийн төлбөр г.м.)-ийг электрон хэлбэрээр санруу шилжүүлнэ.

- Жил бүр сангаас төсөв рүү нэг л удаа, эсхүл урьдчилан тогтсон хязгаарын хүрээнд шилжүүлэг хийнэ.
- Сангаас хөрөнгө зарцуулахад нөөц баялаг шавхагдсаны дараа ч байнга ажиллах боломжтой хөрөнгийн нөөц бүрдүүлэх зорилгоор, эсхүл бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэлтэй уялдуулан хязгаар тогтооно.
- Засгийн газар сангаас зээл авах, орох орлогыг нь бусад зорилгоор зарцуулах зэрэг эрхгүй байна.

Сангийн хөрөнгийг зарцуулах бодлого тус сан нь зөвхөн хуримтлалын, эсхүл тогтворжилтын, эсхүл аль алиных нь чиг үүрэгтэй юу гэдгээс хамаарна. Зарцуулалтад хязгаар тогтоохдоо тус хязгаарыг тодорхойлох бодитой, ил тод зарчмыг баримтлах нь чухал. Эс бөгөөс хязгаарыг янз бүрийн түвшинд тогтоох сонирхол давамгайлж болох юм. Ялангуяа хөрөнгийг зарцуулах эрхийг олгох ямар нэгэн онцгой тохиолдол байх эсэх, байвал чухам ямар үед ийм тохиолдол гарахыг анхааралтай тогтоох хэрэгтэй.

Зарим нэгэн улс оронд сангийн зарцуулалттай холбоотой тогтоосон хязгаарлалтыг танилцуулья. Сао Томе Принципе хэмээх газрын тосны баялагтай Африкийн арал улсын сангийн жил бүр зарцуулах хэмжээгний хөрөнгийн 5 хувь, эсвэл урт хугацаан дахь сангийн бодит өгөөжийн түвшин хоёрын багаар нь хязгаарладаг. Нийт хөрөнгө гэдэг нь тус сангийн байнгын үлдэгдэл, мөн нөөц баялгийн бусад хөрөнгөөс бүрдэнэ. Харин нөөц баялгийн бусад хөрөнгө гэдэгт ирээдүйд олборлох бүтээгдэхүүнийг өмнөх найман жилийн бүтээгдэхүүний дундаж үнэд үржүүлж, хуулиар тогтоосон, хамгийн доод түвшин нь 7 хувь байх хорогдуулах хувийг тооцсон үнэ цэнийг ойлгохоор тогтоосон. Норвег улсын хувьд газрын тосны салбарыг оруулаагүй төсвийн алдагдлын хэмжээгээр сангийн зарцуулалтыг хязгаарласан байдаг. Үнэн хэрэгтээ бусад салбарын төсвийн

алдагдал их хэмжээтэй байж болох тул чанд хязгаар байхгүй гэсэн үг.

Зөвхөн тогтворжилтын зорилгоор байгуулсан сангийн жишээ бол Оросын холбооны улс юм. Оросын сангийн хувьд Урал төрлийн газрын тосны олон жилийн үнийг ашиглан ирээдүйн үнийг тооцоолдог. Энэ үнээс 5 хувиас илүүгээр бодит үнэ дээш доош хэлбэлзсэн тохиолдолд санд хуримтлал хийж, эсвэл зарцуулж байдаг. Тухайлбал, үнэ олон жилийн дундаж тооцоолсон үнээс 5 хувиас илүүгээр хэлбэлзвэл санд хуримтлал хийдэг.

Сангийн удирдлага, хөрөнгө оруулалтын бодлого

Санг удирдах бүлгийг засгийн газар юуны өмнө байгуулах ёстой. Тус бүлэг нь хөрөнгө оруулалтын ямар бодлого, дүрэм журам баримтлахыг тодорхойлно. Түүнчлэн, хөрөнгө оруулалтын зөвлөхүүдийг тодорхойлж, санг удирдуулах байгууллагыг сонгоно. Тухайлбал, Сао Томе-д Удирдлага, хөрөнгө оруулалтын хороо байгуулагдсан ба үүнд Сангийн сайд, Төв банкны ерөнхийлөгч, мөн Ерөнхийлөгчийн томилсон нэг, парламентаас томилсон хоёр санхүү, арилжааны нотлогдсон туршлагатай гишүүнтэй байдаг. Томилогдох гурван хүн нь заавал тус улсын иргэн байх албагүй юм байна. Харин Зүүн Тимор улсад Хөрөнгө оруулалтын зөвлөх зөвлөлийг Төрийн сангийн дарга, Төв банкны ерөнхийлөгч, мөн Сангийн сайдын томилсон 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Сангийн зарцуулалтын бодлогыг зөв тодорхойлж, чанд хэрэгжүүлэх нь чухал. Гол төлөв «тооцоотой хөрөнгө оруулагч»-ийн бодлогыг санг удирдахад хэрэгжүүлдэг ба үүнийгээ хуулинд тодорхойлж өгдөг. Түүнчлэн байнгын хөрөнгийг зарцуулахад нэг (туршлага нэмэгдэх хэрээр харьцангуй уян хатан байж болох) бодлого, харин нөөцлөөгүй хөрөнгийг зарцуулахад өөр (хийж болох хөрөнгө оруулалтад өндөр шаардлага тавигдах) бодлого хэрэгжүүлэх нь элбэг.

Санг удирдахад улс төрийн нөлөөллийг оруулахгүй байх, мөн ашиг сонирхолын

зөрчилтэй нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарах ёстой. Юуны өмнө, дотоодод хөрөнгө оруулахгүй байх, мөн дотоодын иргэдийн өмчийн бизнест хөрөнгө оруулахгүй байх нь чухал. Дотоодын бизнес эрхлэгчдийг дэмжих хөрөнгө оруулалт шаардлагатай бол түүнийгээ тусдаа байгуулж, төсвөөс санхүүжүүлэх хэрэгтэй. Сангийн хөрөнгө, түүний ирээдүйд орох орлогыг барьцаалж зээл олгох, авахыг хориглодог.

Сангийн хяналт

Ил тод байдлыг дээд зэргээр хангах нь сангийн амжилтын үндэс байх болно. Тухайлбал, санд орж байгаа болон гарч байгаа бүх хөрөнгийн хэмжээ, зориулалт, сан, түүний үйл ажиллагааны талаарх санхүүгийн иж бүрэн мэдээлэл, хувийн нууцлалтайгаас бусад бүх байгуулж байгаа гэрээ хэлцэл, сангийн ирээдүйн орлогын тооцоолсон өнөөгийн үнэ цэнэ зэрэг мэдээллийг хуулиар заавал ил тод тайлагнадаг байхаар зохицуулах нь чухал. Түүнчлэн мэдээллийг олон нийт интернэтийн вэб хуудсаар тухай бүрт нь авч болох нөхцлийг хангах хэрэгтэй.

Сангийн үйл ажиллагаанд хяналт тавих тусгай бүтцийг ил тод байдлыг хангах, мөрдөн байцаалт явуулах, сангийн дүрмийн хэрэгжилтийг хангах, бүр зарцуулалтыг зөвшөөрөх зэрэг зорилгоор байгуулсан туршлага бий. Ийм бүтцэд зөвхөн төр засаг бус, компани, иргэний нийгэм, сөрөг хүчин, бүр олон улсын байгууллагуудын төлөөллийг ч оруулж болох юм. Түүнчлэн тухайн улсад ажиллаж буй хууль хяналтын, аудитын, мэргэжлийн хяналтын байгууллагуудыг ч сангийн үйл ажиллагаанд хяналт тавихаар зохицуулж болно.

Сангийн тогтвортой байдлыг хангах нь нэн чухал бөгөөд сангийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах бол дийлэнх олонхийн саналаар, эсхүл бүх нийтийн санал асуулгаар, эсхүл бүр үндсэн хуульд өөрчлөлт оруулахаар шийддэг байж болох юм. Мөн олон улсын түвшинд «итгэлцэл»-ийн гэрээ хэлцэл байгуулах, гуравдагч талын батлан даалт

гаргуулах зэрэг хэлбэрээр сан нь тогтвортой, урт удаан хугацаанд үйл ажиллагаагаа явуулахыг бататгаж болно.

Эцэст нь, олон нийтийн дэмжлэггүйгээр сан үүсгэн байгуулах, үйл ажиллагаагаа явуулах боломжгүй юм. Олон нийтийн итгэлийг хүлээж, тэдэнд мэдээллийг байнга

хүргэдэг, саналыг нь үйл ажиллагаандаа тусгадаг байж л амжилтад хүрнэ. Мэргэжлийн болон байгууллагын чадавхийг бүрдүүлээд зогсохгүйилтод, шударга зарчмыг баримталж, ашиг орлоготойгоор ажиллаж чадсан үед л тэр итгэлийг олж авах боломжтой.

Дүгнэлт: Иргэддээ ээлтэй уул уурхай ба ил тод байдал

1. Томоохон уул уурхайн ордыг ашиглах асуудал анх тавигдсан цаг үеэс буюу 2005 оноос хойш Нээлттэй нийгэм форум өөрийн шинжээчид болон хөндлөнгийн шинжээчид урьжирүүлэн уул уурхайн салбарын бодлогын асуудал, түүн дотроо хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, гэрээний хувилбарт үнэлгээ өгөх, уул уурхайн болон татварын хууль тогтоомжийг шинэчлэх, уул уурхайн гэрээтэй холбоотой асуудлаар гаргасан санал зөвлөмжийг энэхүү гарын авлагад бүлэглэн тусгалаа. Мөн Монгол Улсын онцлог болсон уул уурхайд төрийн оролцоо бий болгох асуудлаар гаргасан санал зөвлөмжийг ч тухайлан авч үзлээ.

2. Мөн Оюу толгойн ордыг ашиглах цогцолбор төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газар ба Айвенхоу майнз монгол инк ХХК-ийн хооронд хийх хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд хийсэн дүн шинжилгээг мөн гарын авлагад дэлгэрэнгүй оруулсан болно.

3. Уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээний хувилбарыг үнэлэх тооцооны загвар, санал болгож буй татварын дэглэм, бүтээгдэхүүн хуваах гэрээ зэрэг санал зөвлөмжүүдийг мөн оруулсан болно.

4. Энэхүү гарын авлага нь Засгийн газар, хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулах, боловсронгуй болгох онол арга зүйн практик ач холбогдолтой гэж үзэж байна. Мөн уул уурхайн болон татвар, орлого, үүнтэй холбогдсон захиргааны зохицуулалт, үнэлгээ, шинжилгээний чиглэлээр ажилладаг судлаачид, их, дээд сургуулийн багш, оюутан, иргэний нийгмийн байгууллагын зүтгэлтэн, ажилтнуудад шинэ мэдлэг олох нэг тулгуур баримт бичиг байх болно.

5. Эцэст нь энэхүү гарын авлагын оршил хэсэгт асуусан асуултын зарим нь энэхүү гарын авлагад хариулагдсан ч зарим нь Нээлттэй Нийгэм Форум болон хөндлөнгийн шинжээчдийн хийсэн шинжилгээнд шаардлагатай хэмжээний бүрэн мэдээлэл олдоогүй, Засгийн газар гэрээний төслийн үндэслэл болгосон шинжилгээний болон зарим тоон материалаа нийтэд ил болгоогүй учир хариулагдаагүй болно.

Хавсралт болон зураг

Хавсралт 1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, тооцох арга зарим улс оронд

2006 оны 2 дугаар сарын 6-ны өдөр

Улс	Зэсийн нөөц ашигласны төлбөр	Алтны нөөц ашигласны төлбөр
АНУ	Холбооны газарт олгосон ашигт малтмалын лицензийн хувьд бүтээгдэхүүн (баяжмал)-н үнийн дүнгийн 5 хувь.	
Канад		
Алберта	-Уурхай дээрх аливаа төлбөр хийгдэхийн өмнөх орлогын 1 хувь -Уурхай дээрх нийт орлогын 1 хувь, эсхүл төлбөрүүд хийгдсэний дараахи цэвэр орлогын 12 хувийн аль өндөр	
Хятад	Нийт борлуулалтын үнийн 2 хувь	Нийт борлуулалтын үнийн 4 хувь
ОХУ	Нийт борлуулалтын үнийн 6 хувь	Нийт борлуулалтын үнийн 8 хувь
Австрали		
Нью Саут Уэлс	Зарим зардлыг хассан орлогын 4 хувь	Зарим зардлыг хассан орлогын 4 хувь
Баруун Австрали	(а) Баяжмал хэлбэрээр борлуулвал 5 хувь, (б) Метал хэлбэрээр борлуулвал 2.5 хувь, эсхүл (в) Никель дайвар бүтээгдэхүүн хэлбэрээр борлуулвал (2005 оны 6 сарын 30-наас хойш), дараахи томъёог хэрэглэж байна: $P \times \frac{U}{100} \times \frac{2.5}{100} = \$R \text{ per tonne}$	- 2000 оны 6 сарын 30-наас хойш олборлосон алтны хувьд 2.5 хувь (07/01/1998-06/30/2000 хооронд 1.25 хувь байсан). - Алтны дундаж спот үнэ унц нь 450 австрали доллараас бага тохиолдолд улиралд 1.25 хувь.
Куинсланд	- тогтмол 2.7 хувь, эсхүл - металын үнээс хамааран 1.5-4.5 хувийн хооронд хувьсах. (Улирал бүр шинэчилдэг, төлөх металаас тооцдог. Жилд \$30,000-н хөнгөлөлт үзүүлдэг. Нөөц ашигласны төлбөр төлөх босго 4 сая доллар. Хөнгөлөлтийг мужид боловсруулалт явуулсан тохиолдолд эдлэнэ.)	- тогтмол 2.7 хувь, эсхүл - металын үнээс хамааран 1.5-4.5 хувийн хооронд хувьсах. (Улирал бүр шинэчилдэг, төлөх металаас тооцдог. Жилд \$30,000-н хөнгөлөлт үзүүлдэг.)
Хойд газар нутаг	Ашигт малтмалын төрөл, олборлосон газрын төрлөөс үл хамааран ашигт малтмалын цэвэр үнийн 18 хувь Цэвэр үнэ= Үйлдвэрлэлийн нэгжээс борлуулсан үнэ– (тухайн жилийн үйл ажиллагааны зардал + Хөрөнгийн хэмжээтэй холбоотой хөнгөлөлт + Зөвшөөрөгдөх хайгуулийн зардал + Яамнаас зөвшөөрсөн бусад хөнгөлөлт)	
Замби	Цэвэршүүлсэн бүтээгдэхүүний үнийн 2–5 хувь	

2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ зарим улс оронд

Улс	Алт	Нүүрс	Төмрийн хүдэр	Зэс
Аргентин	0-3	0-3	0-3	0-3
Канад-Куэбэк	Татвар ногдох орлогын 20 %	Татвар ногдох орлогын 20 %	Татвар ногдох орлогын 20 %	Татвар ногдох орлогын 20 %
Канад-Бритиш Колумби	Татвар ногдох орлогын 15 %	Татвар ногдох орлогын 15 %	Татвар ногдох орлогын 15 %	Татвар ногдох орлогын 15 %
Канад – Онтарио	Татвар ногдох орлогын 18 %	Татвар ногдох орлогын 18 %	Татвар ногдох орлогын 18 %	Татвар ногдох орлогын 18 %
Хятад	4	1	2	2
Гренланд	Тохирдог	Тохирдог	Тохирдог	Тохирдог
ОХУ	6	4	4.8	8
Индонези	2	13.5	2.5	2.5
Мексик	1.5	1.53	--	1.5
Казахстан	Тохирдог	Тохирдог	Тохирдог	Тохирдог
Папуа Шинэ Гвиней	2	--	--	2
Филиппин	23	--	2	2
Польш	10	2	--	3
Узбекистан	4	5.4	3	7.9
Австрали	2.5	7.5	2-7.5	5-7.6
Ирланд	1.5-4.5	1.5-4.5	1.5-4.5	1.5-4.5
Боливи	1-7	--	1	1
Ботсвана	3-10	3-10	3-10	3-10
Лесото	5-10	5-10	5-10	5-10
Малави	5-10	5-10	5-10	5-10
Мозамбик	3-10	3-10	3-10	3-10
Свазиланд	1-2.51-2.5	1-2.5	1-2.5	1-2.5
Танзани	3	3	3	3
Замби	2-5	2-5	2-5	2-5
Зимбабве	2-10	2-10	2-10	2-10
Буркино Фасо	3	2.5	2.5	2.5
Гана	3-12	3-12	3-12	3-12
Зааны ясан эрэг	3	2.5	2.5	2.5
Ангол	2.-5	2-5	2-5	2-5

3. ОХУ-д газрын тосны нөөц ашигласны төлбөрийг тооцдог арга

Нэг тон газрын тосонд ногдох нөөц ашигласны төлбөр (рубль/тон) = $(P - 8) * E / 252$, Үүнд:

P – Татвар тооцох хугацааны Уралын газрын тосны дундаж үнэ US\$/баррель;

E – US\$-н рубльтэй харьцах ханш Төв банкны тогтоосноор.

Хавсралт 2. Уул уурхайн төсөв, санхүүгийн дэглэмийн харьцуулсан судалгаа

Улс	Засгийн газрын оролцооны хэлбэр	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зохицуулалт	Ашгийн татвар	Бусад татвар (Гэнэтийн ашгийн татвар, нөөцийн түрээсийн татвар)	Эх сурвалж
Аргентин	Байхгүй.	Нөөц ашигласны төлбөрийг мужийн захиргаатай тохиролцдог, гэхдээ муж бүр роялти төрлийн татвар ногдуулдаггүй.	Компанийн орлогын татварын түвшин 35 хувь. Нийт бодит татварын хэмжээ 40 хувь. ⁴⁰		Отто (2007) Торрес, Минера Андес
Австрали	Байхгүй. 1999 оны байдлаар хуурай газар дээрх болон 3 далайн милийн доторх нүүрс ус төрөгчийн өмчийн эрхийг муж эзэмшиж байсан. Далай дахь бусад нөөцийн өмчийн эрхийг Хамтын нөхөрлөл эзэмшдэг.	Байгаа. Зарим муж нөөц ашигласны төлбөрийн хэмжээг тодорхой зааж өгөх хэлбэрээр төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ хэлэлцээр хийдэг. Баруун Австрали, Тасмани зэрэг хувь хэмжээг нь тохиролцдог мужаас бусад мужид газрын тосны хөрөнгө оруулалтын 10 хувьтай тэнцэх хэмжээтэй. Далай дахь нөөц ашигласны төлбөр анхдагч лицензийн хувьд 10 хувь ба хоёрдагч лицензийн хувьд 11-12.5 хувь байдаг.	Нийт бодит татварын хэмжээ Баруун Австралид 36.4 хувь байна.	1999 оны байдлаар нүүрсний хөрөнгө оруулалтад хэт өндөр ашгийн татвар ногдуулдаггүй. Зарим нэг онцгой тохиолдлоос бусад бүх оффшор газрын тосны төсөлд нөөцийн түрээсийн татвар ногдуулна. Татварыг тооцох үндэслэл нь бэлэн мөнгөний урсгал юм. (Уг татварыг зөвхөн бэлэн мөнгөний нийт урсгалын одоогийн үнэлгээ эерэг байх тохиолдолд ногдуулдаг.) Татварын хэмжээ 40 хувь бөгөөд орлогын албан татварыг тооцоход түүнийг бүрэн хасч тооцдог.	Дэлхийн банк, Отто (2007), Баруун Австралийн Парламент, Баруун Австралийн батлагдан хуулиуд, Отто (2006), Конрад
Боливи	Засгийн газар нь уул уурхайн зарим компаниудад илүү идэвхтэй хувь хөрөнгө эзэмших үйл явцыг эхлүүлээд байна.	Төрөөс гэрээ хэлэлцээр байгуулж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг тогтооног. Жиндал Стил энд Пауэр компанитай төмрийн хүдрийн ордын нөөц ашигласны төлбөрийг 8-% хувиар тохиролцсон	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар-25 хувь, зарим жилд 25 хувийн нэмэгдэл татвар ногдуулдаг. Албан татварын нийт хэмжээ 42.8 хувь		Отто (2007), Хинду Бизнесс Лине, Вэласко

⁴⁰ Энэ багана дахь нийт бодит татварын хувь хэмжээнд нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг оруулж тооцсон болно.

Ботсвана	15 хувь Засгийн газарт хадгалагдах лиценз-Засгийн газар шинээр байгуулагдаж буй компанид арилжааны нөхцлөөр 15 хувь хүртэл хувь эзэмших боломжтой	10 хувийг үнэгүй эзэмшдэг	Ашигт малтмалын төрлөөс шалтгаалж өөр өөр байна.	Бусад салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудтай харьцуулахад доогуур татвар ногдуулдаг	Үндэсний энциклопеди
Буркина Фасо		Байхгүй (Онтарио)	Жишээ нь Саскачеван компани өөрийн харьцангуй давуу тал бүхий ашигт малтмалд нөөц ашигласны төлбөрийн тусгай хэмжээ тогтоолгосон. Ерөнхийдөө, ихэнх орон нутагт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тогтолцоо байдаггүй. Албертад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг орд бүрийн олборлолтод үндэслэн тогтоох ба газрын тосны хувьд 10-40 хувь, байгалийн хийд 15-35 хувь төлбөрийг үнэ, олборлолтын хэмжээ, ордыг нээсэн огноо болон бусад эдийн засгийн буюу геологийн хүчин зүйлийг харгалзан ногдуулна. Гэхдээ зарим онцгой тохиолдолд ялгаатай төлбөр ногдуулах нь бий.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 35 хувь	Отто, 2007
Канад			Жишээ нь Саскачеван компани өөрийн харьцангуй давуу тал бүхий ашигт малтмалд нөөц ашигласны төлбөрийн тусгай хэмжээ тогтоолгосон. Ерөнхийдөө, ихэнх орон нутагт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тогтолцоо байдаггүй. Албертад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг орд бүрийн олборлолтод үндэслэн тогтоох ба газрын тосны хувьд 10-40 хувь, байгалийн хийд 15-35 хувь төлбөрийг үнэ, олборлолтын хэмжээ, ордыг нээсэн огноо болон бусад эдийн засгийн буюу геологийн хүчин зүйлийг харгалзан ногдуулна. Гэхдээ зарим онцгой тохиолдолд ялгаатай төлбөр ногдуулах нь бий.	Алберта мужид газрын тосонд илүүдэл ашгийн татвар ногдуулдаггүй. Бритиш Колумбид нүүрсний уурхайн ашиглалтад оруулсан хөрөнгө оруулалтаас илүү гарсан ашигт 13 хувийн Цэвэр орлогын татвар ногдуулдаг. Жил бүр үйлдвэрлэлд хэрэглэгдэж буй бэлэн мөнгөний урсгалд 2 хувийн татвар ногдуулдаг. Уг татварыг цэвэр орлогын татвараас хасаж тооцож болно.	Отто (2007), Отто 2006, Конрад

Чили	Байхгүй	Ашигт малтмалын төрлөөс шалтгаалж өөр өөр байх бөгөөд зарим нэг ашигт малтмалын хувьд 5 хувь хүртэл.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 15 хувь бөгөөд компаниуд хоёр төрлийн дэглэмээс сонголт хийж болно. Зөвхөн ашиг болон ногдол ашгаасаа татвар төлсөн тохиолдолд албан татварын нийт хэмжээ 36.6 хувь байна. 20 жилийн тогтвортой байдлын гэрээ байгуулсан тохиолдолд албан татварын нийт хэмжээ 49.5 хувь байна.	Дэлхийн банк, Отто 2007, Омалу
Хятад	Одоогоор байхгүй	Газрын тосны хувьд эргээс дотогш ба эргээс гадагш ордууд гэсэн хоёр өөр тогтолцоо үйлчилдэг. Аль аль нь газрын тосны хувьд 0-12.5 хувь, байгалийн хийн хувьд 0-3 хувь гэсэн шаталсан төлбөр ногдуулна. Уг шатлалыг нөөцийн болон олборлолтын хэмжээг харгалзан тогтооно.	Төв Засгийн газар нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 10 хувиар авдаг бол орон нутгийн Засгийн газар нь 3 хувийг ногдуулдаг. Албан татварын нийт хэмжээ 41.7 хувь	Отто 2007, Конрад
Гана	10 хувийг үнэгүй эзэмшинэ. 20 хувийг хэлэлцээрээр эзэмшинэ.	Ашигт малтмалын үнийн дүнгийн 3-12 хувь	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 35 хувь, албан татварын нийт хэмжээ 54.4 хувь	Дэлхийн банк, Отто 2007, Омалу
Гринланд	байхгүй		Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 35 хувь, албан татварын нийт хэмжээ 50.2 хувь	Отто 2007
Гвиней	байхгүй	байхгүй	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 35 хувь, албан татварын нийт хэмжээ 51.3 хувь	Отто 2007

Индонези	Орон нутгийн хувь хөрөнгө 20 хувь байх ба 5 жилийн хугацаанд 51 хувь болж өснө. 1999 оны байдлаар, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнд ерөнхийдөө олсон илүү ашиг бүрийг гүйцэтгэгч тал болон Пертамина 66 хувь, гүйцэтгэгч тал 34 хувийг авна. Нийт ашгийн 15 хувийг гүйцэтгэгч тал, 85 хувийг Засгийн газар авахаар хувь хэмжээг тогтоосон байна.	Зах зээлийн үнийн 1-5 хувь. 1999 оны байдлаар 3 дахь үеийн зэс олборлох гэрээнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 1 тонн метрт 25 ам.доллараар тогтоосон. Нөөцийн үеийн тодорхой хувиар тогтоосон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ (ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ба экспортын татварын нийлбэр) 3.6. Уг төлбөрийн хэмжээ тухайн ордын шинж чанараас хамаарч өөр өөр байна.	7 дахь үеийн ажлын гэрээний хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 30 хувь байна. Өмнөх татварын хэмжээ 22.5-48 хувь. Албан татварын нийт хэмжээ 46.1 хувь буюу 52.25 хувь (ажлын гэрээ байхгүй бол) байна. Стандарт хэмжээ нь: -10 сая хүртэл рупид 15 хувь -10-50 сая рупид 25 хувь -50 саяас дээш рупид 35 хувь	Тухайн компани хайгуулаас олборлолтод шилжихэд газрын түрээс төлж эхлэх бөгөөд хэмжээ нь нэмэгдэнэ. Газрын тосонд илүүдэл ашгийн татвар ногдуулдаггүй. (1999 оны байдлаар)	Дэлхийн банк, Отто 2007, Омалу, Конрад
Зааны ясан эрэг	10 хувийг үнэгүй эзэмшдэг	Ашигт малтмалын төрлөөс шалтгаалж өөр өөр байна.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 35 хувь, албан татварын нийт хэмжээ 62.4 хувь		Отто 2007
Казахстан	Байхгүй	Ашигт малтмалын төрлөөс хамаарч өөр өөр байна.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 30 хувь, албан татварын нийт хэмжээ 46.1 хувь	Илүүдэл ашгийн татвар ногдуулж болно.	Отто 2007
Лаос	Засгийн газар хуучин төсөлд түүхэн үнэлгээгээр 10 хувийг эзэмшиж болно.	Компаниуд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг Засгийн газартай тохиролцоо ёстой. Сепоны алт, эзсийн уурхайн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 4.5 хувь байдаг.	Стандарт хэмжээ 35 хувь байдаг бөгөөд хөрөнгө оруулагчид татварын хэмжээг 10 хувь, 15 хувь, эсхүл 20 хувь болгон тохиролцож болно.	Газрын түрээсийн хэмжээг талууд хэлэлцэн тохиролцоно. Ерөнхийдөө түрээсийн хэмжээг га дутмаар тооцох бөгөөд тухайн компани хайгуулаас олборлолтод шилжих явцад нэмэгдэх хандлагатай байдаг.	ЖМС Бизнесс форум, Охиана
Мали	Байдаг. Үнэгүй хувь эзэмшдэг				Отто 2007
Мозамбик	байхгүй	Хэмжээ нь янз бүр	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 32 хувь		Отто 2007

Мексик	Байхгүй	1999 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 10-35 хувь байв.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 34 хувь, албан татварын нийт хэмжээ 49.9 хувь	1994 онд нөөцийн түрээсийн татварыг нэвтрүүлсэн бөгөөд анхдагч хэмжээ нь 64 хувь байв. Гэхдээ энэ нь тухайн ордоос шалтгаалж өөр өөр байна. Илүүдэл ашгийн татвар ногдуулдаггүй	Дэлхийн банк, Отто 2007, Конрад
Пакистан		Холбооны Засгийн газар ба орон нутгийн Засгийн газар Катя оул энд Газ компанитай тус компанийн Синдх мужид нүүрс, метаний хайгуул хийх эрхийн талаар тусгасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн гэрээ байгуулсан		Туркистан газ сонин	
Папуа шинэ Гвиней	Засгийн газар хэлэлцрээ хийж 10-30 хувийн орон нутгийн хувь эзэмшиж болно.	Ашигт малтмалын төрлөөс шалтгаалах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тогтолцоо үйлчилдэг	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 30 хувь, татварын тогтвортой байдлын гэрээ байгуулсан бол 32 хувь байна. Албан татварын нийт хэмжээ 42.7 хувь	Нөөцийн түрээсийн татварыг нэвтрүүлсэн анхны орнуудын нэг	Дэлхийн банк, Отто 2007
Перу	Байхгүй	2004 онд хууль баталж 60 ам.доллар хүртэл худалдах үнэд 1 хувь, 60-120 ам.долларт 2 хувь, 120 ам.доллараас дээш худалдах үнэд 3 хувийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахаар заасан. Гэхдээ энэ хуулийн талаар хэлэлцүүлэг үргэлжилсээр байгаа	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 27 хувь бөгөөд татварын тогтвортой байдлын гэрээ байгуулбал 29 хувь байдаг. Албан татварын нийт хэмжээ 46.5 хувь	Засгийн газар гэнэтийн ашгийн татвар ногдуулахын оронд уул уурхайн компаниудтай хэлэлцээ хийж, 5 жилийн хугацаанд 772 сая ам. долларыг ядуурал, хүнс тэжээлийн хомсдлыг бууруулах, нийгмийн эмзэг бүлгийнхэнд туслахад зориулж авахаар болсон	Отто 2007, ИДРС, Экономист 2007а
Польш	Байхгүй	Ашигт малтмалын төрлөөс шалтгаалж өөр өөр байна	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 22 хувь, албан татварын нийт хэмжээ 49.6 хувь		Отто 2007

Өмнөд Африк	Байхгүй	1999 онд төлбөрийн хэмжээ 2-5 хувь байв	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 30 хувь, албан татварын нийт хэмжээ 45.0 хувь	20-40 хувийн нөөцийн түрээсийн татварыг боловсруулаагүй газрын тосны олборлолтод татварын дараахи ашгаас нь тооцож ногдуулдаг. Татварын хэмжээ нь нийт хэдий хэр татвар ногдох орлого хөрөнгийн зардлаас илүү гарснаас шалтгаална. Алтны олборлолтод илүүдэл ашгийн татвар ногдуулдаггүй	Дэлхийн банк, Отто 2007, Экономист 2007a, Конрад
Швед	Байхгүй	Байхгүй	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 28 хувь, албан татварын нийт хэмжээ 28.6 хувь		Отто 2007
Танзани	Байхгүй	Төлбөрийн хэмжээ янз бүр байдаг	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 30 хувь, албан татварын нийт хэмжээ 47.8 хувь		Отто 2007
АНУ	Байхгүй	Ашигт малтмалын "онцгой орд"-ын хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг тусгай хэлэлцээгээр тогтооно. Аризона мужид ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зарим хэсгийг ашигт малтмалын бүтээгдэхүүний нээлттэй үнэ хаялцах худалдаагаар тогтоодог бөгөөд байгуулсан гэрээ бүрт баталгаа болгож нэмэлт төлбөрийн хэмжээг тогтоодог. Офшор газрын тосонд 16 гуравны хоёрын холбооны Үнэгдсэн улсын\ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулдаг.	Төлбөрийн хэмжээ 35 хувь хүртэл шатлан өсдөг. Албан татварын нийт хэмжээ Аризонад 49.9 хувь	Газрын тос, нүүрсэнд илүүдэл ашгийн татвар ногдуулдаггүй.	Дэлхийн банк, Отто 2007, Отто 2006, Аризона ДММР, Конрад

Узбекстан	Байхгүй	Төлбөрийн хэмжээ янз бүр байдаг	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 33 хувь, албан татварын нийт хэмжээ 62.9 хувь	Отто 2007
Замби	Уул уурхайн лицензийг олгохдоо Засгийн газрын оролцооны эрхийг харгалзан үздэг	2007 онд Замби Улс эзсийн орлогод эзлэх хувиа нэмэгдүүлэх үүднээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон аж ахуйн нэгжийн албан татварын хэмжээг нэмэгдүүлсэн. Тус улс төлбөрийн хэмжээг ийнхүү нэмэгдүүлсний дараа уул уурхайн гэрээнүүдийг шинэчлэхээр хэлэлцээ хийж байна.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 25 хувь. Энэ жил ашгийн татварыг 25 хувиас өсгөж 30 хувь болгох санал гарсан	Дэлхийн банк, Хүмүүсийн сонин Онлайн, Муила
Зимбабве	Байхгүй	Засгийн газар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн татварын тогтолцоог бий болгох эсэх талаар судалж байгаа	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 35 хувь, албан татварын нийт хэмжээ 39.8 хувь	Дэлхийн банк, Отто 2007

Хавсралт 3. Төсвийн дэглэмийн хувилбаруудыг тоогоор үзүүлэх тооцооны загвар

Монгол Улсын тогтвортой байдлын гэрээний заалтуудыг хэрхэн өөрчилснөөс хамааран гарах боломжит үр нөлөөг үзүүлэхэд тооцооны загварыг ашиглав. Энэ цаг хугацаанд ингэж үзүүлэх болсон нь хоёр зорилготой. Нэгд, Монгол Улсын шийдвэр гаргагчид энэ жишээнд ашигласны нэгэн адил загварыг боловсруулах нь 1) гэрээний янз бүрийн хувилбаруудыг хараат бус байдлаар үнэлэх боломжийг олгох, 2) харьцангуй эрсдэл, өгөөжийн хэмжүүрийг бий болгох, мөн 3) үнэлж буй тодорхой орд газрын техник үзүүлэлтүүдийн талаар гэрээ байгуулж болзошгүй талуудтай бүтээлч хэлэлцээр хийх үндэс болж өгөх зэрэг зорилтыг хангахад ихээхэн чухал. Хоёрт, доорх үзүүлбэрүүдийг сонгохдоо гэрээний зарим заалтыг, тухайлбал татварын хөнгөлөлт чөлөөлөлт, нөөц ашигласны төлбөр зэргийг өөрчилснөөс үүсэх болзошгүй ашиг, алдагдлыг үзүүлэх зорилгыг агуулсан. Ашигласан загварын хэрэглээ хязгаарлагдмал тул гарсан үр дүн нь бүрэн төгс бус, зөвхөн тодорхой асуудлуудыг тайлбарлан үзүүлэх хэлбэртэй. Гэхдээ үр дүнгийн ерөнхий чиг хандлага үнэн зөв юм.

1. Загвар. Загварт Оюу Толгой төслийн «Ашиглалтын цогцолбор төлөвлөгөө: Гүйцэтгэлийн хураангуй»-д танилцуулсан өгөгдлийг ашиглав. Тухайлбал, бүх үр дүн нь «I үе шат: Суурь кейс»-ийг Бүлэг 10-д танилцуулсан байгаа. Энэхүү дүн шинжилгээнд ашигласан угтвар нөхцлүүдийг энэхүү хавсралтын тайлбар хэсэгт бичсэн болно. Өнөөгийн цэвэр үнэ цэнийн бүх тооцоонд 8 хувийн хорогдуулан тооцох хүүгийн түвшинг ашигласан байгаа.

2. Өр төлбөрийн нөлөө. Авахад хялбар зээл нь хөрөнгө оруулагчаас шаардагдах өөрийн хөрөнгийн хэмжээг бууруулдаг ба үүний дүнд хөрөнгө оруулалтын эрсдлийн зарим хэсгийг зээлдүүлэгчдэд шилжүүлдэг. Хөрөнгө оруулагчийн хувьд үүсэх нэмэлт ашиг нь хүүгийн зардлаа татвараас хасах боломж юм. Ийнхүү хүүг хасан тооцооноор төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнийн илүү их хэсэг Засгийн газраас хөрөнгө оруулагчдад шилжинэ. Энэ чиг хандлагыг Хүснэгт 1-т үзүүлэв. Хөрөнгө оруулагчийн өр төлбөр нэмэгдэх хэрээр төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнийн Засгийн газарт ногдох хувь хэмжээ буурч, харин хөрөнгө оруулагчийн хувьд дотоод өгөөжийн түвшин (IRR) нэмэгдэж байна.⁴¹

Хүснэгт 1. Ашиг өгөөж талуудад ногдох байдалд компанийн өр төлбөр нөлөөлөх нь

Компанийн өр төлбөр, хөрөнгийн хэмжээний харьцаа	0	0.25	0.5	0.75	1
Нийт өнөөгийн цэвэр үнэ цэнэ	3330	3330	3330	3330	3330
Хөрөнгө оруулагчийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ	2039	2124	2209	2292	2374
Засгийн газрын өнөөгийн цэвэр үнэ цэнэ	1291	1206	1121	1038	956
Хөрөнгө оруулагчийн IRR	20.0 хувь	22.45 %	26.11 %	32.54 %	51.53 %

⁴¹ Дотоод өгөөжийн түвшнийг зөвхөн тайлбарлах зорилгоор үзүүлсэнийг анхаарна уу. Ерөнхийдөө дотоод өгөөжийн түвшин нь хөрөнгө оруулалтын ашигтай байдлын сайн үзүүлэлт болж чаддаггүй ба түүнийг хөрөнгө оруулалтын оновчтой шалгуур гэж хэрэглэх нь нэн ховор.

3. Гэрээлэгч талд өгөөжийн доод түвшнийг хангаж өгөх. Байгуулж болзошгүй гэрээ хэлэлцээрт дүн шинжилгээ хийх нэг хандлага бол «Гэрээлэгч тал уг гэрээнд гарын үсэг зурахын тулд хамгийн багадаа ямар хэмжээний төлбөр авах вэ?» гэсэн асуулт тавих явдал юм. Төслийн өнөөгийн үнэ цэнийг тогтмол гэж үзвэл эрсдлийг тооцсон ийм хамгийн доод хэмжээнээс илүү төлбөр хийх шаардлагагүй.⁴² Зөвхөн тайлбарлан үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулагчийн өгөөжийн хамгийн доод түвшин эрсдлийг тооцсоны дараа 20 хувь ба Засгийн газар зөвхөн уг өгөөжийг л хангах тогтолцоог бүрдүүлсэн гэж үзье. Өр төлбөр, хөрөнгийн хэмжээний харьцаа тэгээс илүү тохиолдолд эрсдлийг тооцсон өгөөж нь шаардагдах хамгийн доод түвшнээс илүү байгааг Хүснэгт 1-ээс тодорхой харж болно. Бусад зүйлс тэнцүү байхад Засгийн газар гэрээг хүчинтэй байлгахын хамт нөөц ашигласны төлбөр болон татварын бодлогыг ашиглан Монгол Улсад ногдох ашгийн хувь хэмжээг нэмэгдүүлэх боломжтой.

Боломжит сонголтуудыг тайлбарлахын тулд хоёр алхамт процедурыг ашиглав.⁴³ Нэгд, татварын хөнгөлөлт чөлөөлөлт (ашгийн татварын түвшин 15 хувь байх таван жилийн хугацаанд) болон хөрөнгө оруулалтын хөнгөлөлтийг хасан тооцно. Дараагаар нь хөрөнгө оруулагчийн дотоод өгөөжийн түвшин 20 хувьтай тэнцүү болтол алт болон зэсийн нөөц ашигласны төлбөрийн түвшнийг хувь тэнцүү хэмжээгээр өөрчилнө. Энэ туршилтыг өр төлбөр, хөрөнгийн хэмжээний харьцаа тус бүрийн хувьд гүйцэтгэнэ. Мөн чанартаа энэ нь Засгийн газар санхүүгийн тухайн хөшүүргийн түвшнээс 100 хувь ашиг өгөөжийг нь хүртэх тогтолцоог боловсруулах дасгал юм.⁴⁴ Үр дүнг Хүснэгт 2-т харуулсан ба Засгийн газрын орлогын өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлтийг цаг хугацааны хувьд Хавсралт Зурагт харуулав.

Хүснэгт 2. Туршилт: Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг арилгаж хөрөнгө оруулагч 20 хувийн өгөөжийн түвшнийг хадгалах байдлаар нөөц ашигласны төлбөрийг өөрчлөх

Өр төлбөр, хөрөнгийн хэмжээний харьцаа	Нөөц ашигласны төлбөрийг хувь тэнцүү нэмэгдүүлэх	Засгийн газарт ногдох өнөөгийн цэвэр үнэ цэнэ (8 хувь)	Компанийн IRR
0	1	1291	20 хувь
0.25	1.39	1278	20 хувь
0.5	4.61	1792	20 хувь
0.75	7.81	2304	20 хувь
1	10.96	2808	20 хувь

Жич: IRR нь бүхэлдсэн тоо болно.

⁴² Эдийн засгийн рент-ийн тодорхойлолт нь тодорхой үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай хамгийн доод хэмжээний төлбөрөөс илүү гарсан хэмжээ (худалдан авч байгаа тохиолдолд худалдан авагч төлөхөд бэлэн байгаа дээд хэмжээнээс доогуур хэмжээ)-г хэлдэг.

⁴³ Энэ дасгалын зорилго нь тодорхой урьдчилсан нөхцлүүдийн хувьд Засгийн газар авч болох дээд хэмжээний орлогыг тодорхойлох зорилго болохыг анхаарах нь чухал. Энэ нь Засгийн газар гэрээг зурахад хангалттай доод хэмжээг олох асуудлаас ихээхэн ялгаатай. Засгийн газрын хувьд хөрөнгө оруулагчаас бүх хэт өндөр ашгийг ашиг олохоос нь өмнө (ex ante) авч, харин дараа нь гэрээнд гарын үсэг зурахгүй байх боломжтой. Энгийнээр хэлбэл, энэ тохиолдолд ашигт малтмалыг ашиглах өртөг нь ашиг өгөөжөөсөө давсан байна.

⁴⁴ Мөн чанартаа энэ хоёр алхам нь нийлээд 100 хувийн хэт өндөр ашгийн татварыг бий болгож байгаа.

Хүснэгт 2 дахь өгөгдлүүд нь өр төлбөр, хөрөнгийн хэмжээний харьцаа хувьсахад хөрөнгө оруулагчийн дотоод өгөөжийн түвшнийг тогтмол 20 хувь байлгаж, нөөцийн төлбөрийг хувь тэнцүү нэмэгдүүлсэн тооцоо юм. Тухайлбал, нөөцийн төлбөрийн суурь түвшин 2.5 хувь ба хөрөнгө оруулагчийн өр төлбөр, хөрөнгийн харьцаа 50 хувь бол нөөц ашигласны төлбөрийг 11.5 хувь (2.5×4.61) болгон нэмэгдүүлэх боломжтой. Энэ түвшнийг хөрөнгө оруулалтын хөнгөлөлтгүй, ашгийн 30 хувийн татварын түвшинтэй хамтатгавал хөрөнгө оруулагч 20 хувийн хөрөнгө оруулалтын өгөөж авах явдлыг хангах болно.

Ашгийн татварын өөрчлөлтийг нөөцийн төлбөрийн бүтцэд өөрчлөлт оруулах явдалтай хамтад нь хэрэгжүүлснээр үе тус бүр дэх, үүний дотор эхэн үеүдэд хийгдэх төлбөрийн хэмжээг ч нэмэгдүүлж байна. Үүнийг хавсралт дахь Зураг 1-т үзүүлэв. Засгийн газарт төлөх төлбөрийн хэмжээ ерөнхийдөө төлөвлөсөн олборлолтын хэмжээг дагадаг ба нөөц ашигласны төлбөр нэмэгдэхэд (мөн л санхүүгийн хөшүүргийн үр өгөөжийг бүрэн хүртэхийн тулд) илүү өндөр болдог. Гэхдээ уурхайн ажиллах хугацааны эхэн хэсэгт өр төлбөр, хөрөнгийн харьцаа тус бүрийн хувьд төлөх төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ хэрхэн илүү байгааг тэмдэглэж байна. Эдгээр үр дүн нь тайлбарлан үзүүлэх зорилготой ба бүрэн төгс биш. Учир нь бид татварын өөрчлөлт талуудад хуримтлагдах орлогын хэмжээнээс өөр зүйлд нөлөөлөхгүй гэдэг урьдчилсан нөхцөл тавьсан. Нөөц ашигласны төлбөр өндөр байх нь ангилалтыг сайжруулах, эсхүл уурхайг ашиглах хугацааг бууруулах үр дагавартай байж болно. Учир нь нэмэлт (ахиуц) хэмжээний нөөцийг олборлоход ашигтай бус байх болно. Засгийн газрын хувьд боломжийн сонголтуудыг тооцохын тулд ийм үр нөлөөг авч үзэх шаардлагатай. Гэхдээ уг үр дүнгээс харахад Монгол Улсын хувьд илүү ашигтай төлбөрийн бүтцийг бий болгох хувилбаруудыг, магадгүй үүнд хэт өндөр ашгийн татвар, ашгийн татварын илүү саармаг хувилбар болон илүү боломжийн нөөц ашигласны төлбөр зэргийг Засгийн газар авч үзэх шаардлагатай байна.

4. Бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт. Хөрөнгө оруулагч болон Засгийн газарт ногдох ашиг өгөөжийн төлөвт үнийн өөрчлөлт хэрхэн нөлөөлөхийг үзүүлэх зорилгоор хэд хэдэн туршилтыг гүйцэтгэв. Уг тооцоонд дараахи урьдчилсан нөхцлийг хэрэглэсэн. Үүнд:

- а/ Нөөц ашигласны төлбөрийн хувь нь суурь хувь (2.5 хувь)
- б/ Хөрөнгө оруулалтын хөнгөлөлтийг хассан ба ашгийн татвар уурхайг ашиглах бүх хугацаанд жилийн 30 хувь. (Татварын хөнгөлөлт чөлөөлөлт ба ашгийн татварын хөнгөлөлттэй хугацаа байхгүй.)
- в/ Өр төлбөр, хөрөнгийн хэмжээний харьцаа 50 хувь.

Суурь кейстэй харьцуулан орлогыг өөрчилж туршлагыг гүйцэтгэсэн (суурь кейс = 1). Суурь үеийн орлоготой харьцуулахад орлогыг 20 хувь ба 10 хувиар бууруулсан ба 10 хувь ба 20 хувиар нэмэгдүүлсэн. Гарсан үр дүнг Хүснэгт 3-т үзүүлэв.⁴⁵

Засгийн газарт ногдох хувь хэмжээ аль ч үнийн түвшний хувьд харьцангуй тогтмол байгааг анхаарна уу. Тиймээс үнийн өөрчлөлт бүрийн хувьд талуудад ногдох орлогын хувь хэмжээний өөрчлөлт харьцангуй тогтмол байна. Энэ нь Засгийн газрын орлого ихээхэн хэмжээгээр ашгийн татвараас хамаарч байгаатай холбоотой ба ашгийн татвар нь эрсдлийг хуваалцах хэрэгсэл болох нь тодорхой. Засгийн газарт ногдох хувь хэмжээ харьцангуй тогтмол байгаа нь зарим гэрээнд нийтлэг байдаг өсөн нэмэгдэх төлбөр (үнэ нэмэгдэхэд дагаад нэмэгдэж байдаг нөөц ашигласны төлбөр, эсхүл хэт өндөр ашгийн татвар) ямар нэгэн хэлбэрээр байхгүй байгааг харуулж байна.

⁴⁵ Хорөгдуулан тооцох хувийг аль аль талын хувьд 8 хувь байхаар өнөөгийн үнэ цэнийг тооцов.

Хүснэгт 3. Засгийн газар болон хөрөнгө оруулагчид ногдох харьцангуй хувь хэмжээнд үнийн өөрчлөлтийн үзүүлэх нөлөө

Бүтээгдэхүүний үнийн түвшин	0.80	0.90	1.00	1.10	1.20
Засгийн газрын өнөөгийн үнэ цэнэ	646	882.00	1,121.00	1,359.00	1,597.00
Хөрөнгө оруулагчийн өнөөгийн үнэ цэнэ	1,252	1,731.00	2,209.00	2,688.00	3,166.00
Засгийн газарт ногдох орлогын хувь	34.04%	33.75%	33.66%	33.58%	33.53%
Засгийн газарт ногдох орлогын хувийн өөрчлөлт	NA	36.53%	27.10%	21.23%	17.51%
Хөрөнгө оруулагчид ногдох орлогын хувийн өөрчлөлт	NA	38.26%	27.61%	21.68%	17.78%

5. Дүгнэлт. Дээрх үр дүн нь тайлбарлан үзүүлэх зорилготой болохыг дахин онцлоё. Гэхдээ эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөхөд төлбөрийн урсгал хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар тогтвортой байдлын гэрээний санхүүгийн нөхцлүүдийг Засгийн газар үнэлэх шаардлагатай байгааг эдгээр жишээ харуулж байна гэж найдаж байна. Иймэрхүү аргачлалыг улам боловсронгуй болгон гэрээ хэлэлцээрийг хийх үед сонголтуудаа үнэлэхэд ашиглах нь тустай байх болно. Түүнчлэх дараахи төрлийн дүн шинжилгээг хийх нь мөн ашиг тустай байх болно. Үүнд: а) Эрсдлийн системчилсэн дүн шинжилгээний аргуудыг ашигласан эрсдлийн илүү дэлгэрэнгүй дүн шинжилгээ. б) Төлбөрийн бүтцийн төрөл бүрийн хувилбарыг ашиглан (нөөц ашигласны төлбөр, орлогын татвар болон хэт өндөр ашгийн татвар (үнэ эсхүл ашгийн түвшинд суурилсан)). в) Төлбөрийн өнөөгийн үнэ цэнээс суутгал татвар авсаны (хэрэгцээ ба) үр дүн. г) Компани доторх арилжаа ба шилжүүлгийн үнийн дүрмээс үүсэх үр нөлөө. д) Нөөц ашигласны төлбөр ба Монголын талын орлогын эх үүсвэрийг тооцоход ашиглах цэвэр ашгийн (net back) үнийг тооцох хувилбарууд. Дээрх саналууд тустай байх болно гэдэгт итгэж байна.

Тайлбар

Урьдчилсан нөхцлүүд

1. Загвар нь Оюу Толгой төслийн «Ашиглалтын цогцолбор төлөвлөгөө: Гүйцэтгэлийн хураангуй»-д танилцуулсан өгөгдөлд суурилсан.
2. Гүйцэтгэлийн хураангуй-д танилцуулсан үр дүнг яг дууриан тооцох боломжгүй байв. Үүнийг нөхөхийн тулд өр зээл байхгүй байх суурь хувилбарт дотоод өгөөжийн түвшин 20 хувьтай тэнцүү байхаар орлогыг нэмэгдүүлэн авсан.
3. Инфляцийг тэгтэй тэнцүү байхаар авсан.
4. Орлогын татвар
 - а. Алдагдлыг дараа дараагийн улиралд хязгааргүйгээр шилжүүлэх боломжийг олгосон.
 - б. Элэгдэл хорогдол ба хүүгийн хасалтыг тухайн хуримтлагдсан жилд нь хийнэ.
 - в. «Нарийн санхүүжүүлэлт» хийхгүй байх дүрэмтэй.⁴⁶
 - г. Татварыг хуримтлагдсан жилд нь төлнө.

⁴⁶ «Нарийн санхүүжүүлэлт» гэж хөрөнгө оруулагч холбоотой нэгжид өөрийн хөрөнгөд хөрөнгө оруулах бус зээл олгох явдлыг хэлнэ.

- д. Санал болгож буй гэрээнд тодотгосон байгаа хөрөнгө оруулалтын хөнгөлөлтийг зөвхөн суурь кейсийн хувьд хүчинтэй байхаар тооцов.

1. Санхүүжилт

а/ Эхний үеүдэд сөрөг бэлэн мөнгөний урсгалыг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгө дээр зээл тулгуурлана. Сөрөг бэлэн мөнгөний урсгал нь гол төлөв хөрөнгө оруулалтын зардлаас хамааралтай үүснэ.

б/ Өр төлбөр нь хөрөнгө оруулалтын үед хуримтлагдах хэдий ч хүүгийн зардлыг тооцохгүй.

в/ Хүүгийн түвшин нь хорогдуулан тооцох түвшин юм (дээрх жишээнүүдэд 8 хувьтай тэнцүү). Өр төлбөр/хөрөнгө харьцаа 100 хувь байхад хүүгийн төлбөр нь цорын ганц өөрийн хөрөнгө хэлбэртэй санхүүжилт болохыг анхаарна уу. (Эсрэг тохиолдолд өр төлбөр/хөрөнгө харьцааны энэ түвшинд дотоод өгөөжийн түвшин хязгааргүй байх болно.) Зээлийн болон хорогдуулан тооцох хувь хэмжээг 8 хувь байхаар тооцох нь зээлийн өнөөгийн үнэ цэнэ тэгтэй тэнцүү гэсэн үг. Тиймээс хөрөнгө оруулагч болон Засгийн газар хоёрын дунд ногдох өнөөгийн цэвэр үнэ цэнийн хувь хэмжээ үзүүлэн тус бүрийн хувьд тогтмол байх болно. Параметр дахь өөрчлөлт хоёр талд тус бүрт ногдох хувь хэмжээнд хэрхэн нөлөөлж байгааг үзүүлэх зорилгоор ийм аргыг хэрэглэсэн.

г/ Зээлийн үндсэн өрийг үйл ажиллагааны төгсгөлд нэг дор төлөхөөр тооцсон.

д/ Зээлийн элэгдлийг тооцох төрөл бүрийн хувилбарууд нь дотоод өгөөжийн түвшинд нөлөөлөх боломжтойг тэмдэглэх нь чухал. Өөрөөр хэлбэл, зээлийг нэг дор төлөхтэй харьцуулахад жил бүр хэсэгчлэн хорогдуулан тооцох (хөрөнгийн элэгдлийг тооцдогийн адилаар) нь өөр хэмжээтэй (гол төлөв доогуур) дотоод өгөөжийн түвшинд хүргэдэг.

е/ Өр зээлийг ямар нэгэн өртөггүй гэж тооцсон. Өөр нэг хувилбар бол бүр өр төлбөрийг компанийн дотоод өр төлбөр гэж тооцох явдал юм. Дотоод өгөөжийн түвшин нь энэ тохиолдолд өртөггүй өр зээлтэй харьцуулахад доогуур байна. Учир нь энэ тохиолдолд өр төлбөр бол хөрөнгө оруулалтын үед үнэндээ өөрийн хөрөнгө (эсхүл компанийн бэлэн мөнгөний гадагшлах урсгал) юм. Энд өр төлбөрийн ганц давуу тал нь орлогын татвартай холбоотой. Өртөггүй өр төлбөрийг ашигласнаар хүүгийн орлогын татварын үр дагаварыг тооцохгүй байх боломжийг (Монголд, эсхүл компанийн «эзэн» улс оронд) олгож байна.

2. Татвар


а/ Санал болгож буй нөөц ашигласны төлбөрийг суурь кейст ашигласан.

б/ Суурь кейст санал болгож буй таван жил татвараас чөлөөлж, дараагийн таван жил ашгийн 15 хувийн татвартай байх хувилбарыг ашигласан.

в/ Ашгийн татварын түвшин аливаа хөнгөлөлт чөлөөлөлтгүй ба 30 хувьтай тэнцүү.

г/ Татварын хөнгөлөлт чөлөөлөлт нь зөвхөн хувь хэмжээнд хамаатай. Татварын дэглэмийн бусад хэсэг, тухайлбал суурь татварыг тооцох болон татварын алдагдлыг дараа үед шилжүүлэн тооцох явдал хүчинтэй.

Зураг 1. Өр зээл, хөрөнгө оруулагчийн хөрөнгийн харьцааны янз бүрийн түвшин дэх өнөөгийн үнэ цэнэ



Хавсралт 4. Өнөөгийн үйлчилж буй хууль, гэрээний төслийн заалтуудын харьцуулалт

Хэрэгсэл	Өнөөгийн хууль	Гэрээний төсөл
Нөөц ашигласны төлбөр	Борлуулсан, ачуулсан, эсхүл ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнийн 5.0 хувь.	Борлуулсан, ачуулсан, эсхүл ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнийн 5.0 хувь.
Ашгийн татвар	Хувь хэмжээ: Жилийн татвар ногдох орлого 0-3.0 тэрбум төгрөг бол 10 хувь, 3.0 тэрбум төгрөгөөс илүү бол 300 сая төгрөг дээр татвар ногдох орлогын 25 хувь. Хөрөнгө оруулалтын хөнгөлөлт: Хөрөнгө оруулалтын хөнгөлөлт олгох салбаруудын жагсаалтад уул уурхай ороогүй байгаа. Алдагдлыг ирээдүйд шилжүүлэх: Тухайн жил бүрийн татвар ногдох орлогын 50 хувиар хязгаарлагдсан хэмжээгээр дараагийн 2 жил шилжүүлнэ.	Хувь хэмжээ: Жилийн татвар ногдох орлого 0-3.0 тэрбум төгрөг бол 10 хувь, 3.0 тэрбум төгрөгөөс илүү бол 300 сая төгрөг дээр татвар ногдох орлогын 25 хувь. Хөрөнгө оруулалтын хөнгөлөлт: Анхны хөрөнгө оруулалтын хувьд хөнгөлөлтийг 10 хувиар үзүүлэхээр байгаа. Алдагдлыг ирээдүйд шилжүүлэх: Тухайн жил бүрийн татвар ногдох орлогын 50 хувиар хязгаарлагдсан хэмжээгээр дараагийн 5 жил шилжүүлнэ.
Гэнэтийн ашгийн татвар	Экспортод гаргасан зэсийн баяжмалын хувьд үнэ, суурь үнэ болох 2600 ам доллар ба хайлуулах зардлын нийлбэр хоёрын хоорондын эерэг зөрүүнд 68 хувь байна. Нэг унц алтны хувьд үнэ, 500 ам доллар хоёрын эерэг зөрүүнд 68 хувь байна.	Чөлөөлсөн.
Хил дээр суутгах татвар	Гэрээгээр тусгайлан өөрчлөөгүй бол ногдол ашгийн 20 хувь Канад руу гарах ногдол ашгийн 5 хувь Засгийн газар хоорондын гэрээнд өөрөөр заагаагүй бол хүүгийн төлбөрийн 5 хувь Технологийн төлбөрийн 5 хувь	Бүтцийг нь зөв тодорхойлсон бол чөлөөлөгдөнө Хөрөнгө оруулагчийн Айвенхоу Майнз Лимитед, Рио Тинто болон тэдний харьяа гадаадад орших компаниудад төлөх хүү, менежментийн төлбөр, эрхийн шимтгэл, техникийн болон уул уурхайн зардал зэрэгт давхар татварын гэрээний дагуу татвар ногдуулна. Хэрэв тийм гэрээ байхгүй бол Монгол Улсын хууль тогтоомж үйлчилнэ. 5 хувь байна гэж ойлгож байгаа.
Нэмэгдсэн өртгийн татвар	10 хувь (гэхдээ бүтээгдэхүүнийг экспортлох үед баяжмалын хувьд ч, эцсийн бүтээгдэхүүний хувьд ч НӨАТ тооцох орлого үүсэхгүй)	10 хувь (гэхдээ бүтээгдэхүүнийг экспортлох үед баяжмалын хувьд ч, эцсийн бүтээгдэхүүний хувьд ч НӨАТ тооцох орлого үүсэхгүй) Татварын буцаан олголт хийгдэж дуустал, эсхүл бусад төлөх татвараар буцаан олголт нөхөгдтөл илүүдэл хэмжээнд 3 хувийн хүү тооцогдоно.

Хэрэгсэл	Өнөөгийн хууль	Гэрээний төсөл
Гааль	Холбогдох заалтын дагуу тогтоосон хувь хэмжээ үйлчилнэ.	Барилга байгууламжийг барих үед чөлөөлөх ба түүнээс хойш өнөөгийн үйлчилж буй хувь хэмжээгээр ногдуулна.
Тогтворжилт	Харилцан тохиролцоогүй тохиолдолд байхгүй.	<p>Татварын ерөнхий хуулийн 16, 17-р зүйлд заасан бүх татварын хувьд (тэдгээрээр хязгаарлагдахгүй) бүрэн тогтворжино. (онцгой, хувь хүний татвар, тэмдэгтийн хураамж, усны болон рашаан ашигласны төлбөр, автомашин болон өөрөө явагч хэрэгслийн татвар, газрын төлбөр, мөн бусад татвар, төлбөр, хураамж).</p> <p>Тогтвортой байдал нь хоёр талд тэгш үйлчлэхгүй байна. Татвар нэмэгдэхэд хөрөнгө оруулагч хамгаалагдсан байна. Харин татвар буурахад хөрөнгө оруулагч буурсан хэмжээгээр татвар төлөх боломжтой байна.</p>
Төрийн эзэмших хувь	34 хувь хүртэл хувь эзэмших боломжтой.	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 5-р зүйлээс чөлөөлөх тохиолдолд гэрээ байгуулагдсан өдөр төр 34 хувь эзэмших эрхтэй (5-р зүйлд төрийн өмчлөх хувь хэмжээ ба Монголын хөрөнгийн бирж дээр тухайн компанийн 10 хувийг арилжих заалтууд хамаарна). Гэрээ хүчин төгөлдөр болсны дараа өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх бүх хөрөнгө оруулалтын зардлын 34 хувийг Засгийн газар гаргах ёстой.</p> <p>Засгийн газар өөрт ногдох хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх үүднээс хөрөнгө оруулагчаас зээл авч болно. Лондонгийн банк хоорондын зээлийн хүү (LIBOR) дээр 3.3 хувийн хэмжээтэй хүү төлөх болно. Бүх зээл, хүүг бүрэн барагдуултал ирээдүйн ногдол ашгаас төлбөрийг хийх болно.</p> <p>Менежментийн төлбөр үйлдвэрлэл эхэлтэл бүх хөрөнгийн зардлын 3 хувь, түүнээс хойш бүх хөрөнгийн болон үйл ажиллагааны зардлын 6 хувь байна.</p> <p>Бусад хөрөнгө оруулагчийн зөвшөөрөлгүйгээр Монгол Улс өөрийн хувьцаагаа бүхэлд нь буюу хэсэгчлэн бусдад шилжүүлэх эрхгүй.</p> <p>Монгол Улс менежментийн ямар нэгэн эрх мэдэл эдлэхгүй.</p>

Хавсралт 5. Гэрээнд үнэлгээ өгөх ажлыг эхлэхэд шаардлагатай мэдээллийн загвар тайлан

А. Бэлэн мөнгөний урсгал

	Зүйл	2007	2008
I.	Технологи ба үйлдвэрлэлийн хүчин зүйлс		
	Олборлолтын хэмжээ		
	Баяжмалын хэмжээ		
	Боловсруулсан хүдрийн хэмжээ		
II.	Ерөнхий санхүүгийн мэдээлэл		
	Дотоод борлуулалт		
	Экспортын борлуулалт		
	Үйлдвэрлэлийн зардал (Импортлосон, дотоодоос авсан зэрэг зүйл ангиар ангилсан, мөн харилцан холбоотой этгээдээс авсан үнэ, мөн тухайн зах зээлийн үнэ зэргээр үзүүлсэн байх)		
	Хөрөнгө оруулалтын зардал		
III	Засгийн газарт хийх төлбөр ба Засгийн газрын оруулах хөрөнгө оруулалт		
	Хөрөнгө оруулалтын зардал (аливаа зээлийн санхүүжилтийг хасах)		
	Төслийн мониторингийн зардалтай холбоотой аливаа шууд зардал		
	Засгийн газрын хийх хөрөнгө оруулалтын санхүүжилтийн өртөг (хэрэв байгаа бол)		
	Нөөц ашигласны төлбөр		
	Ашгийн татвар		
	Ногдол ашиг		
	Бусад татвар (зүйл бүрээр байж болно)		

В. Ашигласан төсөөлөл, урьтал нөхцлүүд:

- а/ Орц, гарцын үнэ
- б/ Хүүгийн түвшин (мөн өнөөгийн үнэ цэнийг тооцоход шаардлагатай хорогдуулах хувь)
- в/ Хөрөнгө оруулагчийн зээлийн бүтэц
- г/ Харилцан хамааралтай талуудын хооронд ямар зардал гарах тухай тодотгол

Хавсралт 6. Монгол Улсын Засгийн газар, Айвенхоу майнз монгол инк ХХК-ийн хооронд байгуулагдах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл ба Оюу толгой төслийн хувь нийлүүлэгчдийн гэрээний төсөлд өгөх тайлбар, санал⁴⁷

2007.7.25

Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл

Оршил. Гэрээний оршил хэсэгт хөрөнгө оруулагч 400 сая гаруй ам. долларын хөрөнгө оруулалт хийсэн гэж тэмдэглэсэн байна. Энэхүү гэрээнд уг тоог хөндлөнгийн зүгээс нягтлан шалгах, мөн энэ хөрөнгө оруулалт Айвенхоу Майнз-ын Монгол Улсад эзэмшиж буй бусад лиценз, эрхтэй холбоотой бус зөвхөн Оюу Толгойд хамааралтай болохыг тодорхойлох талаар огт дурьдаагүй байна. Хөрөнгө оруулагчийн бүтэц, зохион байгуулалтыг тодруулах шаардлагатай. Гэрээ нь албан ёсоор Айвенхоу майнз монгол инк ХХК (АММИ) ба Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулагдахаар байгаа ч хөрөнгө оруулалтын гэрээнд «Хөрөнгө оруулагч» гэсэн нэр томъёонд мөн Виржины Арал дахь толгой компанийг багтаан ойлгохоор заажээ. Энэ толгой компани нь Айвенхоу майнз монгол инк ба АММИ-ийн, эсхүл эрх шилжүүлэн хүлээн авсан этгээдийн хувьцааг эзэмших болно. Тиймээс гэрээний бүхий л хэсэгт талуудын эрх үүрэгтэй холбоотой үл ойлгогдох байдал үүсч байна. Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтын гэрээг Монгол дахь тусгай зөвшөөрөл эзэмшигчээс өөр этгээдтэй хийхээр заагаагүй байгаа. Харин Виржины арал дахь компани, Засгийн газрын хоорондын АММИ-ийн өмчлөлтэй холбогдох эрхийн талаархи харилцааг тусдаа Хувь нийлүүлэгчдийн гэрээгээр зохицуулахаар байгаа. АММИ өөрийн хүлээсэн бүх үүргээ, түүний дотор ялангуяа уурхайн үйл ажиллагаагаа зогсоосны дараа хүлээх үүргээ биелүүлэх илүү баталгааг Засгийн газарт олгох үүднээс АММИ-ийн хүлээх үүргийг түүний толгой компаниуд болох Айвенхоу майнз лимитэд болон Рио Тинто давхар баталгаажуулж болох юм. Виржины арал дахь компани нь ихээхэн хөрөнгөтэй бус учир баталгаа гаргах оновчтой этгээд болж чадахгүй.

1 дүгээр зүйл.

1.5 дахь хэсэг. Энэ заалт, 1.11 дахь хэсгийн хамтаар гэрээ байгуулагдсаны дараагаар Монгол Улсад ирээдүйд батлагдах аливаа хуулийг АММИ-ийн хувьд үйлчлэхгүй байх нөхцлийг бүрдүүлж байна. Гэрээнд л тодорхой зохицуулаагүй бол гэрээ нь өнөөгийн хуулийн тогтолцоог бүхэлд нь 30 жилийн туршид хөдөлгөөнгүй болгож байна. Тухайлбал, хөдөлмөр, ус, байгаль орчинтой холбоотой хууль тогтоомж, тэр ч бүү хэл эрүүгийн хуулинд өөрчлөлт орвол эдгээр өөрчлөлт нь АММИ-д хамаарахгүй болох нь. Гэхдээ өөрт нь таатай бус хуулийн аливаа өөрчлөлтөөс АММИ хамгаалагдаж байгаа ч, түүнд таатай шинээр бий болох аливаа хуулийн, эсхүл гэрээний заалтуудыг өөрийн сонирхолд нийцүүлэн ашиглах боломжийг олгож байна. Ашигтай байж болох өөрчлөлтийг ашиггүй байж болох өөрчлөлттэй нь хослуулан зохицуулахгүйгээр, нэг талд үйлчлэх тогтворжилтыг санал болгосон байна. Эдгээр заалтууд нь нийтлэг практиктай

⁴⁷ Эдгээр гэрээ нь Монгол, Англи хэл дээр хийгдэх ба хоёр хувилбар адил тэгш эрхтэй байх ч зөрүүтэй бол Англи хувилбар нь давамгайлахаар байгаа. Харин Англи хувилбарыг Засгийн газар ч, Айвенхоу ч өнөөдрийн байдлаар нийтэд тараагаагүй байна (2007 оны 7-р сарын 24-ний байдлаар). Тиймээс гэрээг эцэслэн батлахын өмнө Англи хувилбарыг нягтлан шалгаж, Монгол хувилбартай тулгах ажилд онцгой ач холбогдол өгөх ёстойг тэмдэглэж байна.

нийцэхгүй байгаагаас гадна Ашигт малтмалын тухай хуулинд зөвшөөрсөн тогтворжилтын хэлбэрээс, өөрөөр хэлбэл татварын орчны тогтворжилтоос давсан зүйл болжээ.

1.7 дахь хэсэг. Энэ заалт нь «түүнтэй холбоотой үйл ажиллагаанд», мөн 15.2-т заасан бусад лицензд хамаарна гэж зааснаар гэрээний үйлчлэх хүрээг өргөтгөж байгаа юм. Энэхүү бусад лицензийн талаар илүү мэдээлэл байхгүй тохиолдолд уг хөрөнгө оруулалтын гэрээгээр хамарч байгаа үйл ажиллагааг бүхэлд нь тодорхойлох боломжгүй юм. Энэ заалтын дагуу АММИ нь Оюу Толгой (6709А)-гоос олсон орлогоос бусад лицензийн дагуу хийсэн хайгуул, бусад үйл ажиллагааны зардлыг хасах боломжтой болж байна. Ийм тохиодолд лиценз тус бүрийн хувьд «тойруулан хаших» аргыг хэрэглэх илүү оновчтой туршлага байдаг ба ингэснээр аль нэг хөрөнгөтэй холбоотойгоор эрж хайх, ашиглах, үйлдвэрлэл явуулахад хүлээсэн алдагдлыг өөр хөрөнгөтэй холбоотойгоор олсон орлогоор нөхөх боломжийг олгохгүй байх юм.

1.10 дахь хэсэг. Энэ заалт нь Монголын хөрөнгийн биржээр хувьцааны 10 хувийг арилжаалахаар санал болгох шаардлагаас хөрөнгө оруулагчийг чөлөөлж байгаа ба ингэснээр уг төсөлд монголчууд хувь эзэмшигчээр оролцох боломжийг хааж байна. Цаашилбал, АММИ-ийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод тайлагнах шаардлагыг сулруулж байгаа юм. Толгой буюу гадаад дахь компаниуд мэдээллийг ил тод тайлагнах үүрэг хүлээсээр байх ч хөрөнгийн биржийн шаардлагын дагуу мэдээллийг олон нийтэд заавал хүргэх, мөн хувьцаа эзэмшигчийг хамгаалах түвшинд энэ тайлагнал нь хийгдэхгүй юм. Хөрөнгө оруулагч өөрийн хувьцааг дотоодын хөрөнгийн биржид зарах нөхцлийг шаардахгүй байлаа ч гэсэн Засгийн газар өөрийн мэдлийн 34 хувиас тодорхой хэмжээгээр хөрөнгийн биржээр арилжих эрхийг хадгалж, үүнд нь хөрөнгө оруулагч дэмжлэг үзүүлэх нөхцлийг тавьж болох юм. Ийнхүү өөрийн хувиас арилжаалахыг Хувь нийлүүлэгчийн гэрээ хориглож байгаа юм. АММИ-д хийж байгаа хөрөнгө оруулалтын үнэ цэнэ цаг хугацаа өнгөрөх тусам буурах магадлалтайг тэмдэглэх хэрэгтэй. Учир нь АММИ нь ганц актив буюу Оюу толгойн уурхайг эзэмшиж байгаа ба энэ нь өөрөө хорогдох хөрөнгө юм.

1.11 дэх хэсэг. 1.5 дахь хэсэгтэй холбоотой тайлбарыг үзнэ үү.

2 дугаар зүйл

2.1 дэх хэсэг. Энэ заалт нь гэрээ хүчин төгөлдөр болох үед үйлчилж буй бүх татвар, хүү, төлбөр, мөн татварын орлогыг тодорхойлох аргыг хөдөлгөөнгүй болгож байна. Ашигт малтмалын тухай хуулийн 29-д татварын орчныг тогтвортой байлгах талаар заасан байгаа. Гэхдээ ийм тогтворжилтод их дүнтэй бус, зардалд суурилсан зарим татвар, төлбөр, хураамжийг хамааруулахгүй байх боломжтой. Түүнчлэн албан татвараас бусад олон төрлийн үйлчилгээ үзүүлсэн, бүтээгдэхүүн нийлүүлсэнтэй холбоотой төлбөр, хураамж, тухайлбал ус, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг, ургамал зэргийг ашигласны төлбөрийг чөлөөлсөн байгаа ба эдгээрийн үнэ өртөг 30 жилийн дотор өөрчлөгдөх нь гарцаагүй. Мөн инфляци, өртөг нэмэгдэх зэргийг үүнд тусгахгүй байна гэсэн үг. Ер нь бол тогтвортой байдлыг нэрлэсэн үнээр тооцож байгаа аливаа төлбөрт олгох ёсгүй. Энэ нь хураах зардал өндөр байдаг ба хөрөнгө оруулагчид нэг их ашиг байхгүй. Энэ хэсэгт мөн тодорхой хувь хүмүүст ногдох орлогын татварыг хөдөлгөөнгүй болгосон байна. Энэ татвар нь тухайн хөрөнгө оруулагчид бус, түүний ажилтнуудад ногдох учиртай. Тиймээс ийм татварыг хөрөнгө оруулагчтай хийж байгаа хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулах ёсгүй. Харин ингэх юм бол АММИ-ийн ажилчид, түүний дотор монгол ажилчид ирээдүйд бусад иргэдтэй харьцуулахад давуу тал эдлэх боломж үүсч байна.

2.3.1 дэх заалт. Уг заалт алтыг Төв банкинд зарсан нөхцөлд Гэнэтийн ашгийн татвараас чөлөөлж байна. Банк нь АММИ-д дэлхийн зах зээлийн түвшинд үнийг нь төлөх үүрэгтэй. Энэ чөлөөлөлт нь хөрөнгө оруулагчийн хувьд ялангуяа төслийн эхний үе шатанд, мөн алтны үнэ

өндөр байхад онцгой ач холбогдолтой. Тухайлал, 2 дахь жилд алтны үйлдвэрлэл сая унцээс илүү байхаар байгаа. Зөвхөн энэ нэг жилд л алтны гэнэтийн ашгийн татвараас орох орлого 100 сая доллараас давж болох юм. Ашигт малтмалын тухай хуулийн 29-р зүйл татварын орчинг тогтворжуулахыг зөвшөөрснөөс чөлөөлж, хөнгөлөхийг заагаагүй. Хөнгөлөлт, чөлөөлөлтийг хууль эрх зүйн тодорхой шаардлагуудыг биелүүлсний үндсэн дээр УИХ-аар шинэ хууль батлан гаргасан тохиолдолд л үзүүлэх боломжтой гэж үзэж байна.

2.3.2 дэх заалт. Энэ заалт АММИ нь таван жилийн дотор өөрөө дангаараа буюу бусадтай нийлж 500,000 тонн баяжмал боловсруулах хүчин чадалтай хайлуулах үйлдвэр барих тохиолдолд түүнийг зэсийн гэнэтийн ашгийн татвараас чөлөөлж байгаа юм. Өнөөгийн үйлчилж байгаа хуулийн дагуу АММИ нь хайлуулах үйлдвэр барьтлаа гэнэтийн ашгийн татварыг төлсөөр байх ёстой. Хайлуулах үйлдвэр барьсаны дараа ч АММИ нь боловсруулаагүй аливаа баяжмалын төлөө гэнэтийн ашгийн татварыг төлсөөр байх учиртай. Мөн хайлуулах үйлдвэрийн хүчин чадал нь олборлох баяжмалын зөвхөн нэг хэсгийг л боловсруулах хүчин чадалтай байх байгаа нь үлдсэн хэсгээс нь авах ёстой байсан Гэнэтийн ашгийн татварын орлогыг алдахад хүргэнэ гэсэн үг юм. Үнийн түвшин ямар байхаас хамааран энэ татвараас авах байсан орлогын хэмжээ нь хайлуулах үйлдвэр байгуулах зардлаас хавьгүй илүү байж болох юм.

2.6.1 дэх заалт. Тус заалт нь АММИ буюу хөрөнгө оруулагч Айвенхоу майнз лимитэд болон Рио Тинто, мөн тэдний салбар компаниудад төлөх ногдол ашгийг татвараас чөлөөлж байна. Энэ нь үндсэндээ өнөөгийн үйлчилж буй хуульд, эсхүл холбогдох татварын хэлэлцээрт өөрчлөлт оруулж байгаа явдал юм. Үндсэндээ 2.4.1-д ногдол ашигт 10 хувийн татвар ногдуулахаар заасныг ч чөлөөлж байгаа мэт ойлгогдож байна.

2.7.2 дэх заалт. Татварын алба хөрөнгө оруулагчийн оруулсан гэх 400 сая долларыг Оюу Толгойтой холбоотой эсэхийг тодорхойлох болно. Энэ зардлыг хүлээн зөвшөөрөх нь үндсэндээ 100 сая долларын шууд татварыг авахгүйд хүрнэ гэсэн үг. Энэ хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулагчид (хувь нийлүүлэх хөрөнгө биш байдлаар) АММИ-г санхүүжүүлэхээр нийлүүлсэн хэмжээгээр хувь нийлүүлэгчийн гэрээний дагуу Монгол Улс санхүүжилт гаргах үүрэг хүлээх тул үнэн хэрэгтээ уг татварын алдагдлын 34 хувийг үүрч байгаа хэрэг.

2.8 дахь хэсэг. Энэ заалт хөрөнгө оруулсны төлөө нэмэлт 10 хувийн татварын хөнгөлөлт эдлэх боломжийг АММИ-д олгож байна. Өнөөгийн мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу уул уурхайн салбар нь Засгийн газраас гаргасан тэргүүлэх ач холбогдолтой салбарын жагсаалтад ороогүй тул энэ хөнгөлөлтийг эдлүүлэх ёсгүй юм.

2.9 дэх хэсэг. Энэ заалтын үйлчлэх хүрээ нь Бүлэг 9-д «үндсэн үйл ажиллагаа»-г тодорхойлсон байдалтай холбоотойгоор тодорхой бус байна. Энэ заалт уг нь тодорхой хэмжээнд «тойруулан хаших» ('ring fencing') оролдлого мэт харагдаж байгаа ч үүнийг тодруулах шаардлагатай.

2.14 дэх хэсэг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу алдагдлыг дараагийн 2 жил шилжүүлэн тооцохыг зөвшөөрсөн ч энэ заалтад 5 жил гэж заасан байна. Уг нь бол татварын сайн бодлого нь алдагдлыг ийнхүү илүү урт хугацаагаар шилжүүлэн тооцохыг зөвшөөрөх бодлого байх болно гэж үзэж байна. Гэхдээ энэ заалт нь өнөөгийн хуультай зөрчилдөж байгааг тэмдэглэж байна.

2.15 дахь хэсэг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.3 дахь хэсгийн дагуу алдагдлыг хязгаарлаж өгсөн энэ заалт нь чухал бөгөөд Монгол Улсад ашигтай. Энэ төсөл ашигтай байхад татварын нийт орлогод нэг их нөлөө үзүүлэхгүй ч энэ орлогын тодорхой хувийг аль болох ойрын үед авах боломжийг олгож байна.

2.16 дахь хэсэг. Энэ заалтаас харахад хайгуул хийх, уурхайн ашиглалтад бэлтгэхэд гарсан бүх зардлыг, үүний дотор биет бус хөрөнгийг 5 жилийн хугацаанд шимтгэн тооцохоор байна. Ингэж ойлгох нь зөв эсэхийг тодруулах шаардлагатай.

2.19 дэх хэсэг. Уг заалтад засвар үйлчилгээ зэрэг зардалд хязгаар тогтоож, шаардлагатай санхүүжилтийн талаар холбогдох заалтуудыг оруулж өгөх хэрэгтэй.

2.20 дахь хэсэг. Экспортлогдсон бүх бүтээгдэхүүний хувьд (үүнд хайлуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн ч орно) НӨАТ-ыг нөхөн олгох тул ийм нөхөн олголтыг хийх ажлыг зохион байгуулах зардал өндөр байж болох юм. Үйл ажиллагаатай холбоотой бус зүйлийг оролцуулахгүйгээр уурхайг НӨАТ-с чөлөөлөх нь илүү хялбар ч байж болох юм. Үүнд тухайн худалдан авалт нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой эсэхийг аудитлах шаардлагатай ч ийм аудит хийх зардал нь нөхөн олголтыг зохион байгуулахаас хямд төсөр байж болно. Энэ замыг хэд хэдэн улс сонгосон байдаг.

2.29-30 дахь хэсгүүд. 2.1 дэх хэсэгтэй холбоотой тайлбарт дурьдсанчлан, ажилтнууд, гэрээлэгчид, бусад хүмүүсийн төлөх орлогын албан татварыг уг гэрээний татварыг тогтворжуулах заалтуудад оруулах нь зохисгүй юм. Монгол Улсад оршин суугчид аль улсын иргэн байхаас үл хамааран нийтлэг үйлчлэх хуулийг л мөрдөх ёстой. Айвенхоу-ийн ажилчид монголчууд байна уу, гадаадынхан байна уу гэдгээс үл хамааран илүү давуу эрх эдлэх учиргүй. Энд дурьдсан татварын хувь хэмжээ нь өнөөгийн үйлчилж байгаа хувь хэмжээ байна.

2.32 дахь хэсэг. Шилжүүлгийн үнийн талаарх ЭЗХАХБ-ын стандартуудад тухайн арилжаа тус бүрийн хувьд хэд хэдэн шилжүүлгийн үнийг тооцох аргыг ашиглахыг зөвшөөрсөн байдаг. Тиймээс энэ заалтын хувьд үнийг урьдчилан тогтоох гэрээ, эсхүл аль аргыг ашиглах тодорхой зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хувьд хангалттай хамгаалалт болж чадахгүй юм.

2.33 дахь хэсэг. Энэ заалт АНУ-ын доллараар данс бүртгэлийг хөтөлвөл валютын ашгийн ханш өөрчлөгдсөнөөс олох ашиг, хүлээх алдагдалд хэрхэн татвар ногдуулах талаар тодорхой заагаагүй байна. Мөн тухайн үед мөрдөж буй валютын ханш гэдэг нь тодорхой бус байна. Энэ нь бэлэн мөнгөн суурьтай, эсхүл аккрузель суурьтай бүртгэлийн алин дээр үндэслэх вэ?

3 дугаар зүйл

3.2 дахь хэсэг. Дэд бүтэц гэсэн нэр томъёог тодорхойлоогүй байна. Үүнд цахилгаан станц, хайлуулах үйлдвэр зэрэг хамаарах эсэх нь тодорхой бус байна.

3.5 дахь хэсэг. Энэ заалтыг хэрхэн хэрэгжүүлэх нь зарим талаараа тодорхой бус байна. Жишээ нь дотоод болон гадаад хайлуулах үйлдвэрт хийх борлуулалтыг төрөл бүрийн нөхцлийн дагуу урт хугацааны гэрээгээр хийж болно. Олон улсын тогтсон үнэ байхгүй тохиолдолд ийм гэрээний үнийг зөвхөн 3.5.3-т үндэслэн хийх нь. Энэ тохиолдолд борлуулалтын үнэлгээ нь гэрээний үнэ байх уу (үнэн хэрэгтээ авсан мөнгө), эсхүл олон улсын үнэ байх уу? Мөн уг үнэлгээг ашиглаж нөөц ашигласны төлбөр, орлогын татварыг тооцох уу? Татвар, нөөц ашигласны төлбөр зэргийг олон улсын үнийн индексийг ашиглан хэрхэн тооцох талаар тодорхой тоон жишээг оруулж өгөх нь илүү оновчтой юм.

3.6 ба 3.7 дахь хэсэг. Энэхүү хайлуулах, цэвэршүүлэхтэй холбоотой зардлыг хэрхэн тооцох нь юунд ашиглагдах нь тодорхой биш байна (жишээ нь, нягтлан бодох бүртгэлийн зорилгоор, татварын зорилгоор, эсхүл нөөц ашигласны төлбөрийг тооцох зорилгоор г.м.). Зөвхөн 3.7 дахь хэсэгт зааснаар нөөц ашигласны төлбөрийг төлөхөд ашиглагдах мэт ойлгогдож байна. Хайлуулах үйлдвэрийн төлбөр нь олон улсын зах зээлийн зардлаас өөр байх тохиолдолд энэ заалтын дагуу нягтлан бодох бүртгэлийн зардлыг тодорхойлж болохгүй. Түүнчлэн «олон улсын зах зээл дээрх дундаж зардал» гэдгийг тодорхойлоогүй байгаа ба хэд хэдэн жишээ оруулах гэх мэт аргаар нэмэлт тайлбар хийх шаардлагатай байх.

3.12 дахь хэсэг. Уурхайг хаахад зориулж хөрөнгө хуримтлуулж байгаа нь шаардлагатай бөгөөд зохистой зүйл. Гэхдээ хуримтлал бүрдүүлэх үүргийг зөвхөн сүүлийн долоон жил

биелүүлэхээр заасан нь хангалттай хэмжээний мөнгө хуримтлуулахгүй байх, эсхүл зардлаас шалтгаалж төлөвлөснөөс наана уурхайг хаахад хүргэж болох юм. Ер нь бол ийм хөрөнгийг бие даасан тусдаа дансанд байршуулах нь чухал. Уурхайг хаах үед АММИ нь бага хэмжээний хөрөнгөтэй, эсхүл огт хөрөнгөгүй үлдсэн байх тул энэ хаахтай холбогдон гарах зардлыг хөрөнгө оруулагчийн толгой компани болох Айвенхоу майнз лимитэд, Рио Тинто нар гаргах баталгааг гаргаж өгөх ёстой.

4 дүгээр зүйл

4.4 дэх хэсэг. Газар ашиглах гэрээ нь их чухал гэрээ байх болно. Энэхүү хөрөнгө оруулалтын гэрээг хэрэгжүүлэх явцад АММИ-ийн Газар ашиглах гэрээний дагуу хүлээх үүргээ биелүүлэх явдлыг баталгаажуулсан заалт огт байхгүй байгаа нь анхаарал татаж байна. Энд АММИ болон түүний хөрөнгө оруулагчид баталгаа гаргах ёстой. АММИ-ийн (эсхүл хөрөнгө оруулагчдын – энэ нь тодорхой бус байна) газар ашиглах эрхийн хугацаа дуусгавар болсон ч дээр нь байгаа бүх байгууламж түүний өмчлөлд байхаар байна.

5 дугаар зүйл

5.4 дэх хэсэг. Байгалийн нөхөн сэргээлтийн тухайн жилийн зардлын 50 хувийг татан байршуулах энэ заалт нь өнөөгийн мөрдөж буй хуулийн дагуу хийгдсэн байгаа ч хэрэгжүүлэхэд хүндрэл учирч болзошгүй заалт юм. Тухайлбал уг зардлыг бодит хэмжээнээс багаар тооцох сонирхолыг төрүүлэх болно.

5.7 дахь хэсэг. Энэ заалт нь байгаль орчны хохирлыг нөхөх хөрөнгө оруулагчийн үүргийг «шууд зардал»-ын хэмжээгээр хязгаарлаж байна. Бусад хохирлыг Засгийн газар өөрөө хариуцах нь байна.

6 дугаар зүйл

Цахилгаан станцын хувьд эцсийн үүрэг хариуцлагыг хэн хүлээх нь маш тодорхой бус байна. Нэг заалтад Засгийн газар цахилгаанаар хангах үүрэгтэй байна. Өөр нэг хэсэгт АММИ цахилгаанаар хангах эрхтэй байна. Хэрэв энэ нь хөрөнгө оруулагчийн үүрэг бол хэд хэдэн зүйлийг тодруулах шаардлагатай байна. Жишээлбэл, цахилгаан станцыг АММИ өмчилж, үйл ажиллагааг нь явуулах уу? Эсхүл өөр этгээд үү? Орлого, зарлагыг нь хэрхэн тайлагнах вэ г.м.

6.3.3 дахь заалт. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь хөрөнгө оруулагч дангаар хэрэглэх байлаа ч томоохон хэмжээний цахилгаан станцыг барих, үйл ажиллагааг нь явуулахад ямар нэгэн тусгай зөвшөөрөл, лиценз шаардахгүй (тэгээд магадгүй хяналт шалгалтгүй) байх нь анхаарал татаж байна. Эрчим хүчний хуулинд 1.5 мВаттаас доош үйлдвэрт ийм зөвшөөрлийг өгсөн байдаг. Оюу толгойн хувьд үүнээс дээш хүчин чадалтай үйлдвэр байх нь ойлгомжтой.

6.5.1 дэх заалт. Энэ заалт нь Засгийн газрын зүгээс хангах цахилгааны үнийг өнөөгийн түвшинд барих утга агуулж байна. Ирээдүйд зардал яаж ч өөрчлөгдөж болно. Тиймээс зардал нэмэгдвэл үнэн хэрэгтээ Оюу толгойд Засгийн газраас татаас өгч байгаа хэлбэр болно.

6.8 дахь хэсэг. Гашуун сухайтын чиглэлд барих олон улсын чанартай зам нь 6.6.2-р заалтад хамаарах эсэх нь тодорхой биш байна. Тийм тохиолдолд АММИ зардлаа ашиглалтын төлбөр, хураамжаар нөхөх боломжтой. Засгийн газар ийм төлбөр, хураамжийг тогтоохоор заасан байгаа ч хураасан мөнгө хэнд очих нь тодорхой биш байна. Тухайн замын элэгдэл, эвдрэлийг хөрөнгө оруулагчийн хүнд даацын өөрөө явагч, ачааны машин үүсгэх магадлал өндөр ч Засгийн газар засвар үйлчилгээг нь хариуцахаар байна.

8 дугаар зүйл

8.5 дахь хэсэг. Энэ заалт мөн дахин 400 сая долларын хөрөнгө оруулалтын зардлыг өнөөг

хүртэл гаргасныг тэмдэглэж байна. Үүнийг аудитаар баталгаажуулах шаардлагатайг өмнө нь дурьдсан.

9 дүгээр зүйл

9.5 дахь хэсэг. Энэ заалтыг илүү тодотгох хэрэгтэй. Сайд гэрээг цуцлаад зогсохгүй, АММИ үүргээ биелүүлээгүйтэй холбогдон алданги авах буюу хохирлыг барагдуулах нөхцлийг хангах боломжтой байх ёстой. Мөн өмнө дурьдсанчлан, хөрөнгө оруулагчийн толгой компаниуд АММИ-ийн үүргийг баталгаажуулсан үүрэг хүлээх ёстой.

Хувь нийлүүлэгчийн гэрээний төсөл

4-р зүйл

4.1 дэх хэсэг. АММИ нь тодорхой зорилгоор байгуулагдсан компани биш учир түүний хийж болох хөрөнгө оруулалтад ямар нэгэн хязгаарлалт байхгүй. Тиймээс АММИ нь татвар төлөгч этгээд болохын хувьд «тойруулан хаших» аргыг энд хэрэглэх боломжгүй болох юм. АММИ-ийн үйл ажиллагааг Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан үйл ажиллагааны хүрээнд хязгаарлах нь илүү оновчтой хувилбар байж болох юм.

4.5 дахь хэсэг. Энд Засгийн газрын томилсон гишүүн нэг талаас Засгийн газрын ашиг сонирхолыг илэрхийлэх эрх (тухайлбал хөдөлмөр хамгаалалтын бодлоготой холбоотой)-ээ хэрэгжүүлэх, нөгөө талаас «компанийн эрх ашигт хамгийн сайнаар нийцүүлэн» ажиллах хоёрын хооронд зөрчил гарч болзошгүйг тэмдэглэх хэрэгтэй.

4.8 ба 4.10 дахь хэсгүүд. ТУЗ, эсхүл хувь нийлүүлэгчдийн шийдвэр гаргах дүрмийн дагуу Айвенхоу-гаар дамжуулан хөрөнгө оруулагчид үндсэндээ шийдвэр гаргах бүх эрхийг хяналтандаа авсан байна. Удирдлагын багийн шийдвэр гаргахын хувьд компанийн хуулийн дагуу байна гэж ойлгож байна. Нэгэнт уурхайг ашиглах технологи, мэдлэгийг хөрөнгө оруулагчид авчирч байгаа тул энэ нь хамгийн оновчтой хувилбар байж болох юм.

5 дугаар зүйл

Энэ зүйлийн зорилго нь олонхи хувьцааг эзэмшигчид шилжүүлгийн үнийг буруугаар ашиглаж (эсхүл өөр санхүүгийн аргуудыг өөрт тохируулан ашиглаж), ашгийг бууруулж, улмаар ногдол ашгийг багасгаж болзошгүй эрсдлээс цөөнх хувьцаа эзэмшигчийг хамгаалах зорилготой гэж ойлгож байна. Энэ нь Компанийн тухай хуулиас арай өөр хэлбэрээ зохицуулагдсан гэж ойлгож байна. Харилцан холбоотой этгээдийн хооронд олон тооны төлбөр (жишээ нь хүү, менежментийн төлбөр, байнгын бус оршин суугч ажилтны үйлчилгээний хөлс, (металын) туршилтын зардал, түрээс, санхүүгийн түрээс, технологийн роялти, нийлүүлэлт г.м.) хийгдэнэ гэж тооцвол ТУЗ-ийн гишүүд (эсхүл тэдний ажилтнууд болон томилсон этгээдүүд) бичиг цаасны ихээхэн хэмжээний ажлыг гүйцэтгэхэд бэлтгэгдсэн байх ёстой. Энэ ажлыг хийхийн тулд Засгийн газар ямар нэгэн хөрөнгө мөнгө гаргах шаардлагатай болох байх. Энд мөн заалтууд тэгш үйлчлэхгүй, эсхүл тодорхой бус байгаа байдал ажиглагдаж байна. Засгийн газар аливаа асуудлыг хөндөн тавиад, уг асуудал батлагдахгүй бол шинжээчтэй холбоотой зардлыг Засгийн газар гаргахаар байна. Харин Засгийн газрын зүгээс ямар нэгэн асуудлыг хөндөн тавих тухай заалтын хувьд компанид учрах хохирлын тодорхой хэсгийг, тухайлбал экспертын зардал г.м. зардлыг хөрөнгө оруулагч мөн адил хариуцах эсэх нь тодорхойгүй байна. Эдгээр заалтын харилцан хамаарал нь Засгийн газрын зүгээс хоорондоо холбоотой компаниудтай зүй бус гүйлгээ, хэлцэл хийгдсэн гэж үзээд асуудал тавих боломжийг ихээхэн хязгаарлаж өгөх юм.

6 дугаар зүйл

6.3 дахь хэсэг. Энэ менежментийн төлбөр нь хэт өндөр гэж төсөөлөгдөж байна. Энэ төлбөрт ямар төлбөрүүд орж байгааг тодруулах нь чухал. Засгийн газар бусад газар ийм төлбөрийн жишиг ямар байдаг талаар судалгаа хийж, УИХ-д танилцуулах ёстой гэж үзэж байна. Тухайлбал, цахилгаан станц, хайлуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, хөрөнгийн зардал уг төлбөрт шингэсэн эсэхийг тодруулах хэрэгтэй. Бид үгүй байх гэж бодож байна, гэхдээ энэ нь тодорхой биш байна. Мөн энэ төлбөрт ороогүй, харин тусад нь төлөх ёстой зүйлсийг ч энд тодотгох шаардлагатай. Харилцан холбоотой этгээдүүдээс АММИ-д үзүүлэх бүхий л үйлчилгээний зардал энд шингэсэн үү? Харилцан холбоотой, эсхүл өөр этгээдийг төлөөлөн ажиллаж байгаа удирдлагын багийн гишүүний Монголд оршин суух зардал үүнд орох уу? Харилцан холбоотой

этгээдүүдийн мэргэжлийн багаас хангаж байгаа ноу хау, мөн технологийн бусад мэдээллийг үүнд хамааруулах уу? Ингэж тодотгохгүй бол АММИ, түүний дотор Засгийн газар үйлчилгээний төлөө давхар төлбөр хийхэд хүрэх боломжтой.

7-р зүйл

7.2 дахь хэсэг. ТУЗ-ийн бүх гишүүд аудиторуудтай харьцсан бүх баримтыг, түүний дотор удирдах багийн зүгээс бичсэн захидлуудыг авах эрхтэй байх ёстой. Шаардлагатай бол цөөнх хувьцааг эзэмшигчдийг төлөөлж буй гишүүд гадны шинжээчдийг авч аудит хийгдсэн болон хийгдээгүй санхүүгийн тайланг өөрсдийн өмнөөс хянуулах эрхтэй байх ёстой. Энэ зардлыг нь компани хариуцах ёстой.

8 дугаар зүйл

Санхүүжүүлэх хүсэлтийг Айвенхоу майнз гаргахгүй бол (хэдийгээр ийм зүйл болох магадлал бага ч) ямар үр дагавар үүсэх талаар тодорхой биш байна. Мөн Айвенхоу-ийн үйл ажиллагааг санхүүжүүлэх бүтэц (зээл, өөрийн хөрөнгийн харьцаа) тодорхой биш байгаа ба үүнийг тодорхой зааж өгөх хэрэгтэй.

8.5 дахь хэсэг. Энэ заалт хэрэгжвэл ТӨК-ийн зээл нь ТӨК төрийн мэдэлд байх нөхцөл хангагдсан тохиолдолд эргэн төлөгдөх бүрэн баталгаатай биш байна. Өөрөөр хэлбэл ТӨК-ийн зээлийг эргэн төлөх үүрэг түүний авах ногдол ашгийн хэмжээгээр хязгаарлагдаж буюу барьцаалагдаж байна. Энэ нь зөв заалт ба хувь нийлүүлэх хөрөнгөө ашгаас төлөх тохиолдолд ийм заалт орж өгөх нь түгээмэл байдаг.

9-р зүйл

9.1 дэх хэсэг. Энэ заалтын дагуу ногдол ашгийг хэрхэн тодорхойлох нь тодорхой бус байна. Ногдол ашгийг татварын дараах үйл ажиллагааны ашгаас ногдол ашгийг хуваарилах ч энэ дүнг гаргах тооцоо нь тодорхой бус байна (жишээ нь бондын хүү, хөрөнгө зарсантай холбоотой хувьцааны ашиг ба алдагдал зэргийг хэрхэн тусгахыг заагаагүй байна). Мөн ашигтай байсан ч ногдол ашгийг тухайн үед төлөөгүй тохиолдолд тодорхой хуримтлал үүсэх талаар зааж өгөх хэрэгтэй. Мөн үндсэн хөрөнгийг хуваарилах бодлого тодорхой бус байна. Хуримтлагдсан ашгийн наад зах нь 50 хувийг ногдол ашиг хэлбэрээр төлөхөөр заасан байгаа ч хөрөнгө оруулагчид менежментээр дамжуулан ногдол ашгийн хэмжээг багасгах тодорхой алхмуудыг хийх боломжтой. Мэдээж Засгийн газар 34 хувь эзэмшихээр шийдэж байгаа тохиолдолд ийм алхам хийсний эдийн засгийн үр ашгийг хүртэхийн тулд ногдол ашиг авах нь ихээхэн чухал.

10 дугаар зүйл

Айвенхоу майнз болон Рио Тинто өөрсдийн эзэмших хувиа бусдад шилжүүлэхэд үнэндээ ямар нэгэн хязгаарлалт байхгүй байна. Учир нь Виржины Арал дахь өөрсдийн эзэмшдэг компанийн хувьцааг шилжүүлэх замаар шууд бус аргаар өөрсдийн хувиа шилжүүлэх боломжтой. Ийм шилжүүлгийг ямар нэгэн байдлаар хязгаарлаагүй байна. Харин ТӨК-ийн хувьд ийм хязгаарлалтууд байгаа (дор үзнэ үү). Түүнчлэн Айвенхоу майнз болон Рио Тинто АММИ-ыг хянах хувьцаагаа бусдад шилжүүлэхээс өмнө Засгийн газрын зөвшөөрлийг авах талаар ямар нэгэн заалт хөрөнгө оруулалтын ч, хувь нийлүүлэгчийн ч гэрээнд байхгүй байна. Ингэснээр харьцангуй хариуцлага сул, эсхүл Монгол Улсын хувьд тааламжтай бус хүлээж авах улс орны гуравдагч этгээдүүдэд уурхайг шилжүүлэх боломж олгогдож байна. Харин ТӨК-ийн хувьд байдал эсрэгээр байна. ТӨК нь өөрийн эзэмших хувийг гуравдагч талд шилжүүлэх бол эхлээд заавал бусад хувь нийлүүлэгчдэд дээрх гуравдагч талд борлуулахтай адил нөхцлийг санал болгох ёстой. Худалдан авч болзошгүй этгээд ямар нэгэн үнийн санал өгвөл түүнийг нь

бусад хувьцаа эзэмшигчид эсэргүүцэж болохыг мэдэх тул Засгийн газрын хувд өөрийн эзэмших хувиас зарахад ихээхэн хүндрэлтэй байх болно. ТӨК нь өөрийн (ТӨК буюу толгой компанийн) хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр зарах боломжтой ч АММИ-д эзэмших хувиасаа уг биржээр борлуулах боломжгүй байна.

11 дүгээр зүйл

ТУЗ-ийг хөрөнгө оруулагчид хянах тул энэ зүйлийн дагуу хөрөнгө оруулагчид өөрсдийн хүссэн мэдээллийг компанийн өмчлөлийн талаарх нууц мэдээлэл гэж сонгож болох нь. Ингэснээр УИХ ч тэр, Монголын олон нийт ч тэр Айвенхоутай холбоотой энэхүү стратегийн хөрөнгө оруулалтыг болон түүнтэй холбоотой компани, Засгийн газар хоорондын санхүүгийн урсгалыг хянах ямар ч боломжгүй болох магадлалтай. Ингэснээр Засгийн газраас нэгдэн орохоор шийдсэн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй байдалд хүрч болно. Рио Тинто уг санаачлагыг бүрэн дэмжихээ илэрхийлсэн ч гэрээний хувьд үүнийг үүрэг болгосон заалт ороогүй байна. Энэ заалтыг өөрчилж, АММИ-ийн санхүүгийн тайлангууд болон компанитай холбоотой бүх материаллаг зүйлсийн талаарх мэдээллийг жил болгон нийтийн хүртээл болгож байх нөхцлийг оруулах шаардлагатай. Ер нь бол мэдээллийг ил тод тайлагнахын хувьд хөрөнгө оруулагчийн аливаа эрх Монгол Улсын хуулийн дагуу байх ёстой ба ийм хууль нь «тогтворжилт»-д хамаарах учиргүй.

13 дугаар зүйл

Энэ зүйлд Оюу толгойтой холбоотой бус актив, лицензийг АММИ-ээс бусдад шилжүүлэхээр заасан байна. Хөрөнгө оруулалтын болон хувь нийлүүлэгчдийн гэрээний хувьд ингэж АММИ-ийн үйл ажиллагааг хязгаарлах нь оновчтой зүйл ба ирээдүйд ямар нэгэн ашигт малтмалын ашиглалтын асуудлаар тусад нь гэрээ хэлцэл хийж болох юм. Гэхдээ өнөөг хүртэл хийсэн гэж хөрөнгө оруулалтын гэрээнд дурьдаад буй 400 сая долларын зардал нь Оюу толгойтой холбоотой бус үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр зарцуулагдсан байх магадлалтай тул энэ дүнг багасгаж засварлах шаардлагатай.

Хавсралт 7. Боловсруулах шатны ашгийг хүртэхийг эрмэлзэхээс үүсэх эрсдлийн жишээ

2007.07.27

I. Оршил

Олон хүмүүс Оюу Толгой зэрэг уул уурхайн үйл ажиллагаанд хувь эзэмших хэлбэрээр төр оролцох ёстой, мөн хайлуулах үйлдвэрийг дотооддоо байгуулах шаардлагатай гэж үзэж байгаа. Боловсруулах шатны үйл ажиллагаанд ийм байдлаар хөрөнгө оруулснаар уул уурхайн үйл ажиллагааны нэмүү өртгийн илүү их хувийг Монгол Улс хүртэх болно гэж тэд үзэж байгаа. Ингэж мэдэгдэх нь үнэнд нийцэх ч, асуудал үүгээр дуусахгүй ба үүнд хоёр шалтгаан байгаа. Нэгд, уул уурхайн нэмүү өртгийн илүү их хувийг хүртэх нь Монгол Улсыг илүү баян болгоно гэсэн үг биш. Монгол Улс илүү баян болох эсэх нь уг нэмүү өртгийн илүү их хувийг хүртэхийн тулд оронд нь ямар боломж алдаж байгаа, юуг золиосолж байгаагаас хамаарна. Хоёрт, боловсруулах болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлснээр Монгол Улсын хувьд хүлээх эрсдлүүдийн мөн чанар өөрчлөгдөнө.

Доорхи зохиомол жишээг ашиглаж энэ хоёр санааг тайлбарлая. Боловсруулах шатны үйл ажиллагаанд илүү хэмжээнд оролцсоноор Монгол Улсын олох ашиг, хүлээх алдагдлыг хэмжиж тооцсон судалгаа бидний мэдэхээр байхгүй байгаа тул ийм бодит бус жишээг авч ашиглаж байгаа болно. Гэхдээ «дараагийн» шатны үйл ажиллагаанд оролцсоноор эдийн засагт ямар байдал үүсч болохыг үзүүлэх зорилготойгоос гадна ийм үйл ажиллагаанд хөрөнгө оруулах эсэх, оруулах бол хэдий хэмжээний хөрөнгө оруулах шийдвэрийг аль болох мэдээлэлтэйгээр гаргахад шаардлагатай ямар төрлийн дүн шинжилгээ байж болох талаар санаа өгөхийг зорьсон болно.

II. Жишээ

- а/ Уул уурхайд оролцох доорх гурван арга зам байна гэж үзье:
- Газар доорх ашигт малтмалын өмчлөгч байх;
 - Уул уурхайн үйл ажиллагаанд хувь эзэмшигчээр оролцох, эсхүл;
 - Хайлуулах үйлдвэр ажиллуулах.
- б/ Дээрх үйл ажиллагаа тус бүрт ногдох нэмүү өртгийн хувь хэмжээ тус бүр 30 хувь, 30 хувь, 40 хувь гэж үзье.
- в/ Улс орон газар доорхи ашигт малтмалын өмчлөгч ба үйлдвэрлэлийн сонголтуудыг авч үзэж байгаа гэж үзье. Үүнд наад зах нь дараахи гурван сонголт байна:
- Ашигт малтмалын өмчлөлөө хадгалж үлдэж, гадаадын хөрөнгө оруулагчид хүдрийг ухан гаргаж, хүдрийг гадагш нь экспортлож, гадаад дахь хайлуулах үйлдвэрт боловсруулалт хийх ажлыг шилжүүлэх;
 - Газар доорх ашигт малтмалаа өмчилж, уурхайн үйл ажиллагааг өөрсдөө явуулж, баяжмалыг гадаадад гаргаж хайлуулах үйлдвэрт өгөх;
 - Газар доорх ашигт малтмалаа өмчилж, уурхайн үйл ажиллагааг өөрсдөө явуулж, дотооддоо хайлуулах үйлдвэр барих.
- г/ Ашигт малтмалаас олох орлого нь тодорхой бус байдлаас хамааралтай. Тухайлбал, энэхүү орлого нь 20-200 нэгжийн хооронд 20 нэгжийн заагтайгаар 10 ялгаатай утгатай байх боломжтой гэж үзье. Мөн энэ 10 утга буюу орлогын түвшин бүгд бодитоор гарах магадлал

ижил тэнцүү гэж бодье. Өөрөөр хэлбэл, тухайн орлого бүрийн хувьд магадлал нь 10 хувь байна.

- д/ Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий уул уурхайгаас бусад үйлдвэрлэлээс бүрэлдэх хэсгийг Бусад ДНБ гэж нэрлэе. Энэ бусад ДНБ нь ямар нэгэн эрсдэлгүй буюу тодорхой бөгөөд дотоодын уул уурхайн боловсруулах шатны үйл ажиллагаа эрхлэхгүй тохиолдолд 100-тай тэнцүү гэж үзье.
- е/ Боловсруулах шатны үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийхэд хувь нийлүүлэгчээр оролцох хөрөнгө гаргах (Айвенхоу майнз-д 34 хувь эзэмшихийн нэгэн адил), мөн хайлуулах үйлдвэр байгуулах зардлыг төлөх (гэнэтийн ашгийн татвараар, эсхүл бусад үйл ажиллагаагаа бууруулах замаар, өөрөөр хэлбэл, хайлуулах үйлдвэрийг гадаадын хөрөнгөөр босгосон тохиолдолд ч уг хөрөнгө нь тухайн (уул уурхайн) үйл ажиллагаатай холбоотой бол уг үйлдвэр нь үнэгүй зүйл биш юм) тул Бусад ДНБ нь буурна. Хувь нийлүүлэгчээр оролцсон тохиолдолд Бусад ДНБ нь 60 болж (уул уурхайн компанийг байгуулах, үйл ажиллагааг нь явуулахад хөрөнгө оруулалтын зардалд 40-г зарна), харин хайлуулах үйлдвэр барих тохиолдолд 20 болж (хайлуулах үйлдвэрт оруулах хөрөнгө нь 40) буурна гэж үзье.

Дээрх мэдээлэлд үндэслэн нийт ДНБ-ийг хувилбар тус бүрээр тооцох боломжтой. Түүнчлэн дундаж дүн, мөн эрсдлийн хэмжээг (стандарт хазайлтыг ашиглан) тооцож болно. Эдгээр тооцооны үр дүнг Хүснэгт 1-т танилцууллаа. Эдгээр үр дүнтэй холбоотой дараахи асуудлуудыг анхаарна уу. Үүнд:

Бүх шатны үйл ажиллагааг төр хариуцаж байгаа тохиолдолд улс орон нэмүү өртгийг 100 хувь хүртэж байгаа ч ашигт малтмалын орлого өндөр биш л бол бусад хувилбартай харьцуулахад илүү ядуу байна.

Дунджаар авч үзвэл, тухайн улс уул уурхайн үйл ажиллагаанд хөрөнгө оруулснаар (зүгээр л нөөц баялгаа өмчлөх хувилбартай харьцуулахад) илүү ядуу болж байгаа ба хайлуулах үйлдвэрт хөрөнгө оруулбал (нөөц баялгаа өмчлөх болон нөөц баялгаа өмчлөөд, мөн уул уурхайн үйл ажиллагаа явуулах хоёр хувилбарын аль алинтай нь харьцуулахад) бүр ч ядуу болж байна.

- а. Улс орны хүлээх эрсдэл (стандарт хазайлтаар хэмжсэнээр) нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, нөөц баялгаа өмчлөгч байж, түүнийгээ зүгээр бусдад зараад байж байхтай харьцуулахад улс орон илүү ядуу болоод зогсохгүй илүү их эрсдэлийг үүрэх болж байна.

Мэдээлэл дээр тулгуурлаж зөв шийд гаргахад юу хэрэгтэй вэ?

Ийм дүн шинжилгээ хийж, сонголтуудыг тооцож үзсэн рациональ хүн, эсхүл Засгийн газар дээрх жишээнд үзүүлсэн боловсруулах болон хайлуулах шатны үйл ажиллагаанд хөрөнгө оруулахгүй нь лавтай. Харин Оюу Толгойн гэрээний төсөл хэр ашигтайг шийдэхэд тулгарах нэг асуудал бол хайлуулах үйлдвэр болон хувь нийлүүлэгчээр оролцох хувилбаруудыг сонгосноор үүсэх эрсдэл, ашиг өгөөжийг эдийн засгийн үүднээс бидний ойлгож байгаагаар судлаж үзээгүй байгаа явдал юм. Ийм дүн шинжилгээг хийх боломжтой ба гэрээг батлах, эс батлах шийдвэр гаргахаас өмнө зайлшгүй хийсэн байх шаардлагатай юм.

Тухайлбал, уг дүн шинжилгээ нь дараахь гурван хэсгийг агуулсан байна:

- б. Нөөц баялгаа өмчлөх эрхээ хадгалж, татваруудаа хураах хувилбараас үүсэх эрсдэл, ашиг ямар байх вэ? (Өөрөөр хэлбэл, уул уурхайн үйл ажиллагаанд төр хувь нийлүүлэгчээр оролцохгүй байхаар гэрээ байгуулбал гарах ашиг, алдагдал ямар байх вэ?)
- в. Уул уурхайн үйл ажиллагаанд оролцсоноор үүсэх эрсдэл, ашиг ямар байх вэ? Оюу толгойн хувьд Засгийн газар хувь нийлүүлэгчээр оролцох болсноор үүсэх санхүүгийн ашгаасаа ирээдүйд хийгдэх бүх хөрөнгө оруулалтын 34 хувийг санхүүжүүлэх ёстой. Тиймээс

хайлуулах үйлдвэр барихгүй тохиолдолд Засгийн газар ашигт малтмалын эзэмшлээс бүх ашгаа хүртээд, дээр нь хувь нийлүүлэгчийн хувьд 34 хувийг эзэмшинэ. Үүний өртөг нь бусад салбар дахь нэмүү өртөг (хамгийн багадаа хөрөнгө оруулалтын зардлын хэмжээгээр) буурах явдал ба ашигт малтмалын үнийн өөрчлөлтөөс илүү хамааралтай болох явдал юм (магадгүй эдийн засгийн бусад салбарт үүсэх эрсдэл буурах явдлаар энэ өртөг тодорхой хэмжээгээр нөхөгдөнө).

- г. Нөөц баялгаа өмчлөх, 34 хувийн хувь нийлүүлэгчээр оролцох, мөн дотоодоо хайлуулах үйлдвэр барих хувилбараас үүсэх эрсдэл, ашиг ямар байх вэ? Үүний ашигтай тал нь уул уурхайгаас үүсэх нэмүү өртгийн (үүнд зарим хэсэг нь 34 хувь эзэмших, мөн татвар хураалтаас орж ирнэ) илүү их хувь хэмжээг хүртэх явдал юм. Харин энэ хувилбарын өртөг нь бусад салбар дахь үйлдвэрлэл (гэнэтийн ашгийн татвар авахгүй байх, мөн бусад алдагдсан боломжийн шууд өртгөөс хамааран санхүүжилт буурах замаар) буурах ба илүү их эрсдэл үүрэх явдал юм.

Дээрх гурван сонголтын үнэ өртөг, тэдгээрийн зөрүүг тооцох боломжтой ба эрсдэл хүлээх явдлыг ч ямар нэгэн хэлбэрээр хэмжих боломжтой. Улсын Их Хурал мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргахад ийм дүн шинжилгээ хийгдсэн байх нь чухал гэж бид үзэж байна.

Хүснэгт 1

Боловсруулах шатны нэмүү өртгийг хүртэх оролдлогоос үүсэх эрсдлийн жишээ

Төр нөөц баялгийн өмчлөгч л байх хувилбар	Нөөц баялгийн өмчлөгч ба уул уурхайн үйл ажиллагаанд хувь нийлүүлэгч байх хувилбар			Нөөц баялгийн өмчлөгч, хувь нийлүүлэгч, мөн дотоодын хайлуулах үйлдвэр байгуулах хувилбар					
	Уул уурхайн борлуулалтын орлого	Уул уурхайн ДНБ	Бусад үйл ажиллагааны ДНБ	Нийт ДНБ	Уул уурхайн ДНБ	Нийт ДНБ	Уул уурхайн ДНБ	Бусад ДНБ	Нийт ДНБ
20.00	6.00	100.00	106.00	12.00	60.00	72.00	20.00	20.00	40.00
40.00	12.00	100.00	112.00	24.00	60.00	84.00	40.00	20.00	60.00
60.00	18.00	100.00	118.00	36.00	60.00	96.00	60.00	20.00	80.00
80.00	24.00	100.00	124.00	48.00	60.00	108.00	80.00	20.00	100.00
100.00	30.00	100.00	130.00	60.00	60.00	120.00	100.00	20.00	120.00
120.00	36.00	100.00	136.00	72.00	60.00	132.00	120.00	20.00	140.00
140.00	42.00	100.00	142.00	84.00	60.00	144.00	140.00	20.00	160.00
160.00	48.00	100.00	148.00	96.00	60.00	156.00	160.00	20.00	180.00
180.00	54.00	100.00	154.00	108.00	60.00	168.00	180.00	20.00	200.00
200.00	60.00	100.00	160.00	120.00	60.00	180.00	200.00	20.00	220.00
Дундаж			133.00			126.00			130.00
Эрсдэл (Стандарт хазайлт)			17.23			34.47			57.45

Урьдчилсан нөхцөл: нөөц өмчлөгч, татвар хураагч хувилбарт орлогын 30%, хувь нийлүүлэгч хувилбарт 30%, хайлуулах үйлдвэр бүхий хувилбарт орлогын 40% тус тус ногдоно.

Хавсралт 8. Жишиг дүн шинжилгээг хийхэд ашигласан урьтал нөхцөл

	Зүйл	Нөхцөл	Монгол Улсад ногдох хувьд үзүүлэх нөлөө
1	Нөөц ашигласны төлбөр	Хайлуулах үйлдвэрийн зардлыг тооцсон үнийн 5%	Тээврийн болон бусад боловсруулах зардлыг оруулаагүй бол их
2	Хайлуулах үйлдвэрийн зардлыг тооцсон үнэ	ЛМБиржийн Үнэ – (300 +.09 (Зэсийн ЛМБ-н Үнэ)) тонн тутамд	Алтны үнийг ашиглаагүй тул бага Бусад төлбөр (хайлуулах үйлдвэрээс ачих тээвэр, торгууль г.м.)-ийг оруулан тооцох юм бол их
3	Инфляци	0%	Бага – Ашгийн татвар, гэнэтийн ашгийн татвар нь инфляциас хамаарахгүй тул инфляци Монгол улсад эерэгээр нөлөөлнө.
4	Хүүгийн түвшин	Зээлийн хүү болон өөрийн хөрөнгийн ашгийн түвшин хоёрын хувьд ижил хувь хэмжээ ашигласан. Хүүгийн түвшин кейс бүрт өөр байна.	Тодорхой бус – зээлийн хүүгийн түвшин болон өөрийн хөрөнгийн өртгийн хоорондын харьцаанаас хамаарна
5	Татвар, санхүүгийн дэглэм	Хүснэгт 1-н дагуу	
6	Үйлдвэрлэл	Гэрээний төсөлд заасны дагуу	
7	Хөрөнгө оруулалтын зардал	Гэрээний төсөлд заасны дагуу	
8	Үйл ажиллагааны зардал	Айвенхоу-н Орд ашиглалтын төлөвлөгөөний Гүйцэтгэлийн хураангуй-д заасны дагуу	
9	Ногдол ашиг	Татварын дараахи ашгаас зээлийн төлбөрийг хассан дүнгээр тодорхойлно. Хөрөнгийн өгөөжийг татварын элэгдэл гэж тодорхойлно. (Ногдол ашгаас анхны хөрөнгө оруулалтыг эргэн төлөх явдлыг салгах шаардлагатай. Татварын дараахи ашиг тэгтэй тэнцүү, эсхүл сөрөг утгатай байхад хувь нийлүүлэгчдэд төлбөр хийж болно. Үүнийг хувь нийлүүлэх анхны хөрөнгийн эргэн төлөлт гэж үзнэ.	Бага – хэрвээ ногдол ашгийг татан буулгахтай холбогдсон, эсхүл өөр ямар нэгэн дүрмийн дагуу хувь нийлүүлэгчид олгож байгаа төлбөрөөс бусад төлбөр гэж тодорхойлбол.
10	Компаний өрийн эргэн төлөлт	Хүүг тухайн жилд нь, харин үндсэн өрийг нэг дор төслийн эцэст төлнө.	Тодорхой бус – Зээлийг өмнө нь эргэн төлбөл үйлдвэрлэл явагдах үеийн илүү эхэнд орлогын татвар илүү өндөр болно. Үйлдвэрлэлийн эхний үед ногдол ашиг бага байна, учир нь зээлийг төлөхийн тулд бэлэн мөнгө зарцуулна.

Зүйл	Нөхцөл	Монгол Улсад ногдох хувьд үзүүлэх нөлөө
11 Монголын 34 хувийг санхүүжүүлэх зээлийг эргэн төлөх	Зээлийн үлдэгдлийг нөхөн төлж дуустал Монгол Улс ногдол ашиг болон хөрөнгийн эргэн төлөлтийг авахгүй	Тодорхой бус --- Засгийн газрын өрийг хэрхэн эргэн төлөх хуваариас
12 Биет бус хөрөнгийг хэрхэх	Хайгуул, үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн өмнөх зардлын хувьд 5 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдэл тооцно.	ИХ-Татварын хуулинд биет бус хөрөнгийг хэрхэн тооцох талаар тодорхой бус байгаа. Хайгуулийн зардлыг 5 жилийн хугацаанд элэгдэл тооцож хорогдуулна, харин бусад биет бус хөрөнгө, үйлдвэрлэлийн өмнөх зардлыг хэрхэх талаар тодорхой заагаагүй.
13 Дотоодын хайлуулах үйлдвэр	Хайлуулах үйлдвэрийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ тэгтэй тэнцүү гэж үзсэн. Дотоод, гадаадын хайлуулах үйлдвэрийн хувьд хайлуулах зардал адилхан гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, дотооддоо хайлуулах үйлдвэрээс ямар нэгэн нэмүү өртөг бий болгохгүй гэж үзсэн.	Их - Хайлуулах үйлдвэрийн өрсөлдөөнт үнийн түвшин дэх Өнөөгийн цэвэр үнэ цэнэ тэгээс бага байх магадлалтай. Тийм биш бол гэнэтийн ашгийн татвараас шалтгаалан компани хайлуулах үйлдвэрт хөрөнгө оруулахгүй байсан.
14 Цахилгаан	Зардлыг үйлдвэрлэлийн зардалд шингээнэ. Тиймээс цахилгааныг хаанаас авахаас үнэ хамаарахгүй. Цахилгаан станц барьсан тохиолдолд Өнөөгийн цэвэр үнэ цэнэ нь тэгтэй тэнцүү байна гэж үзсэн.	Их -- Үнийн талаархи нөхцөл нь дотоодын цахилгаан хангамжид ямар нэгэн татаас өгөхгүй байхтай адил утгатай.
15 Менежментийн төлбөр	Хувь нийлүүлэгчийн гэрээний төсөлд заасны дагуу Өнөөгийн үйлчилж буй хуулийн хувилбарын хувьд тэг хэмжээтэй	Өнөөгийн хуулийн хувилбарын хувьд их.
16 Валютын ханш	Дотоод валютаар төлбөр хийх зардлын хувь хэмжээ тодорхой бус. Тиймээс валютын ханш төслийн хугацаанд өөрчлөгдөхгүй гэж үзсэн.	Мэдэхгүй --- Долларын ханш төгрөгтэй харьцуулахад чангарах, сулрахаас хамаарна.
17 Дотоодын компанийн зээлийн бүтэц	Дотоодын компани зээл авбал өөрийн хөрөнгөөр хийх санхүүжилтийн хэмжээ Засгийн газар, гадаад хөрөнгө оруулагч аль алиных нь хувьд хувь нийлүүлсэн хэмжээтэй пропорциональ хэмжээгээр буурна.	
18 Баяжмалын үйлдвэрлэл	Хүдэр дэх агуулга нь 2 хувь, Айвенхоу-ийн Орд ашиглалтын төлөвлөгөөнд үндэслэн.	

Хавсралт 9. Суурь кейсийн үр дүн

	Өнөөгийн цэвэр үнэ цэнэ	Дотоод өгөөжийн түвшин	Өнөөгийн цэвэр үнэ цэнийн ногдох хувь
Нийт төсөл	9,495.00	40.53 %	
Өнөөгийн хууль			
Хөрөнгө оруулагч	4,840.00	40.91 %	50.97 %
Монгол Улс	4,655.00	-	49.03 %
Гэрээний төсөл			
Хөрөнгө оруулагч	4,823.00	54.87 %	50.80 %
Монгол Улс	4,672.00	60.09 %	49.20 %
Гэрээний төсөл + гэнэтийн ашгийн татвар			
Хөрөнгө оруулагч	4,157.00	42.22 %	43.78 %
Монгол Улс	5,338.00	69.11 %	56.22 %

Тайлбар. Урьтал нөхцлүүд: Холбогдох бүлгээс үзнэ үү.

**Хавсралт 10. Үнэ өөрчлөгдөх үеийн Монгол Улсад ногдох
Өнөөгийн үнэ цэнийн хувь**

Зэсийн үнэ	Өнөөгийн хууль	Гэрээ+Гэнэтийн ашгийн татвар	Гэрээний төсөл
1.00	45.94 %	50.18 %	50.18 %
1.50	40.14 %	50.84 %	50.84 %
2.00	49.03 %	56.22 %	49.20 %
2.50	63.44 %	63.41 %	46.51 %
3.00	72.27 %	67.73 %	44.84 %
3.50	78.21 %	70.54 %	43.68 %

Хавсралт 11. Зээлийн бүтэц өөрчлөгдөх үеийн Монгол Улсад ногдох өнөөгийн үнэ цэнийн хувь

Зээлийн эзлэх хувь	Өнөөгийн хууль	Гэрээ+Гэнэтийн ашгийн татвар	Гэрээний төсөл
0.00 %	51.17 %	57.60 %	50.63 %
25.00 %	50.09 %	56.92 %	49.91 %
50.00 %	49.03 %	56.22 %	49.20 %
75.00 %	47.98 %	55.59 %	47.98 %
100.00 %	46.93 %	54.90 %	47.84 %

ХАВСРАЛТ 12. Хорогдуулах хувь өөрчлөгдөх үеийн Монгол Улсад ногдох өнөөгийн үнэ цэнийн хувь

Хорогдуулах хувь	Өнөөгийн хууль	Гэрээ+Гэнэтийн ашгийн татвар	Гэрээний төсөл
0.00 %	46.81 %	57.70 %	51.70 %
2.50 %	46.79 %	57.11 %	51.02 %
5.00 %	47.13 %	56.65 %	50.34 %
7.50 %	47.86 %	56.35 %	49.73 %
10.00 %	49.03 %	56.22 %	49.20 %
12.50 %	50.70 %	56.35 %	48.77 %
15.00 %	52.98 %	56.79 %	48.49 %
17.50 %	56.01 %	57.58 %	48.39 %
20.00 %	59.99 %	58.66 %	48.51 %
22.50 %	65.31 %	60.23 %	48.90 %

Хавсралт 13. Санал болгосон санхүүгийн дэглэм (САНАМЖ: ХУВИУДЫГ ТОДОРХОЙЛНО) 2007 оны 7 дугаар сарын 25

Санхүүгийн хэрэгсэл	Тайлбар
Нөөц ашигласны төлбөр	Хайлуулах үйлдвэрийн зардлыг тооцсон цэвэр үнийн Y% эсхүл Лондонгийн бараа түүхий эдийн бирж дээрх зэсийн үнийн болон алтны хамгийн наад захын үнийн XX% (тухайлбал, 60%) хувь хоёрын аль ихээр. Хайлуулах үйлдвэрийн зардлыг тусгасан цэвэр үнийг гэрээнд нарийн тодорхойлж нийтлэх бөгөөд улмаар эндээс нөөц ашигласны төлбөрийг тооцоход ашиглах үнийг олон нийт тооцон гаргаж болно. Зах зээлийн бодит үнийн боломжит хувийг тооцоолохын тулд зарим нэг судалгаа хийх шаардлагатай.
Ашгийн татвар	<p>Хувь: 25%</p> <p>Заалтууд</p> <p>1. Дараахи шалгуурыг хангасан холбогдох аль ч талын гүйлгээнд Урьдчилсан үнэ тогтоох гэрээтэй байх шаардлагатай.</p> <p>а/ 2.5 сая доллараас (инфляцийг тохируулаад) давсан аливаа нэг удаагийн төлбөрт б/аливаа дахин давтагдах (давхар гарч болзошгүй) төлбөр хураамж (технологи ашигласны төлбөр гэх мэт)</p> <p>2. Толгой компанид хийх төлбөрийг уг төлбөрийн бодит гүйцэтгэлээс доогуур байхаар, эсхүл инфляцийг тохируулсны дараахь 1.5 сая доллараар (жишээ нь) хязгаарлав.</p> <p>3. Капиталжуулалтын хязгаарлалт: Аливаа зээлийн өрийн хүүгийн төлбөрийн хэмжээг хүүгийн хасалтыг үл харгалзан татвар ногдох орлогын 50 хувиар хязгаарлав. Илүүдэл хасалтыг ямар нэг хязгаарлалтгүйгээр шилжүүлж болно.</p> <p>4. Алдагдлыг дараагийн жилүүдэд шилжүүлэх: Хугацааны турш хэмжээний хязгааргүй байна. Алдагдлыг дараагийн жилүүдэд шилжүүлэхдээ татвар ногдох орлогын бүрэн хэмжээгээр хийж болно. (Дараагийн жилд шилжүүлэх алдагдлыг АНУ-ын ДНБ-ний дефлятраар индексжүүлж, хөрөнгө оруулагчын алдагдал инфляцийн нөлөөгөөр буурахааргүй болгож болох юм.)</p> <p>5. Үйлдвэрлэлийн өмнөх зардлуудын элэгдэл хорогдол: Байж болох үйлдвэрлэлийн өмнөх зардлуудыг (түүний дотор машин механизм, байшин барилга, биет бус хөрөнгүүд, зохих ёсны холбогдох бүх зардлууд) 100 хувь капиталжуулах бөгөөд арилжааны үйлдвэрлэл явагдаж эхэлсэн өдрөөс эхлэн 6 жилийн турш элэгдэл хорогдол тооцно.</p> <p>6. Үйлдвэрлэлийн дараахь зардлуудын элэгдэл хорогдол: Уурхайд холбогдох бүх машин механизм, тоног төхөөрөмж, байшин барилгад татварын хуулинд заасан нормын дагуу элэгдэл хорогдол тооцно. Аливаа капиталжуулсан биет бус хөрөнгийн элэгдлийг 6 жилийн хугацаагаар тооцно.</p> <p>7. Гадаад валютын олз ба алдагдал: Акруэль сууриар татвар ногдуулна.</p> <p>8. Хамгаалалтын сангийн зардлууд: Хасагдуулахгүй (эсхүл Монгол дахь үйлдвэрлэлийн хувь хэмжээг дэлхийн бусад хэсгийн үйлдвэрлэлтэй харьцуулсан хувиар хасагдуулна.)</p> <p>9. Засвар үйлчилгээ: Аливаа хөрөнгийн тохируулсан суурь үнийн 10 хувиас хэтэрсэн засвар үйлчилгээний зардлыг тухайн хөрөнгийн тохируулсан суурь үнэ дээр нэмнэ.</p> <p>10. Ногдол ашгийн татварын данс:</p> <p>а/ Тухайн үйлдвэрийн газар бүрэн дампуурснаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдэдээ өөрийн хөрөнгийнх нь хэмжээтэй хувь тэнцүүлэн олгож байгаа аливаа хуваарилалтыг ногдол ашиг гэж тодорхойлдог.</p> <p>б/ Ногдол ашгийн төлбөрт тухайн ашиг хүртэгч этгээдийн хаана оршиж сууж байгаагаас үл хамааран дараахи хэмжээгээр татвар ногдуулна:</p> <p>-хэрэв аж ахуйн нэгжийн орлогын татвар бүрэн төлсний дараа ногдол ашиг төлж байгаа бол 0%.</p> <p>-хэрэв татвар ногдуулаагүй орлогоос ногдол ашиг төлж байгаа бол 25% байна.</p> <p>в/ Татвар бүрэн төлсөн орлогыг тооцохдоо ногдол ашгийн татварын данс бий болгох бөгөөд төлсөн буюу хуримтлагдсан аж ахуйн нэгжийн бүх татваруудад ногдол ашгийн хуваарилалттай нь харьцуулсан хувиар нэмэлт, хасалтууд хийх юм.</p> <p>11. Хилийн чанад руу хийх төлбөрүүд: Стандарт гэрээний хувиуд, эсхүл татварын хуулийн аль тохиромжтойг хэрэглэнэ.</p>

Санхүүгийн хэрэгсэл	Тайлбар
Хэт өндөр ашгийн татвар	<p>Хоёр хувилбар санал болгож байна.</p> <p>Хувилбар 1: Нөөцийн түрээсийн татвар Татварын хувь: ZZ% Суурь: Үйл ажиллагаанаас хуримтлагдсан бэлэн мөнгөний урсгал:</p> <p>1.Аливаа жилийн бэлэн мөнгөний урсгалыг тэр жил тухайн уурхайд орсон бэлэн мөнгөн орлого ба бэлэн мөнгөн зарлага хоёрын зөрүү гэж тодорхойлдог. а/Бэлэн мөнгөний урсгалд дараахи зүйлс орно:</p> <ul style="list-style-type: none"> • Бүх татварууд, улсад төлөх төлбөрүүдийн хасалтууд • Бүх капиталын буюу нөгөө талаар капиталжуулсан, зарлагуудыг тэр дор нь хасна <p>б/Бэлэн мөнгөний урсгалд дараах зүйлс орохгүй:</p> <ul style="list-style-type: none"> • Аль нэг холбогдох талд төлсөн буюу түүнээс хүлээн авсан төлбөр • Ямар нэг зээл эсвэл зээлийн төлбөр <p>2.Хуримтлалтын хүчин зүйл а/ Хуримтлагдсан бэлэн мөнгөний урсгалыг тооцохдоо өмнөх жилийн хуримтлагдсан бэлэн мөнгөний урсгал дээр тухайн жилийн бэлэн мөнгөний урсгалыг нэмнэ. Өмнөх жилийн бэлэн мөнгөний урсгалд $1+A$ гэсэн хорогдуулагч коэффициентээр жил бүр тохируулга хийнэ. б/ (ХУВИЛБАР 1): 'A' хэмээх нэр томъёог $A = rf + \beta(rm - rf)$ гэж тодорхойлох бөгөөд энд: rf = АНУ-ын Төрийн сангийн 30 өдрийн тооцооны хувийг жилд шилжүүлсэн хувь rm = Стандарт энд Поорсийн Глобал 1200 индексээс таван жилээр тооцсон дүн Rf = эрсдэлгүй хүүгийн хувь (нэг бол 1%-н инфляцийн тохируулга хийсэн, эсхүл АНУ-ын Төрийн сангийн 30 өдрийн тооцооны хувийг жилд шилжүүлсэн хувь</p> <p>β = Айвенхоугийн эзэмшил хөрөнгийн жилээр тооцсон хувь хэмжээ, β-г Стандарт энд Поорсоос гаргаж нийтэлдэг (Энэ бол Айвенхоугийн зах зээлээс тогтоож, эрсдлийг тохируулсан хөрөнгийн өгөөжийн хувийн нэг хэмжүүр юм.)</p> <p>в/ (ХУВИЛБАР 2): Гэрээнд 'A' гэсэн нэр томъёог өрийг тооцоогүй нэрлэсэн хувь (инфляцийг оруулсан) гэж тодорхойлно. г/Хэрэв үйл ажиллагаанаас хуримтлагдсан бэлэн мөнгөний урсгал тэг, эсхүл хасах байх юм бол ямар ч татвар авахгүй. Зөвхөн татвар ногдуулаагүй үлдэгдэл нь эерэг байх юм бол татвар авна.</p> <p>Хувилбар 2</p> <p>Одоогийн Гэнэтийн ашгийн татварт дараахи өөрчлөлт оруулж хэрэглэх:</p> <p>1. Уг татварыг баяжмалын нийт үйлдвэрлэлд (борлуулалтад бус) хэрэглэх бөгөөд тээвэр лэх газраас (дотооддоо борлуулах, эсхүл экспортлох) үл хамааран ногдуулна. 2.Хөрөнгө оруулагч нэг бол 10 жил, эсхүл хуримтлагдсан бэлэн мөнгөний урсгал эерэг болох өдөр хүртэлх хугацааны аль бага хугацаагаар нь татвараас чөлөөлөгдөнө.</p>
Нэмэгдсэн өртгийн болон гаалийн татвар	<p>АММИ-ийн бизнесийн зорилгод шууд хамааруулж болох бүх бараа, үйлчилгээг татвараас чөлөөлнө. Түүнээс бусад бүх бараа бүтээгдэхүүнд бүтэн хувиар татвар ногдуулна.</p>

Санхүүгийн хэрэгсэл	Тайлбар
Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө	<p>Хоёр хувилбар санал болгож байна</p> <p>Хувилбар 1: Хувьцаа худалдан авах</p> <p>Засгийн газар бусад хөрөнгө оруулагчдын нэг адил нээлттэй зах зээл дээрээс Айвенхоугийн (Канадын компани) хувьцааг худалдан авч болно. Хэрэв Засгийн газар ийм хөрөнгө оруулалт хийхээр сонговол, эхэндээ Монголын капиталын төсвийн нэг хэсэг гэж үзэх бөгөөд үүнд хууль тогтоох байгууллагаас үнэлэлт дүгнэлт гаргуулна.</p> <p>Хувилбар 2: Хувьцаа худалдан авах</p> <p>АММИ Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргаж болно. Засгийн газар хууль тогтоох байгууллагын үнэлэлт дүгнэлтийн дагуу анх тогтоосон үнэлгээгээр АММИ-ийн (нийт эзэмшлийн) 34 хүртэл хувийг худалдан авах эрхтэй. Хэрвээ ийм зарлага гаргах тохиолдолд Монголын капиталын төсвийн нэг хэсэг гэж үзэх болно. Хэрэв хөрөнгө бүрдүүлэх зорилгоор хэзээ нэгэн цагт нэмэлт хувьцаа гаргах болбол Засгийн газар тухайн үед санал болгосон үнээр, хууль тогтоох байгууллагаас зөвшөөрсний дагуу өмчлөлийн 34 хувиа хэвээр хадгалах хэмжээнд хүртэл хангалттай тооны хувьцаа худалдан авах эрхтэй.</p>
Бусад заалтууд	<p>АММИ нь дотооддоо нэгдмэл нэг корпораци байна (ямар нэг салбартай байхыг зөвшөөрөхгүй)</p> <p>Тойруулж хаших: АММИ нь цорын ганц зорилготой хуулийн этгээд байна. Энэ үйлдвэрийн газрын цорын ганц зорилго бол Оюу толгойн орд газрыг ашиглах явдал юм. Хайлуулах үйлдвэрээс гадна цахилгааны эрчим хүчний станц ажиллуулах, зам тавих зэрэг бусад аль ч үйл ажиллагаа нь АММИ-ийн нэг хэсэг байх болно.</p> <p>Тогтвортой байдал: Нэг бол: Татварын хувийн тогтворжуулалт (дээш, доош), гэхдээ зөвхөн энд авч үзсэн татваруудаар хязгаарлагдана</p> <p>аль эсхүл: Татварын хувь ба бааз суурийн тогтворжуулалт (олон нийтийн шүүмжлэл, үнэлэлт дүгнэлт, хууль эрхийн сорилтуудад өртөх зохицуулалтуудад тодруулга хийхээс бусад)</p> <p>Монгол Улс энэхүү гэрээнд хяналт шинжилгээ хийх гадны хуулийн мэргэжилтнүүд, мөн татварын болон бусад аудит хийх олон улсын нягтлан бодох бүртгэлийн компанитай байна. Аудитын ажлын үр дүнг нийтлэнэ.</p>

Хавсралт 14. Бүтээгдэхүүн хуваах гэрээ, олон улсын харьцуулалт

	Ангол 1989 БХГ-ний загвар ⁴⁸	Индонези 2-р үе. 1984 оноос өмнөх үе ⁴⁹	Экваторын Гвиней Ашгийн түвшин ROR-д суурилсан БХГ ⁵⁰	Хятад, далай дахь ордын БХГ ⁵¹	
Талбай	Тусгайлан заасан блокууд	Хязгаарлалт байхгүй, тусгайлан заасан блокууд	125,000 акр дөрвөлжин блокууд		
Хайгуулын үргэлжлэх хугацаа Үйлдвэрлэл	5 жил (3 + 2 удаагийн нэг жилийн сунгалт) 20 жил	3 жил 20 жил	5 жил, 3 удаагийн 1 жил/1 цооногийн сунгалттай Арилжааны нөөц илэрснээс хойш 30 жил, хийн хувьд 50 жил	7 жил 15 жил + зөвшөөрөл аван сунгах боломжтой	
Тайлбайг буцаан хүлээлгэн өгөх		25 хувь, эсхүл нөөц илрээгүй бол 100 хувь	3-х жилийн эцэст 40 %, 5-х жилийн эцэс хүртэл 20 %		
Хайгууль хийх үүрэг		Олон цооног гаргах үүрэг	Өрөмдлөгө		
Нөөц ашигласны төлбөр	Тэг	Тэг	10%	Газрын тос, Баррель өдөрт 20,000 хүртэл 20,001-30,000 30,001-40,000 40,001-60,000 60,001-80,000 80,001+	Хувь, % 0 4 6 8 10 12.5
Урамшуулал				Хий, ММСFD	Хувь, %
Гарын үсэг зурсны	Тийм	Янз бүр	\$1 MM	195 хүртэл 195-338 338-484 484+	0 1 2 3
Үйлдвэрлэлийн	Тийм	Янз бүр – гэрээ бүр ялгаатай	10,000-20,000 баррель өдөрт ± байхад \$2-5 сая		
Илрүүлэлтийн			\$300,000 +		
Боловсролын	Тийм				

	Ангол 1989 БХГ-ний загвар ⁴⁸	Индонези 2-р үе. 1984 оноос өмнөх үе ⁴⁹	Экваторын Гвиней Ашгийн түвшин ROR-д суурилсан БХГ ⁵⁰	Хятад, далай дахь ордын БХГ ⁵¹
Зардал (өртөг) нөхөлт	50% хязгаар Хуучин гэрээнд ашиглалтын зардлыг 6 жилийн туршид нөхөхөд 61% өсгөн нэмэгдүүлэн тооцох боломжтой	Хязгааргүй, хөрөнгө оруулалтын урамшуулал 20% барилга байгууламж, платформ, дамжуулах хоолойн зардалд тооцдог; нөхөн авах боломжтой, Гэхдээ татвар ногдуулдаг	Нөөц ашигласны төлбөр төлсөний дараа хязгаар байхгүй	Үйлдвэр барих зардлын 50-62.5% -г 9%-ийн хүүтэй нөхөх боломжтой
Элэгдэл хорогдол	5 жил шулуун шугамын аргаар	Тос: 7 жил 2 дахин буурсан үлдэгдэл нь 5 дахь жилээс шулуун шугамын аргын тооцоонд орно. Хий: 7 жил буурсан үлдэгдэл 8 дахь жилээс шулуун шугаманд шилжинэ.	Жилд бүх зардлын 25%	6 жил шулуун шугамын аргаар
Ашигт тосны хуваалт	Талбар тус бүрээр хоёр жишээ: Өсөн нэмэгдэх бүтээгдэхүүн, сая баррель 25 хүртэл 25-50 50-100 100-с дээш Өсөн нэмэгдэх бүтээгдэхүүн, MMBBLs 25 хүртэл 25-75 75-175 175-с дээш	3Г = 65.9091% Компани = 34.0909%	Хоёр жишээ: Гэрээлэгчийн татварын өмнөх ROR 30% хүртэл 30-40% 40-50% 50%-с дээш Гэрээлэгчийн татварын өмнөх ROR 20% хүртэл 20-40% 40-60% over 60%	(тохиролцоно) Үйлдвэрлэлийн түвшин, баррель/өдөр 10,000 хүртэл 10,000-20,000 20,000-40,000 40,000-60,000 60,000-100,000 100,000-с дээш Хуваах %, ЗГ/Компани. 10/90 20/80 30/70 40/60 50/50 60/40
Ашигт хийн хуваалт		3Г = 20.4545% Компани = 79.5455%		

	Ангол 1989 БХГ-ний загвар ⁴⁸	Индонези 2-р үе. 1984 оноос өмнөх үе ⁴⁹	Экваторын Гвиней Ашгийн түвшин ROR-д суурилсан БХГ ⁵⁰	Хятад, далай дахь ордын БХГ ⁵¹
Татвар	50% ашгийн татвар	56% ашгийн татвар	25% ашгийн татвар	30% ашгийн татвар (бус нутгаар ялгавартай) + 2% орон нутгийн ашгийн татвар + 10% нэмэлт татвар
Ордыг тусад нь тойруулан хязгаарлах	Лиценз тус бүрээр хязгаарладаг	Лиценз тус бүрээр хязгаарладаг		Өртөг нөхөх тооцооны зорилгоор байдаг, харин ашгийн татварын хувьд бус
Дотоод зах зээлийн үүрэг	Үгүй	Тухайн талбараас 60 сарын үйлдвэрлэлийн дараа гэрээлэгч тосны 25 % -с \$0.20/bbl-г авдаг	Хүсэлт гаргасан тохиолдолд гэрээлэгч ЗГ-т түүхий тосыг зах зээлийн үнээр зардаг	Үгүй
Хөрөнгө оруулалтыг өсгөн нэмэгдүүлэн тооцох	Үндсэн хөрөнгийн биет зардлын 40 %			
Бусад	Өмнөх гэрээнүүд \$20/bbl үнийн дээд хязгаартай байсан (1987 оны үнэ). Энэ үнийг НҮБ- ын хөгжингүй улс орнуудаас гаргах эцсийн бүтээгдэхүүний экспортын фактороор үржүүлээд үнээс дээш үнийн ашгийг ЗГ авна. 1992 оны хязгаар үнэ =\$35/bbl			
Төрийн оролцоо	Тийм, ашиглахад 51 хувь хүртэл оролцох сонголт – гүн усанд хувь нь бага	50% хүртэл – энэ боломжийг тун ховор хэрэгжүүлдэг		Арилжааны олборлолтын 51 %

⁴⁸ Johnston p. 212.⁴⁹ Johnston p. 229.⁵⁰ Johnston p. 224.⁵¹ Johnston p. 218

	Боливи Үйл ажиллагаа, хамтын ажиллагаа, үйлчилгээний гэрээ ⁵²	Франц 1980-аад оны сүүл ⁵³
Талбай	Уламжлалт талбайд 1 сая га-гаас хэтрэхгүй Уламжлалт бус талбайд 1,5 сая гагаас хэтрэхгүй ба 20000 га бүхий багц талбаруудтай	Талбайг буцаан хүлээлгэн өгсөний дараа доод тал нь 175 кв км.
Хайгуулын үргэлжлэх хугацаа	Дээд тал нь 30 Хий нээсэн бол 4 жил + 2	5 жил + дээд тал нь 5 жилийн хугацаатай 2 удаагийн сунгалт
Үйлдвэрлэл	24-26 жил, сунгалтаас хамаарна	5 жил + 2 5-жилийн сунгалт талбай нь < 2.1 сая баррель Том талбайн хувьд 50 жил хүртэл
Талбайг буцаан хүлээлгэн өгөх	Хайгуулын шатны дараах ашиглалтын талбай 3 багц талбараас хэтэрч болохгүй (60,000 гектар)	5 жилийн дараа 50% Сунгалт 12.5% (37.5%-г үлдээнэ)
Хайгуулын талаар хүлээх үүрэг		
Нөөц ашигласны төлбөр	Нийт үйлдвэрлэлийн хэмжээ суурьтай 19 %-н үндэсний улсын татвар 11 % яамны оролцооны роялти 1 % улсын нөхөн олголтын роялти	Тос Өдөрт 1,000 баррель хүртэл 1,001-2,000 2,001-6,000 6,001+ Хий 30 сая CFD
Урамшуулал		
Гарын үсэг зурсны Үйлдвэрлийн		
Илрүүлэлтийн		
Боловсролын		
Тосны анхны борлуулалтын		
Зардал (өртөг) нөхөлт		Консессийн тогтолцоо, 100%
Элэгдэл хорогдол		
Ашигт тосны хуваалт		
Ашигт хийн хуваалт		
Татвар	Цэвэр ашгийн 40 % -н татвар	50 % ашгийн татвар Татварыг хойшлуулах, хорогдуулах боломж Нийт ашгийн 23.5 % эсвэл нэмэлт хайгуулд хөрөнгө оруулсан бол цэвэр ашгийн 50 %

	Боливи Үйл ажиллагаа, хамтын ажиллагаа, үйлчилгээний гэрээ ⁵²	Франц 1980-аад оны сүүл ⁵³
Ордыг тусад нь тойруулан хязгаарлах		
Дотоод зах зээлийн үүрэг		
Хөрөнгө оруулалтыг өсгөн нэмэгдүүлэн тооцох		
Бусад		
Төрийн оролцоо		Тэг

⁵²*Johnston p. 215.*⁵³*Johnston p. 225.*


Хавсралт 15. Бүтээгдэхүүн хуваах энгийн жишээ

Тосны үнэ-Нэг баррельд 60
 Үйлдвэрлэлийн өртөг-Нэг баррельд 30
 Засгийн газарт ногдох хувь-68 хувь


Цаг хугацаа	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
Тосны үйлдвэрлэл	-		100.00	110.00	121.00	133.10	146.41	161.05	136.89	116.36	98.91
Тосны борлуулалтын орлого			6.000.00	6.600.00	7.260.00	7.986.00	8.784.60	9.663.06	8.213.60	6.981.56	5.934.33
Хөрөнгө оруулалтын зардал	6.000.00	8.000.00	-	-	-	-	-	-	-	-	-
Үйл ажиллагааны зардал			3.000.00	3.300.00	3.630.00	3.993.00	4.392.30	4.831.53	4.106.80	3.490.78	2.967.16
Өртөгт тосны тооцоо											
Тосны үнэ	60.00	60.00	60.00	60.00	60.00	60.00	60.00	60.00	60.00	60.00	60.00
Нийт зардал /хөрөнгө оруулалтын зардлыг тооцсон дүн/	6.000.00	8.000.00	3.000.00	3.300.00	3.630.00	3.993.00	4.392.30	4.831.53	4.106.80	3.490.78	2.967.16
Ирэх жилүүдэд шилжүүлсэн алдагдал	-	6.000.00	14.000.00	11.000.00	7.700.00	4.070.00	77.00	-	-	-	-
Нийт зардал /ирэх жилүүдэд шилжүүлсэн алдагдлыг оролцуулаад/	6.000.00	14.000.00	17.000.00	14.300.00	11.330.00	8.363.00	4.469.30	4.801.53	4.106.80	3.490.78	2.967.16
Зардлыг нөхөхөд шаардлагатай тосны хэмжээ, баррелиар	100.00	233.33	283.33	238.33	188.83	134.38	74.49	80.53	68.45	58.18	49.45
Үйлдвэрлэсэн тосны хэмжээ баррелиар	-	-	100.00	110.00	121.00	133.10	144.41	161.05	136.89	116.36	98.91
Өртөгт тос	-	-	100.00	110.00	121.00	133.10	74.49	80.53	68.45	58.18	49.45
Хуваах тос											
Хуваах тос		-	-	-	-	-	71.92	80.53	68.45	58.18	49.45
Засгийн газрын хувь		-	-	-	-	-	46.75	52.34	44.49	37.82	32.14
Хөрөнгө оруулагчийн хувь		-	-	-	-	-	25.17	28.18	23.96	20.36	17.31
Хөрөнгө оруулагчийн мөнгөний урсгал											
Өртөгт тос		-	6.000.00	6.600.00	7.260.00	7.986.00	4.469.30	4.831.53	4.106.80	3.490.78	2.967.16
Хуваах тос		-	-	-	-	-	1.510.36	1.691.04	1.437.38	1.221.77	1.038.51

Цаг хугацаа	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
Хөрөнгө оруулалтын зардал	6.000.00	8.000.00	-	-	-	-	-	-	-	-	-
Үйл ажиллагааны зардал	-	-	3.000.00	3.300.00	3.630.00	3.993.00	4.392.30	4.831.53	4.106.80	3.490.78	2.967.16
Хөрөнгө оруулагчийн мөнгөний урсгал	(6.000.00)	(8.000.00)	3.000.00	3.300.00	3.630.00	3.993.00	1.587.36	1.691.04	1.437.38	1.221.77	1.038.51
Хөрөнгө оруулагчийн NPV өнөөгийн цэвэр үнэ цэнэ	2.43										
Хөрөнгө оруулагчийн дотоод өгөөжийн түвшин	8.409 %										
Засгийн газрын мөнгөн урсгал											
Хуваах тос		-	-	-	-	-	2.804.95	3.140.49	2.669.42	2.269.01	1.928.66
Засгийн газрын өнөөгийн үнэ цэнэ	5.871.28										
Өнөөгийн цэвэр үнэ цэнийн Засгийн газарт ногдох хувь	0.96										


ЗУРАГ 1. Зэсийн үнийн өөрчлөлт Монгол улсын авах өнөөгийн үнэ цэнийн хувь хэмжээнд нөлөөлөх нь (санал болгож буй гэрээ ба өнөөгийн үйлчилж буй хуулийн төслийн харьцуулалт, хорогдуулах хувь = 10%)



ЗУРАГ 2. Зээлийн бүтэц Монгол улсын авах өнөөгийн үнэ цэнийн хувь хэмжээнд нөлөөлөх нь



ЗУРАГ 3. Хорогдуулах хувь Монгол улсын авах өнөөгийн үнэ цэнийн хувь хэмжээнд нөлөөлөх нь




ЗУРАГ 4. Бүтээгдэхүүн хуваах гэрээ

Хүснэгт 1: Бүтээгдэхүүн хуваах нь



ЗУРАГ 5. Төрийн хувь эзэмших оролцоотой бүтээгдэхүүн хуваах гэрээ

Хүснэгт 2: Төрийн хувь эзэмших оролцоотой бүтээгдэхүүн хуваах нь



ЗУРАГ 6. Түлшнээс бусад ашигт малтмалд өргөн хэрэглэгддэг төсөв санхүүгийн хэрэгслүүд⁵⁴



⁵⁴ Монгол Улсын хувьд ашгийн татвараас өмнө гэнэтийн ашгийн татвар тооцдог. Зарчмын хувьд энэ зурагт үзүүлсэнээс онцын ялгаагүй юм.